

ТОЛИНД ХАРАГДАХ ҮЛ ТАНИХ ХҮН



СИДНИ ШЕЛДОН

СИДНИ ШЕЛДОН

ТОЛИНД ХАРАГДАХ ҮЛ ТАНИХ ХҮН

www.kiebooks.com

ЭХЛЭЛ

Энэхүү тайлагдашгүй хачин үйл явдал 1969 оны 11-р сарын сэрүү татсан нэгэн бямба гаригийн өглөө Нью-Йорк хотын боомтноос Гавр орохоор бэлтгэж байсан тавин таван мянган тоннын усан түрц бүхий "Бретень" хэмээх зорчигч тээврийн хурдан хөлөг онгоцонд гарчээ.

"Бретень" хөлгийн аж ахуйг эрхлэгч Клод Дессар нь нямбай, ёсорхог хүн агаад захирагдагсадаа өөрийн ихэд эрхэмлэх дуртай "төмөр нударга"-аар удирдана. Арван таван жилийн турш хөлөг онгоцонд алба хаахдаа осолтой, үймээнтэй олон арван төвөгтэй асуудалтай тулгарч явжээ. "Бретень"-ийг францынх гэдгийг эс тооцвол энэ нь үнэхээрийн агуу ололт бөгөөд, захирагч дарга нь Дессарын ажлын ур чадварыг өндрөөрүнэлдэг аж. Тэр л нэгэн өдөр арван хар тамаас үгсэн ирсэн ирсэн болов уу гэлтэй мянга мянган чөтгөр шулмууд түүний эсрэг нэгдсэн мэт болсон байна. Америк-Францын Интерполын бригад, хөлгийн аюулаас хамгаалах албаныхан тэр өдрийн болсон үйл явдалд ямар ч тайлбар өгч чадахгүй, байж ядан бажгадаж байхад Дессар франц хүний бардам зангаар нөхцөл байдалд туйлын тайван хандсан ажгуу.

Дэлхий даяар зарлан хашгичиж байсан энэ тайлагдашгүй эмгэнэлт явдалд хутгалдсан хүмүүс нь ил байсан ч гэлээ хэргийн нууц нь хаалттай хэвээр үлджээ.

Клод Дессар эндээс эвтэйхэн зайлж чөлөөнд гарч, Ницад нэгэн зоогийн газар эзэмшин, хааяа нэг сониуч үйлчлүүлэгчид тэрхүү арван нэгдүгээр сарын аймшигт өдрийн тухай хуучилдаг байв.

Эл хэрэг Нэгдсэн улсын ерөнхийлөгчөөс цэцэг ирснээр бүх юм эхэлсэн мэт Клодад санагддаг аж.

Далайд гарахаас цагийн өмнө засгийн газрын дугаар бүхий хар лимузин Гудзон голын зогсоолд ирж, саарал судалтай хар өнгийн пиджактай эр гартаа "стерлинг силвер" сортын сарнай цэцгийн гурван баглаа барьсаар машинаас бууж ирэв. Тэрээр "Бретень" хөлгийн манааны офицер Ален Сэффордтой хэдэн үг солиод дараа нь тэрээр цэцгийн баглаагаа хөлгийн бага офицер Женанд ёслол төгөлдөр гардуулахад, цаадахь эр эзэнд нь хүргэж өгөхөөр Клод Дессарыг хайлаа.

-Таныг энэ тухай мэдэх ёстой гэж би бодсон юм. Дөнгөж сая хатагтай Темплд Ерөнхийлөгчөөс цэцгийн баглаа ирлээ. гэж Жанен түүнд дуулгав.

Жилл Темпл хүүхний гэрэл зураг сүүлийн үед Нью-Йоркоос Бангкок, Парижаас Ленинград хүртэл дэлхийн олон орны бүх сонин сэтгүүлийн нүүрэнд хэвлэгдэх болжээ.

Клод Дессар тэр бүсгүйг дэлхийд нэрд гаран бишрэгдсэн бүсгүйчүүдийн нэрсийн жагсаалтанд тиим ч хойгуур байранд ордоггүйг санаж байлаа. Америкчууд үргэлж нутгийн хэн нэгэн бүсгүйгээ дээш нь товойлгон гаргах дуртай юм хойно Жилл

Темпл мөн тэдний нэг нь болон тодорчээ. Олон эцэг эхчүүд шинээр мэндэлсэн охиддоо

түүний нэрийг хайрлацгаасан байна. Гэтэл түүний эр зориг, итгэмээргүй ялалт нь эцэстээ эмгэнэлт ялагдал болон хувирсанд бүх дэлхийг цочирдуулжээ.

Сонгодог драм, эмгэнэлт явдал зэргийг бүгдийг агуулсан бодит мэдрэмж, үнэн зүрхний агуу их хайрын түүх...

Клод Дессар америкчуудыг тийм ч их таалдаггүй атлаа энэ удаад тэдэнд туслахдаа баяртай байлаа. Тэрээр хэн нэгнийг хатагтай Темпл шиг шагшин гайхах нь тун ховор юмсанж. Дессар бүсгүйг сурсан дадал, чадлынхаа хэрээр найрсаг үгээр шагнав. Бүсгүй үнэхээрийн баян сурвалжит эмэгтэй. Тиймээс мань эр эл аялал түүний бүхий л амьдралын туршид сэтгэлд нь хоногшин үлдээсэй хэмээн санаа тавина!

Жилл Темплийн тухай сайхан бодолд умбан аж ахуйн ойр зуурын ажил эрхлэх зуур зорчигчдын нэрсийн жагсаалтыг сайн нягтлавал тэнд Тун Чухал Хүмүүст-ТЧХ тооцогддог америкчууд энд цугларчээ. Америкчууд хэн нэгнийг туйлын бүдүүлгээр үнэлдэг тул Дессар энэхүү товчилсон үгэнд яс махнаасаа дургүй ажээ. Нэгэн үйлдвэрийн баян эзний эхнэр ганцаараа аялаж явааг нь анзааран мушигнаад, жагсаалтанд хар арьст алдарт хөл бөмбөгчиний нэрийг хайвал Мэтте Эллис гэсэн нэр тэр даруй нүдэнд нь тодроход сэтгэл хангалуун толгой дохив.

Жинхэнэ ахмадын дайны хүндлэл хүртэх болно гэсэн үг байлаа. Клифтон Лоренс гэгч нь хөлөг хөдлөхөөс өмнө амжиж өрөө захиалжээ. Дессар царайгаа барайлган ноён Лоренсыг хэрхэн яах вэ гэдэг маш төвөгтэй асуудал гарч ирсэн ч урьдын адил энэ хүнийг ширээний ахмадтай нэн даруй суулгавал ямар ч асуудал гарахгүй, тэр хаана явсан газраа бусадтайгаа өнөө л зугаатай онигоогоо дэлгэж чаддаг нэгэн. Клифтон Лоренс, урьд нэгэн цагт олон арван алдарт одод театрын тэнгэрт гялалзаж байсан тэр цагийн төлөөлөгч юм. Гэвч энэ бүгд өнгөрч. . . Урьд ноён Лоренс хамгийн тансаг люкс өрөөг эзэгнэдэг байсан бол энэ удаагийн явалтандаа доод тавцангийн ганц хүний 1-р зэрэглэлийн өрөөг захиалсан байв. Гэвч Клод Дессар жагсаалтыг бүрэн үзэж судлалгүйгээр яаран дүгнэлт гаргахаас түдгэлзэв.

Эдгээр зорчигчдын дунд доройтолд орсон овгийн хааны, дуурийн алдарч дуучин, Нобелийн шагналаас татгалзагч Оросын зохиолч байлаа.

Үүд тогшин Дессарын бодлыг тасалдуулан зөөгч Антуан орж ирлээ.

-За, юу гэв? гэж Клод асуувал, Антуан нулимс гүйлгэнэсэн нүдээ анивчин, тээнэгэлзэн хэллээ.

-Та кино танхимыг хаах тушаал өгсөн үү?

-Чи юу ярина вэ? гээд Дессар хөмсөг зангидав.

-Би таныг гэж бодсон юм. Өөр хэн тэгэх вэ? Хэдэн минутын өмнө бүгд хэвийн байгаа эсэхийг нь шалгахаар очтол үүд нь хаалттай, хэн нэгэн кино үзэж байх шиг байсан юм.

-Бид зогсоол дээр хэзээ ч кино үзүүлдэггүй, үүд нь үргэлж онгорхой байдаг. Би өөрөө явж

үзье хэмээн аж ахуйн эрхлэгч хэлэв.

Клод Дессар даруйхан очиж учрыг магадлах байсан ч далайд хөвж гарах эцсийн мөчид үргэлж л аар саар ажил ар араасаа овоордог хойно доо.

Бэлэн мөнгөө тоолж амжаагүй, кассчин хамгийн сайн өрөөний тасалбарыг андууран хоёр удаа зарчихсан, ахмад Монтен-ийн захиалсан хуримын бэлгийг шал өөр хөлөгт хүргэж өгсөнд ахмад уурандаа тэсрэх шахаж байжээ. Дессар хором хэртээ зогсон хөлгийн хүчирхэг хөдөлгүүрийн хүржигнэх танил чимээг сонслоо. "Бретень" хөлөг зогсоолоос аажим тасран суваг тийш ухрав. Дессар хойшлуулшгүй асуудалд анхаарал тавихаа таг мартжээ.

Хагас цагийн дараа зугаалах тавцангийн ахлах үйлчлэгч Леон түүнийг хайж олжээ.

-За бас яасан бэ, Леон? гэж Дессар тэсгэлгүй асуув.

-Төвөг удсанд өршөөгөөрэй, гэхдээ миний бодлоор та энэ тухай мэдэх ёстой гэж бодож байна.

-За юу болоов? гэсэн боловч аж ахуйн эрхлэгч, хүндэт зочдоо ахмадын ширээнд хэрхэн суулгах вэ гэсэн төвөгтэй асуудалдаа анхаарлаа хандуулсан байжээ.

Ахмад язгууртны хүрээний хүн биш тул түүний хувьд орой бүр эелдэг яриа хөөрөө дэлгэн хатагтай нарыг зугаацуулах гэдэг хүндхэн сорилд орох нь. Иймээс Дессар тэднийг зохицуулан залах амаргүй үүрэг байнга хүлээх болж дээ.

-Хатагтай Темплтэй холбоотой юм. . . гэж Леон яриагаа эхлэв.

Дессар яаран гараараа дохин, эгшин зуур жижигхэн хар нүд нь гялалзан, чих нь сортойгоод ирлээ.

-Яриадах!

-Би дөнгөж сая түүний өрөөний дэргэдүүр өнгөртөл чанга дуугаар хашгирахыг сонслоо. Үүдний цаанаас бараг юу ч сонсогдохгүй байсан л даа, гзвч "Та нар намайг, та нар намайг алчихлаа!" хэмээн бүсгүй дахин дахин үглэхийг нь сонслоо. Бусдын хэрэгт оролцох хэрэггүй гээд энэ тухай танд нэн даруй дуулгах ёстой гэж шийдлээ.

-Чи зөв юм хийжээ, Леон. Би өөрөө очиж үзье гээд Дессар толгой дохин сайшаалаа.

Цааш одох үйлчлэгчийн араас харан зогсоод "Итгэмээргүй юм! Хатагтай Темпл шиг хүнд муу юм хийж зүрхлэх хэн нэгэн байх гэж үү!" Дессарын уужим сэтгэлийнх нь мэдрэмж нь гүн хорслыг төрүүлж, тэрээр дүрэмт хувцсаа өмсөн толинд зэрвэс

Сонин хэвлэлийн хуудаснаа дуу дуугаа авалцан гарч байсан нэрт сенатор, латин америкийн тайчих урлагын од Карлина Росса хоёр зэргэлдээ өрөөг эзэгнэдгийг нь Клод Дессар яахан умартаж чадах билээ.

Дессар жагсаалтыг цааш уншвал Дэвид Кеньон гэгч тэр чигээрээ мөнгө ханхлуулсан, агуу их баялаг нүдэнд нь торжээ. Тэр "Бретень" хөлгөөр нэг бус удаа аялсан тул Дессар өндөр, царай зүс сайхантай, наранд борлосон, тамирчин хүний гуалиг биетэй эрийг сайтар санаж байлаа. Тэр эр намуун дөлгөөн, олон таван үггүй энэ зангаараа орчин тойрны хүмүүстээ хүндэтгэл хүлээж чаддаг нэгэн билээ. Клод түүний нэрийн өмнө ширээний ахмад "ША" гэсэн тэмдэглэл тавьж, энэ нь уг зорчигч хараад үүд рүү чиглэтэл утас хангинан дуугарвал хормын төдий тээнэгэлзээд ямартаа ч гэсэн харилцуураа авлаа.

-Клод оо, Бурхныг бодож кино танхим руу хэн нэгнийг хувин, ус алчууртай явуулаалаарай. Тэнд бүх юм цусанд будагджээ гэх гуравдугаар туслахын дуу хадав.

Дессарын зүрх палхийгээд явчихжээ.

Тэр мэдээд байсан юмаа.

-Одоохон. Аж ахуйн эрхлэгч хариулан харилцуураа тавьж, усан цэрэг дуудан тушаал буулгаад хэсэг зуур бодлогоширсноо хөлгийн эмчийн утсанд залгав.

-Андре уу? Клод байна гээд аль болох тайван ярихыг хичээн,

-Чам дээр хэн нэгэн тусламж гуйж ирсэн үү? . . . Үгүй, үгүй далайн өвчнөөс сэргийлэх эмний тухай бишээ. . . Шархаа оёулан цус тогтоолгосон ч юм уу нэг тиймэрхүү тусламж гуйж ирсэн үү? Ойлголоо... байлаа. .

Дессар муу совинд автан яриагаа дуусгаад Жилл Темплийн өрөө рүү явах замд нь бас нэгэн гай тохиолдов. Дессар нүднийхээ булангаар тэнгис руу харахад хөлөг Эмбразын хөвөгч гэрэлт цамхагийн тийш явж байв. Гэтэл "Бретень"-ийн хөдөлгүүрийн дуу гэнэт чимээгүй болж хөлөг зогсжээ.

Нилээд төвөгтэй юм болсон бололтой.

Дессар хашлага тийш гүйн очиж доош харвал зүтгүүр онгоц "Бретень"-ийн ачааны хэсэгт тулж ирчихсэн хоёр усан цэрэгачаа ачиж үзэгдэв. Мөн бяцхан хөлөг рүү рүү олсон шатаар нэг зорчигч бууж явлаа. Клод дөнгөж л зорчигчийн шилэн хүзүүгнь харж амжсан тул андуурсан гэдэгтээ итгэлтэй байлаа. Байж боломгүй юм. Өөрийн санаа өөртөө зөв ч гэлээ ХЭН НЭГ НЬ ИЙМ маягаар хөлөгөөс дайжин явж байгаа нь Дессарт бүүр түгшүүр төрүүллээ. Мань эр гэдрэг эргэн Жилл Темплийн өрөө рүү яаравчлан очиж хаалга тогшвол хэн ч хариу өгсөнгүй. Тэрээр дахин тогшлоо.

-Хатагтай Темпл, би Клод Дессар, аж ахуйн эрхлэгч байна. Танд ямар нэг зүйлээр туслах уу? Бас л нам гүм. Дессарын дотор сэтгэлд нь "дохиоллын систем" ажиллан түгшүүрийн харанга дэлдчин цуурайтаж зхлэв. Түүний зөн совин нь бүсгүйтэй холбоотой таагүй явдал болж, базаахгүй гай зовлон учирсан тухай хэлнэ.

Туйлын зэрлэг, итгэмээргүй таамаглал Дессарын тархинд багтаж ядан оволзоно. Бүсгүй алагдчихаж... хулгайлагдчихаж ... эсвэл.. .

Клод бариулыг хөшин дарвал үүд түгжээгүй байлаа. Тэрээр алгуурхан нээвэл Жилл Темпл өрөөний цаад буланд онгоцны гэгээвчээр ширтэн цааш харан зогсож байв. Дессар үг дуугарахыг завдан амаа ангайсан боловч хөделгөөнгүй хөшиж орхисон эл бүсгүйн дүрс түүнийг хазаарлан зогсоов. Тэрээр орох эсвэл явах хоёрын аль нь зөв болохыг шийдэж ядан будилж дороо хавчигнаж зогсоход шархадсан араатны амь тавин чарлахтай адил хүний бус цангинасан орилоон түүнд сонсогдлоо. Бусдын зовлонг сонссондоо хирдхийн цочирдож юу хийхээ мэдэхгүй балмагдсан Дессар чимээ гаргалгүй эргэн гарч, болгоомжтой гэгч нь үүдийг нь хаав. Хэсэг хүлээн үг дуугүй цурхиран уухилахыг сонсоод сэтгэл нь ихэд шаналан зовж, кино танхим бүхий гол тавцан тийш гэлдрэв. Усан цэрэг үүднээс эхлэн цусан замыг алчуураар арчиж байлаа.

"Бурхан минь, юу гээч нь энэ вэ?" гэж Дессар бодов. Үүдийг түлхвэл хавгас нээгдэн зургаан зуугаад зорчигч элбэг тухлан сууж болох уужим байранд Дессар орлоо. Танхим хов хоосон.

Тэрээр өөрийн мэдэлгүй явсаар аппаратын өрөөний үүдэнд хүрч очив. Цоож цуурга нь түгжээтэй, түлхүүр нь ердөө л Дессар, киномеханикч хоёрт байдаг ажээ. Клод түлхүүрээрээ үүдийг нээн харвал бүгд хэвийн мэт санагджээ. Өрөөний голд байрлуулсан кино проекторуудын зүг очиж бүгдийг алгаараа тэмтэрч үзвэл нэг аппарат арай илүү бүлээн байлаа.

Дессар механикчийг хайхаар доод тавцан руу бууж очин кино танхимд сая хэн байсныг мэдэхгүй хэмээн гэгээн бүхний нэрийг барин андгайлах киномеханикчийг олжээ.

Дессар өрөө рүүгээ явах замаа товчлон гал зуухаар дайран өнгөрлөө. Түүний замд уур хилэн нь бадарсан тогоочийн ахлагч уулзан,

-Ямар дүүрчихсэн мангуу амьтан юу хийснийг хар даа! Тэр надтай нэг учирнаа! гэж заналтайяа хэллээ.

Гантиг ширээн дээр хуримын ёслолд зориулсан гайхалтай бялуун дээрх сүйт бүсгүй, нөхрийн гуалиг дүрст чимэглэл байв. Гэтэл хэн нэг нь сүйт бүсгүйн толгойг няцалсан байлаа.

-Энэ үед л би ямар нэг аймшигт явдал болох нь гэдгийг ойлгосон юм даа хэмээн Клод Дессар зоогийн газрынхаа сэтгэл татам байнгын үйлчлүүлэгчдээ хүүрнэн суув.

НЭГДҮГЭЭР ДЭВТЭР

Бүлэг 1.

Детройт 1919 онд дэлхийн хамгийн баян, цэцэглэн хөгжиж буй үйлдвэрийн хот байлаа. Дэлхийн 1-р дайнд Детройт хотын үйлдвэр заводууд танк, чиргүүлт хөлөг онгоцоор хангасан нь холбооны цэргүүдийн ялалтанд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Байлдааны аюул занал өнгөрч, автомашины үйлдвэрүүд энх цагийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжин, өдөрт дөрвөн мянга хүртэл машин үйлдвэрлэж эхлэв. Мэргэжилтэй, мэргэжилгүй ажилчид ертөнцийн зүг бүрээс ажил хайн ийш хушуурч, итали, ирланд, германчуудын цуваа ч тасарсангүй.

Энд ирэгсдийн дунд шинэхэн гэр бүл Пауль Темплархаус, эхнэр Фрида хоёр мөн ирсэн ажээ.

Ноён Пауль Мюнхенд махны худалдагчийн дагалдан хийж байгаад Фридатай гэрлэн, Нью-Йорк хотод цагаачлан ирж эхнэрийнхээ хуримын инжээр махны мухлаг нээсэн бөгөөд хэдэн сарын дараа үгүйрэн хоосрохын даваан дээр тэрээр гэр бүлээрээ Сент-Луис, дараа нь Бостон, эцэст нь Детройдод нүүж ирсэн ажгуу. Бүх л хотууд нэг хэвийн цэцэглэн хөгжих үедээ орж, хүмүүс хоол хүнсээ хэмнэхээ болин, махны худалдагчид, хүнсний мухлагийн эзэд үлгэрийн юм шиг хурдан баяжин хөлжиж байхад, Пауль Темплархаус мухлаг нээсэн газар бүрдээ сүйрэн хоосрох аргаа олж чадсаар явлаа. Тэр хэдийгээр махны сайн худалдагч ч гэлээ бизнесийн ажилд юу ч мэдэхгүй, үнэнийг хэлэхэд хөрөнгө хуримтлуулахаасаа илүү шүлэг бичих дуртай нэгэн байлаа.

Пауль үг үеэ хурцлан, сүүл холбох эрэлд бэдэрч, цаасан дээр яруу найраг амилуулах гэж асар их хүч, цагаа зориулдаг байв. Өөрийн бүтээл туурвилаа сонин, сэтгүүлд илгээх авч энэрэх сэтгэлгүй хэвлэлийн газрынхан шүлгүүдийг нь байг гэхэд үхэлгүй мөнхийн бадгаас нь ч хэвлэсэнгүй. Паулийн хувьд энэ бүхэн ямар ч утга учиргүй санагджээ. Тэрээр бараагаа хэн хүнд хамаагүй зээлээр өгч, хавь ойрын оршин суугчид сайн мах үнэгүй авья гэвэл Темплархаусын мухлагыг зорих хэрэгтэй гэдгийг бүгд мэддэг болжээ.

Паулийн эхнэр Фрида нь зүс царай муутай, эрчүүдтэй ойлголцож чаддагүй тул Паультай учрахаас өмнө хэн нэгэн түүнийг болзоонд ч урьж байсангүй. Гэтэл түүнтэй гэрлэх санал тавин үнэн шударгаар түүнийг эцгээс нь гуйсан эр гарч иржээ. Фрида эцэг эхийгээ зөвшөөрч өгөхийг аргадан гуйж байсан хэдий ч охин нь эрд гарахгүй гэртээ өтлөн, үхэн үхтэл нь сэтгэлийн там болох бий гэж үнхэлцгээ хагартал айж байсан хөгшин удаан ятгуулсангүй. Эцэг нь Фридаг нөхрөө даган Германаас шинэ ертөнц рүү явахад нь туслан хүүхнийхээ инжийг хүртэл нэмжээ.

Фрида нөхрөө анх харсан цагаасаа эргэцүүлэн бодсон ч үгүй шууд дурлажээ. Бүсгүй урьд нь хэзээ ч жинхэнэ яруу НАЙРАГЧТАЙ уулзаж явсангүй. Халзан, туранхай, хараа муутай цэхэр нүд, мөрөөдөмтгий нүүр царайтай Пауль түүний хүсэл мөрөөдөл нь болжээ. Хэдэн сарын дараа л энэ сайхан залуу жинхэнэдээ түүнийх болсныг мэдэв.

Бүсгүй бөөн махан бөмбөөхий бие, зааных шиг бүдүүн хөл гээд өөрийн болхи гадаад төрхөндө санаа зовохоо больжээ.

Түүний нүүр төрх нь өвөг эцгээс нь дамжин ирсэн том төмсөн хамар, өвөөгийнх нь өндөр

ташуу дух, эцгийнх нь дөрвөлжин ёрдойсон эрүү гээд бусадтай адил авч гагцхүү нүд нь хамгийн сайхан гүн цэнхэр өнгөтэй ажээ. Гэвч зарим үед Бурханаас заяасан эл бие хаа нь залуу сайхан бүсгүйд шоронд хоригдох хүндхэн ял оноосонтой адил санагдана. Түүний хувь дутахад хүмүүс Фридагийн дотоод сэтгэлд нь юу нуугдаж байгааг нь өнгийн харахгүй атлаа хуншгүй зан гарган зөвхөн эрэмдэг төрхийг нь ажин анзаарахдаа гаргууд байдаг байв.

Паулаас л бусад нь бүгдээрээ шүү. Гэвч нөхөр нь хонь, үхрийн махтай ноцолдсон махны худалдагчийн ажлаас нь салгах цорын ганц боломж нь түүний инж гэж ихэд олзуурхан үзэж байгааг Фрида бүсгүй огт мэдсэнгүй. Паулийн мөрөөдөл нь өөрийн гэсэн өөдтэйхэн ажил эрхэлж хөрөнгөжин дуртай яруу найрагтаа олсон бүхнээ зориулахыг хүснэ.

Залуу хосууд бал сараа Зальцбургын ойр орших нуга, ойгоор хүрээлэгдсэн нуурын үзэсгэлэнт эрэг дээрх хуучны сайхан дэн буудалд өнгөрөөжээ. Фрида хуримын эхний шөнө Пауль үүдээ хаагаад, түүнийг тачаадан тэвэрч, янагийн сайхан үг чихэнд нь шивнэж, хувцсыг нь тайчин эцэг эхээсээ нууж уншсан бяцхан ногоон номонд бичсэн шиг хайртай нөхрийнх нь халуун янаг уруул нь түүний уруулыг тэмтчин олоод шуналтайяа үнсэн, тэрээр нүцгэн биеийг нь үнсэн таална хэмээн хэдэн зуун удаа өөртөө төсөөлөн боджээ. Эр нөхрийнх нь ичимхий жад мэт омогтой нь аргагүй гандайн босч, Пауль бүсгүйг өргөн ор руу авчран болгоомжтой гэгч нь хэвтүүлээд тэврэн авах болно гэж бодсоор.

"Фрида чи миний бурхан, би чиний биенд хичнээн их хайртай гээч. Эцэнхий тураалтай юм шиг хүүхнүүд нэг л биш дээ. Чиний бие жинхэнэ бүсгүй хүнийх, жинхэнэ бүсгүй хүнийх шүү!

Гэвч тун удалгүй Фрида ихэд цочирдон гайхжээ. Пауль түүний бодсончилон үүдээ хаагаад, дараа нь. . . Урам гутаасан бодит байдал сайхан мөрөөдлийг гутаалаа. Фрида бүсгүй Пауль хэрхэн цамцаа шалавлан тайчиж, үсгүй мулзан цээжээ гарган, өмдөө тайлан угтаа хүртэл цагираглан нуугдсан мэт өчүүхэн жижигхэн нуудгайгаа гаргаж ирэхийг мэл гайхан харж байв. Номны зурган дахь сэтгэл хөдөлгөсөн сайхан юм энэ хүнд өчүүхэн ч байсангүй. Пауль орон дээр сунан унаж эхнэрээ хүлээн хэвтээд өгөв. Тэрээр өөрийг нь хувцсаа тайч гэж буйг нь ойлгон палаажаа алгуурхан тайлж эхэллээ.

"За яахав дээ, том жижгийн ялгаа ч яах вэ. Пауль бол миний жинхэнэ эрхэм амраг минь байх болно".

Хэсэг хугацааны дараа залуу эхнэр энгэр нэгтгэх орондоо нөхөртэйгээ зэрэгцэн хайр дурлалаа илтгэхийг нь сонсохоор хүлээн хэвтэж байв. Гэвч Пауль үг дуугүй дээр нь мордон гарч ноомой үлбийсэн хөдөлгөөнөөр хэд оцогноод, багтарч үхэх нь үү гэлтэй амьсгаадан хажуу тийш өнхрөн хэвтлээ.

Хуримын анхны шөнө эхэлж амжилгүй тэр дорхноо дуусч бүсгүйг гайхуулан цочроов. Пауль өдийг хүртэл Мюнхений янхан хүүхнүүдтэй хавиралдаж заншчихаад, одооноос эхлэн түрийвч рүүгээ гар сунган төлбөр хийх хэрэггүй болсноо тэрээр санажээ. Мань эр энэ цаг мөчөөс иймэрхүү төрлийн үйлчилгээг бэлэг мэт хүртэх болно.

Пауль өөрийн тачаалаа тайлсан даруйдаа дуг нойрондоо дугжирч эхлэхэд Фрида саяын үзсэн

санаанд оромгүй зүйлээ аль болох бодохгүйг хичээн нүдээ бүлтийлгэн удаан гэгч нь сэрүүн хэвглээ.

"Секс үүгээр дуусахгүй ээ. Пауль сайн нөхөр байх болно" гэж өөрийгөө тайтгаруулна.

Энэ тухайд бүсгүй алд дэлэм андуурчээ.

Хэдэн долоо хоногийн дараа Фрида нөхөр Паулийнхаа тарыг нь таньжээ. Бүсгүй эм хүний байр нэг бол гал зууханд хүүхдүүдтэйгээ хамт, нэг бол сүмд гэж тунхагласан немц уламжлалаар хүмүүжсэн тул эр нөхөртөө үг дуугүй захирагдах бөлгөө. Тэрээр эр нөхөр нь бусдын адил, бизнесменүүдийн

адил илүү сайн сайхныг хүсэхгүй байгааг анзаарахгүй байж чадсангүй. Пауль дэнгийн эрвээхэй шиг дэгэлзэж байхад рида өрх гэрийн хүмүүжлийн дэгийг ёсчлон баримтлан суугаад Пауль ээлжит тэнэг юмаа хийхэд нь, Фрида байдлыг эвтэйхэн зохицуулан гарч дөнгөдг болжээ. . Гэр бүл болсныхоо дараахан бүсгүй өр нимгэнтэй, дүйнгэ нөхрийнхөө ажилд хушуу дүрэлгүй, түүний мөнгийг хэрхэн үрэн таран хийж буйг үг дуугүй харан санаа зовниж суудаг байв. Тэр үед гэр бүл нь Детройт рүү шилжиж, Фрида болж байгаа бүхнийг цаашид тэсвэрлэхээ болин шуударч, нөхрийнхөө мухлагийн ажилд ханцуй шамлан ороод, кассанд суун, нэн түрүүнд "Зээлээр өгөхгүй" гэсэн зарлал өлгөж авав.

Пауль эл бүхнийг ихэд гайхсан боловч энэ нь ердөө л эхлэл байлаа. Фрида махны үнийг өсгөн гойд сайн худалдааны зарлал түгээж эхлэв. Энэ мөчөөс эхлэн Фрида шийдвэр гаргах, тооцоо бүртгэлээ хөтлөх гээд бүхнийг гартаа атган, харин Пауль зөвхөн захирагдан дагах болжээ.

Эр нөхрийнхөө нь арчаагүй байдалд гайхаж цочирдсон Фрида жинхэнэ эзэгтэй болон хувирч, хүмүүсийг захирах авьяас эзэмдэж, өнөөгөөс хойш юу ч түүний мэдлээс ангид байхаа больжээ. Фрида хөрөнгө хэрхэн хуримтлуулах, тэд хаана амьдрах, амрах, хэзээ үр хүүхэдтэй болох зэргийг бүгдийг зааж зааварлана.

Тэрээр Паульд хүүхэд төрүүлэх хүсэлтээ хэлэн энэ талаар түүнийг санаа тавихыг шаардвал хөөрхий эр мэдрэлийн саад дайруулчих шиг боллоо. Тэрээр сексийн ийм идэвх гаргах нь түүний эрүүл мэндэд муугаар нөлеөлнө гэж үнхэлцгээ хагартал айж байсан бол Фрида зорьсноосоо няцахгүй байлаа.

-Намайг эзэмд! хэмээн тэрээр тушаасанд эр нөхөр нь,

-Яаж тэр вэ? Би хүсэхгүй байна хэмээн эрс эсэргүүцлээ.

Ингээд Фрида үлбэгэр дорой нуудгайг нь сэргээн гандайтал босгохыг оролдон элдэвлэж эхлэв.

-Бурхан минь, Фрида чи юу хийж байна аа? хэмээн зэвүүцэн бөвтгөнөхийг нь үл хэрэгсэн илж таалан аягласаар хүссэндээ хүрч, эрхтэнийг нь хүртэл өөрийнхрүүгээ шургуулаад нөхрийнхөө энэ үйлийг дуусгахыг хүлээнэ.

Шөнө бүр Фридагийн тарчлаасны үр дүнд гурван сарын дараа бүсгүй жирэмслэн мань эр арай гэж амрахтайгаа болжээ. Пауль охинтой, харин Фрида хүүтэй болохыг хүсч байсан учраас хүү төрсөнд хэн нь ч гайхсангүй.

Фрида эх баригч авчран гэртээ төрнө гэж өөрийнхөөрөө зүтгэжээ. Терөлт хэвийн хүндрэлгүй явагдаж, нялх үр нь хорвоод мэндлэн гарч ирэхэд эх нь түүнийг харан алмайрчээ. Бяцхан үр нь бүх талаараа ердийн хүүхдүүдтэй яг адилхан, зөвхөн. . . Хоёр улаан гуян завсар нь гайхалтай том, бараг л том хүний ичимхийн дайны хэмжээтэй бор болжмор үзэгдэв.

"Эцэгтэйгээ адилгүй юм" гэж Фрида тун ч бахархалтайгаар бодсон байна.

Бүсгүй хүүгээ мужийн захирагчдаа хүндэтгэл үзүүлэн Тоби гэдэг нэр өгчээ. Пауль Фридад хүүгээ өөрөө хүмүүжүүлнэ, жинхэнэ эр хүн болгоно гэдгээ андгайлжээ.

Фрида түүний хэлэхийг сонсон инээмсэглэсэн хэдий ч гэлээ нөхрийгөө хүүдээ алхам ойртуулсангүй. Тэр Тобигоо өөрөө гардан налиг нялцанхай зан гаргалгүй төмөр нударгаар хүмүүжүүлэв. Тоби таван нас хүрэхэд хорчийсон эцэнхий, зээрэн хөлтэй, эхийнхээсээ илүү гэрэлтсэн цэнхэр нүдтэй, бодол болсон бяцхан нүүртэй болжээ. Тоби эхдээ ухаангүй хайртай тул түүний магтаалыг хүртэх гэж бяцхан биеийнхээ чадлаар бүхнийг хийдэг байлаа. Ээж нь түүнийг тэвэрч аваад булцгар зузаан дулаахан гуян дээрээ суулган энхрийлэн цээжиндээ наагаасай хэмээн хүү ихэд хүснэ. Гэвч Фридад иймэрхүү нялуун зан гарган суух цаг зав олохгүй, хамаг хүч тэнхээгээ өрх гэрээ боломжтой бүхнээр хангахыг чармайн зүтгэнэ. Эх нь бяцхан Тобид хичнээн хайртай ч гэсэн эцэг шигээ үлбэгэр биш эр зоригтой, хүчтэй болгон өсгөх гэж бат хатуу шийджээ. Тоби сургуульд ормогц түүнээс илүү гарах хүн байх ёсгүй гэсэн шаардлага тавин, хүүгийн хичээл номыг зааж давтуулна.

-За залуу минь, гар хумхиж суухгүй ээ, ханцуй шамлан ажилдаа ор гэнэ.

Эхийгээ хатуу чанд байх тусам Тоби ээжийгээ улам хайрлан

түүнийг уурлуулах вий гэхээс ихэд эмээнэ. Фридагийн

магтаалд хайрлах сэтгэл цухалздаг хэдий ч шийтгэлээс тойрч

гарна гэдэг гонжийн жоо, харин хатуу чанд арга хэмжээ нь

зөвхөн Тобигийн өөрийнх нь тусын тулд гэдгийг сайн мэднэ. Хүүгээ анх тэвэрсэн тэр мөчид л Фрида хүү нь хэзээ, хаана дэлхий даяар дуурсагдах агуу хүн болохыг нь мэдэхгүй байсан ч гэлээ Бурхан тэнгэр энэ тухай өөрөө түүнд шивнэжээ.

Хүүгийн амьдралын хамгийн аз жаргалтай мөч нь том гал зуухны өрөөнд хичээл хийн суух байжээ. Эх нь хуучин том зуухны дэргэд зогсон гайхалтай сайхан үнэртэх зайдас хөвсөн зутан шөл, төмстэй пирожки хайрах эсвэл гурил эсгэн алим, чавганы амтат боов хийж зогсоно. Тоби ээж рүүгээ гүйн хүрч бүдүүн бэлхүүсэнд нь нүүрээ наан тас тэвэрдэг байлаа. Ээжийнх нь өвөрмөц үнэр, гал тогооны үнэртэй холилдон ханхалахад хүүд туйлын сайхан санагдах ажээ. Үхэн үхтлээ ээжийнх нь залуу дүр төрх, алимтай жигнэмэгний үнэр түүний ой

ухаанд мөнхөд шингээстэй үлдэнэ.

Тобиг арван хоёр настай байхад нь нутгийн ховч эм, гүйлгэнэсэн хар нүдтэй, хорчгор шулам хатагтай Деркин тэднийд ирж эцэж цуцахаа мэдэхгүй дэмий чалчиж гарав.

Хатагтай Деркинийг явсны дараа Тоби түүнийг дуурайн элэглэн шоолоход Фрида элгээ хөштөл хөхөрчээ. Тоби эх нь ингэж инээж хөгжиж байхыг анх удаа харж, тэр цагаас хойш ээжийгээ баясгахын тулд худалдан авагчид, багш, ангийн нөхдөө элэглэн дууриахад ээж нь чангаар хөхөрнө. Эцсийн эцэст тэрээр түүнд сайшаалгах аргаа олжээ!

Чингэтэл сургууль дээр нь жүжиг тавих болж Тоби хүүд аз дайран гол дүрийг өгчээ. Тоглолтын үдэш эх нь хамгийн урд эгнээнд суугаад бусдаас илүү чангаар алга ташиж байв. Энэ үед Фрида, Бурхан тэнгэрийн лүндэн заавал биелэх юм гэдгийг ойлгов.

Амеркмйн эдийн засгийн уналтын эхэн үе гучаад оны хүнд бэрх цаг эхлэв. Кинотеатрын эзэд хоосон суудлаа дүүргэх гэж урамшуулал, бинго, азтай үзэгч шалгаруулах, төгөлдөр хуурчдыг хөлслөх, жүжигчин болох хүсэлтэй хүмүүсийн шалгалуулах гэж зүсэн зүйлийг амлацгааж байв. Фрида аль кинотеатрт ээлжит сонгон шалгаруулалт болохыг хүлээн кинотеатруудын хуваарыг сайтар нягтлан үзнэ. Тэгээд Тобиг тийш нь явуулан, хүүгээ цаг үеийг хошигнон элэглэхийг нь үзэн үзэгдчийн дунд сууна.

Хүү нь үргэлж тэргүүн шагнал хүртэнэ.

Жаал хүү өсөж торнисон ч урьдын адил гэмгүй тод цэнхэр нүд гялалзуулсан бяцхан нүүртэй хэвээрээ байв. Хүмүүс Тобиг хармагцаа тайтгаруулан амьдралын дарамт зовлонгоос хамгаалах гэсэн мэт халуун дотноор чанга тэвэрдэг байжээ. Тэд хүүд хайртай, хүүгийн тоглолтыг үзээд халуунаар талархан алга ташихад Тоби бүх юм ээжийнх нь хэлснээр болж, тэрээр ээжийнхээ төлөө, Бурхны төлөө алдарт хүрч од болно гэдгээ ойлгожээ.

Тоби анх удаа бүсгүй хүн хүсэх сэтгэл нь арван таван настайд нь төржээ. Тэр ганцаараа угаалгын өрөөндөө байхдаа гар хангалга хийсэн нь түүнд хангалтгүй санагдаж Тоби эр хүн болохоор шийджээ.

Нэгэн үдэш Тобигийн ангийн хүүхдийн эгч, нөхөрт гарсан бүсгүй Клара Коннорс түүнээс гэртээ хүргэж өгөхийг гуйлаа. Сайхан том хөхтэй, цайвар үст бүсгүйтэй зэрэгцэн суусан залуу эрийн тэсгэлгүй их хүсэл оргилон, тээнэгэлзсээр түүний өвдөг дээр гараа тавив. Эсэргүүцэлтэй тулгараагүй залуу эр зориг орон, хэрэв бүсгүй хашгирч эхэлбэл гараа угз татан авахад бэлхэн шиг банзал доогуур нь гараа шургуулчихав. Кларагийн уур хилэн нь буцлахаас илүүтэй залуугийн зан байдал зугаатай санагдаж байснаа Тоби өмдний товчоо тайлахад нь ичимхий эрхтэнийг нь харан түүнийг шууд гэртээ аваачжээ. Маргааш өдөр нь ч Тоби загас наадуулан баясаж, бие биеэ эзэмдэн бахдав.

Энэ нь Тобигийн амьдрал дахь мартаж боломгүй адал явдал болжээ Тэрээр савандсан алганы оронд тэсэж ядан оволзох хөлсөнд чийг даах гоолиг бие, чацвалзан чинэрэх ЭРХТЭНГ НЬ шингээн шимэх бүлээхэн нарийн эдийг мэдэрчээ. Кларагийн ёолон дуу тавих нь түүний ичимхийг улам улам чинэрүүлэн хатууруулж тэр л амтлаг сайхан бяцхан үүрнээс гарах тун

дургүй тийм хэмжээнд хүргэжээ. Өөрийн ичимхийн хэмжээ цаг үргэлж Тобид нууцхан ичгүүр төрүүлдэг байсан бол өдгөө эсрэгээр эргэн түүний эр биеийнх нь эрхэм бахархал болов. Клара амаа хамхиж явж чадаагүйгээс Тоби даруй өөрийн хүчийг үл хайрлан хөрш бүсгүйчүүлд үйлчлэх болжээ.

Сүүлийн хоёр жилд тэрээр ангийн охидын бараг талынх нь аргыг олон охин биенээс нь хагацааж чадсан байна. Түүний үе тэнгийнхэн хөл бөмбөг сайн тоглож, мөнгө ихтэй эсвэл сайхан царай зүстэй байсан ч тэд ялагдал хүлээж, харин Тоби улам бүр ялан дийлсээр байлаа. Охид урьд өмнө түүнээс илүү хөгжилтэй зугаатай, ухаалгыг үзээгүй тул уруу татах туршлагатай лантай, цэнхэр нүдэт хонгор залуугийн өмнө тэсвэрлэж үл чадна.

Тоби хэдийнэ арван найман насанд хүрч сургуулийн он жилүүд дуусах тийшээ хандаж байтал нэгэн сайхан өдөр сургуулийн захирал түүнийг дуудуулжээ. Захирлын өрөөнд Тобигийн ээж аадар борооны үүл мэт уйтгартай, баргар царайтай, католик гэр бүлээс гаралтай арван зургаан настай Эйлин Хенеген охин мэгшин уйлж, түүний эцэг цагдаагийн дэслэгч, дүрэмт хувцастай бүдүүн эр гурав байв. Тоби хэцүүхэн аянга буух нь гэдгийг даруй ойлгожээ.

-Тоби, ажил хэрэгтээ шууд орьё гэж захирал хэлээд,

-Эйлин жирэмсэн гэнэ, хүүхдийнх нь эцгийг чамайг гэж байна. Энэ үнэн үү? гэлээ.

Гэнэт Тобигийн ам нь хатан хуурайшиж гагцхүү Эйлиний булбарай бие түүний дор гүрвэлзэн хөдөлж, аль байдгаараа чармайн тонгичин, жаргалтай гэгч ёолж байсныг нь санах.

-Дахиад, Тоби, дахиад лавхан шиг хий, хүчтэй. . . хэмээн бүсгүй түүнээс гуйж байжээ.

Гэтэл одоо байж байгааг нь хараач гэм.

-Алив хурдан хариул, гөлчгий минь! Чи миний охинтой хавиралдаж зүрхэлнэ гэнэ ээ?! гэж Эйлиний эцэг бархирчээ.

Тоби эхийгээ хулгай нүдээр сэм харлаа. Ээж нь энд сууж түүний ичгүүргүй үйлийг нь мэдсэн нь залуу хүүг юу юунаас илүү зовоожээ. Тэр нэрээ бузарлан, өөрийн явдлаараа эхийгээ цааш түлхсэн.

Залуу хэрэв Бурхан тэнгэр түүнийг ивээн энэ удаад түүнд туслан эвтэйхэн мултарч чадвал энэ яваа насандаа дахин нэг ч охид хүүхнүүдтэй зууралдахгүй хэмээн шийджээ. Даруй эмч дээр очиж хэзээ ч эр эмийн явдлыг бодохгүй болтол нь хөнгөлөөд өгөөч гэж гуйхсан...

-Тоби! Чи энэ охинтой унтсан юм уу? хэмээн эх нь асуув.

Тоби шүлсээ гудхийтэл залгиад цээж дүүрэн амьсгаа аван,

-Тийм ээ, ээж ээ гэж арай ядан хэллээ.

-Тэгвэл чи түүнтэй гэрлэх л болж дээ гэж Фрида уйлсандаа хамар нь хавдсан, цурхиран уйлах охиныг харан үл зөвшөөрөн татгалзсан аястай өгүүлэв.

-Чи ингэхийг хүсч байна уу?

-Т-тийм хэмээн Эйлин баяртайгаар дуу алдаад,

-Би түүнд хайртай. Өө Тоби, тэд намайг бүгдийг яриулж дөнгөсөн. Би чамайг хэлэхийг хүсээгүй юм гэлээ.

Эйлиний эцэг цагдаа эр чухам хэнд хандаж байгаа нь үл мэдэгдэн,

-Миний охин дөнгөж арван зургаан настай! Энэ чинь насанд хүрээгүйчүүдийг хүчиндсэн гэсэн зүйл ангид багтах гэмт хэрэг. Тэр өрөвдөлтэй амьдралынхаа сүүлийн мөчийг хүртэл шоронд өнгөрөөж болох юм. Гэвч хурим найрын тухай ярьж байгаа бол...

Тэнд байгсад бүгд тушаал авсан мэт нэгэн зэрэг Тоби руу харлаа. Тэрээр дахин шүлсээ гүдхийтэл залгилан,

-Тийм ээ, эрхэм ээ! Би. . . Ийм юм болсонд, өршөөгөөрэй гэж арай ядан дуугарав.

Гэр хүрэх бүхэл замын турш тэд огт дуугарсангүй. Тоби шалдаа бууж яревдөлтэй амьтан ээжтэйгээ зэрэгцэн суужээ. Түүнийг ямархуу зовлонд унагаснаа ухамсарлана. Юуны түрүүн түүнд гэр бүлээ тэжээх ажил хайн, эцгийнхээ махны мухлагт туслах болж дээ. Би өөрөө аягатай цай руугаа шороо цацчихлаа шүү дээ, ирээдүйн бүх л төлөвлөгөө минь, бүх хүсэл мөрөөдөл минь баяртай!

Тэд гэртээ ирмэгц Фрида,

-Дээш гарья! гэж товчхон тушаалаа.

Тоби эхийнхээ араас даган өрөө рүү болох гэж буй таагүй явдалд бэлтгэн бор зүрх нь пол пол хийж, богино хавирга нь шир ширхийн явав. Өрөөнд ороод эх нь таг дуугүй чемодан гарган, түүний хувцаснуудыг хийж эхлэв. Тоби бүр гайхширч, ихэд эргэлзсэн байдалтай эхийгээ ширтэн,

-Ээж ээ, та юу хийж байна аа? гэв.

-Би юу? Юу ч хийгээгүй. Чи аль болох хурдан явах хэрэгтэй гээд сэтгэл нь шулуудан хүүгийнхээ нүд рүү ширтэж,

-Би чамайг ялихгүй юмнаас болж өөрийн амьдралаараа тоглохыг зөвшөөрнө гэж бодож байна уу?! Чи тэр охинтой унтчихаж, тэгээд хүүхэдтэй болох гэнэ, үүнээс болж үү дээ? Энэ чинь чамайг эр хүн, харин түүнийг мунхаг эм гэдгийн л баталгаа! Үгүй шүү, миний хүү хэний ч сохроор хуримлах урхинд татагдахгүй. Бурхан чамд гялалзсан авьяас заясан, Тоби! Чи Нью-Йорк руу яв, алдартай болмогцоо намайг дууд гэлээ.

Тоби нулимс гүйлгэсэн нүдээ цавчилан, эх рүүгээ харайн очвол ээж нь толгойг нь энгэртээ наан чанга тэвэрч, бяцхан хүүхэд шиг бүүвэйлэв. Эхийгээ орхин явна гэдэг Тобид гэнэт энэ том дэлхийд төөрч, ганцаардсан мэт болох шиг санагдав. Гэвч санаанд нь нэгэн сонин

сэтгэгдэл төрж, шинэ үл мэдэгдэх амьдралын баясгалант дөл бадарчээ! Тэр Шоу-бизнес
ажиллана! Тэр агуу хошин урлагийн алдарт од болно! Ээж нь ингэж хэлсэн биш үү, тэр хэзээ
ч эндүүрдэггүй!

Бүлэг 2.

Хямралын жилүүд дуусч, ерөнхийлөгч Франклин Рузвельт энэ үеэс эхлэн хүмүүс юунаас ч айх аюулгүй боллоо, Америк дэлхийн хамгийн цэцэглэн хөгжиж буй орон болно гэж зарлан тунхагласан нь тэр ёсоор болж, хүн бүр мөнгөтэй болж, бүгд хуруу хумсаа мэрэлгүй зарж үрнэ. Бродвей дахь театрт нэгэн зэрэг гучин шоу тоглон, сул суудал огт олдохгүй боллоо.

Тоби зам зуур хэрэглэ гэж ээжийнхээ өгсөн зуун долларыг өвөртлөн Нью-Йоркод иржээ. Тэр алдарт хүрч баяжин, ээжийгээ дуудан, тансаг байранд хамтдаа амьдарч, эх нь орой бүр театрт очин эхний эгнээнд сууж, үзэгчид хүүд нь хэрхэн алга ташихыг ажиг болно. Гэвч одоо ажил олох хэрэгтэй байв.

Тоби Бродвейн бүхий л театруудаар орж, сонирхогчдын уралдаанд шагнал авснаа, авьяастайгаа тоочин захирлуудын ятгасан ч амжилтанд хүрсэнгүй. Тэд бүгд татгалзжээ.

Төвхнөх гэсэн оролдлого нь бүтэлгүйсээр Тоби шөнийн клуб, эстрэд тоглодог ресторанд сэм орон хошин урлагын шилдэг тоглолтыг шуналтайгаар үзэж байв.

Мөнгө нь дуусч, сав угаагчийн ажил хийх болов. Тоби өрөөнийхөө үнийг төлөх гэж хагас сайн бүрийн еглөө ээж рүүгээ утасдаг байв. Нэг удаа Фрида Тобид түүний зугтсан нь хэрхэн сандралд оруулж байгааг ярьж өглөө.

-Чи тэднийг харсан ч болоосой Цагдаа эр орой бүр эргүүлийн машинаараа залран ирж, биднийг гангстер аятай аашилна гээч Тэгээд цаг үргэлж чамайг хаашаа явсныг асууж шалгаана.

-Та тэгээд юу гэж хэлэв? гэж Тоби сэтгэл зовон асуухад нь,

-Үнэнийг. Чи шөнө, яг л хулгайч аятай хотоос оргож зайлсан, хэрэв би хэзээ нэг цагт чамайг олдог л юм бол өөрийн гараараа боомилж ална гэсэн гэжээ.

Тоби чангаар инээд алдан хөхөрчээ.

Зун нь Тоби товч мэт гөлийсөн нүдтэй бүдүүн, мулгуу хууран мэхлэгч нэгэн илбэчний туслахын ажил олж дөнгөжээ. Тэрээр Агуу Мерлин гэсэн нууц нэрээр тоглодог аж. Тэд хоёр дугаар зэрэглэлийн буудлуудаар яван ажиллаж, Тобигийн гол үүрэг нь фургонд Мерлины зарлалын хүнд самбарыг ачиж буулгах, тоглолтын үед илбэчин бортогоноос гаргаж ирдэг зургаан цагаан туулай, гурван канар бялзуухай, хос үхэр хулганыг тэжээнэ. Мерлин ан амьтад даа ихэд санаа зовдог тул Тоби

ханын шүүгээнээс томгүй өрөөнд тэднийг асрамжлахаар хамт амьдарч, залуу эрд ой гутам муухай үнэрт нэвт шингэсэн мэт санагдана.

Тэрээр давхар ёроолтой нууц тасалгаатай хайрцагнуудыг зөөж, ийш тийш гүйлдэх ан амьтдын араас хөөцөлдсөөр туйлдаа хүртэл ядарснаа цаг үргэлж мэдрэнэ. Тоби хэдэн цагаар ягтаа тулсан ядуу уйтгартай тасалгаанд суун шоу-бизнесийн замд хэрхэн хөл тавихаа тархиа

гашилтал бодон, толины өмнө элэглэх дасгал сургууль хийж байхад өмхий үнэртэй амьтад түүний цорын ганц үзэгдчид нь болж байлаа.

Зуны сүүлчээр Тоби урьдын адил гэр рүүгээ ярьвал энэ удаа эцэг нь утсаа авчээ.

-Тоби байна аа, аав аа. Яаж шуухан амьдарч байна вэ?

Хариуд нь дув дуугүй болов.

-Байна уу? Сонсож байна уу?

-Сонсож байна, Тоби гэх аавынх нь дуу Тобигийн хамаг биеийг жихүүцүүлэв.

-Ээж яасан бэ?

-Өчигдөр эмнэлэгт хэвтүүлсэн.

Тоби харилцуурыг тас атгахад хэврэг хуванцар эвдрэх нь үү гэлтэй шажигнав.

-Тэр яагаа вэ?

-Эмч зүрхний дайрлага гэсэн.

Үгүй! Зөвхөн ээж л биш үү!

-Эдгэрнэ гэнэ үү? хэмээн аймшигтай тулалдахаас буцахгүй улайран байгаа юм шиг хашгиран,

-Эдгэх үү? гэж асуув.

Тэрээр хэрхэн хашгирч байгаагаа өөрөө ч анзаарсангүй.

-Бүх юм сайхан болно гэж ээжид хэлээрэй!

Алс хол, сая милийн тэртээгээс эцгийнх нь уйлах дуу сонсон,

-Тэр... тэр хэдэн цагийн өмнө өнгөрсөн гэх нь тэр.

Эцгийнх нь хэлсэн үгс зангидсан нударгаар нүүрэн дундуур нь татаад авч, улайдсан халуун лавын урсгал Тобиг сорон өөртөө уусган үгүй хийх мэт болсон ч гэлээ хамаг бие нь галд автан халуу шатахыг хараахан мэдээгүй байв. Эцэг нь худал хэлж байна! Тэр үхэж болохгүй, болохгүй! Тэд тохирсон биш үү! Тоби од болж, ээж нь үргэлж хажууд нь байж, түүнийг тансаг орд харш, жолоочтой лимузин, ангийн үсэн дээл, бриллант хүлээж. ..

Тоби цурхиран уйлсандаа багтарч, амьсгаа ч авч чадахгүй зүүдэлж байгаа мэт болоход тэртээ алсаас,

-Тоби! Тоби! гэх дуулдав.

-Би харилаа. Оршуулга хэзээ вэ?

-Маргааш. Чи наашаа ирж болохгүй. Тэд чамайг хүлээж байгаа. Эйлин хэзээ мөдгүй төрөх гэж байгаа, харин эцэг нь чамайг ална гэж тангараг тавьчихсан. Энд үзэгдэх л юм бол бүгд өнгөрлөө гэсэн үг.

Тэгэхээр мань хүн хорвоо дээр хайрлаж байсан цорын ганц хүнтэйгээ ч салах ёс хийх эрхгүй болох нь ээ.

Тоби бүхэл өдөржингөө орондоо хэвтэн эхийгээ дурсав. Ээжийн дүр төрх яг л амьд байгаа юм шиг гал зууханд хоол унд бэлтгэн, хүүтэйгээ ямар сайхан ирээдүй түүнийг хүлээж байгааг, театр, хамгийн урд эгнээ, баярын нулимстай нүдтэй алга ташихаа ярилцан. . . Түүний хошигнох, элэглэн дууриахыг сонсон элгээ хөштөл инээж. . . Түүний хувцас хунарыг чемоданд савлах зуур, "Агуу хүн болмогц, намайг дуудаарай..."

Тоби уй гашуудаа автан бэгтэрч огт хөдлөхгүй хэвтсээр. Тархинд нь "Амьд байсан цагтаа энэ өдрийг хэзээ ч мартажгүй. 1939 оны 8 сарын 14. Миний амьдрал дахь хамгийн чухал өдөр" гэсэн бодол тасралтгүй эргэлдсээр байв.

Эхийнх нь үхэлтэй холбоотой биш, харин энэ мөчид Техас мужийн Одесс хотод болж байгаа мэдээллээс үүдэн энэ өдөр түүний цаашдын хувь заяанд ихэд нөлөөлжээ.

Гоц гойд юмгүй юмгүй, тусламжийн өнгө гэвэл илүү зохилтой өнгө бүхий эмнэлгийн гунигтай байранд нам гүм ноёрхоно. Дотор талд нь эмч нар хамаг хүчээрээ золгүй хүмүүсийн зовлонг нимгэлэх гэж оролддог жижигхэн тасгуудад хуваагджээ.

Чимээгүй үхэл гэгчийн үе өглөөний дөрвөн цаг болж байв. Энэ үе бол өдөр бүр эцэж цуцахгүй тэмцлийн өмнөх ажилчдын амралтын цаг юм.

Хагалгааны дөрвөн номерын өрөөнд эх барих бригадынхан шургуу хөдөлмөрлөнө. Ердийн төрөлт шиг эхэлснээ энэ мөчийг хүртэл бүгд хэвийн сайхан явснаа гэнэт бүгдийг сандаргаж эхлэв. Хатагтай Цински эв эрүүл, эх баригчдын мөрөөдөл болдог тариачин авхайн өргөн таазтай, залуу бүсгүй ямар ч хүндрэлгүйхэн байлаа. Базлалт хоорондын зай улам бүр ойртсоор. Тэр бүү хэл Уилсон эмч хүүхэд хөлөөрөө гарах нь гэж хэлэх үед хэн ч сандарсангүй. Иймэрхүү төрөлт нэг бол ердийн төрөлтийн адил явагдаж, эмчийн тусламж шаардахгүй, эсхүл эмч нар оролцох явдал гардаг ажээ.

Хүүхэд саван дотроо үхэж шаантаглах нь хамгийн хэцүү үе.

Уилсон эмч төрөлт давгүй явагдаж байна гэж сэтгэл хангалуун хэллээ. Удалгүй шинэ хүний тавхай, дараа нь бяцхан хоёр хөл цухуйж эхлэв. Дахин базлаж хүүхдийн бөгсөн бие га0рч ирлээ.

-За харж байна уу, одоохон хөнгөрөх нь гэж Уилсон эмч урамшуулаад,

-Хүчтэйхэн дүлээд өг! гэв.

Эх нь эмчийн хэлснийг сонссон хэдий ч дүлж чадсангүй.

-Алив, хамаг хүчээрээ ганц сайн оролдоодох гэж эмч хөмсөг зангидан хэлээд хүүхдийн хөлнөөс аяархан татвал өчүүхэн ч хөдөлсөнгүй.

Уилсон хавчигхан гарц руу гараа шургуулан ургийг болгоомжтойхон шинжив. Духан дээгүүр нь хелс бурзайн ирэхэд сувилагч бүсгүй арчууранд гүйж одлоо.

-Бага шиг хүндрэл гарах нь гэж эмчийн аяархан хэлэхэд хатагтай Цински СОНСЧИХООД,

-Юу болов оо? хэмээн сандрав.

-Зүгээр! Зүгээр! Уилсон эмч толгойг хүртэл гараа шургуулаад хүүхдийг болгоомжтой түлхэхийг оролдвол хүүхэд илт хавчигджээ. Хуруугаараа хүйг тэмтэрвэл хүүхдийн бие, эхийн умайн булчин хоёрын дунд хавчигдан шинэ хүнд агаар очихгүй болсон байв.

-Фибропотоскоп гэж эмчийн шаардахад эх баригч эхийн гэдсэн дээр багажаа тавин хүүхдийг зүрхний цохилтыг сонсохыг оролдоно.

-Минутанд ойролцоогоор гуч гэж тэр бөвгөнөв.

Уилсон эмчийн хуруу тэр чигээрээ эхийн хэвлий рүү далд орон тэмтчин судалсгар.. .

-Судасны цохилт буурч байна! Зүрх нь цохилохгүй байна! гэж эх баригч эмэгтэй дуугарав.

Хүүхэд бүтэж үхжээ. Яаж хугацаа хожин тэмцээд түүний амийг аврах боломж байсангүй. Хүүхдийг гарган авч тархины гэмтлийг эс тооцон зүрхийг нь цохиулахын тулд хиймэл амьсгаа хийнэ гэхэд ердөө л дөрвөн минутын хугацаа үлджээ.

-Цагаа тэмдэглэ! гэж Уилсон эмч тушаав.

Тасалгаанд байсан бүгд зөнгөөрөө өөрийн эрхгүй цаг руу харцгаахад минутын том зүү 12 дээр зогссосхийснээ тэднийг сандаргах гэсэн мэт дахин тойргоор яаравчлан гүйж эхлэв.

Эх барих бригадынхан ажилдаа улайрцгаажээ. Хагалгааны өрөөнд дахин нэг хүчил төрөгчийн төхөөрөмж оруулж ирж байхад Уилсон эмч хүүхдийг аарцагны нь өрцнөөс татаж авахаар оролдож байв. Тэрээр Брехгийн гардан авах аргыг хийхээр шийдэн үтрээний гарц амсрыг цэвэрлэн, хүүхдийн мөрийг эргүүлэх гэж оролдов. Юу ч тус болсонгүй. Анх удаа төрөлтөнд орж байсан дадлагын сувилагчийн дотор гэнэт муухайран тасалгаанаас гарч гүйв.

Карл Цински хагалгааны өрөөний үүдэнд эвэршсэн том гараараа малгайгаа тасар татах нь холгүй базлан, нааш цааш байж ядан холхино. Өнөөдөр түүний амьдралын хамгийн жаргалтай мөч байв. Карл модчин, аз жаргал бол гэр бүл өнөр өтгөн байх ёстой гэж үздэг нэгэн ажээ. Карл энэ хананы цаана түүний анхны хүүхэд төрж байна гэж бодохоос сэтгэл хөдлөлөө нууж чадахгүй байлаа. Тэрээр эхнэртээ тун их хайртай бөгөөд түүнгүйгээр амьдарч чадахгүй гэдгээ мэдэх бөлгөө.

Хагалгааны өрөөнөөс гүйн гарч ирэх сувилагчийг харангуут

Карл түүнийг амдан гүйж очоод,

-Эхнэр маань яаж байна? гэв.

Аймшигт агшиныг мартаж чадахгүй ухаан алдах шахсан бүсгүй биеэ барьж чадалгүй,

-Тэр үхчихлээ! Үхчихлээ! гэж хашгирчихаад цааш эргэн огиудас хүрэхэд нь бөөлжисөө барьж ядан гудмаар цааш гүйлээ.

Ноён Цинскийн царай цонхийн цайж, амьсгаа нь давчдан багтарч үхэх шахахдаа хоёр гараараа цээжээ тэмтчин шалан дээр сөхрөн уналаа. Энэ үед хагалгааны өрөөнд шинэ хүний амийг аврах гэж гар хумхилгүй ажиллаж байсан тулд түүнд хэн ч тус болж чадсангүй өнгөрчээ.

Төрөх тасагт Уилсон эмч урагшлан гүйх цагийн зүүтэй тэрсэлдэн уралдаж, найдвар муутайхан тулалдсаар. Тэрээр хүйнд хүрсэн хэдий ч ургыг гаргаж авах ямар ч боломж байсангүй. Дотор хүн нь түүнийг гуйж, хүч хэрэглэн хүүхдийг татаж авахыг тушааж байсан ч гэлээ, иймэрхүү маягаар хорвоод мэндэлсэн хүүхдүүд ямар тавилантай учирдагийг эмч олонтоо үзсэнсэн.

Хатагтай Цински өвдсөндөө болон ухаан алдах шахан чангаар ёолно.

-Дүлээрэй, хатагтай Цински! Хүчтэй! Дахиад!

Бүх юм талаар өнгөрчээ. Уилсон эмч цаг руу хяламхийн харав. Хайран хоёр минут алджээ, хүүхдийн тархинд цус хүрэхгүй болжээ. Эх баригчийн өмнө хэрэв хүүхдийг дөрвөн минутаас хэтрүүлэн аварч чадвал юу хийх вэ? гэсэн бас нэгэн асуудал гарч ирлээ. Мэдсээр байж үүрдийн оюун ухааны хомсдолтойгоор амьдраг гээд орхих уу? Эсвэл түүнд өвтгөхгүй, нигүүлсэнгүй үхлийг бэлэглэх үү?

Түгшүүрт бодлоо таягдан хаяад Уилсон эмч яаравчлан ажиллаа. Тэрээр нүдээ анин бүсгүйн биед юу болж байгааг мэдрэхээр тэмтчин анхаарлаа төвлөрүүлээ.

Эх баригч Морисо-Смел-Вейтын эх барих даралтыг сулруулан, хүүхдийг гаргаж авах цогц хүнд хөдөлгөөн хийдэг аргыг хийхээр оролдож эхлэв. Тэгээд гэнэт алганд нь ямар нэг юм хөдлөхийг мэдэрч,

-Хавчуур, хурдан гэж зандрав.

Эх баригч багажийг өгмөгч Уилсон эмч хавчуурыг аван хүүхдийг толгойг хавчин авлаа. Хормын төдийд бүх юм дуусан хүүхэд хорвоод мэндлэв.

Эхийнхээ харанхуй, тохь тухтай дулаахан хэвлийгээс гарч ирэн энэрэлгүй хүйтэн ертөнцийн гэрэлд нүд нь гялбан байх улаан нялзрай бяцхан шинэ шинэ хүнийг гайхамшигтайгаар гардан эх барьж авна гэдэг эх баригчдийн хувьд үргэлжийн ялгуусан баяр бахдал байдагсан.

Гэвч энэ хүүхэд цэлдэн хөхөрчихсөн, хөдөлгөөнгүй, хорвоод мэндэлснээ мэдэгдэн уйлж ч

чадахгүй таг дуугүй охин байлаа.

Цаг! Ердөө хагас минутын зай үлдэж!

Олон жилийн туршлагатай эх баригчдын хурдан, гавшгай гэж жигтэйхэн. Эмч хуруугаа марлиар ороож агаар оруулах замыг нээн хүүхдийн амьсгалын замыг салснаас нь цэвэрлэв. Эх баригч түүнд цахилгаан сорогчид холбосон төвөнх харагч багаж өглөө. Эмч багажаа хийгээд толгой дохивол эх баригч товчийг дарахад хол хол хийн сорох дуу сонсдогдов.

Уилсон цаг харвал хориод секунд үлджээ. Судасны цохилт байдаггүй.

15... 14. . . Зүрх цохилсонгүй.

Шийдвэр гаргах мөч ирлээ. Дэндүү оройтож, тархины хүнд гэмтэл авсан байж болох юм. Гэвч хэн ч үүнд итгэсэнгүй. Уилсон эмч өрөөг тойруулан харвал гурван настай балчир хүүхдийн ухаан нуугдсан том улсын өрөвделтэй төрх үзэгдэн, байдал үүнээс ч дор байлаа.

10 секунд амьдрана гэсэн өчүүхэн итгэл байсангүй. Эмч Бурхан түүнийг ойлгон, өршөөгөөрэй хэмээн залбирсаар.

Тэр аппаратыг унтрааж хүүхдийг аварч чадахгүйгээ хэлнэ. Хэн ч түүнийг хууль бус үйлдэл хийлээ гэж буруутгахгүй,

Эмч дахиад хүүхдийн биед хүрвэл нойтон, хүйтэн хэвээр байв.

3 сек.

1 сек. Зүрхний булчингийн агшилтгүй.

Боллоо.

Эмч унтраах товч руу гараа явуултал хүүхдийн бяцхан зүрх туниа муутай гэгч нь хариугүй жирсхийснээ, дахиад, бас дахин чичирнэлээ. Зүрхний цохилт олшрон хүчтэй, хэмнэлттэй болов. Өрөөнд байсан эмч нар баярлан дуу алдаж бие биедээ ялан дийлсний баяр хүргэж байхад Уилсон эмч тэднийг сонссонгүй гагцхүү ханын том цаг руу ширтсэн хэвээр зогсоно.

Эх нь Краковт амьдардаг эмээг нь хүндэтгэн Жозефина гэж нэрлэжээ.

Уилсон эмч хатагтай Цинскид Жозефина охиныг зургаан долоо хоног тутамд эмнэлгийн үзлэгт авчирч байхыг анхааруулжээ.

Эмчийн үзлэг бүр хүүхэд ердийн өсөлт бойжилттой байна гэж дүгнэж байлаа.

Гагцхүү цаг хугацаа бүгдийг харуулна.

Бүлэг 3.

Зуны улирлын ажил нь Катскилл ууланд дуусан Агуу Мерлин, Тоби хоёр хамтдаа ажилгүй болцгоов. Тэрээр эрх чөлөөтэй болон одоо дөрвөн зүг найман зовхис тийш хаа дуртай газар руугаа явж чадна. Гэвч хаашаа явах вэ? Тэр орон гэргүй, гэр бүлгүй, халаас хоосон үлджээ. Нэгэн зочид буудалд амьдрагч бүсгүй түүнийг гурван хүүхдийн хамт Чикаго хүргэж өгвөл Тобид хорин таван доллар өгөхөөр амлажээ. Тоби Агуу Мерлин түүний өмхий самхай ханхлуулсан амьтадтай салах ёс ч хийлгүй яваад өгчээ. 1939 онд Чикаго хурдан хөгжин дэгжиж буй хот болон эмэгтэйчүүдээс эхлээд улс төрчид тэр бүү хэл хар тамхичид хаанаас юу худалдаж авч болохоо бүгд сайн мэднэ. Гудамж бүрд завхай зайдангаараа хэний ч сэтгэлийг татаж чаддаг шөнийн клубын хаяг гэрэлтэнэ. Тоби олон бужигнасан "Парижид" хэмээх газраас эхлэн Раш-стрит дэхь хамгийн жижиг баар

хүртэл газар сайгүй хэсүүчлээд, эцэст нь эд бүгдээс ганцхан хариу сонсчээ. Өөрийгөө хошин жүжигчин хэмээн нэрлэсэн тэнүүлчин залуу хэнд ч хэрэггүй байлаа. Элсэн цагт тун бага элс үлдэж, эхийнхээ хүслийг биелүүлэх цаг хэдийнэ болжээ.

Тоби арван есөн нас хүрэх дөхөж байв. Түүний үргэлж орж гардаг клубын нэг "Ни хай"-д уйтгартай гурвал хөгжимчид, энд тэндгүй хөөгдөж явдаг согтуу хошин шогч, "Эгч дүү Перри" гэдэг нууц нэрээр тайчих урлаг үзүүлэгч Мэри, Жери хоёр зочдыг зугаацуулдаг ажээ. Хачирхалтай нь дажгүй үзэсгэлэнтэй хориод настай тэд төрсөн эгч дүүс байсан агаад тэднийг хэвлэлээр нэг хямдхан бузар булай амьтад гэж тараасан удаатай. Оройхон хэрд Жери бааранд орж ирээд Тобигийн дэргэдэх ширээнд суулаа. Залуу эр инээмсэглэн эелдэгээр,

-Таны тоглолт надад их таалагддаг хэмээн хэллээ.

Жери толгой өндийн харвал хүүхдийнх шиг царайтай, хувцас муутай, тарчигхан амьдардаг гэнэн залуу нүдэнд нь үзэгджээ. Бүсгүй хайхрамжгүйгээр толгой дохиод нүүр буруулах гэтэл Тоби явахаар завдан босвол өмднийх нь товч юу юугүй зад тавах нь уу гэлтэй томбойсон байхыг Жери харчихав. Бүсгүй залуу эрийн гэм хоргүй цэнхэр нүдийг дахин ширтэн,

-Бурхан тэнгэр минь! Наадах чинь үнэхээр чиний эд үү? гэж асуужээ.

-Үнэмших ганц л арга байдаг биш үү?

Энэ шөнийг Тоби эгч дүү хоёртой цугтаа оронд өнгөрүүлжээ.

Бүгдийг урьдаас төлөвлөн шоу эхлэхээс хагас цагийн өмнө Жери клубын хошин жүжигчинг Дайверс авенью дахь тоглоомын газарт аваачин шунал хөдөлгөсөн тоглоомонд оруулан суулгажээ. Тоглоом ид дундаа явж байхад жүжигчин,

-Бидэнд хэдхэн минут үлдэж! Би одоохон хэмээн сэтгэл нь хөөрөн, уруулаа шилэмдэн долоож хэлэв.

Хагас цагийн дараа Жери чимээгүйхэн алга болоход хошин жүжигчин аз шовойвол ганц амжилттай хаялтаар алдар хүнд,

амжилт, эд баялгыг нэгэн зэрэг хүртэнэ гэсэн мөрөөдлийн ертөнцөд умбан ясан шоо тэчъядан хаясаар хоцорчээ.

Энэ үед Тоби "Ни Хай"-д үсээ нямбай гэгч нь засуулчихсан, цэмцийсэн сайхан залуу бэлэн болон хүлээж суув.

Оройн тоглолт эхлэхэд жүжигчнийг эзгүй байсанд клубын эзэн бачууртлаа уурсан тайзны ардуур сандчин ийш тийшээ гүйнэ.

-Энэ шааран амьтан өнгөрөө, та нар ойлгов уу?! Тэр миний клубт алхам ч ойртох ёсгүй!

-Таныг ойлгож байна гэж Мэри гүнгэнүүлэнгээ,

-Гэвч бидэнд аз тохиожээ, бааранд шинэ жүжигчин сууж байна. Дөнгөж сая Нью-Йоркоос ирсэн гэнэ гэлээ.

-Юу?! Хаана тэр вэ? !

Эзэн баар рүү харайн орлоо.

-Ээ сахиусан тэнгэр минь, түүний асрагч эх нь хаа байгаа юм бол? Энэ чинь шал нялхаараа амьтан байна!

-Тэр үнэхээр гайхамшигтай юм билээ! хэмээн Жери чин үнэнээсээ өгүүлэн түүнийг ятгалаа.

-Түүнд боломж олгооч дээ. Та юу алдах юм бэ? гэж Мэри хажуунаас нь хошуу нэмэрлэлээ.

Клубын эзэн мөрөө хавчисхийлгээд Тоби руу очин, -Тэгэхлээр та хошин жүжигчин гэв үү? гэлээ.

-Тийм ээ. Сайхан Калбан ууланд ажиллаж байлаа гэж хайш яйш хариулав.

Эзэн түүнийг дахин цоо ширтээд,

-Чи хэдтэй вэ? гэлээ.

-Хорин хоёртой гэж Тоби хэнэг ч үгүй залжээ.

Дүүрсэн хэрэг! Алив, явья. Хөгөө хөлдөө чирвэл хорин хоёр ч наслахгүй гэж мэдээрэй..

Ингээд бүх юм эхлэв. Тоби Темплийн хүсэл биелэн тэрээр тайзан дээр гэрлийн дугуй цагираган дунд зогсон, найрал хөгжим түүнд зориулан талархалын марш тоглож, үзэгчид шинэ хошин жүжигчиндээ алга ташин угтав.

Тоби хүмүүсийн наалинхай занд сэтгэл нь хөөрөн хоолой нь зангиран үзэгчидтэй үл үзэгдэх ид шидийн шижмээр холбогдсон мэт санагдав. Тэрхэн зуур эхийгээ дурсан, ээж нь өдийд хаа нэгтээгээс хүүгээ харж байгаа гэдэгт итгэлээ.

Хөгжим зогсон Тоби,

-Оройн мэнд, жаргалтайхан хүмүүс минь! Намайг Тоби Темпл гэдэг. Та бүхэн өөрийн нэрсийг сайн мэднэ гэж бодож байна! Танхимд таг чимээгүй. Тоби үргэлжлүүлэн, - Чикагогийн мафийн шинэ толгойлогчийн тухай сонссон уу? Язгууртан хүн юм билээ. Өнөөдрөөс эхлэн "Үхлийн үнсэлт" хөтөлбөрт бүжигтэй оройн зоогт орсон байна гэлээ.

Нэг ч хүн инээсэнгүй, бүгд Тобиг дайсагнасан хүйтэн харцаар харах нь залууд аймшигт хурц савраар гэдэс дотрыг нь ханзартал хуу татах мэт санагджээ. Хамаг бие нь уур манангаар хучигдан далдлагдаж үзэгчидтэй холбосон өнөөх ид шидийн шижим нь гэнэт алга болжээ.

Гэвч тэр цөхөрсөнгүй.

-Би саяхан Менд ажиллаж байлаа. Тэр театр өтгөн ойд байх агаад тэдний захирал нь баавгай гуай байсан шүү.

Бас дахиад л нам гүм. Тэр ч битгий хэл дотно бус хандлага илт мэдрэгдэх шиг болов.

-Энд гагцхүү хэлгүй дүлий улс цугласан гэж надад хэн ч сануулаагүй юмсан. Эсвэл "Титаник" дээр болж байгаа үдэшлэг юм уу? Хөлөг живэж, харин аврах завь нь алга.

Тоглолт эхлээд хоёр минут болж байтал энд тэндээс дургүйцэн исгэрч, шүгэлдэх дуу цуурайтаж клубын эзэн сандчин Тобигийн дууг нам дарахаар чанга тоглохыг хөгжимчдөөс шаардан гараа савчин дохив. Тэрээр дарвайтал инээх дүр үзүүлэх боловч нүдэнд нь нулимс цийлэгнэн ***** гадас шиг зогсоор байв.

Залуу урмыг нь хугалсан дайсагнасан уур хилэнг цалгитал орилохыг ямар их хүснэ вэ?

Хатагтай Цински шөнийн нам гүмд муу ёрлон яс янгинам чангаар орилохыг сонсон нойрноос сэрж. . . Бүсгүй орноосоо

босонгуут хүүхэд уйлсныг ухааран хүүхдийн өрөө рүү яаравчлав. Жозефинагийн царай хөхрөн, татвалзан яраглаж байв. Дадлагын эмч хүүхдэд тайвшруулах эм өгвөл охин тайвширан унтлаа. Хатагтай Цинскийн хүүхдийг эх барьсан Уилсон эмч Жозефинаг дахин сайтар үзээд ямар ч гажиг олсонгүй. Гэвч түүнд нэг л биш санагдсаар. Эмч төрөх тасгийн ханан дахь өлгөөтэй байсан цагийг яагаад ч мартаж чадахгүй байв.

Бүлэг 4.

1891 оноос 1932 онд "Палас" театрыг хаагдах хүртэл варьета хэмээх урлагийн хөнгөн төрөл америкчуудын үзэх дуртай зугаа наадам болж байлаа. Хошин жүжигчин болох хүсэлтэй хэн бүхэн баян үзэгчдийн хонзонтой дур хүсэл, ааш аягт нь тохируулах гэж өөрийн хурц ухаанаа ирлэдэг өрсөлдөөний энэ л талбарт хүч сорьцгооно. Ялсан хэн ч болов үзэгчдийн талархлыг хүлээн нэр алдрын гавьяа шагналыг хүртдэг ажээ.

Алдар цуугаа дуудуулсан олон арван хошин жүжигчид варьетагийн сургуулийг дүүргэжээ.

Төд удалгүй энэ төрөл уналтанд орсноор өөр аргаар амь зуух арга хайх болов. Олонд цуутай одод ямар ч зовлон байсангүй, тэднийг радио, концертын танхим, шөнийн клубуудад урьж байхад Тоби мэтийн нялзрай жүжигчдэд тун хэцүү байлаа. Тэд оддынхоос арай өөр зэрэглэлийн шөнийн клуб, бааруудад орцгоох ажээ.

Сахал хуузандаа баригдсан согтуу үйлчлүүлэгчид нь аяга тавгаа хангинуулан, энд тэндгүй чангаар хэхрэх сонсогдон, тайчигч бүсгүйчүүдийг хоргоож, жүжигчдийг шоолон исгэчиж, "Жорлон" хэмээн зөөлрүүлэн хэлсэн нэрээрээ алдаршсан иймэрхүү баар цэнгээний газрууд орон даяар энд тэндгүй элбэг тоХИОЛДОНО.

Умгар заваан нүүр будах өрөөний агаарт нь спирт, шээс шинхэг, завхай зайдангийн гээд есөн бусын өмхий ханхлах агаад энэ бүхний цаана гагцхүү аймшигийн гашуун үнэр ноёлох ажээ. Эндхийн шан харамж нь идэхийн эцэсгүй хоолноос эхлээд өдөрт таваас арван доллар, зарим үед үзэгчид хэрхэн хүлээж авснаас шалтгаалан хоногт арван таван доллар хүртэл янз бүр байлаа.

Тоби Темпл энэ газруудыг бүгдээр нь явсан нь түүнд ихээхэн сургууль болжээ. Зөвхөн хотуудын нэр нь өөр өөр болохоос ийм клуб, баарууд нэг л хэвийн үнэр танар, хоол унд, хөгжим, үзэгчдийн үзэн ядалт гээд бүгд л ялгахын эцэсгүй адилхан аж. Хэрэв тэдэнд жүжигчин таалагдаагүй бол түүний зүг пивоны хоосон сав мөндөр мэт бууж ирэн, хашгиралдан хөлөө дэвслэн исгэрч тоглогчийг тайзнаас хөөн буулгана.

Энэ хүнд бэрх сургалт, хэрцгий догшин ёс жудагийн даван эсэн мэнд гарсан хэн ч хатуужин, хал үзэж хашир суусан эр болдог авай. Тоби согтуу жуулчид, архи уудаггүй ганстеруудтай үг хэлээ ололцоход, хэрүүл өдөөгч, орилоо эрийг хэзээ ч эндүүрдэггүй туршлагатай нүдээр таньж, магнайд нь бурзайсан хөлсийг нь арчин ая тал засан тайвшруулах зэрэгт суралцжээ. Тэрээр Лейк-Кьямеша, Шаванга-Лож, Эйвон, Уайлвуд гэх мэтийн Бурханд хүртэл мартагдах шахсан хамгийн өрөвдөлтэй бөглүү цэнгээний газруудыг ч алгасалгүй ажиллан басхүү суралцсаар явжээ.

Түүний хувийн тоглолт нь алдартай дуучин, кино жүжигчин Гейбл, Богарт, Грант, нарыг элэглэн, авьяаслаг зохиолчдыг хөлслөн авч чаддаг алдартай хошин жүжигчдийн жүжиглэл, үг хэллзгээс хулгайлан тоглоно. Бүх л жулдрай жүжигчид ичгүүр сонжуургүйгээр бусдыг шоглон, жүжиглэлийг дуурайчихээд ичих ч үгүй шинэ залуу жүжигчдээс илүү хэмээн сагсууран цээж дэлдчин ханхалзана.

Тоби юуны ч өмнө сөхрөлгүй үзэгчдийн хайхрамжгүй, хуншгүй ааш занг нь хонгорхон царай, гэм хоргүй гэнэн цэнхэр нүдээрээ татгалзахын аргагүй болтол нь уяраадаг байв. Тэр,

-Эскимос эр морь харж байхыг харсан уу? хэмээн асуугаад өмднийхөө товчийг тайлан алгаа дэлгэн атга дүүрэн шоо мөс үзүүлдэг байв.

Заримдаа Тоби алчуур зангидан дэвсгэр даавуугаар биеэ ороож,

-Могой сургагч Абдул хэмээн зарлаж, бүрээ үлээх зуур утаснаас татахад нь резинэн наж могой мурилзан гарч ирнэ.

Иймэрхүү тоглолт хөгтэй санагддаг хүмүүс үзэгчдийн дунд бас байдаг байлаа. Пивоны хоосон шил агаарт нисэн ирэхээс урьтан сэдвээ өөрчлөх зуур үзүүлдэг иймэрхүү арга заль түүнд тун олон бий.

Тоби орон даяар автобусаар хэрэн хэсэж дараагийн хотод очин хамгийн хямд зочид буудалд муу тавилгатай өрөө хөлслөн аваад шөнийн клуб, баар, тоглоомын газраар явдаг байв. Тэрээр гутлын улныхаа цоорхойг хатуу цаас дэвсэж бөглөөд, угаалгын мөнгөө хэмнэх гэсэндээ цамцныхаа захыг шохойгоор цайлган шохойдож байлаа. Нэгэн хэвийн уйтгартай бааруудын хоол унд нь ч хоолой давахгүй, хамгийн аймшигтай нь ганцаардал түүнийг цаг үргэлж сүүдэр мэт дагах ажээ. Энэ хорвоо дээр нэг ч төрөл садан Тобид үлдсэнгүй, түүний үхсэн амьд хэнд ч падгүй мэт. Тоби хайрлгхаас илүүтэй үүргээ ухамсарлан аавдаа үргэлж захидал бичнэ. Залуу эр хужирхайгаа тэнийтэл хэн нэгэнтэй сайтар ярилцан, хүсэл мөрөөдлөө хуваалцчих, өөрийг нь ойлгох найз нөхөртэй болохсон хэмээн машид хүсч байлаа. Амжилганд хүрсэн мэргэжил нэгт хүмүүс бие хамгаалагч, туслахаа дагуулан, үзэсгэлэнтэй хүүхэн сугадчихаад нэгдүгээр зэрэглэлийн клубын хаалгаар гарч ирэн гялалзсан сайхан лимузинд суухыг хараад тэдэнд үхтлээ атаархана. Хэзээ нэгэн цагт би...

Тобиг эхэлж амжаагүй байхад эсвэл тоглолтоо хийж байхад үзэгчид шүгэлдэн тайзнаас буулгахад нь тэрээр ичиж үхэх шахдаг хамгийн гутамшигтай үе нь байлаа. Энэ мөчид Тоби Темпл үзэгчдийг үзэн ядаж тэднийг хиартал буудахсан гэж хүсдэг ажээ.

МАНЬ эр азгүй хувь заяатайгаа эвлэрэн эцсээ хүртэл тэсвэрлэж байгаа тул ажил хэрэг нь хараахан ягтаа тулчихаагүй, тэгээд ч эхний гишгүүрээсээ доош бууж хаана ч гишгэх билээ дээ.

Тэрээр ядуу дорой зочид буудлын өрөөндөө үүдээ түгжиж аваад тайзан дээр хүмүүсийг хөгжөөн зогсох гэсэн хомхой хүслээс нь салгаж түүнийг мөрөөр нь орхихыг Бурхнаас гуйн уйлна.

"Тэнгэр минь! Надад худалдагч, эсвэл махны худалдагч болохыг минь ятган сэнхрүүлээд өгөөч! Жүжигчин л биш бол юу ч хийсэн яах вэ?" хэмээн залбиран гуйдаг байв.

Эх нь эндүүрчээ. Бурхан түүнийг олны дундаас ялгасангүй. Тэрээр хэзээ ч оройд нь гарч од болон гялалзаж чадахгүй нь. Маргаашаас эхлэн өөр ажил хайж есөөс тав хүртэл ажиллан ердийн хүний амьдралаар амьдрах болно.

Гэвч маргааш орой нь Тоби өөрийг нь дайсагнахаас нь өмнө үзэгчдийг байлдан дагуулахыг хичээн бас л тайзан дээр зогсон кино оддыг элэглэн ярвагнаж хошигнож байв.

Тоби эсэргүүцэх аргагүй болтол инээмсэглээд,

-Тэжээмэл нугастай нэгэн эр амьдардаг байж гэнэ. Тэрээр нугасандаа ухаангүй хайртай тул нэгэн удаа кино үзэхдээ аваад явжээ. Гэвч тасалбар түгээгч түүнийг оруулсангүй гэнэ. Тэгэхээр мань эр нугасаа өмдөндөө хийчихээд тасалбар аван зааланд орчихжээ. Нугас сандчин тонгочиж эхлэхэд эзэн нь өмнийдөө товчийг тайлбал шувуу түүгээр толгойгоо шургуулан гаргажээ. Гэтэл түүний дэргэд нэгэн эмэгтэй нөхөртэйгээ сууж байж гэнэ. Бүсгүй нөхөртөө хандан хажууд нь суугаа эр эрхтэнээ гаргачихаад байна гэж хэлжээ. Гэтэл нөхөр нь тун тайвнаар түүнийг битгий тоо гэжээ.

Хэдэн минутын дараа өнөө бүсгүй сандран,

-Ральф... түүний эрхтэн хэмээн шулганав.

-Би чамайг битгий тоо гэж хэлээ биз гэж цухалдан шивнэв.

-Чадахгүй нь ээ, тэр. . . тэр миний эрдэнэ шишийг идээд байна гэж гайхаж цочирдсон бүсгүй гиншигнэв.

Гэх мэтийн онигоо түүний урын санд их бий. Тоби хурим найр, дайллага цайллаганд оролцож цаг тутамд суралцсаар байлаа.

Заримдаа тэрээр гоёмсог нэртэй жижигхэн кино театрт өдөрт тав зургаан тоглолт хийдэг байв. Гэвч Тоби хэзээ ч цөхөрсөнгүй. Эцэст нь тэрээр жижигхэн хотын ядуу дорой газруудад өдрийн турш тоглоод олонд үнэлэгдэж нэрд гарахгүй байгаагаа ойлгожээ. Нэг л зоригтой юм хийх хэрэгтэй байлаа. Гэтэл асуудал гэнэт өөрөө шийдэгдчих нь тэр.

1941 оны 12-р сарын өвлийн нэгэн хүйтэн ням гаригт Нью-Йоркийн 14-р гудамж дахь "Дьюи" театрт тоглолт хийж, Тоби хөтөлбөрөө үүргийнхээ дагуу зарлав. Эхний шоу амжилттай өндөрлөж, Тоби "Нисдэг Каназава" хэмээн акробатчин япон гэр бүлийн тоглолтыг зарлатал үзэгчид исгэрч, хөлөө дэвслэж гарлаа. Тоби яаран тайзны ар руу ухран далд ороод, -Тэд юунд орилолдоод байгаа юм бол? гэж гайхвал,

-Чи сонсоогүй гэж үү? Япончууд хэдхэн цагийн өмнө Перл-Харбоыг бөмбөгдсөн гэж хэн нэг нь тайлбарлав.

-Тэгээд юу гэж? хэмээн гайхав. Дараагийн тоглолтонд акробатчидыг тоглохын өмнө Тоби

ТАЙЗАН дээр гарч, -Ноёд, хатагтай нар аа! Та бүхэнд дөнгөж саяхан Манилагаас ирсэн алдартай акробатчдын танилцуулья. "Нисдэг Филиппинчүүд!" гэж зарлажээ. Үзэгчид япончуудыг хармагцаа мөн л шүгэлдэцгээжээ. Тоби дараагийн тоглолтод тэднийг "Жаргалтай Гавайчууд", "Галзуу Монголчууд", "Эрвэлзэн нисэх эскимосчууд" гэж янз бүрээр зарлаж үзэвч тэдэнд гавьтай тус болж чадсангүй. Өөрийгөө ч аварч чадахгүйгүйгээ мэдмэгц тэр оройдоо

аавгайгаа яривал, түүнд цэргийн зарлан дуудах ирснийг хэлжээ. Ингээд зургаан долоо хоногийн дараа тэрээр цэрэгт татагдах нь тэр. Тобиг тангараг өргөж байсан тэр өдөр үг хэлж чадахгүй болтол шанаа орчим нь лугшин өвдөж байлаа.

Толгой өвдөх нь улам бүр нэмэгдэж бяцхан Жозефинад хэн нэг нь аварга том сарвуугаараа өрөвдөн хайрлахгүй гавлыг нь базаж байгаа мэт санагдаж, ээжийгээ зовоохгүйн тулд уйлахгүйг хичээж байв. Хатагтай Цински сүжигтэн болж, шашинд оржээ.

Тэрээр охин Жозефинагийнхаа хамт нөхрийнхөө үхэлд ямар нэг хэмжээгээр буруутайгаа сэтгэлийнхээ гүнд үргэлж мэдэрч, өдөртөө залбирлын сүмд очиж шашны цуглаанд суун, номлогчийн хилэнтэй сургаалын сонсоно.

-Та бүгд бузар буртаг, гэмт явдалдаа живэцгээж байна! Бурхан тэнгэр та нарыг гал дээр эргэлдэн дүүжлэгдэх бузар хорхой мэт үл хэрэгсэн тамын ёроолгүй ангальн ирмэг дээр торгоон барьж байна. Хараал идсэн нүгэлт та нар нарийхан хялгасан утсан дээр дүүжлэгдэн дэнжигнэж байгаа бөгөөд хэрэв нүглээ наминчлан бузар үйлээ зогсоохгүй бол түүний уур хилэнгийн дөл бүгдийг тасар татах болно.

Хатагтай Цински Бурхны үгийг сонсон ойлгоод яагаад ч юм сэтгэл нь ихэд хөнгөрчээ.

-Энэ бол бид чиний эцгийг алсны төлөө Бурхны цээрлэл гэж эх нь Жозефинад дахин дахин давтахад охин хэдийгээр нялх балчир ч гэлээ эл үгсийн цаад утгыг ойлгон ямар нэг тэнэг үйл хийсэн бол зүрх сэтгэлээсээ өөрийн гэмээ цагаатган, хийсэн бүхэндээ хэрхэн харамсаж байгаагаа эхдээ тайлбарлахыг хүснэ.

Бүлэг 5.

Цэргийн албаны эхний өдрүүд Тобид аймшигт эргэлт болов.

Тэрээр хээрийн цэргийн дүрэмт хувцастай, нэр овоггүй шахам, бусдад үл анзаарагдах хүмүүсийн адил олон сая жагсаалын цэргүүдийн дунд уусан хэн ч биш болжээ.

Тобиг Жоржийн сургалтын лагерь руу явуулан дараа нь анги салбарынх нь дагуу Английн Суссекст явуулжээ. Тоби бригадын генералтай ярих хүсэлтэй байгаагаа дэслэгчид илтгэв. Гэвч тэрээр ахмадаас дээгүүр тушаалтантай уулзаж

чадсангүй. Ахмад Сэм Уинтер гэгч хар үстэй, гучаад насны ухаалаг царайтай, нэвт шувт ширтэх гярхай нүдтэй нэгэн, -Байлдагч Темпл, юу болоов? гэж эсуухад нь, -Би жүжигчин, хошин жүжигчин юм л даа, ахмад аа. Жирийн иргэн байхдаа шоу-бизнес ажиллаж байсан юм гэлээ.

Тэрээр ахмадыг өөрийн эрхгүй инээлгэх гэсэндээ их нухацтайгаар ярьж байв.

-Чи тэгээд юу хийж байв даа?

Бүгдийг, бага багаар, элэглэн дуурайж, шог ший гэснээ Тоби ахмадын нүдний харцыг нь анзаарснаа самуурч, -Энэ төрлийн бүгдийг гэлээ.

-Хаана ажиллаж байсан бэ?

Тоби тоочин эхлэх гэснээ ямар ч найдвар үгүйг мэдрэн дуугаа хураалаа. Нью-Йорк, Голливуд гэх мэтийн газруудыг нэрлэвэл офицерийн чихийг сортойлгон сэтгэгдэл төрүүлэх болно. Гэвч тэр цагаа дэмий үрж байгаагаа ойлгожээ.

-Та тэр газруудыг сонсоо ч үгүй дээ гээд эцэст нь урамгүйхэн хариулав.

Ийм асуудлыг шийдэхэд миний эрх мэдэл хүрэхгүй, гэвч ямар нэг юм хийж болно гэж би бодож байна.

-Ойлголоо. Их баярлалаа, ахмад аа гээд Тоби толгой дохив.

Тэрээр ахмадад ёслоод явжээ. Харин ахмад Уинтер саяын ярилцсан залуугийн тухай бодон ширээний ард удаан суулаа. Сэм цэрэгт явахдаа фашизмын эсрэг шудрага дайнд зайлшгүй ялна гэж бодож байсан бол Тоби Темпл мэтийн нусгай балчир залуустай арми дайснаа хэрхэн дарах билээ гэсэн бодлоо

тэсвэрлэж чадсангүй. Үнэн, хэрэв энэ залуу эр үнэхээр авьяастай бол эрт орой хэзээ нэгэн цагт тодрон, авьяас нь бул чулуу дороос ургаж буй эмзэгхэн цэцэг шиг байсан ч түүнийг хэн ч зогсоож чадахгүй тэр заавал ургаж л таараа.

Ахмад Сэм Уинтер фронтод явах гэж Голливудын уран сайхны киноны продюссер гэдэг сайхан албан тушаалаа орхижээ.

Дайнаас өмнө тэрээр "Пан Пасифик" компанид хэд хэдэн кино хийлгэж явахдаа Темпл шиг итгэл өвөрлөсөн олон арван залуучуудтай уулзаж явжээ. Тэд бараг л бүгдээрээ хүсэлдээ хүрэх боломж хүртэж чадсан аж.

Ингээд ахмад Уинтер хурандаа Бичтэй ярилцахаар шийдэв. -Түүний хүсэлтийг тусгайлан сонсоход болохгүй юмгүй гэж бодож байна. Миний бодлоор тэр дажгүй залуу шиг санагдсан. Бурхан харна биз, цэргүүдийнхээ урмыг сэргээж зугаацуулан, хөөрхий залуу жаахан ч болов баярлаг гэсэнд, Хурандаа Бич Сэмийг хөлөөс толгой хүртэл ширтээд хүйтнээр,

-Таны зөв, ахмад аа. Надад илтгэх хуудас бичээд өг! гэжээ. Тэрээр гарч яваа Уинтерийн араас удтал харлаа. Хурандаа Уэст-Пойнтийг төгссөн жинхэнэ цэргийн мэргэжилтэн агаад энгийн хүмүүсийг эс тоомсорлох тул ахмад Уинтер түүний нүдэнд тэдний нэгэн адил харагджээ. Ахмадын мөрдөс бүхий дүрэмт хувцас өмсөөд ч энгийн хүн хэзээ ч жинхэнэ цэрэг эр болж чадахгүй. Хурандаа илтгэх хуудсыг авч үзээд, хөндөлдүүлэн хайнгаар: "Хүсэлтийг татгалзъя" хэмээн таталган бичээд сая нэг санаа нь амарчээ.

Тоби хамгаас илүүтэйгээр үзэгчдээ үгүйлж байх шиг. Түүнд олж авсан жаахан ч болов туршлагаа алдахгүйн тулд үргэлж дасгал сургуулилт хийх хэрэгтэй байлаа.

Тэрээр боломж гармагц дарга, захирагч, кино оддыг элэглэн дуурайж уйдсан харуул, гал зуухны жижүүр, хот орохоор автобусанд яваа цэрэг дайчдыг гололгүйгээр тоглож, тэдний элгийг хөштөл, нулимсыг нь гарган инээлгэхэд, дайчдын алга ташилт нь түүний сэтгэлийг хөгжөөнө.

Нэгэн удаа ахмад Уинтер ийм тоглолт дээр нь санамсаргүй буучихжээ. Тобигийн тоглож дуусахыг хүлээгээд Сэм түүн рүү очин,

-Таны гуйлт талаар өнгөрсөн нь харамсалтай байна, Темпл. Танд авьяас байна. Дайны дараа Голливуд ордог юм бол надтай уулзаарай гэж хэлээд жуумалзан инээгээд,

-Мэдээж намайг тэнд ажиллуулдаг л юм бол шүү дээ хэмээн нэмж хэлжээ. Дараагийн долоо хоногт Тобигийн батальоныг тэргүүн шугам рүү илгээв.

Хожим Тоби дайны тухай дурсахдаа тулалдааны тухай биш харин Сен-Лод Бингу Кросбиг дуурайж ямар амжилттай байсан тухайгаа ярьдаг байна. Ахенд байхдаа тэр цэргийн эмнэлэг рүү сэм орон хоёр цаг шахам шархадсан цэргүүдийг зугаацуулаад элгээ хөштөл инээсэн нэг цэрэг оёдлоо зад тавьчихлаа гэж сувилагч нар түүнийг хөөж гаргатал нь тогложээ.

Мецэд тоглолтын үеэр нь фашистын шумбагч онгоцнууд ирж түүний тоглолт талаар болжээ.

Германы командын байрыг булаан авч эр зориг гаргасны төлөө гавьяа хүртсэн тулалдаанд Тоби бараг л дайтсангүй

өнгөрчээ. Үнэнийг хэлэхэд энэ үед Жон Уэйныг дуурайн зугаацаад юу болж байгаагаа ч ойлголгүй, айж амжаагүй явтал бүх юм дууссан байлаа.

Тобигийн хувьд дайныг иймэрхүү янзтай туулан, дажгүй амь зууж цаг хугацаа нисэх мэт өнгөрчээ.

1945 онд германчууд бууж өгөхөд тэрээр хорин таван нас хүрч, нүүр царай нь огт өтлөсөн шинжгүй, гэнэн хүүхэд төрхөөрөө хэвээр, тод цэнхэр нүд нь урьдын хэвээр арчаагүй, санаашран хорвоо ертенцийг ширтэн байв.

Дайн дуусч бүгд л гэр гэртээ харина гэж хөөрцөглөн нэг цэргийн сүйт бүсгүй Канзас хотод үлдсэн, нөгөөгийнх нь хөгшин эцэг ЭХ Бейоннед, удаах нь Сент-Луист бизнес эрхэлдэг гэхчилэн ярьцгаахад Тобиг гагцхүү алдар нэрнээс өөр хэн ч, юу ч хүлээж байсангүй. Тэрээр хүсэл мөрөөдлөө биелүүлэх цаг болж, Бурхан түүний ариун хүсэл мөрөөдөлд нь туслах болсон хэмээгээд Голливуд орохоор шийджээ.

-Та нар Бурхныг мэдэх үү? Түүний дүрийг хэзээ нэг цагт ХАРСАН уу? Ах дүүс минь би түүнийг харсан, түүний дууг сонссон. Тэр өөрийн өмнө бөхийн, хөлний нь өмнө өвдөг сөхөрсөн хэн бүхэнтэй ярилцан нүглийг нь наминчлах болно. БУРХАН Тэнгэр өмнөө өвдөг сөхрөөгүй нүгэлтнийг хүлээж авахгүй. Нум бол Бурхны татаж буй хилэн, сум нь таны нүгэлт зүрх рүү чиглэсэн Түүний нүглийг номхотгогч гал, Тэр хэзээ нэг цагт хөвчөө тавихад Түүний өр төлөөсний зэвсэг таны мөнх бусын бие махбодийг үгүй хийх болно. Оройтоогүй дээрээ Түүнд хандацгаа!

Жозефина сүмийн тааз руу айн харвал түүн тийш хөвөн нисэж буй сумыг олж хараад, татгасхийн эхийнхээ гараас зууран авбал эх нь юу ч анзаарсангүй, нүд нь тэчъядан гялалзана.

-Гэгээн минь! гэж гудмын тэртээгээс бахирах дуу сонсогдов. Шашны цуглаан Одессийн эрэг дээрх асар том сүмд хурдаг агаад хатагтай Цински Жозефинагаа ийш нь үргэлж дагуулан очно. Номлогчийн модон индэр газраас зургаан футын өндөрт сүндэрлэж, түүний урд талд, намхан тороор хашаалсан нийтийн өмнө нүглээ наминчлах "нүгэлтний талбай" байх ба уг талбайд нүгэлтнүүд ариусан гэгээрч залбирлын газраас гарч явцгаана.

Цаахна талд нь шашны үнэн шүтлэгтэнгүүд өдөр өнжилгүй ирж айж сүрдэн аврал эрэн суудаг хатуу модон урт вандан сандлууд эгнэжээ. Зургаан настай балчир хүүхдийн мэдрэл Бурхны заналхийлэл ял шийтгэлийн тухай орилохыг хэрхэн тэсвэрлэх билээ.

-Хамгаас хүчирхэг Иеговын өмнө дагжин чичрэх хөөрхий нүгэлтнүүд өвдөг сөхөрцгөө! Учир нь та нарын шившигт үйл Христын зүрхийг зүсч, үүний төлөө Түүний эцгийн уур хилэн та бүхнийг гэсгээн цээрлүүлнэ! Шунаг тачаалын дүнд үр тогтсон эрэмдэг зэрэмдэг үр хүүхдүүдээ харцгаа!

Жозефина охин бүгд түүнийг сонжин харахыг мэдэрч, ичсэндээ байж суухын эцэсгүй болдог байв. Толгой нь ган төмрөөр бүслүүрдэх мэт дахин янгинан өвдөж эхлэхэд Жозефина : "Энэ бол Бурханы цээрлүүлэл юм байна" хэмээн мэдэх болжээ. Охин өдөр бүр Бурхан түүнийг өршөөн, өвчингүй болгоосой, ямар нүгэл хийснээ мэдэхсэн гэж сүслэн залбирна.

-Намайг "Аллилуйя" хэмээхэд та нар дагалдан "Аллилуйя" гэж бүгдээр Бурхныг магтан дуулцгаая.

-Архи чөтгөрийн цус, тамхи түүний амьсгаа, тачаадан зугаацах нь түүний баяр баясгалан. Та нар чөтгөр шуламтай нөхцсөн буруутай юу? Хэрэв тийм бол мөнхвд халуун тамд шарагдаж, үүрд хараалын муугаар хараалгаж, Люцифер та нарын сүнсийг авахаар ирнэ!

Жозефина айн дагжин чичирч ийш тийш ширтэн, чөтгөр шуламд хөтлөгдөөд явчихгүй гэсэндээ хамаг хүчээрээ сандалд наалдан сууна.

Аянга мэт нүргэлэх номлолын дараа жинхэнэ гайхамшиг ЭХЛЭН Жозефина хазгар доголон, ёололдсон, зарим нэг нь тахир дутуугийн тэрэгтэй зэрэмдэг эрэгтэй, эмэгтэй хүмүүс "нүгэлтний талбай" тийш очицгоохыг өөрийн эрхгүй мэгдэн ажиглажээ. Номлогч тэдний зулайд адис өгөн тэнгэрийн их хүч энэлэн, шаналагсдыг эдгээхийг гуйн залбирна. Гэтэл тэд гэнэт суга таяг, саваа модоо хаялцгаан, зарим нь шашны аялагаар үл ойлгогдох хэл дээр маань мэгзэм уншин бувтнаж эхлэхэд Жозефина айн сандалдаа улам шигдсээр суулаа. Энэхүү цуглаан үргэлж өргөл барьц цуглуулан, номлогчийн ерөөлөөр дуусгавар болдог байжээ.

-Гэгээн Иисус та бүхнийг харна. Тэр харамч занг үзэн яддаг гэдгийг санаж авцгаа!

Хараал хариулга хэдийнэ дууссан ч гэлээ айдас хүйдэс Жозефина охины зүрх сэтгэлийг эзэмдсэн хэвээр үлдэнэ.

Эрт цагт Техас нутгийг Индианчууд эзэмшиж байхад оршин суугчдын аманд цөлийн тоос шажигнаж байсан бол өдгөө 1949 Техасын Одесс хотын оршин суугчид бурам хүлхдэг байжээ.

Эл нутагт нефтийн томоохон хөрөнгөтнүүд, жирийн иргэд буюу ядуус гэсэн хоёр өөр ангийн хүмүүс аж төрөн амьдарч байв. Хөрөнгөтнүүд ядуустаа огтхон ч ихэрхэг зан гаргадаггүй, харин ч бүр эсрэгээр тэднийг өрөвдөн хайрладаг учраас "Дээд тэнгэр тэдэнд хувийн онгоц, "кадиллак" машин, усан сан эдлүүлэн, архи, дарс нь булаг шанд мэт оргилсон үдэшлэгт зуу зуун зочдод урилга тараан цэнгэл эдлэхийг зөвлөлийн гишүүдийн нэг нь байсан юмсанжээ.

Жозефина уг мэдээг сонсоод тархи нь хагарчих шахам өвдөн арай гэж хашгиралгүй биеэ барьжээ. Тэр шагнал хүртчих гэсэн хүслийг нь Бурхан мэдчих вий гэхээс үнхэлцгээ хагартал айж байвч Агуу хүчит Дээд Тэнгэр бүгдийг харсан мэдсэн учраас дайрлага нь эхэлсэн нь лавтай. Охин шөнө эхийгээ сэрээхгүй гэсэндээ дэрэндээ нүүрээ шаан чимээгүйхэн мэгшин уйлжээ.

Уралдааны дүнг зарласнаас хойш хэд хоногийн дараа нэгэн амралтын өдөр Жозефинаг Хадсоны гэрт урьжээ. Жозефина Тинагийн өрөөнд чулуун тавиур дээр байрлуулсан алтан аягыг удаан гэгч нь харав.

Охин гэртээ эргэж ирсний дараа аягаа цүнхэндээ хийж, унтлагын хувцсан доогуур нуун, Тинагийн ээж хулгайлсан эдийг авахаар ирэн иртэл тэндээ байсаар байжээ.

Жозефинагийн ээж модноос урт мөчир хугалан авч охиноо хэрцгийгээр зодож гарав. Гэвч охин эхдээ өчүүхэн ч гомдн сонгүй. Харин гялалзах үнэт эдлэлийг гартаа барьж үзсэн тэр хэдхэн хоромд Жозефина асар их зовлон доромжлолыг амссан ажээ.

Бүлэг 6.

Дөчөөд оны дэлхийн киноны төв болох Голливуд авьяастай, мулгуу, хомхой шунаг, шулуун шударга, үзэсгэлэнтэй, галзуу солиотой гээд энэ хорвоогийн сайн муу, сайхан муухайн есөн шид нь бүрдсэн хэн бүхнийг соронзон мэт татаж байлаа. Тэрээр зүүдний ид шидийн хаант улсад шилдэг нь болохыг] хүссэн хэн бүхний дамжих талбар нь болж байлаа. Голливуд нэгэн шенийн дотор хэн нэгнийг од болгон, нөгөөг нь үгүй-рүүлэн хоосруулах асар том казино, жүржийн цэцэрлэг бүхий нийтийн байр, тэр ч бүү хэл сүм дуган хүртэл болдог төдийгүй хүн бүр бусдаас ялгарах өөрийн хувь заяагаа хардаг ид шидэт дуран авай хүртэл болдог байжээ.

Тоби Темплийн хувьд Голливуд нь үргэлжид хүсэн тэмүүлж байсан газар нь байв. Тоби энд ирэхдээ цэргийн үүргэвчээ үүрэн, халаасандаа ердөө л гурван зуун доллар өвөртлөн иржээ.

Кахуэнгийн цэцэрлэгт гудамж дахь хямдхан дотуур байранд төвхнөж аваад цаашид хэрхэх тухайгаа бодлоо. Тоби үтэр түргэн ажил олохгүй бол тун удахгүй сохор зоосгүй үлдэнэ гэдгээ тун сайн ойлгожээ. Голливуд шиг ийм хотод хувцсаар нь угтдаг тул тэр даруй Вайн-стритийн эрэгтэйчүүдийн хувцасны дэлгүүрт шинэ хувцас захиалаад халаасандаа ердөө л хорин доллартой үлдэв. Ингээд Тоби ажиг ч үгүй исгэрэн, бүх кино оддын хооллодог "Браун дерби" рестораныг зорилоо. Рестораны танхимын хананд бүхэлд нь голливудын алдартай жүжигчдийн шог зургийг өлгөжээ. Тоби далдын хүчний мэдрэмжээр чухам энд л шоу-бизнесийн сэтгэл хөдөлгөсөн орчин байгааг мэдэрчээ.

Хорин хоёр орчим насны шаргал үстэй, гоолиг нуруутай, царайлаг үйлчлэгч бүсгүй түүнд дөхөн ирээд инээмсэглэн,

-Танд юугаар туслах вэ? гэхэд нь, Тоби тэсгэлгүй гараа сунган бөВ бөөрөнхий тарвас мэт чавхайсан хөхийг нь базаад авлаа. Бүсгүй хэрдхийн цочиж юу юугүй хашгирахаар ам ангайхад Тоби харалган хүн мэт нэг цэгт ширтээд, -

Уучлаарай, хатагтай ... би ... би юу ч харахгүй... гэж хэлбэл,

-Өө, надад тун харамсалтай байна гэж бүсгүй золгүй түүнд бүх зүрх сэтгэлээсээ харамсал илэрхийлэн гэмшин дуу алдав. Бүсгүй Тобигийн тохойноос нь түшин, ширээ рүү аваачин суухад нь туслаад хоолыг нь захиалахаар явлаа. Хэдэн минутын дараа бүсгүйг эргэж ирэхэд өнөөх харалган эр ханан дахь шог зургийг харчихсан,

-Ёстой гайхалтай! Би дахиад хардаг болчихлоо хэмээн инээд алдан сууж байв.

Өмнөө байгаа олиггүй эрийн гэм хоргүй гэнэн харцыг хараад бүсгүй тэсэж чадалгүй инээд алдаж, тэр ч байтугай Тобигийн хооллож байхад ч, явсан хойно нь ч, бүр орондоо орсон хойноо ч түүний даажигнасныг бодон бодон хөхөрсөөр байв.

Шоу-бизнес оёр байвал ямар ч ажил хийхэд бэлэн байсан Тоби төлбөрт зогсоолд ажиллаж алдарцуутнууд ирэхэд нь хавтай нь гэгч машиных нь хаалгыг нээн өгч хүндэтгэл үзүүлэхэд хэн ч түүнийг нэг нүдээрээ хялайж харахгүй нь гачлантай. Мань залуу тэдний хувьд амьд үхсэн нь хэнд ч хүртээлгүй, хэнд ч үл тоогдох урд хойно нь гүйдэг өнөөх л нусгайчуудын

нэгэн байв. Тоби машинаас буух үнэтэй бариу даашинз өмссөн бөгс хаялан гунхалзах бүсгүйчүүлийн араас хараад, "Нэгэн сайхан өдөр та нар миний хэн болсныг мэдмэгц энэ хямсгар зан чинь ул мөргүй арчигдах бий вий!" хэмээн бодно.

Тоби шоу-бизнесийн агентуудтай уулзахаар улаа ханзартал яваад цагаа дэмий үрж байгаагаа даруй ойлгожээ. Өөрөө бус, харин тэд түүний хойноос гүйлдэх ёстой сон.

Тоби хамгийн авьяастай жүжигчдийг төлөөлөн, ер бусын гэрээ байгуулж чаддаг Клифтон Лоренсын нэрийг олонтоо сонссон агаад хэзээ нэг цагт Клифтон Лоренсыг өөрийн агентаа болгоно гэж баттай шийдэв.

Тэрбээр шоу-бизнесийн сонин болох "Дейли вэрайти", "Голливуд рипортер"-ыг захиалан унших болсон бөгөөд тэднийг гарчиглах тоолондоо өөрийгөө жүжигчдийн гэсэн тэр нэгэн гэр бүлийн гишүүн болсон мэт санадаг болжээ. Уг сониноос "Киноны мэдээ" гарчигийг харан сууснаа,

"Продюссер Сэм Уинтер "Пан Пасифик" кино студийн дэд ерөнхийлөгчөөр томилогдов" гэсэн мэдээллийг үзэнгүүт зүрх нь хавиргаа хугарчих шахан цохиллоо.

Бүлэг 7.

Сэм Уинтер дайнаас гэртээ эргэж ирмэгц "Пан Пасифик"-т түүнд хийх ажил байсангүй. Гэвч хагас жилийн дараа томоохон өөрчлөлт гарч студийн тэргүүн халагдаж Сэмээс захирлын

алба хашихыг хүсчээ. Уинтерийг албан үүргээ сайн гүйцэтгэж чадна гэдгийг мэдэх тул өөр хэн нэгнийг хайх санаа хэнд ч төрсөнгүй Сэмийг уран сайхны кино үйлдвэрийн дэд ерөнхийлөгчөөр албан ёсоор томилжээ. Энэ ихээхэн ачаалалтай, хэл ам ихтэй, зүдэргээтэй ажил ч гэлээ Сэм Уинтер чухамхүү кино урлагийн ажилд бүхнээс илүү дуртай нэгэн бөлгөө.

Голливуд солиотой галзуу мэт амьтад энд тэндгүй бүжиглэн дүүлсэн багтаж ядсан гурван тайзтай цирк, хормын төдийд АГААРТ цацагдаж мэдэх минижүүлсэн талбар мэт санагдана.

Жүжигчид, найруулагчид, продюссеруудын олонх нь байж боломгүй хувиа хичээгч, ихэмсэг инд донтогсод, өширөн хонзогногч шалихгүй амьтад байдаг байлаа. Гэвч Сэм авьяас бол үзэгчдийн сэтгэл зүрхийг нээх ид шидийн түлхүүр учраас тэд авьяастай бол бусад нь огт падгүй хэмээн үздэг нэгэн.

Өрөөнийх нь үүд алгуур нээгдэн Сэмийн нарийн бичгийн дарга Люсиль Элкинс орж ирэн өглөөний шуудан авчирлаа. Люсиль бол шилдэг мэргэжилтнүүдийн нэг тул хэдэн арван боссуудыг элээн студэд үүрд ажиллах чадвартай бүсгүй юм.

-Клифтон Лоренс тантай уулзахаар иржээ хэмээн бүсгүй хэлэв.

-Оруулчих. Сэмд өөрийн гэсэн ижилгүй стильтэй Лоренс ихэд таалагдах болжээ. Энэ хотод нэр төртэй, хүний мөстэйг ганцхан хүнийг үзээд өгье ч гэсэн нүдний гэм, харин Клифтон хамгийн

шударга, төлөв төвшин агент байлаа. Тэр Голливудын домог болж, түүний үйлчлүүлэгчдийн жагсаалт нь "Хэн нь хэн бэ?" шоу бизнесийн лавлахыг санагдуулна. Лоренс Лондон,

Швейцар, Нью-Йорк гээд хаа сайгүй ажиллан олон үйлчлүүлэгчтэй болсон байна. Клифтон Голливудын нөлөө бүхий хүмүүстэй ойртож дотносон долоо хоног бүр студийн гурван

тэргүүнтэй хөзрийн ширээний ард уулзан тухалж, жилдээ хоёр гурван удаа дарвуулт хөлөг хөлслөн үзэсгэлэнт загвар өмсөгчдийг баян студийн захирагчдийн хамт "Долоо хоног загасчлах"-аар аялдаг байлаа. Клифтон анд нөхөддөө дуртайяа хэрэглүүлдэг тэнгисийн хаялган дээрх тохилог сууцтай ажээ. Лоренс Голливуд хоёр нэг тэрэгний хоёр дугуй мэт бие биедээ заяагдсан гэлтэй.

Сэм цэмцгэр, гуалиг биетэй дэгжин хувцасласан Клифтонтой мэндлэхээр бослоо. Агент ширээнд дөхөн ирж, өө сэвгүй зассан хумстай гараа сунган,

-Хурдхан ороод гарья гэсэн юм, мэнд үү? Ажил ямар байна, анд минь? гэлээ.

-Үүнээс илүү байна гэж яахыг хэлэх вэ? Өдөр хоногийг хөлөг онгоцны нэрээр нэрлэдэгсэн

бол, енөөдрийг "Титаник" хэмээн нэрлэх байна шүү гэсэнд, Клифтон Лоренс талархан мишээлээ.

-Өчигдрийн киноны талаар ямар шүүмж хэлмээр байна? гэж Сэм сониучирхан асуув.

-Киногоо эхнээс нь хорин минут хас, төгсгөлийг нь өөрчил, тэгвэл чи нэг юм сонсоно шүү!

-Чөтгөр ав гэж! Үүнийг чинь хийнээ. Чи үйлчлүүлэгчдийнхээ талаар юу гэмээр байна? Хэн нэгнийг нь түр өгөхгүй биз? гэвэл,

-Өршөөгөөрэй, бүгд завгүй гээд агент инээмсэглэв.

Энэ ч чин үнэн л дээ, Клифтон Лоренсын үйлчлүүлэгчид бол гялалзсан шилдэг найруулагчид, продюссер, авьяаслаг кино одод байдаг болохоор ихээхэн эрэлт хэрэгцээтэй биз ээ.

-Баасанд уулзацгаая, Сэм ээ. Хамт хоололцгооё, чао! гэж Клифтон салах ёс гүйцэтгээд үүд рүү эргэв.

Харилцуурын чанга яригчаар,

-Даллас Берк тантай уулзах гэнэ хэмээх Люсилийн дуу сонсогдов.

-Оруулчих.

-Бас Мел Фосс тантай уулзахыг хүссэн дээ. Яаралтай хэрэг гарсан гэнэ лээ.

Мел Фосс нь "Пан Пасифик" телестудийн тэргүүн аж.

Сэм ширээний хуанлиг харснаа,

-Түүнд маргааш өглөө 8.00 -д "Поло Лонж"-д өглөөний цай уух зуур уулзья гээрэй.

Нарийн бичгийн даргын утас хангинаж, Люсиль харилцуураа аван,

-Ноён Уинтерийн албан өрөө байна гэвэл,

-Сайн уу! Агуу хүн өргөөндөө бий юу? гэж үл таних хүн асуув.

-Өршөөгөөрэй та хэн бэ?

Армид цуг алба хашиж байсан хуучин анд Тоби Темпл байна гэж хэлээч. Сэм хэзээ нэг цагт Голливуд орвол өөртэйгээ уулзаарай гэсэн юм. Би энд ирчихээд байна гэлээ.

Ноён Темпл босс зөвлөлгөөнтэй байна. Тан руу утасд гэж хэлэх үү?

-Сайхан л санаа байна!

Тоби дугаараа хэлж өгч, харин Люсиль дугаар бичсэн цаасаа даруй хогийн сав руу чулуудчихлаа. Энэ ч эхний удаагийн үйлдэл биш, улиг болсон фронтын найз нь дэд ерөнхийлөгч Уинтертэй орооцолдохыг хичээж байх шив.

Даллас Берк америкийн киног үүсгэн байгуулагчдын нэг,

гарамгай найруулагч хүн. Беркийн эртний кинонуудыг сонгодог, үлдсэнийг нь үнэхээрийн суут бүтээл гэж үздэг тул ирээдүйн кино урлагын мастеруудыг бэлтгэж буй бүх коллежуудад сургалтын үзүүлэн болгон байнга хэрэглэдэг ажээ. Даллас өдгөө нас сүүдэр дал хүрч идэр залуугийн чийрэг мөр нь бөгтийж костюм нь хатингар биенд нь өлгүүрт өлгөсөн мэт хэлхийх болжээ.

-Даллас, тантай дахин уулзсандаа тун их баяртай байна!

хэмээн Сэм хөгшинг хүндэтгэн мэндчилэв.

- Сайн уу, хүү минь! гээд Даллас цуг яваа хүнээ заан,

-Миний агентыг таньж байна уу? гэлээ.

-Танилгүй яах вэ, амьдрал ямар байна, Питер? гээд тэдсууцгаалаа.

-Танд надад дуулгах шинэ кино зохиол байгаа гэж сонслоо гээд Уинтер яриагаа эхлэв.

-Ёстой эрхэм бүтээл шүү! хэмээн хөгшин сэтгэл хөдлөн үгийг нь таслан хэллээ.

-Ярихыг чинь хүлээж тэсэхгүй нь. Алив Даллас, битгий удаад бай! гэвэл Даллас Берк үл ялиг урагш тонгойгоод яриагаа эхлэв.

-Ертөнцийн хүмүүс юуг илүүтэй сонирхож байна вэ, хүү минь? Мэдээж, хайрыг биш үү? Дэлхий дээрх хамгийн ариун хамгийн гэгээн үрээ хайрлах эхийн хайрыг!

Берк хормын төдий залуужив уу гэлтэй чанга тод дуугаар өгүүлэв.

-Энэ түүх арван есөн настай залуу бүсгүй баян гэр бүлд нарийн бичгийн даргаар ажиллаж байгаагаар эхлэнэ. Хуучны хөрөнгөтөн. Эндээс бид гол үйл явдлыг эхлэх болно, тийм үү? Дээдсийн хүрээнийхэн. Бүсгүйн ажиллаж байгаа айлын хархүү нь мөс мэт цэвдэг хүйтэн, хатуу ширүүн ёсорхуу нэгэн язгууртан бүсгүйтэй гэрлэжээ. Нарийн бичгийн дарга бүсгүй хархүүд таалагдаж, харин нүдэнд дулаахан олон насаар ах эзэн эр нь бүсгүйн дурыг булаана.

Сэм зочныхоо ярихыг сонсон, иймэрхүү сэдвийн түүхийг түүнд долоо хоногт хэд хэдэн ч удаа авчирч сонсгодгийг залхуутайяа бодон суулаа. Кино зохиол муу байсан ч хөгшин түүнийгээ заавал худалдана гэдгийг тэрээр сайн мэднэ. Хэн нэгэн Беркэд кино тавихыг даалгаж байсан тэр цагаас хойш хорин жил өнгөрчээ. Далласын сүүлийн гурван кино хуучинсаг маягтай, тэсвэрлэшгүй үнэрхсэн байсансан. Үзэгчид киноны дундаас нь гарч явцгаагаад Даллас Беркийн үе өнгөрснийг илтгэж байжээ. Гэвч хөгшин өнгөрсөн алдар хүндээ ашиглахыг шургуу хичээн энх тунх амьдарч байгаа ч гэхнээ өргөн тэтгэх хайр халамж дутагдаж, арга

чаргыг олон ажиллах гэсэндээ хамаг байдгаа үрж бараад сохор зоос ч үгүй болжээ. Беркийг ахмад жүжигчидийн халамжийн сууцанд амьдрахыг санал болгоход нь тэрээр эгдүүцэн татгалзсан байна.

-Та нарын бөөсөндөө баригдсан тэр тусламж чинь надад хэрэггүй. Та нар Дуг Фэрбенкс, Жек Барримор, Милтон Сим, Билл Фарнум нартай ажиллаж байсан хүнтэй ярьж байгаагаа мэдэж байна уу! Би агуу хүн, та нар өрөвдөлтэй үхээнц амьтад, муусайн гичийн зулбасгууд! гээд хашгичиж гарчээ.

Үнэндээ Беркийн зөв байж, тэрээр домог мэт агуу суу билэгтэн болон тодорчээ. Сэм продюссераар ажиллахаар томилогдмогц танил агентдаа утасдан шинэ кинодоо Даллас Беркийн санааг авахыг гуйжээ. Уинтер тэр цагаас хойш одоог хүртэл түүний дэмий балай түүхийг нь хөгшний амь зуулганд хүрэлцэхүйц мөнгөөр байнга худалдан авч байсан агаад, цэргийн алба хашиж байх зуураа ч үүнийгээ үргэлжлүүлэн

хийлгэхээр орлогчоо гуйж байсан удаатай.

-Тэгээд хэмээн Даллас Берк үргэлжлүүлэн,

-Хүүхэд эхээ мэдэхгүй өснө. Гэвч бүсгүй хүүхдээ мартаж чадсангүй, түүнийг алхам тутамд салахгүй дагана. Киноны төгсгөлд охиныг баян эмчтэй суулган ёсолж ураг барилдуулах болно. Тансаг даашинз, нөлөө бүхий хүмүүс. Сэм ээ, уг киноны шигтгээг юу болохыг мэдэж байна уу? Анхааралтай сонсож бай, ёстой

гайхалтай! Тэрээр охиныхоо ураг барилдах ёслолыг хажуугийн хаалгаар сэм харах болно! Төсөөлж байна уу? Үзэгчид мэгшин уйлж, бахардана гэж мөрийцье. Ингээд гүйцээ. За ямар байна Сэм агентыг харвал мань хүн аягүйрхэн харц буруулан үнэтэй гутлынхаа хоншоорыг ширтэж эхлэв.

-Гайхалтай! хэмээн Уинтер дуу алдаад,

-Ийм л кино зохиол хэрэгтэй байгаа юм гээд агентад хандан,

-Хуулийн хэлтэс руу утасдаж гэрээ байгуул, Питер. Би тэдэнд хэлчихье гэтэл агент дуугүйхэн толгой дохилоо.

-Ахиухан мөнгө гарга гэж хэл, тэгэхгүй бол зохиолоо "Уорнер бразерс" руу аваачиж өгнө шүү. Бид сайн нөхөд учраас л би наашаа ирсэн юм! гэж Даллас хөндлөнгөөс айлган үг хавчуулав.

-Би энэ зохиолыг чинь өндрөөр үнэлж байна гэдэгт итгэж үз хэмээн Сэм хариулав.

Тэгээд Даллас, агент хоёр салах ёс гүйцэтгээд гарцгаав. Хатуухан хэлэхэд Уинтер компаний мөнгийг иймэрхүү зохиолд зарах эрхгүй бөгөөд зөв зүйтэй, уян сэтгэлийн алхам хийж байна хэмээн тайлбарлаж чадах нь юу л бол доо. Гэвч Даллас Берк шиг авьяастай хүмүүс байгаагүй бол ямар ч кино байхгүй байх асан тул кино үйлдвэрүүд тэдэнд ихээхэн өртэйсэн.

Маргааш өглөө 8.00-д Сэм Уинтер "Беверли-Хиллз" буудлын үүдэнд ирээд төдхөн "Поло

лонж" зоогийн газрын ширээнүүдийн хоорондуур сүлжин явах зуураа найз нөхөд, танил хүмүүс, өрсөлдөгч нартайгаа толгой дохин мэндчилж байв.

Бүх л студийн албан тасалгаанд ажил хэрэг ярьснаас энэ зааланд өглөө, өдрийн зоог барин, коктейль уух зуур томоохон ажил бүтээхэд нь илүү дөхөмтэй байдаг ажээ.

Мел Фосс Уинтерийг ойртон ирэхийг хараад толгой дохин,

-Өглөөний мэнд, Сэм хэмээн эрчүүд гар барин мэндлээд Сэм Фоссын өөдөөс харан тухлан суулаа. Сэм найман сарын өмнө "Пан Пасифик" студийн телекиноны хэлтсийн захирлын үүрэгт ажилд Фоссыг томилжээ. Телевиз хэмээх шинэхэн төрсөн зугаа цэнгэлийн нялх үйлдвэр гайхалтай хурдацтай хөгжиж байв. Телевизийг урьдаас нэвт харсан бүх студиуд өдгөө телекино хийн уралдацгаах болжээ.

Үйлчлэгч ирэн тэднээс захиалга аваад явлаа.

-За Мел минь яриад байгаарай, сайхан мэдээ дуулгана биз гэж Сэм яриа эхлэвэл Фосс толгой сэгсчин,

-Юуных нь сайхан мэдээ байх вэ! Манайд ихээхэн бэрхшээл тулгараад байна!

Сэм дуугүй хүлээзнэв.

-Эфирээс "Довтлогчид"-ыг хасах хэрэгтэй байна.

-Яагаад? Рейтинг өндөртэй муугүй кино. Жинхэнэ хитийг олно гэдэг тийм амаргүй гэдгийг чи өөрөө мэднэ шүү дээ!

-Хэргийн учир нь кинонд байгаа юм биш Жек Ноланаас болж байна хэмээн Фосс санаа алдлаа.

Нолан "Довтлогчид" киноны гол дүрд тоглон тун их амжилт үзүүлэн шүүмжлэгчид, үзэгдчийн дунд ам сайтай байгаа сан.

-Тэр яагаав? гэж Сэм тэсвэр алдан асуулаа. Тэрээр Мелийн

хэзээ ч, юуг ч шууд хэлчихгүй, түүний ам хэлээ татаж чангаалгаж байж арай гэж нэгийг сонсгодог занг нь тэсвэрлэдэггүй ажээ.

- "Пик" сэтгүүлийн сүүлийн дугаарыг уншсан уу? -Би түүнийг ер уншдаггүй! Хогийн тантан гэлтэй билээ! гэснээ Фосс юу хэлэх гээд байгааг гэнэт ойлгон ярвайн дуу алдан, -Тэд Ноланыг олзолчихоо юу? гэлээ.

-Үнэнийг хэлэхэд, улайтал барьчихаж. Солиотой НОВШ ЧИНЬ ҮДШИЙН сүлжээсэн даахинз өмсөөд үдэшлэгт очсон байна. Хэн

нэг нь зургийг нь дарж амжжээ.

-Яасан булай юм бэ?

-Үүнээс булай юм гэж байх уу даа. Спонсорууд, захирлууд Нолантай гэрээгээ цуцлахыг шаардаж байна.

-Мулгуу амьтан! гээд Сэм санаа алдав.

Ирэх сард Нью-Йоркод болох захирлуудын эөвлөлийн хурал дээр телестуди аятайхан тайлан тавина хэмээн ихэд найдаж байтал Ноланы түйвээсэн гай бүх найдварыг нь хөсөрдүүлжээ.

"Довтлогч" киног хаана гэдэг хэрэв. . . хэрэв...тэрээр түргэн гарах гарц хайж олохгүй бол аймшигт дохилт болох байлаа.

-Сэм өрөөндөө эргэж ирэхэд Люсиль багц зурвас гардуулахаар дохин, - Яаралтай шүү. Дарга таныг асууж. . .гэхэд нь,

-Дараа, дараа больё. "Ай-би-си"-гийн Уильям Ханттай даруй холбоодох гэв.

Хоёр минутын дараа Сэм "Интернэшнл бродкастинг компани"-ийн босстой ярьж суув. Тэрээр Хантыг олон жилийн тэртээгээс мэдэх авч тэд төдийлөн ойртож дотносоогүй ч гэлээ Уильям Сэмд ихэд таалагддаг ажээ. Хант өмгөөлөгчдийн холбооны авьяастай залуу гишүүдийн адил ажлын гараагаа албан тушаалын хамгийн доод шатнаас дэвшин дээшилсээр оройд нь гарч чаджээ.

Өдгөөг хүртэл Уинтер Хант хоёрын хооронд ажил төрлийн холбоо байгаагүйд Сэм ихэд харамсана.

Уильямын дууг сонсоод Сэм аль болох тайван, хайш яйш ярихыг хичээлээ.

-Сайн уу, Билл!

-Ямар сонин хүн бэ? Уулзалгүй удлаа шүү, Сэм ээ, хэмээн Хант эелдэгээр хариулав.

-Тийм ээ, их удаж. Бизнес маань төвөг учраад байна, Билл! Таалагддаг хүмүүстэйгээ уулзаж ярилцах цаг зав олдохгүй юм!

-Тэр үнэн шүү!

-Чи хөө, "Пик" сэтгүүлд гарсан тэр золигийн тэмдэглэлийг уншаагүй биз? гэж ямартаа ч гэсэн асуугаад авлаа.

-Уншсан, та нар ойлгож байгаа биз дээ. Ийм учраас уг киног эфирээс хасах болсон гэж Хант тайван хариулав.

Хэлэх үг олдсонгүй ч гэлээ Сэм эцсийн оролдлого хийн,

-Билл, хэрэв би Ноланыг зориудаар хийлгэсэн гэж нотолбол та юу гэж хэлэх вэ? гэлээ.

Харилцуурын нөгөө үзүүрт инээд алдах сонсогдов.

-Ийм уран сэтгэмжээрээ та сайн зохиолч болох байсан биш үү, Сэм ээ?

-За үгүй дээ, би үнэнийг хэлж байна гэж Сэм тангараглах шахан хэлээд,

-Би Жек Ноланыг сайн мэднэ. Тэр завхай амьтан биш. Зургийг багт наадам дээр авчээ. Түүний найз бүсгүйн төрсөн өдөр байсан тул Жек тоглоом хийхийг бодсон юм билээ.

Сэм духан дээгүүр нь хөлсний дуслууд бурзайхыг мэдэрчээ.

-Би чадахгүй...

-Жект итгэх миний итгэлийг батлахын тулд би түүнд дараа жил эхлэх бүрэн хэмжээний "Ларедо" киноны гол дүрийг өгөх гэж байгаа шүү.

Харилцуурт нам гүм боллоо.

-Сэм та үнэхээр хэлж байна уу?

-Тэгэлгүй яах вэ? Киноны төсөв гурван сая доллар болсон. Хэрэв Жек Нолан замрах аваас биднийг харанхуй ангал хүлээж байна. Та намайг ийм эрсдэлд орохыг хүсээд байна гэж арай бодоогүй биз? !

-Гэвч... хэмээн Хант тээнэгэлзэн үгээ сунжруулав. -Билл, боль доо, бөөс хуурсандаа баригдсан гудамжны нэг шалиг шар сонин шулуун шударга хүнийг дайрч доромжлохыг та зөвшөөрч байна гэж үү? Олон ангит цуврал кино танд таалагддаггүй юм уу? -Маш их таалагддаг! Сайхан кино. Гэвч... ивээн тэтгэгчид... -Энэ танай компани шүү дээ. Төлөвизийнхнийг бодвол танайх илүү ивээн тэтгэгчидтэй. Бид хит-шоуг та нарт өгсөн. Аз туршихын хэрэг алга. Бид дахин ийм амжилт олж чадахгүй байж магад. -Ер нь. ..

-Мел Фосс ирэх улиралд "Довтлогч" киног хэрхэх гэж байгаа талаар танд хэлээгүй юу? -Үгүй.

..

-Магадгүй, санамсаргүй бэлэг барих гэсэн байх л даа гэж Сэм дайралт хийгээд, - Хүлээгээрэй, та бас бүгдийг мэдээгүй байна! Киноны алдарт зохиолчид, кино оддыг урин зураг авна!

Хэрэв "Довтлогч" рейтингээрээ 1-р байранд орохгүй бол би ажил үүргээ гүйцэтгэж чадсангүй гэсэн үг.

Билл Хант илт тээнэгэлзэн,

-За яахав, Мел Фосс над руу утасдаг. Бид дэндүү эрт үймж

тэвдэцгээсэн бололтой хэмээн бувтнах аядав. -Заавал утасдах болно гэж Уинтер хариулав.

-Бас нэг юм гэвэл Сэм. . . та намайг зөвөөр ойлгоорой. Би

ХЭН НЭГнийг доромжлохыг хүсээгүй юм шүү.

-Тэгэлгүй яах вэ, ойлгож байна. Би таныг сайн мэднээ, Билл. Иймээс үнэнийг дуулгахыг хүссэн юм. -Баярлалаа, танд.

-Ирэх долоо хоногт хамт хооллох уу? -Дуртайяа. Даваа гаригт тан руу утасдья. Сэм харилцуураа тавиад, санаа амран сандлынхаа түшлэгийг наллаа. Жек Нолан гэж хөнгөмсөг шалихгүй хүний оронцог,

үнэнийг хэлэхэд энэ жигшүүртэй явдал аль эрт гарах байсан юм.

Сэмийн хойч ирээдүй ийм солиотнуудаас ихээхэн шалтгаална! Студийг удирдана гэдэг цасан шуурганаар Ниагарын хүрхрээ дээгүүр татсан тороосон татлагаар гарахтай адил. Галзуу хүн л ийм алба хашихыг зөвшөөрөх байх.

Сэм санаа алдаад харилцуур аван Мел Фоссын утсанд залгав.

-"Довтлогч"-ын зураг авалтаа үргэлжлүүл гэлээ.

-Юу уу? хэмээн Фосс гайхан дуу алдахад нь Сэм,

-Чиний сонссоныг чинь хэллээ. Жек Нолантай даруй ярь. Хэрэв тэр дахин ийм юм хийвэл, би өөрөө түүнийг хотоос хөөн зайлуулна гэж хэлээрэй! Би тоглоогүй гэдгийг сануулчихаарай!

Сэм харилцуураа чулуудчихаад шанаа тулан бодолд авглаа. Хантад амласнаа гүйцэлдүүлэн бүгдийг өөрчлөх болох нь, бас "Ларедо" киноны зохиолч олох хэрэгтэй.

Хаалга том дэлгэгдэн босгон дээр айсандаа цонхийж цайсан нарийн бичгийн дарга Люсиль зогсож үзэгдэв.

-Аравдугаар талбай руу хурдлаарай! Хэн нэгэн солиот нь түүнийг шатаачихаж!

Бүлэг 8.

Тоби Сэм Уинтертэй холбоо барих гэж олон удаа оролдоод нарийн бичгийн дарганцар эмэгтэйг ятгаж дөнгөлгүй эцэстээ бууж өгчээ. Тэрээр шөнийн клуб, студиэр эргэлдээд амжилт ололгүй, урьдынхаа ажлаа эрхлэх болжээ. Дараагийн жилд нь Тоби үл хөдлөх хөрөнгө даатгалын гэрээ, зрэгтэй хүний дотуур хувцас худалдан, оройн цагаар базаахгүй баар шөнийн клубуудад ажиллав. Студийн үүд хаалга урьдын адил түүний өмнө хаалттай хэвээр байлаа.

-Ингэх ч үгүй шүү, тэд өөрсдөө чам руу ирцгээг? гэж түүний нэг анд нь хэлэхэд,

-Яаж тэр вэ? Тэднийг хүзүүнээс нь олсоор оосорлож чангаах болж байна уу? хэмээн Тоби увайгүй мушилзав.

-"Экторз уэст" -д бүртгүүл.

-Театрын сургуульд уу?!

-Бас болоогүй. Тэнд жүжиг тавьж, эхний тоглолтыг нь үзэхээр бүх студийн төлөөлөгчид очдог юм билээ.

"Экторз уэст"-д тэр чигээрээ мэргэжлийн уур амьсгал ноёрхож байгааг нь Тоби босгыг алхангуугаа мэдэрчээ. Хананд өлгөсөн төгсөгчдийн зургаас Тоби олон алдартай жүжигчдийг таньжээ.

Нарийн бичгийн дарга цайвар үст бүсгүй хүлээн авах өрөөнд орж ирсэн Тобийг хараад,

-Танд юугаар туслах вэ? гэлээ.

-Би Тоби Темпл байна. Танай сургуульд элсэх гэсэн юм.

-Танд тайзны туршлага бий юу?

-За байз. . . танд юу гэж хэлмээр юм бэ дээ. . . ер нь бол,

үгүй л дээ. Гэвч би... гэж үнэнээ хэлэв. Цайвар үст бүсгүй толгой сэгсрэн,

-Гүн харамсалтай байна, хатагтай Теннер зөвхөн туршлагатай хүнийг л элсүүлдэг юм. Тоби түүнийг гайхан ширтээд,

-Та тоглож байна уу? гэж асуув.

-Үгүй. Тийм дүрэмтэй юм. Тэр хэзээ ч . . .

-Би энэ тухай яриагүй байна. Та намайг хэн болохыг үнэхээр мэдэхгүй байна гэж үү?

-Үгүй.

Тоби гунигтай санаа алдаад, -Ээ Бурхан минь! Хэрэв та Англид ажилладаг бол Голливуд таныг огт мэдэхгүй, төсөөлөх ч үгүй гэсэн Леланд Хэйдардын зөв байж шүү гэснээ инээмсэглэн уучлал эрсэн аясаар,

-Би тоглосон юм. Таныг намайг танина гэж бодсон юм гэлээ. Нарийн бичгийн дарга бүсгүй бүр будилж орхиод, яахаа ч мэдэхээ байлаа.

-Та театрт ажиллаж байсан уу? гэхэд нь,

-Тэгэлгүй яахав дээ гээд Тоби инээмсэглэн толгой дохисонд цайвар үст бүсгүй анкет авч эхлэв.

-Та хаана хэзээ ямар дүрд тоглосон бэ?

-Энд тоглоогүй. Сүүлийн хоёр жилд Англид тоглосон. Байнгын жүжигчидтэй театрт тэр шүү дээ.

-Ойлгомжтой гээд бүсгүй толгой дохиод,

-За яахав юу ч гэсэн хатагтай Теннерээс асуугаадхая гэлээ.

Бүсгүй хажуу тасалгаа руу ороод хэдэн минутын дараа эргэн ирээд,

-Хатагтай Теннер таныг хүлээж байна. Амжилт хүсье гэв.

Тоби цайвар үст бүсгүй тийш нүд ирмэчихээд, гүнзгий амьсгаа аваад үүдийг нээн орлоо.

Элис Теннер гэгч нь гучин тав орчим насны хар үстэй, язгууртан төрхийн үзэсгэлэнтэй царайтай эмэгтэй том ширээний ард суухыг харснаа Тоби босго алхангуугаа түүнийг гуалиг бие бялдартайг нь анзаарчээ.

"Тэр тусмаа сайн, энэ газар надад тохирох юм байна" гэж тэр бодоод дур булаам инээмсэглэл тодруулан,

-Намайг Тоби Темпл гэдэг хэмээн өөрийгөө танилцуулав.

Элис босон түүнийг угтан хүрч ирвэл зүүн хөлөнд нь согог заслын хүнд аппараттай золгүй явдалдаа хэдийнэ дадал болсон алхаагаар хазганан дөхөж ирлээ.

"Саад дайруулчихсан юм байна" хэмээн бодсон Тоби гасланд нэрвэгдсэнд хөөрхий бүсгүйд өрөвдсөнөө илэрхийлэх үү байх уу гэдгээ шийдэж ядав.

-Та манайд суралцахыг хүсээ юу? хэмээн хүүхэн асуув.

-Тийм ээ тун их хүсч байна.

-Яагаад гэдгийг чинь асууж болох уу?

-Яагаад гэвэл, газар сайгүй хүмүүс танай сургуулийн тухай, таны тавьдаг гайхалтай жүжгийн тухай ярилцахыг би олонтоо сонссон юм. Ямар хүндэтгэлтэй ханддаг гээч, мөрий тавьсан ч алзахгүй та ч төсөөлөхгүй л дээ? хэмээн Тоби аль болох үнэн сэтгэлээсээ ярьж эхэлжээ.

-Яагаад үгүй гэж? гэснээ Элис мөрөө хавчисхийгээд,

-Иймээс би луйварчдыг босгоо алхуулахгүйн тулд хоёр дахин сэрэмжтэй байдаг юм гэлээ.

Тоби хацар нь халуу оргихыг мэдэрсэн ч гэлээ баяр баясгалантай балчир хүүхдийн инээмсэглэлээр инээв.

-Юу уу? Тийм хүмүүс энд шургалах гэж оролдох нь олонтой тохиолддог гэж үү?

-Хангалттай олон гэж хатагтай Теннер хатуу хэлээд гартаа барьсан хуудас руу ширтэн,

-Тоби Темпл үү? Англид байнгын жүжигчидтэй хамт тоглож байсан гэв үү?

-Яг үнээн.

Элис түүнийг ширтээд тайван гэгч нь,

-Ноён Темпл, английн театрт америкчуудыг байнгын жүжигчидтэй тоглуулдаггүй, Британын жүжигчдийн үйлдвэрчний эвлэл үүнийг хориглодог юм хэмээв.

Тобигийн дотор нь палхийгээд явчихлаа.

-Эрхэм залуу минь бүгдийг сайтар мэдэж байж бурсан бол эвгүй байдалд орохгүй байж дээ, өршөөгөөрэй та, бид зөвхөн туршлагатай мэргэжилтнүүдийг элсүүлдэг юм.

Хүүхэн цааш ширээ рүүгээ эргэх нь бүх юм дууссаныг илтгэв үү гэлтэй.

-Хүлээгээрэй! гэх Тобигийн дуу тас няс хийн шавчих адил сонсогдон хүүхэн ***** гадас мэт тэр дороо зогсчихов. Тоби юу хийх, юу хэлэхээ ч мэдэхгүй зөвхөн хатагтай Теннерийг ятгаж чадах эсэхээс түүний ирээдүй нь шалтгаална гэдгийг л ухаарчээ.

Өмнө нь зогсож буй хүүхэн нь түүнийг дэвшин дээшлэх анхны алхмаа хийхэд нь, түүний хүсэн мөрөөдсөндөө хүрэхэд нь туслаж чадах учраас одоо л түүнийг зөвшөөрүүлэхгүй бол болохгүй нь туйлын үнэн болой.

-Та тэнэгээр журмаа баримтлан авьяасыг үнэлэхгүй байж таарахгүй, хатагтай. Тийм ээ, би тайзан дээр тоглож байгаагүй. Яагаад тэр вэ, гэвэл тань шиг хүмүүс надад боломж олгохыг хүсэхгүй байна! Миний юу хэлээд байгааг ойлгож байна уу? хэмээн У. К. Фильдсын дуугаар асуулаа.

Элис ичгүүргүй амьтны дууг нь таслахаар ам ангайсан боловч Тоби түүнд боломж олголгүй Жимми Кэгнид хувиран өрөвдөлтэй амьтанд өөрийгөө тодруулах боломж олгооч. хэмээн гуйснаа, Жеймс Стюарт Кэгнитэй зөвшилдөж байгааг дуурайгаад, Тобитой хамтран ажиллах

хүсэлдээ авгсан үхэж хатах нь холгүй байна гэснээ, эцэст нь Кэри Грантын дуугаар эл залууд гялалзсан авьяас билэг байна гэж зарлан тунхаглав. Хормын төдийд Голливудын бүх л одод энэ өрөөнд хошигнон, инээж хөхөрч, онигоо ярих шиг боллоо. Үг нь усны урсгал мэт тасралтгүй асгарахад Тоби бэлэн зэлэн үг нь хаанаас гараад байгааг өөрөө ч мэдэхгүй гайхширав. Тэр харанхуйд төөрч сураггүй болчихоод элэглэл хэмээгч хэврэгхэн мөчрөөс шүүрэхээр улайран оролдож буй хүнтэй тун адил болжээ. Хамаг биеэр нь хүйтэн хөлс цутгасан ч Тоби үл анзааран тасалгаан дундуур нааш цааш гүйн, элэглэж буй баатруудынхаа үйл хөдлөлийг дуурайн яг л өөрийгөө эзэмдэж чадахаа байсан гаж донтонтой адил болжээ.

Тоби гэнэт Элис Теннерийн дуугарахыг сонсов.

-Боль! Одоохон боль! Боллоо гэж хүүхэн нулимсаа гартал, элгээ хөштөл инээгээд амьсгаадан зогсож байв.

Тоби даруй сэхээ орон хэвийн байдалдаа орвол хатагтай Теннер алчуур гарган нулимсаа арчих үзэгдэв.

-Та.. .та лав солиотой байх шүү?

Тоби таг дуугүй хүүхнийг харж байснаа баярласандаа сэтгэл нь хөөрч,

-Тэгэхээр, би танд таалагджээ? ! гэлээ.

Элис Теннер инээдээ барьж ядан гүн амьсгаа аваад,

-Нэг. . . нэг их бишээ? гэв.

Гэнэт Тобигийн уур хилэн бадрав. Хүүхэн түүнийг шоолжээ гэж бодохоос Тобигийн уур нь дүрэлзээд ирэв. Тэр ямар мангуу юм хийчих вэ?

-Тэгвэл та яагаад инээсэн юм бэ? гэж тэрээр эгдүүцэн асуув.

Хүүхэн инээмсэглээд намуухан дуугаар,

-Таныг хараад. Хэзээ ч ийм жүжиглэл үзээгүй юм байна. Хаа нэгтээ кино оддын цаана залуу, авьяастай хүмүүс далдлагдаж байдаг байх нь ээ. Та бусадтай адилгүй юм. Танд хүмүүсийг инээлгэх төрөлхийн авьяас байна гэв.

Тоби уур хилэн хаашаа ч юм сарнин арилахыг мэдэрлээ.

-Та уйгагүй хөдөлмөрлөж чадваас хэзээ нэг цагт алдартай жүжигчин болно гэж бодож байна. Зөвшөөрч байна уу?

Тоби Элист ялдамхан инээмсэглэл бэлэглээд,

-Алив ханцуй шамлан ажилдаа орцгооё хэмээв.

Ням гаригийн өглөө бүр Жозефина ээждээ гэр орноо цэвэрлэхэд нь туслан нуруу тэнийлгэлгүй ажилдаг байлаа. Үд дундад Сисси нөхдийн хамт ирэх охиныг зугаалахаар урьжээ. Хатагтай Цински баячуудын хорооллын хүүхдүүдийн инээж хөхөрсөн дуу цангинасан лимузинд суусан охидын араас хараад, хэзээ нэг цагт Жозефинад таагүй явдал тохиолдох вий. Тэд нар ад чөтгөрийн зулбасганууд. Жозефина ад зэтгэрт бузарлагдах бий дээ? бодов.

Гэгээн Демьентой ярилцах хэрэгтэй, тэр юу хийхийг мэднэ!

Бүлэг 9.

"Экторз уэст"-ийн театрын сургууль нь олонх туршлагатай жүжигчдээс бүрдсэн "Дэлгэц", шинэ сурагчдын суралцдаг "Мастер" гэсэн хоёр бүлэгтэй аж. "Дэлгэц" бүлэгт суралцагсад жүжиг тавьж, тэдний тоглолтыг үзэхээр бүх студийн авьяастан хайгч агентууд ирдэг юмсанжээ. Тобиг "Мастер" бүлэгт оруулсан байна. Элис Теннер "Дэлгэц" бүлэгт ороход бэлэн болтол хагас жилийн зай байна гэж түүнд тайлбарласан ажгуу.

Хичээл сургалт нь Тобид ихэд таалагдах авч, хамгийн гол нь алга ташилт, инээд наргиа, түүнийг гарч ирэхийг харан баясах шүтэн бишрэгчидгүй жинхэнэ урлаг байж боломгүй санагдан эд бүгдээр гачигдана.

Тоби хичээлд сууж эхэлснээс хойш захирал хүүхнийг харалгүй уджээ. Элис Теннер заримдаа "Мастер" бүлэгт оюутнуудын этюд тоглохыг үзэхээр, эсвэл бүтэлгүй амьтдад урам хайрлахаар хаа нэгтээ орж ирдэг байлаа. Тоби заримдаа гудамд түүнтэй тааралдана.

Элисийн тухай бодол толгойд нь байн байн орж ирэх болжээ. Бүсгүй "гял цал хатагтай" гэж нэрлэдэг хүүхнүүдийн нэгэн адил Тобигийн нүдэнд харагдаж, өөрийн гэсэн хэв маягтай, ааш аягтай эл хүүхнийг хүсэх дур хүсэл нь тэсэхийн аргагүй болжээ.

Эхлээд Тобид зэрэмдэг бүсгүй гэж бодохоос нэг нь аягүй санагдаж байснаа сексийн нэг л хачирхалтай сэрлийг амсаад үзэхсэн гэсэн хүсэл оргилох болжээ.

Тэрээр шүүмжлэгч, студийн төлөөлөгчдийн нүдэнд өртчих гэсэндээ тэсгэлгүй хүсэлдээ автан хатагтай Теннерээс "Дэлгэц" бүлгийн оюутнуудын тавьж буй жүжигт дүр өгөхийг гуйж үзэхээр шийдэв.

-Та хараахан болоогүй хэмээн Элис улиг болсон хариултаа урьдын адил давтав.

Хүүхэн амжилтанд хүрэхэд нь саад хийн түүний замд хөндөлдөн байх нь Тобид таалагдсангүй тул тэрээр нэгийг сэдэх шаардлага гарч иржээ.

Жүжгийн анхны тоглолт дээр Тоби өөрийн бүлгийн оюутан зоримог зантай, жүжигчин бөндгөр биетэй, тагжгар Карентэй зэрэгцэн сууж байлаа.

Тэр Карентай хэд хэдэн удаа жүжигт хамт тоглохдоо бүсгүйг дотоож өмсдөггүй, бас түүний амнаас муухай үнэр ханхалдагийг нь мэдэж авчээ.

Карен тэсгэл алдан мунагтаж Тобиг арай л заамдах нь холгүй өвөртөө оруулах гэсэн ч тэрээр юу ч ойлгохгүй байгаа дүр эсгэнэ.

"Ээ гэгээн Тэнгэр минь, түүнтэй хавьтана гэдэг. . ."

Хөшиг нээгдэхийг хүлээх зуур Карен Тобид Лос-Анжелесийн "Таймс", "Гералд экспресс" сонины шүүмжлэгчид, "XX зуун Фокс", "Метро-Голдвин-Мейер", "Уорнер бразерс" студид авьяаслаг жүжигчид сонгон шилж авдаг "тагнуулчдыг" зааж өгөн чалчиж суув. Тэд шинэ

авьяастныг нээхээр ирсэн байхад Тоби үзэгчдийн суудалд мануухай мэт сууж байх ч гэж!

Тоби тайзан дээр харайн гараад өөрийн хошин тоглол-тынхоо нөөц номеруудаасаа аль нэгийг нь тоглон, үзэгчдийг цочирдон гайхуулж, жинхэнэ авьяас гэж юу байдгийг үзүүлэхсэн гэж хорхой нь гозгонон сууж байлаа.

Жүжиг үзэгчдэд таалагдсан ч Тоби түүний ирээдүй, цаашдын амьдрал нь хамаарах хамаг хүсэл мөрөөдлөө биелүүлэхийн тулд хүмүүсийн анхаарлыг татах гэсэндээ галзуу барын аманд гараа хийхээс ч буцахгүй болжээ. Хэрэв зээ "Экторз уэст" нь бусдын анхаарлыг өөртөө татах арга чарга нь мөн л юм бол Тоби чадах бүхнээ хийгээд азаа үзэхэд заавал хагас жил хүлээх нь утгагүй мэт, тэр ч бүү хэл хоёр сар ч гэвчихэд бэрхтэй байх бөлгөө.

Тоби маргааш нь Элис Теннерийн албан өрөөнд орлоо.

-Танд жүжиг таалагдав уу? гэж хүүхэн асуув.

-Гайхалтай! Авьяаслаг сүрхий жүжигчид юм! гэж хариулснаа тэрээр шалдаа буусан янзтай доожоогүйхэн инээхчээ аядаад,

-Чи хараахан бэлэн болоогүй байна гэж хэлж байсныг тань одоо л ухаарч байна гэв.

-Тэдэнд танаас илүү туршлага бий, гэвч та ч гэсэн гарамгай авьяастай хүн дээ. Хэрэв та тэвчиж чадах аваас агуу жүжигчин болж чадна.

-Мэдэхгүй юм даа. Тайзны тухай бодлоо таягдан хаяад даатгалын төлөөлөгч юм уу тиймэрхүү нэг ажилд орсон минь надад дээр юм шиг байна хэмээн Тоби санаа алдан өгүүлэв.

Элис түүн рүү гайхсан харц шидээд,

-Та ингэж ярьж болохгүй! гэлээ..

-Өчигдрийн жүжгийг үзчихээд үү?! Санаанд багтахгүй. . . би хэзээ нэг ингэж... тоглоно гэж бодохоос санаанд багтахгүй...

-Үгүй дээ, Тоби чи чадна. Сургуулиа хаяна гэж санахын гарз, тэгээд ч зөвшөөрөхгүй шүү.

Хүүхний дуунд одоо л нэг Тобигийн эртнээс сонсохыг хүсэн хүлээж байсан хөг аялгуу сонсогджээ. Түүний өмнө оюутандаа сургааль айлдаж буй багш биш, харин эр хүнийг халамжлан сэтгэлийг нь засан тайвшруулахаар оролдож буй эмэгтэй хүн болон хувирав. Зорьсондоо хүрсэн Тобигийн сэтгэл нь ханан, дорой байдлаар мөрөө хавчисхийгээд,

-Би энэ хотод ганцаардаж, хэд гурван үг солих ч хүн алга гэв.

-Та надтай үргэлж уулзаж болно, Тоби. Би таны анд нөхөр чинь больё хэмээн тачаадсан сөөнгө хоолойгоор шивнэв. Залуу эрийн цэнхэр нүд ер бусын гайхамшиг үзэв үү гэлтэй түүнийг ширтэв.

Элис Тобийг үүд тийш эргэн хаалга цоожлохыг таг дуугүй харан зогслоо. Мань эр эргэн ирээд өвдөг сөхрөн Элисийн палаажны хормойд нүүрээ наахад хүүхэн үсэнд нь аяархан хүрэхийг мэдрээд, банзлыг нь зугуухан дээш сөхөн бүдүүлэг хийцтэй төмөр бэхэлгээтэй өрөвдөлтэй зэрэмдэг гуяыг нь ил гаргалаа. Чингээд Тоби аппаратыг нь болгоомжтой мултлан, татуурга оймсыг нь тайлан хонхорхой улаан сорвийг нь энхрийлэн үнсэж, Элисэд хайртайгаа, хүүхэн өөрт нь ямар их хэрэгтэй байгаа тухай зогсолтгүй ярин хөл гуяыг нь зай завсар үлдээлгүй үнсжээ.

Эр хүний мөрөөс болсон хөөрхий зэрэмдэг бүсгүй тачаадан тэсгэл алдахад нь Тоби түүнийг тэврэн авч буйдан дээр хэвтүүлэн дарж авлаа.

Тэр өдөртөө мань эр Элис Теннерийнд нүүж иржээ. Тоби шөнө орондоо хэвтэж байхдаа хувь заяа нь түүнийг айдас хүйдэст зовлонгоо хуваалцах, сэтгэл зүрхээ уудлан ярих анд нөхөр үгүйлсэн золгүй нэгэн ганцаардсан бүсгүйтэй холбосныг ухаарчээ.

Элис Бостон хотод үйлдвэрийн баян эзний гэр бүлд төрсөн агаад эцэг нь охиныхоо нэр дээр банкинд үлэмж их мөнгө хийсэн ч гэлээ түүний төлөө өчүүхэн төдий ч цаг зав гарган анхаарал тавьдаггүй нэгэн байжээ. Элис театрт ухаан тавин дурлаж жүжигчин болохыг хүсч байтал коллежид суралцаж байхдаа мэдрэлийн саа өвчин тусаж бүсгүйн мөрөөдөл бөхөж, эл өвчин нь түүний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн тухай Тобид ярьжээ.

Элистэй сүй тавьсан залуу эр ирээдүйн эхнэр нь үүрдийн зэрэмдэг болсныг мэдмэгц түүнээс нүүр буруулан зугтсан аж. Ингээд Элис сэтгэл зүйч эмчтэй ханилан суутал нөхөр нь хагас жилийн дараа амиа егүүтгэсэн тэр цагаас хойш түүний хайр дурлал, дур тачаал нь торонд хашигдан, дотроо буглаж бөглөрчих шиг болсон байв. Гэтэл идэвхтэй оргилон байсан галт уул дэлбэрэн халуун лав хаяагаа зад татан тал бүр тийш өөрийн замаар урсаж, өтгөн хар хуй салхи намжих тэр нэгэн агшинд Элис ямар их ядарснаа мэдэрч хэцүү бэрх дарамтаас ангижран, бие сэтгэлийн жаргалыг нэгэн зэрэг амсжээ.

Цадаж ханахаа мэдэхгүй Тоби Элисийг дахин дахин шунаглан эзэмдэж хүүхэн ер бусын онго орсон залуу эрийн тачаалд ухаан балартах шахна. Тэр аварга том эдээрээ хүүхнийг цоо хатгачих шахаж, хамаг биеийг нь илэн энхрийлэн янаглах авай.

-Өө хайрт минь, би чамд ямар их хайртай гээч! Тэнгэр минь, ямар жаргал вэ? хэмээн хүүхэн ёолон мурилзана.

Гэвч тун удалгүй Тоби сургуультай хамаатай бүхий л асуудал дээр Элис үргэлжид асга хад мэт хатуу чанд зогсдог болохыг нь ойлгожээ. Тэрээр дараагийн жүжигт дүр өгөхийг, найруулагчтай танилцуулж, студийн захиралуудтай ярьж өгөхийг залбиран гуйсан авч Элисийг ятгаж чадна гэдэг нь хадан уулыг улаэн гараараа нураахтай адил, бүх юм талаар өнгөрчээ.

-Эрт том дүр авах нь бушуу туулай борвиндоо баастайн үлгэр шиг чи ирээдүйгээ баллах болно, хонгор минь! Итгэж үзээрэй.

Анхны сэтгэгдэл хамгийн чухал гэдгийг санаж яв. Хэрэв студийн агентуудад таалагдахгүй

өнгөрөх аваас чамайг үзэхээр дахин хэн ч, хэзээ ч ирэхгүй. Сайн бэлтгэх хэрэгтэй.

Ийнхүү Элис Теннер амнаасаа болгоомжгүй үг унаган, түүний дайсан болжээ. Тэгэхээр энэ хүүхэн түүний эсрэг байх нь ээ!

Тоби уураа барин аль болох эелдэг байхыг хичээв.

-Тэгэлгүй яах вэ, чиний зөв. Гагцхүү надаа тэвчин хүлээх чадал алга. Надад итгэ, би хар амиа бодож амжилтанд хүрэх гэсэн юм биш, чамайг надаар бахархаасай гэсэн юм.

-Нээрээ юу?! Өө Тоби, би чамд хайртай!

-Би ч гэсэн чамд хайртай, Элис.

Тоби өөрийг нь эрхэмлэн хайрладаг хүүхний нүд рүү энхрийлэнгүй харлаа.

Тэр санасандаа хүрэх замд нь хөндөлдөөд байгаа энэ өөдгүй амьтныг залилах арга олохдоо л олно гэдгээ сайтар ойлгожээ.

Тоби хүүхнийг үзэн ядаж догь янхан ч хийж зүрхлэмгүй тийм үйлдэл хийхийг шаардаж түүнийг гэсгээн цээрлүүлэх болжээ. Элис эрхшээлд нь орон, үйлдэл бүхнийг нь зөвшөөрөн байхад Тоби түүний шинэ арга бааш сурсан хавдаа урам хайрлан илэх эзэн мэт загнан хариу илэхэд, хүүхэн амрагтаа таашаал өгсөндөө сэтгэлийн жаргал амсаж байв.

Өөрийгөө танилцуулах түүний төлөвлөгөө биелэж, Элис Теннер "Мастер" бүлгийн оюутнууд ирэх баасан гаригт ахлах курсынхан болон урьсан зочдод зориулан концерт тоглох болсныг дуулгажээ. Оролцсон хүн бүр өөр өөрийн номер тоглох тул Тоби өглөөнөөс үдшийн бүрий хүртэл давган сургуулилжээ.

Чингээд хүсэн хүлээсэн гайхамшигт өдөр нь болжээ. Тоби хичээл тармагц бөндгөр жүжигчин Каренд дөхөн очиж,

-Чи надад нэг тус болохгүй юу? гэж хайнгадуухан асуув.

-Тэгэлгүй яахав, Тоби хэмээн хүүхэн баясан хариуллаа.

Тоби Карены амны муухай үнэрээс зайлсхийн арагш алхам ухраад,

-Хуучин андаараа даажигнах гэсэн юм. Чи Клифтон Лоренсын нарийн бичгийн дарга руу утасдаад Сэм Голдвины туслах ярьж байна гэж танилцуулаад, ноён Голдвин концер-тонд хүрэлцэн ирж залуу, авьяаслаг хошин жүжигчинг ирж үзээч гэж урьж байна. Кассанд түүний билетийг орхино гэж хэлээдхээч гэв.

Карен Тобиг гайхан ширтээд,

-Тэнгэр минь, Теннер авгай мэдвэл намайг цаазаар авна даа! "Мастер" бүлгийн жүжгийн тоглолтонд гадны хүн оруулдаггүйг чи мэднэ шүү дээ!

-Бүх юм зүгээр өнгөрнө, надад итгэ гээд Тоби хүүхний гараас барин, наалинхайтан базаад,

-Чи өнөөдөр завтай юу? гэвэл бөндгөр Карен шүлсээ гүд хийтэл залгиад, амьсгаа нь оволзон,

-Ү... үгүй, хэрэв чи нэг тийш явахыг хүсч байвал завтай гэв. -Тун их хүсч байна. Зүгээр ч нэг явахгүй шүү. Гурван цагийн дараа өөрийн мэдэлгүй болсон Карен бүсгүй Клифтон Лоренсын ажил руу утасджээ.

Асар том танхим оюутан сурагчид, зочдоор пиг дүүрчихсэн, харин Тоби гуравдугаар эгнээний захад суугаа нэгэн эрээс хараа салгасангүй. Тэрээр Лоренс шиг хүн доожоогүй арга залигч нь гадарлан түүний башир арга нь амжилтгүй болох бий гэхээс үнхэлцгээ хагартал айж байтал аз болоход тэгсэнгүй. Лоренс тоглолт үзэхээр хүрэлцэн иржээ Тэгэхээр мань эр сэжиг хар авсангүй бололтой.

Энэ үед тайзан дээр "Цахлай" жүжиг тоглож байв. Тоби энэ бүхэн Лоренсыг залхаан тэрээр гараад явчих вий гэхээс шээс алдатлаа айн дотроо залбирсаар. Арай гэж жүжиг дуусан жүжигчид мэхийн ёслоод тайзны араар орж, Тобигийн гарах ээлж болов.

Ердөө хамар дор хажууханд нь гуравдугаар эгнээнд түүний ирээдүйг шийдэж чадах хүн суугааг эс мэдсэн Элис тэнгэрээс буугаад ирэв үү гэлтэй гэнэт дэргэд нь ирчихсэн түүнд амжилт хүсэн шивнэж байлаа.

Тоби Элист талархан, дахин нэг залбирчихаад мөрөө цэхлэн тайзан дээр гарч, үзэгчдэд хандан хүүхдийн гэнэн инээмсэглэл илгээлээ.

-Хэлло! Намайг Тоби Темпл гэдэг. Сонин нэр байгаа биз? Миний бодлоор үр хүүхэдтэй болмогц бүх эцэг эхчүүдийн тархи толгойд нь есөн шидийн золигийн бодол эргэлддэг байгаа юм. Би ээжээсээ яагаад надыг Тоби гэж нэрлэх болсныг асуусан юм. Гэтэл ээж маань миний хушгыг анх хармагц хажуу айлын нохой тэр даруй санаанд нь орж ирмэгц түүний нэрийг өгчихсэн гэнэ билээ!

Үзэгчид балчир хүүхдийн гэнэн нүдэлсэн хэвтээ хонь үргээхээргүй номхон залууг харан инээдээ барьж чадахгүй хөхөрцгөөв.

Чансаа муутай түүний тоглолт шаардлага хатуутай үзэгчдийг цухалдуулсангүй, харин ч бүр эсрэгээр сэтгэл уяраам Тобиг харсан үзэгчид өхөөрдөн, хамгаалах эл их хайр ивээл нь Тобигийн зүрхийг бүлээцүүлэхэд тэрээр ер бусын баяр баясгаланд автан хөөржээ.

Мань эр ээлж дараалан алдарт хошин жүжигчин, кино одод, жүжигчдийн дүрд хувиран тоглоход, зааланд түүнийг бахдах орилоон, алга ташилтын тасралтгүй нижигнэнэ. Үзэгч олны сэтгэл хөөрөн хөгжиж тачигнасан инээд чих дөжрем сонсогдож ухаан нь ууланд гарчихсан Тоби дүрдээ уусан хөгжиж байтал нэгэн зүйл түүний анхаарлыг гэнэт татсанд тэрээр үзэгчид тийш анзааран харвал Клифтон Лоренс заалаас гарч явах нь тэр.

Бүхэл орой харанхуй манан дунд хөвөлзөн өнгөрлөө.

Концертын дараа хагагтаи Теннер, Тобитой уулзан,

-Чи гайхалтай байлаа, хонгор минь. Би... гэлээ.

Зовхи нь буусан Тоби амраг бүсгүйнхээ царайг харж ч зүрхэлсэнгүй, хэн нэгэн нь түүнийг харан элэг доог хийх болов уу ч хэмээн бодох тэнхэлгүй болжээ. Гагцхүү өөрийн зовлон шаналалтайгаа үлдэн сэмэрсэн сэтгэлийнхээ зовлонг давж гарахыг л хүсэж байлаа. Хамаг хүсэл мөрөөдөл нь өршөөл энэрэлгүй үнэнд гүйцэгдэн нэгэн мөчид сарнин үгүй болжээ.

Тэр өөрийн амжилт олох боломжоо алдсан бололтой. Клифтон Лоренс Тобигийн тоглолтыг дуустал үзэх нь бүү хэл тоглолт шувтрахыг нь ч хүлээсэнгүй. Лоренс авьяастныг таньж илрүүлэхдээ чадварлаг агаад түүний үйлчлүүлэгчдийн олонхи нь жинхэнэ мэргэжилтэн, гялалзсан жүжигчид байдаг билээ.

Хэрэв тэрээр Тоби мэтийн хүмүүстэй ажил хэргийн холбоо тогтоох хэрэггүй хэмээн үзсэн бол... Тоби дотор нь муухайран, гэдэс нь базлахыг мэдрэв.

-Салхинд жаал алхая гээд Элисийг харалгүйгээр доош тонгойн арай ядан хэлэв.

Ингээд тэрээр америкийн алдарт "Коломбиа Пикчерз", "РКО", "Парамаунт" кино студийн дэргэдүүр Вайн, Гауэр гудамжаар дэмийртлээ холхисонд хаалга үүд нь ягштал түгжээтэй ажээ. Тоби цааш эргэн Голливудын цэцэрлэгт гудамж руу эргэн алхаад толгод дээрх анивчин жирэлзэх "Голливудлэнд", "Голливудын орон" гэсэн асар том хаягийг толгой өргөн харав. Үгүй дээ, ийм орон байдаггүй юм, энэ чинь ердөө л ухаанд нь ухна ишиг үхсэн амьтнаас гарах хийрхүү мөрөөдөл, эгэл жирийн зуу зуун хүнийг кино од болон дэлхийд дуурсагдах гэсэн өөрийн мэдэлгүй ухаангүй оролдлого хийлгэхээр өөртөө татагч усны эргүүлэг. "Голливуд" гэгч нь тэр чигээрээ соронз гэсэн үг, ид шид гайхамшиг бүхэн бодит зүйл болдог илбийн орон, бүтэшгүй хий хоосон амлалтаар дурыг татагч урхи, итгэлийн тухай дуу аялан эцэст нь хайр найргүй устгагч хөг аялгуу.

Энэ урт шөнийн туршид Тоби цаашид юу хийж хэрхэн амь зуухаа шийдэхийг оролдон гудамжаар хэсүүлэн тэнэв. Өөртөө итгэх итгэл нь эргэлт буцалтгүй нурж, өөрийгөө юу ч чаддаггүй, хэнд ч хэрэггүй мулгуу амьтан хэмээн бодов. Бүх л амьдралынхаа турш Тоби зөвхөн жүжигчин болж, хүмүүсийг хөгжөөн зугаацуулж тэдэнд баяр баясгалан бэлэглэхсэн гэж эрмэлзэж байсан, гэвч өдгөө эл итгэл найдвар нь угаа мэт замхарч, уйтгарт амьдрал, утга учиргүй хөдөлмөр эрхлэн амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл үйлээ эдлэх торонд суугаа сармагчин мэт амьдрах болох нь. Шалихгүй амьтан, хэнд ч танигдаагүй шалихгүй амьтан. Ийм нэгэн хүн байдаг юм гэж түүний тухай нэг ч хүн мэдэхгүй нь. Тоби ганцаардлын уй гашуун амсуулан ар араасаа хөвөрч байсан саарал өдрүүдийн тухай, хэрэн тэнэсэн нэр усгүй, ялгагдах юмгүй хотуудын тухай, алга ташилт, түүнийг элэглэн инээх, хайрлах, басамжлах хүмүүсийн тухай бодлоо. Тэрээр өнгөрсөн, ирээдүйнхээ тухай, өөрийн үхэл мөхлийн тухай бодоход дотор нь харанхуйлан цурхиран уйллаа.

Тоби үүр цүүрээр Элистэй амьдарч буй цэвэрхэн шаварсан сууцандаа эргэн ирж унтлагын өрөөндөө нойрсож буй эмэгтэйг харан зогслоо. Тэрээр хүүхэн түүний мөрөөдөл хүсэлдээ хүрэх үүд хаалгыг нээгч шидэт түлхүүр гэж ихэд найдаж байсан, гэтэл бүх юм талаар

өнгөрчээ. Эндээс түргэхэн явах хэрэгтэй. Гагцхүү хаашаа тэр билээ? гэдгээ Тоби мэдэхгүй байв. Мань эр хэдийн эрийн цээнд хурч, хорин долоон насыг зооглочихсон байдаг, гэтэл ирээдүй нь? Бүх юм дууссан. Бүх юм.

Тэнхээ нь барагдсан Тоби буйдан дээр лагхийтэл суун нүдээ анин, нойрноос сэрж буй их хотын чимээг чагнан суув. Бүх хотуудын өглөөний дуу нэг л хэвийн адилхан, тэрээр Детройт хотоо дурсав. Ээжийгээ дурсав. Хараач ээж нь гал зуухандаа зогсчихоод алимны бялуу хийхээр гурил зуурна. Тоби тосонд жигнэж буй алимны үнэртэй холилдон ханхлах бүсгүй хүний өвөрмөц үнэрийг мэдрэх шиг санагдан, "Тэнгэр Бурхан чамайг агуу хүн болоосой хэмээн хүсч байна" гэж ээжийнхээ хэлэх үгийг сонсох шиг болов.

Ингээд Тоби гэнэт асар том тайзан дээр ганцаар зогсчихсон, прожекторын хурц гэрэл нүдийг нь гялбуулан байх авч харамсалтай нь өөрийн тоглолтоо таг мартчихсан, нэг ч үг ганхийж чадахгүй зогсож байв. Тоби айдаст автан эргэн тойрон харвал бүх үзэгчид суудлаасаа ухасхийн босч Тоби рүү дайран түүнийг алахаар гүйлдэн ирэх чих дөжрөм нижигнээн сонсогджээ. Тэдний энэрэл хайр нь үзэн ядалт болон хувирч хүмүүс бүслэн барьж авахыгхичээн оролдон,

-Тоби! Тоби! Тоби! гэцгээнэ.

Тоби гэнэт цочин сэрвэл хоолой ам нь хагчихсан, толгой нь тугалгаар цутгасан мэт хүндэрнэ.

Элис Теннер дээрээс нь тонгойн мөрнөөс нь угзчин,

-Тоби! Хурдал! Клифтон Лоренс ярья гэж байна гэв.

Клифтон Лоренсын албан контор Уимшираас чанх урагш Беверли-драйв дахь бага шиг тансаг байшинд байрлах агаад хананд нь францын импрессионист үзэл баримтлагчдын зураг өлгөсөн, эмх замбараагүй уран зураг бүхий хар ногоон өнгийн гантиг ханан зуухны өмнө сийлбэртэй модон сандал, буйдан, уран нарийн хийцтэй жижиг ширээг өнгө үзэмж хослуулан тавьсан байлаа. Тоби урьд өмнө ийм чамин тавилгыг хэзээ ч үзээгүйсэн.

Гуалиг биетэй нарийн бичгийн дарга бүсгүй цай аягалах зуур,

-Ноён Темпл, танд хэдэн саахар хийх вэ? гэлээ.

Ноён Темпл гэнэ үү!

-Хэрэв болгоовол нэг ширхэгийг хийчих.

-За тэгье ээ гээд бүсгүй үл мэдэг жуумалзаад гарч одов.

Нимгэн гангар шаазанд аягалж өгсөн эл цайг чухамдаа Англиас Лоренсод тусгайлан захиалж оруулж ирдэг, дээд зэргийнх гэдгийг Тоби огт мэдсэнгүй, ердөө л гайхалтай сайхан амтыг нь мэдэрчээ. Тасалгаанд байгаа бүхэн бүгд ер бусын тансаг, өрөөний эзэн гавшгай хөдөлгөөнтэй тагжгар эр өөдөөс харсан буйдан сандалд суугаад түүнийг анхааралтай ширтэнэ. Клифтон Лоренс Тобигийн төсөөлж байснаас намхан нуруутай ч гэлээ түүнээс ямар нэгэн, захирах

татах хүч гарч буйг нь илт мэдрэгдэнэ.

-Надыг урьсанд яаж талархалаа илэрхийлэхээ мэдэхгүй байна хэмээн Тоби яриагаа эхлэн,

-Өршөөгөөрэй, заль хэрэглэн таныг хуурах хэрэг гараад!...

Клифтон Лоренс толгойгоо сэгсрэн хөгжилтэй инээгээд,

-Надыг уу? Хуурсан гэж үү? Би өчигдөр Голдвинтэй хооллоод таны авьяастайг үзэж мэдэхээр концертонд орсон, энэ нь ч талаар өнгөрсөнгүй, та ч шазруун зоримог юмаа!

-Гэхдээ та гараад явчихсан! гэж Тоби халаглан хэлэв.

-Хонгор минь, түрс ямар амттайг мэдэхийн тулд заавал бүтэн лаазыг идэх албагүй биш үү? Хормын дараа гэхэд тантай уулзах ёстойг би ойлгосон юм.

Цөхрөнгөө барсан харанхуй шөнийн дараа Тобиг баяр баясгалант сэтгэлийн хөөрөл эзэмдэн толгой эргэм өндөрт гарч, амьдрал урьдын адил түүнд инээмсэглэн. . .

-Танд хамаатай нэг совин татаад байна, Темпл ээ гээд Лоренс толгой дохин,

-Бид амжилтанд хүрнэ. Би аль эртнээс шинэ залуу жүжигчидтэй ажиллан, тэдийг алдарт хүргэвэл зүгээрсэн гэж бодох болсон юм гэв.

Баяр баясгалан гэгч хүчит давалгаа Тобиг хаман авч хөл нь газарт хүрэхгүй хөөрсөн залуу эр үсчин цовхчиж орчлон ертөнц даяар, "Клифтон Лоренс миний агент болохыг зөвшөөрч байна! Лоренс шүү дээ!" хэмээн хашгичихыг хүсч байлаа.

-... тантай ажиллана, гэхдээ нэг болзолтойгоор гээд Лоренс үргэлжлүүлэн,

-Бүх зүйл дээр миний зааврыг дагах ёстой. Би төрхгүй аашлахыг тэвчихгүй! Ганц л удаа үгнээс зөрөх аваас бидний хооронд бүх юм дуусах болно, ойлгов уу? гэв.

-Ойлголоо, эрхэм ээ. Тэгэлгүй яахав хэмээн Тоби яаран толгой дохив.

-Хамгийн гол нь та чанд суралцах ёстой. Та тэсвэрлэхийн аргагүй муу зүйл хийвэл бүх юм өнгөрнө. Хошин жүжиг хамгийн доод төрөл юм шүү хэмээн инээмсэлэн хэлэв.

Гэнэт Тобигийн амьсгаа нь давхцаад ирлээ. Тэгэхээр Клифтон Лоренс түүнтэй хамтран ажиллах гэсэндээ биш, харин ажил руу нь бодлогогүй зан гарган утасдсаных нь төлөө даажигнахаар түүнийг урьжээ. Тэр...

Тагжгар агент яагаад ч юм сүүлчийн цохилт өгөх гэж яарсангүй. Үүний оронд түүнд,

-Өчигдөр би сайн дурынхны концерт үзсэн, та ч тэдэнтэй адилхан сонирхогч! гэчихээд тэрээр босон фрөөн дотуураа холхиж эхлэв.

-Таны чадал чансааг, од болоход юу дугаад байгааг тань би тайлбарлахыг хүсч байна.

Тоби хөдөлж чадахгүй айн хөшчихжээ. -Таны тоглолтоос чинь эхлэе. Дэндүү завхай байна!

-Таны ээв өө, эрхэм ээ} тайзан дээр тийм ч зохимжгүй...

-Цааш нь. Танд ямар ч урлаг алга.

Тоби өөрийн эрхгүй нударгаа зангидав.

-Гэвч үзэгчид, минийхээр бол...

-Цааш нь, та зөв хөдөлгөөн хийж чадахгүй, тээрэм адил гараа сарвагануулж байна.

Тоби юу ч дуугарсангүй.

Агент түүнд дөхөн ирээд Тобигийн дотор санааг нь уншиж байна уу гэлтэй дээрээс нь доош нэвт шувт ширтээд, намуухан дуугаар,

-Хэрэв тэгтлээ муу байгаа, бол энд юу хийж байгаа билээ гээд өөрөөсөө асуугаач? Танд заяасан ийм чухал эрдэнэ мэт чадварыг мөнгөөр худалдаж авч болохгүй гэж ойлгосон учраас таныг урьсан юм. Үзэгчид тайзан дээр таныг дөнгөж үзээд гар сунгаж байна. Тэдний хайр ивээлийг ингэж ч эзэмдэхгүй, тэд таныг зүгээр ч нэг сайшаагаагүй. Энэ юу гэсэн үг болохыг ойлгож байна уу?

Тоби цээж дүүргэн гүн амьсгаа авлаа.

-Надад тайлбарлаад өгөөч.

-Төсөөлж байгаагаас чинь ихийг тайлбарлаад өгье. Дээд зэргийн зохиомж, сайн найруулагч байхад таа агуу жүжигчин болно гэх нь тэр.

Тоби Клифтон Лоренсын ид шидэт үгсийг бахдалтайгаар сонсоод сэтгэл нь дахин хөдлөн энэ хормоос эхлэн амьдралын утга учир бүхэн нь биелэн, аль хэдийнэ ээжийнх нь амласнаар дэлхийд алдартай од болсон мэт санагджээ.

-Жүжигчин хүний, ялангуяа хошин жүжигчний амжилтанд хүрэх түлхүүр нь түүний өөрийн онцлог нь. Түүнийг худалдаж, дуурайж болохгүй, гагцхүү түүнтэйгээ төрдөг юм. Та азтай хүн, залуу минь, ийм азтай төрөх нь зуун жилд нэг удаа тохиодог юм гэснээ алтан цагаа хяламхийн харснаа үргэлжлүүлэн,

-Би бүгдтэй тохиролцсон, өнөөдөр 14 цагт 0' Хэнлон, Рейнжер хоёртай уулзана. Эд хошин шогийн ертөнцдөө шилдэг зохиолчид нь тэд хамгийн алдартай хошин шогчдод ажилладаг юм гэв.

-Надад тийм их мөнгө... гэж Тоби сандран бөвтнөлөө.

Клифтон Лоренс хайнгадуухан гараа савчин,

-Бүү санаа зов, хонгор залуу минь. Эхний шагналаа авсныхаа дараа, хожим төлнө биз хэмээв.

Тоби Темплийн явснаас хойш Лоренс түүний тухай бүлтгэр цэнхэр нүдэлсэн гэм хоргүй царайг бодон инээмсэглэсээр суужээ.

Клифтон шинэхэн жүжигчинтэй сүүлчийн удаа ажил хэргийн холбоо тогтоосноос хойш олон жил өнгөрчээ. Түүний үйлчлүүлэгчид нь бүгд нэртэй хүмүүс байсан тул шилдэг студид тэдэнтэй байнгын гэрээ байгуулахыг санал болгоно. Гэвч агент эр ажлаасаа ийм баяр баясгалан амсалгүй уджээ. Урьд нь өдөр бүр түүний үйлчлүүлэгчид тулалдаанд ялсан мэдээ дуулдаж байв. Лоренс туршлагагүй, шинэ залууг авч дээд зэргийн жүжигчин болгож чадах бол буу? гэсэн эсэргүүцэлтэй тулгаран энэхүү амаргүй даваа нь түүнийг олон сайхан агшинтай учруулах болно доо. Залуу түүнд үнэхээр таалагдаж байлаа.

Уулзалт Лос-Анжелесийн баруун зүгт орших Пикогийн цэцэрлэгт гудамжин дахь "ХХ зуун Фокс" студэд О' Хэнлон, Рейнжер нарын өрөөнд боллоо. Тоби, Клифтон Лоренсынхтай адил тансаг орчинд орох юм бодтол зураг авах талбайн цаахна ягтаа тулсан эмх замбараагүй нэгэн өрөөнд орж явчихав.

Сунасан нэхмэл хантаазтай дунд эргэм насны салан палан нарийн бичгийн дарга бүсгүй Тобиг ханыг нь ногоон тосон будгаар будсан заваандуу өрөөнд оруулав. Уйтгар төрүүлсэн хананд дартс тоглоомын бай, "ИРЭЭДҮЙ ӨӨД ХАР" гэсэн бичигтэй пайз өлгөсөн нь бага зэрэг амь оруулан сэргээх мэт санагдавч сүүлийн үсэг нь зайгүйдсэнээс дээр дээрээс нь давхарлан биччихжээ.

Эвдэрхий туузан хөшигний цаанаас нэвглэн орж ирэх нарны туяа самалдаг болтлоо элэгдсэн хүрэн хивсэн дээр тусна. Зовлон үзсэн бичгийн ширээн дээр гар бичмэл, харандаа, ууж дуусгаагүй кофены үлдэгдэлтэй цаасан аяга хөглөрнө.

-Хэлло, Тоби! Замбараагүй байгааг минь уучлаарай. Үйлчлэгчийн маань амралтын өдөр! гэж өрөөний эздийн нэг залуу эр мэндлээд,

-Намайг О' Хэнлон гэдэг. Харин энэ хүнийг. . . түүнийг хэн гэдэг. . гэв.

-Рейнжер.

-Өө тийм л дээ, саналаа. Рейнжер.

О' Хэнлон аварга том махлаг биетэй, эвэр хүрээтэй том шилний цаанаас сүүмийсэн хараа муутай нүдтэй, харин Рейнжер нь эсрэгээр жижигхэн, туранхай биетэй, тэд хоёул гуч эргэм настай, арваад жил хамт ажиллан жүжигчдийн хүрээнд ихээхэн нэртэй болжээ.

Зочин залуу дарвайн инээгээд толгой дохин,

-Миний ойлгож байгаагаар бол та нар надад хошин шог зохиол бичиж өгөх нь ээ дээ, залуус аа гэлээ.

О' Хэнлон, Рейнжер хоёр харц солилцоод Рейнжер,

-Лоренс таныг Америкийн шинэ секс-симбол болно гэж үзэж байх шиг байна. Алив таны юу чаддагийн үзье! Бэлэн номер байна уу? хэмээн даруухан өнгөөр хэллээ.

-Тэгье л дээ гэж Тоби хариулав.

Тэрээр Клифтон тоглолтыг нь хэрхэн үнзлснийг санавч өөртөө итгэх итгэл нь хаашаа ч юм замхран алга болчихов.

Хоёр зохиолч буйдан дээр гараа зөрүүлэн элгээ тэврэн сууцгаав.

-Алив биднийг нэг хөгжөөгөөдөх! гэж О' Хэнлон хүслээ.

Тоби хоёр эрийг гайхан харж,

-Энд үү? хэмээн асуув.

-Танд юу хэрэгтэй байна гэж? Симфони найрал хөгжим үү? гэж Рейнжер ёжтой асуугаад О' Хэнлонд хандан,

-Хөгжмийн хэлтэс рүү утасдаад ирж чадах уу асуугаадах гэлээ.

"Новшийн амьтад байх шив. Би та нарт үзүүлээд өгнөө, гайгүй" Тэрээр сая л нэг юм тэдний юу сэдсэнийг нь ойлгожээ. Тэд шалгасан дүр үзүүлчихээд Клифтонд, юунд ч тохирохгүй этгээд юм гэж хэлэх нь л дээ. За яах вэ, тэдэнд тэгж доромжлуулахгүй шүү!

Чингээд тэдэнд хуурамч инээмсэглэл илгээгээд алдарт хошин шогч Эббота, Костелло хоёрыг дууриан элэглэж,

"-Хөөе, Лу чамд ичгүүртэй биш байна уу? Чи яг л тэнүүлчин аятай харагдаж байна. Чи яагаад ажилд орохыг хүсэхгүй байгаа юм бэ? !

-Би ажилтай л байгаа шүү.

-Тийм үү, ямар ажилтай болоо вэ?

-Ажил хайх.

-Үүнийгээ ажил гээд байгаа юм уу?

-Тэгэлгүй яах вэ. Бүхэл өдөржингөө, өглөөнөөс орой хүртэл ажилтай, тэгээд орой яг 7. 00-д гэртээ оройн хоолондоо ирнэ."

Хоёр зохиолч Тобигоос нүд салсалгүй ширтэн, сонжин дүгнэлт хийн хэсэг сонсож байснаа түүнийг өрөөнд эгээ л байхгүй байгаа мэт өөр хоорондоо ярьж эхлэв.

-Тэр биеэ авч явж чадахгүй байна.

-Яг л мод хөрөөдөж байгаа шиг гараа савчиж байна.

-Түүнд модчины тухай ганц хүний яриа бичиж өгөх үү?

-Дэндүү мэрийгээд байна.

-Үг нь үү! ЁСТОЙ хар дарсан зүүд шиг.

Тобигийн уур нь хүрэн, улам цухалдсаар. "Энд үлдэн хоёр солиотны доромжлохыг сонсох албагүй! Тэдний бичихчээн аядсан зохиолч дээ, тэнэг үгний цуглуулга л байгаа биз!"

Ингээд цаашид эдний чалчаа үгийг тэсвэрлэх аргагүй болж уурандаа чичигнэсэн хоолойгоор,

-Та нар надад хэрэггүй, муусайн хүний оронцогнууд! Зочилсонд баярлалаа хэмээн бахирчихаад үүд рүү хар хурдаараа гүйлээ.

Рейнжер үнэн голоосоо гайхан харайн босоод,

-Хөөе! Чи яав аа! гэв.

Тоби уурласандаа байж ядан огцом эргэн харж,

-Та нар ойлгохгүй байна, тийм үү? Та нар... та нар...

Тэр хэлэх үг олдсонгүй, нулимсаа арайхийн хүчлэн барьлаа.

Рейнжер тээнэгэлзэн О' Хэнлоныг ширтсэнээ,

-Бид түүнийг гомдоосон бололтой хэмээв.

-Ээ Бурхан минь!

Тоби биеэ эзэмдэхийг хичээн, гүн амьсгаа аваад,

-Та хоёр сонсож бай! Би нар нарт таалагдах үгүй нь надад огт падгүй, гэвч. . .

-Би зүгээр л сонжсон юм аа! хэмээн О' Хэнлон дуу алдав.

-Бид чамайг аятайхан залуу гэж бодож байгаа шүү! гэж Рейнжер хэллээ.

Яах учраа олохоо байсан Тоби тэднийг ээлжлэн харав.

-Юу? Та нар, ямар зан гаргаснаа, яг л...

-Тоби, чиний юу болохгүй байгааг мэдэх үү? Чи өөртөө ердөө ч итгэлгүй байна! Тайвширч үз. Мэдээж чи их суралцах хэрэгтэй, нөгөө талаас нь хэлэхэд чи Боб Хоуп байсан бол энд сууж

байх гүйсэн.

-Яагаад гэдгийг мэдэж байна уу? Боб өнөөдөр Кармелд байгаа гэж О' Хэнлон үг хавчуулав.

-Гольф тоглож яваа? Чи гольф тоглодог уу? гэж Рейнжер сонирхов.

-Үгүй.

Хоёр зохиолчийн бүр урам хугарчээ.

-За тэр харав уу, тэгэхээр гольфийн тухай хошигнол хийж таарахгүй нь. Чөтгөр ав гэж!

О' Хэнлон харилцуур авлаа.

-Кофе аваад ир, дуулав уу, гэснээ Тобид хандан,

-Хичнээн хүн агуу хошин жүжигчин болохыг хүсдэгийг мэдэх үү? гэж асуувал Тоби толгой сэгсэрлээ.

-Одоохон хэлээд өгье. Үүн шиг амархан юм хаа байх билээ. Гурван сая долоон зуун хорин найман сая хүн. Шөнийн цагаар гарч ирж язганалддаг жоом шиг. . . Гэвч зөвхөн ганц нь оройд нь хүрч чадна. Бусад нь бүх л насан туршдаа балчиг намагт амьдрах болно. Хошин шог нь тун нарийн урлаг. Жинхэнэ инээд бэлэглэнэ гэдэг тун хүнд, хошин элэглэгч, хошин жүжигчин байх нь хамаагүй эрч хүч шаарддаг ажил. -Ялгаа юу байна?

-Асар их ялгаатай. Хошин элэглэгч нь шог яриа ярьдаг бол, хошин жүжигчин нь инээдэмтэй жүжиглэл хийдэг юм.

-Аз нь шовойсон хошин элэглэгч нь амжмлтанд хүрч байхад харин нөгөө нэгийг нь яагаад ялзарсан лоолиор шиддэг юм бол гэж чи хэзээ ч юм уураг тархиндаа тунгаан бодож үзсэн үү? гэж зохиолч Рейнжер нухацтай гэгч нь асуув.

-Магадгүй, текстнээс бүх юм шалтгаална биз хэмээн Тоби зохиолчдод зулгуйдан хариулав.

-Ээ нохой долоо гэж! Сүүлийн үеийн шилдэг хошин үгийг Аристофан бодож олсон юм. Гэхдээ сэдэв нь үндсэндээ нэг. Жорж Бернс бусад элэглэгчдийн ярьсан бүх онигоог тоть мэт нэгд нэгэнгүй давтаж байгаа атлаа хавьгүй их амжилтанд хүрч байна. Яагаад гэдгийг мэдэх үү? Бернс бол өөрийн гэсэн онцлогтой бие хүн.

Өөрийн гэсэн онцлог гэнэ ээ! Клифтон Лоренсын хэлзэд байсан онцлог шив!

-Өөрийн эрхэм онцлогоороо эхлээд, дараа нь түүнийгээ ааш авир болгох хэрэгтэй. Хоулыг аваад үзье л дээ. Мань эр тайзан дээр гарч ирээд Беннигийн хошин яриаг ярьж алдвал үзэгчид түүнийг шоолж исгэчиж гарна. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл Хоуп өөрийн гэсэн дүртэй учраас үзэгчид түүнээс хурц ухаан шаардсан хошигнолыг хүсэн хүлээдэг юм. Хоуп бусдын дутагдлыг гярхай ажиглагч хотын ёжтой ихэмсэг залуугийн, ухаантай хүмүүсийн дүрийг бүтээсэн. Харин Жек Бенни бол тэс өөрөө Хоупын эсрэг дүрийг бүтээдэг. Ах дүү

Маркс, Фред Аллен хоёр ч мөн адил. Тэгвэл одоо чамайг аваад үзье л дээ. Чиний гол асуудал юу вэ гэдгийг мэдэж байна уу? Чи бусдаас чимх чимхийг авч, алдарт хошин шогчдыг элэглэж байна. Бүх л насаараа тарчигхан баар клубээр явна гэвэл энэ ч дажгүй л дээ. Хэрэв зээ бие хүн больё гэж бодож байгаа бол өөрийн

гэсэн дүрээ бүтээх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл чамайг тайзан дээр гарч ирмэгц ам нээж амжаагүй байхад чинь тэдний өмнө өөр хэн ч биш, гагцхүү Тоби Темпл зогсож байгааг үзэгчид ойлгох ёстой! Мэдэв үү?

-Мэдлээ.

-За тэгэхээр чамд ямар эрхэм чанар байгааг чи мэдэх үү? Бусдыг байлдан дагуулах хоншоор байна даа. Кларк, Гейблд дурлачихаагүйсэн бол даруй чамтай сээтэгнэхсэн. Чамд ямар нэгэн дур булаах гэнэн зан байна. Хэрэв бүх юм о кэй болбол сая саяар нь өвөртлөж дөнгөнө шүү гэж О' Хэнлон хэлэхэд,

-Ус үзээгүй хормой шуув гэгчээр саяд санаархаад яахав хэмээн Рейнжер үг хавчууллаа.

-Бусдад заяагаагүй их юм чамаас гарна. Сүмийн найрал дууны эвэр бүрээч бяцхан хүү ёсгүй хараал урсгахад томчуул яагаад инээдгийг мэдэх үү? Мань хүүг хэлж байгаа хараалыхаа утгыг ойлгодоггүй гэдэгт тэд итгэдэг юм. Чи бидэн дээр хүрч ирээд өөртөө шог хошин зохиомж бичиж өгөх харчуул мөн үү гэж асуусан уу? Үгүй ээ. Манайх номын мухлаг биш, онигоо ч наймаалцдаггүй. Бид чиний тоглох баатрыг бүтээх л гэж энд суугаа. За юу гэмээр байна даа, залуу минь?

Тоби зохиолчдыг ээлжлэн хараад жаргал дүүрэн инзэмсэглэлээр инээгээд,

-Тэгэхээр ажилдаа ханцуй шамлан орцгоох шив! гэлээ.

Тоби өдөр бүр Лоретт Янг, Бетти Грейбл, Виктор Матьюр гээд олон арван кино ододтой нүүр тулан учрах боломжтой студийн томоохон зоогийн танхимд О' Хэнлон, Рейнжер хоёртой хамт хооллох болов. Тэдний нэг хэсэг нь нийтийн дунд сууж байхад зарим нь төв заалтай зэрэгцээ орших захиргааныханд зориулсан жижгэвтэр танхимд хооллох ажээ. Тоби бүхний танил болсон оддыг харах тун дуртай. Удахгүй, тун удахгүй тэдний нэг болчихоод үзэгчид гарын үсгийг нь гуйх болно. Одоо Тобид хэн ч саад болон зогсоож чадахгүй, гагцхүү алдар нэр хайр хүндлэл түүнийг хүлээж байгаа.

Сонин мэдээ сонсон сэтгэл нь хөөрсөн Элис Теннер хүрч ирэн,

-Чамайг амжилтанд хүрнэ гэдгийг мэдээд байсан юмаа, хонгор минь. Би чамаар бахархаж байна гэвэл мань эр инээмсэглээд, юу ч дуугарсангүй өнгөрчээ.

Бүтээх "дүр" нь ямар байх талаар О' Хэнлон, Рейнжер нар шаггүй маргалджээ.

-Тэр хал үзсэн, хүмүүстэй эвзэ амархан ололцдог, гэвч алхам тутамдаа бүтэлгүйтдэг.

-Энэ хүн маань хаана ажилладаг байх билээ? гэж Рейнжер асуув.

-Энэ нөхөр ээжтэйгээ амьдардаг. Нэгэн бүсгүйд дурлах авч, гэрлээд гэрээсээ явахаасаа айдаг. Сүй тавиад таван жил болж байгаа.

-Үгүй арав байсан нь дээр, тэгвэл хөгтэй биш үү.

-Яг зөв! Арав гэчихье! Ийм хүнийг ээж нь ерөөхөөс өөр яахав. Хүү нь хуримын тухай яриа дэлгэх тоолонд ээжийнх нь ээлжит өвчин хөдөлдөг ажээ. "Тайм" сэтгүүлийн газраас ээж рүү нь Үргэлж утасдаж, анагаах ухааны сонин хачин юутайг сонирхож асуудаг.

Урьд өмнө мэргэжилтнүүдтэй хэзээ ч ажиллаж үзээгүй Тоби тэдний зөвшилцөхийг сонсон тэдний шүүмжийн бай нь өөрөө болж байгаадаа сэтгэл нь татагдан сууна. Зохиолч эрчүүд Тобид зохиомж бичих гэж гурван долоо хоног зарсны эцэст бичсэнээ үзүүлбэл анх удаагаа жинхэнэ сайн материал үзсэн тэрээр ихэд догдолсон ажээ. Тоби хэд хэдэн санал гаргахад зохиолчид бага сага нэмэлт хийн, мөн нилээдгүй мөр хасчээ. Тоби Темпл тоглолтонд бэлэн болж байтал, нэг өдөр нь Клифтон Лоренс түүнийг дуудуулан,

-Бямба гаригийг орой "Боулинг болл"-д ажилла гэх нь тэр.

"Сайро" эсвэл "Трокадеро"-д ажиллах гэрээ хэлцэл хийх юм хэмээн бодож байсан Тоби цочирдон агентыг гайхан ширтэв.

-"Боулинг болл" гэж... юу байдаг юм.

-Уэстерт-авенюд байдаг нэг жижигхэн клуб гэхэд нь урам хугарсан Тоби,

-Ийм газрын тухай огт сонсоогүй юм байна гэж хэгжүүрхэв.

-Тэд ч гэсэн чамайг танихгүй. Энэ чинь их учиртай, хонгор минь. Хэрэв алдаж балрах аваас энэ тухай хэн ч мэдэхгүй өнгөрнө.

Тэгэлгүй яахав, мэдээж Клифтон Лоренсоос бусад нь.

"Боулинг болл" нь орон даяар хаа сайгүй тархсан хэдэн арван жижигхэн бохир баартай усны дусал мэт адилхан азгүйчүүдэд зориулагдсан угаадасны нүх гэлтэй.

Тоби хотын захын иймэрхүү бяцхан бааруудын босгыг элээн мөн ч их тоглосон доо Энэ мзтийн "клуб"-ууд ихэнхдээ хижээл насны ажилчид, дархчуул, үдэш бүр найз нөхөдтэйгээ ёслолын уулзалт хийгчдэд зориулагддаг ажээ. Эндхийн баар танхимд бархирч чарлан, огтор банзал, хэрээс хэтэрсэн ухлаадастай цамц өмссөн ядарсан үйлчлүүлэгчдийн хөл гарыг нь самардаж, хямд виски эсвэл аяга пиво тулган завхай хошигнол ярьж, өөрийн дураар авирлаж болдог газар. Жүжигчид танхимын тэртээ буланд мөнхийн уйтгартай гурвал хөгжимчдийн тоглолтон дор бяцхан тавцанцар дээр тоглодог ажээ.

Энэ орой эхлээд нэрт дуучин эр, дараа нь акробатчид, эцэст нь амьдын төдий наж могойтой хамтран тайчих урлаг үзүүлэгчийн тоглолт болов.

Тоби тавцанцараас холгүй жижигхэн ширээний ард Клифтон Лоренс, О' Хэнлон, Рейнжертэй

хамт сууж байлаа. Тэрээр жүжигчдийн тоглохыг ажиглан, үзэгчдийн сэтгэл санаа ямархан байгааг тааварлахыг хичээн сууснаа,

-Пивоны торхонцорууд хэмээн тэрээр тоомжиргүй гөвтнөв.

Клифтон хатуухан шиг үг хэльюү гэснээ Тобиг хараад залуу эр үнхэлцгээ хагартал айж байгааг нь анзааран биеэ барьжээ. Агент эр Тобийг иймэрхүү газар олонтоо тоглож байсныг нь мэдэх хэдий ч энэ удаа урьдынхаас тэс өөр байх болно. Залуу эрийн өмнө хатуухан сорил хүлээж байгаа гэж бодов.

Лоренс намуухнаар,

-"Пивоны торхонцорууд"-ын зүрх сэтгэлийн эзэмдэж чадвал, үнэтэй оргилуун дарсанд дурлагчид чиний жүжиг дээр түрэн орж ирэх цаг ойртлоо гэсэн үг. Тоби энэ хүмүүс үүр цүүрээс үдшийн бүрий хүртэл нуруугаа бөгтийтөл хөдөлмөрлөдөг тул амрахаар нааш ирэхдээ олсон цент бүрээ дэмий үрэхийг хүсдэггүй улс. Эдэн шиг улсыг инээлгэж чадвал бусдыг нь инээл-гэж чадах болно гэжээ.

Яг энэ агшинд зарлагч уйтгартай дуугаар тоглолтыг нь зарлахыг Тоби сонсчээ.

-Алив хөө, тэдэнд үзүүлээд өг, эр бар минь! гэж О' Хэнлон ерөөлөө.

Тоби бослоо. Тэрээр тайзан дээр аюулыг мэдрэн айж буй араатан аятай түгшүүртэй, сэрэмжилсэн харцаар үзэгчид тийш харж зогсоно.

Үзэгчид толгой бүр нь өөр хоорондоо адилгүй олон толгойт аймшигт мангас болон хувирчээ. Ийм л луусыг инээлгэх хэрэгтэй болсонд Тоби гүн амьсгаа авлаа.

"Бурхан минь, би тэдэнд таалагдаасай билээ!" хэмээн дотроо залбираад ярьж эхэллээ.

Гэвч хэн ч түүнийг сонссонгүйгээр барахгүй, нэг ч хүн инээх нь байтугай жуумалзсангүй.

Тоби духан дээгүүр нь хөлс бурзайгаад ирэхийг мэдэрчээ. Ингээд дууслаа. Бүх юм өнгөрчээ. Уруул ам нь наалдчихаа юу гэлтэй инээж чадахгүй байгаа ч гэлээ үг нь усны урсгал адил ундарч шуугиан согтуу бархирааг дарахыг хичээх авч үйлчлүүлэгчдийн анхаарлыг татна гэдэг гонжийи жоо бололтой, чухамдаа хөгжмийн аясаар муригнан бүжиглэх нүцгэн бүсгүйчүүд л энд хэрэгтэй ажээ.

Бямба гариг бүр энэ тавцанцар дээр гойдын авьяасгүй хошин жүжигчид хэр чадлаараа өөрийн уран хошин үгээ цацдаг авай.

Тоби үзэгчдийн хайхрамжгүй царай зүсийг харан үргэлжлүүлэн ярьсаар байлаа. Тэрээр Лоренс, зохиолчдын зүг хулгай нүдээр ажвал тэд илтэд сэтгэл зовсон янзтай суухыг харсан ч зогссонгүй. Танхимд үзэгчид биш, харин өөр хоорондоо зовлон жаргалаа хуваалцан ярилцах хүмүүс сууж байлаа. Иймэрхүү амжилт гаргавал Тоби эндээс мянган бээрийн тэртээд зугтах

эсвэл газрын гаваар ч орсон яахав болжээ. Айсандаа хоолой ам нь хатаж, үг ч гарахаа

больжээ. Тоби нүдний булангаараа клубын эрхлэгч хөгжимчид рүү очиж явахыг харж амжив. Тэрээр мулгуу хошин шогчийн амыг барих тушаал өгөхөөр шийдсэн болтой. Тобигийн алга нь хөлсөндөө норж, дотор гэдэс нь мушгиж, гэнэт гуяыг нь дагаж халуун шээс дусаллаа. Ичиж үхэх шахсан Тоби текстээ хольж хутган бантсандаа Лоренс болон дагуул эрчүүдийн зүг харж зүрхэлсэнгүй. Клубын эрхлэгч хөгжимчид тийш очин намуухан дуугаар нэгийг шивнэхэд нөгөөдүүл нь Тобигийн зүг харснаа толгой дохив. Гэвч Тоби ажиггүй үргэлжлүүлэхийг хичээсээр байгаа хэрнээ зөвхөн энэ бүхнийг даруйхан дуусгачихаад хаашаа ч хамаагүй зугтан нуугдахыг л хүснэ.

Яг энэ үед Тобигийн эгц өмнө ширээнд суугаа хижээл насны эмэгтэй түүний хошин үгийг сонсон хи хи хэмээн инээхэд эмэгтэйн дэргэд суугаа хүмүүс таг дуугүй сонсоцгооно. Тоби дэмийрч байна уу гэлтэй хошин яриагаа эцэс төгсгөлгүй цацалж, нүдийг нь бүрхэх саарал манантай тэмцээр байв. Тэгтэл инээх дуу алаг цоог сонсдон байтал хэн нэгэн бүр тас тас хөхөрчээ. Эл эмэгтэйн зэргэлдээх ширгээнд суусан хүмүүс мөн хөхрөлдөцгөөж үзэгдэв.

Гэнэт энд тэндгүй сонсдож байсан өнөөх орилоон намжин, яриа хөөрөө зогсож, харин инээлдэх дуу улам бүр чангарлаа. Уйтгарлаж байсан түншүүд нь ч үзэгч болон хувирчихсан хөхрөлдөн сууна. Тоби тэднийг, бүгдийг ялчихлаа! Тэрээр үзэгчдэд таялагджээ, чөтгөр ав гэж! Ажилчин, хэрцгий амьтдаар дүүрэн, хир буртгандаа баригдсан хямдхан клубт болж байгаа нь огтын падгүй, хамгийн гол нь зөвхөн тэдний баяр баясгалан, хөгжилтэй инээд, Тобиг давалгаалан бөмбөчүүлэх тэдний хайр энэрэл. Эд нар үүн шиг хошин жүжигийг амьдралдаа энэ ноохойдоо байтугай, ер нь өөр хаа нэгтээ сонсоогүй нь лавтай.

Тэд алга ташин хашгичиж, чих дөжиртөл шүгэлдэн заалыг золтой л нураачихсангүй! Үзэгчид төрөлхийн авьяас билэгтэн өмнө нь байгааг огт ойлгосонгүй. Харин Лоренс болон зохиолчид, бас Тоби Темплд ч гэсэн бүх юм илт боллоо.

Бурхан тэнгэр өөрийн амлалтаа биелүүлэх нь энэ ажгуу.

Гэгээн хутагт Демьен дүрэлзэх бамбараар Жозефинын царайг гэрэлтүүлээд,

-Хамгаас хүчит Бурхан минь, энэхүү нүгэлт хүүхдэд чөтгөр шулмын хорлол нүүрлэжээ!
хэмээн хүнгэнүүлж гарахад хурсан сүсэгтэн олон нэгэн дуугаар,

-Аминь! хэмээн хүндэтгэлтэйгээр залбирцгаалаа. Жозефинад дүрэлзэн буй бамбар нүүрийг
нь долоон халуун элчээрээ төөнөхийг мэдэрч, Демьен хутагт үргэлжлүүлэн,

-Нүгэлт охинд шүглэсэн чөтгөр шулмыг нь үлдэн хөөхөд туслаач, агуу Бурхан тэнгэр минь!
Бид залбиран түүнийг зүрх сэтгэлээс нь хөөж гарган хараал ширээлдээ живүүлэх болно!

Хэн нэгэн Жозефинаг барьж аван хүйтэн устай түмпэнд нүүрээр нь дүртэл Дээд тэнгэрээс
аврал эрэн залбирагсдын дуу гэнэт тасран шөнийн нам гүм мэт дуулдахаа байлаа. Охин бага
ч болов агаар амьсгалахыг хичээн амь тэмцэн оролдож, ухаан алдахын даваан дээр дээш
татаж гаргахад Демьен хутагтын,

-Бурхан минь, агуу хайр энэрэлд тань талархая! Охин аврагдлаа! Тэр аврагдлаа! хэмээн

тунхаглан зарлах сонсдов.

Жозефинагаас бусад сүсэгтэн олон баярлан хөгжицгөөхөд, харин охины толгойн өвчин улам бүр нэмэгдэн тархи нь заадсаараа салчих нь уу гэлтэй янгинаж эхлэв.

Бүлэг 10.

-Би чамайг Лас-Вегас хотод ажиллах гэрээ байгуулаад, Дик Лэндрийг туслуулахаар тохирчихлоо. Тэр миний мэдэх шөнийн клубын эрхлэгчдийн хамгийн шилдэг нь.

-ЁСТОЙ гайхалтай! Ямар зочид буудагд буух вэ? "Фламинго" -д уу? "Тандерберд" уу?

-"Оазис"-т.

-"Оазис"-ий?

Тоби даажигнаж байна уу гэж бодоод Клифтоныг итгэлгүйхэн харав.

-Би хэзээ ч...

-Мэднэ ээ гээд Лоренс жуумагнаад,

-Энэ тухай чи амьдралдаа төсөөлж ч байгаагүй биз. Тэд ч гэсэн чиний тухай огт дуулаагүй. Бүгд шударга байгаа биз дээ. Би л чамайг гээгүй бол хэнд ч шинэхэн хошин жүжигчинг урих бодол төрөхгүй дээ. Тэд Тоби Темпл нүүр улайлгахгүй шүү гэсэн үгэнд минь итгэцгээсэн юм гэв.

-Санаа бүү зов, бүх юм сайн сайхан болно.

Тоби явахынхаа өмнө Элис Теннерт уг сониноо дуулгалаа.

-Чамайг алдартай жүжигчин болно гэдгийг би мэднэ. Чиний од гийх цаг болжээ. Үзэгчид чамаар бахархах болно, хонгор минь гээд Элис хүзүүнд нь асан дүүжлэгдээд,

-Бид тэгээд хэзээ явах вэ? Хошин урлагийн суут залуугийн анхны тоглолт дээр ямар даадшнз өмсвөл дээр вэ? гэж сэтгэл зовнин асуулаа.

-Би чамтай хамт дуртайяа явахсан, Элис. Гэвч гачлантай нь би шинэ жүжигт бэлтгэж өдөр шөнөгүй ажиллана хэмээн Тоби харамсан толгой сэгсрэв.

Элис урам хугарснаа арайхийн нууж,

-Би ойлгож байнаа, хонгор минь гэснээ хамаг биеэрээ Тобид наалдаад,

-Чи хэзээ ирэх вэ? хэмээн шивэгнэв.

-Сайн мэдэхгүй байна. Хугацааг хараахан тохироогүй.

Элис бүүр түүрхэн сэтгэл нь зовохыг мэдэрснээ, энэ бүхэн шал утга учиргүй явдал хэмээн бодоод,

-Боломж гармагц утасдаарай гэж гуйвал Тоби амраг бүсгүйгээ хальт мөлтхөн үнсчихээд, үүд

рүү нисэх мэт хурдлав.

Тоби Америкийн тоглоомын төв Лас-Вегас хотыг хармагцаа хот тэр чигээрээ зугаа цэнгэлд зориулагдсан мэт санагджээ. Тэрээр 0'Хэнлон, Рейнжерийн хамт нисэх буудалд буухад нь "Оазис" зочид буудлын лимузин тэднийг хүлээж байлаа. Ингээд Тоби удахгүй түүнийх болох гэж буй ид шидийн ертенцийн зах зухаас нь нүднийхээ булангаар ч гэхнээ харж чадахтай болжээ. Үнэтэй хар машинд суугаад, зөөлөн суудалд ихэмсэгээр заларчихаад явж байхад нь жолооч эр,

-Нислэг ямар болов, ноён Темпл ээ? хэмээн хүндэтгэлтэйгээр асуухыг сонсох юутай бахархалтай гээч.

Тоби өчүүхэн хүн хэн ч биш байхад нь түүний авьяас билгийг нээн харсныг нь бодож явснаа дуулдах төдийхнөөр хайш яйшхан,

-Урьдын л адил уйтгартай байлаа гэхэд 0'Хэнлон, Рейнжер хоёр бие биес рүүгээ мушигналдахыг нь Тоби нүднийхээ булангаар анзаарчихаад тэдэн рүү харан жуумалзав.

Энэхэн л мөчид Тоби тэдэнтэй алаг бөөрийн холбоотой ах дүүс мэт дотносон амь нэгтэй болсноо ухаарчээ. Одоо тэд шоу бизнесийн хамгийн шилдэг баг болж чаджээ, чөтгөр ав гэж!

"Оазис" төв гудамжнаа байрлах таван одтой дээгүүр зэрэглэлийн буудал аж. Тоби буудлын барилгыг анзаарвал "Фламинго", "Тандерберд"-ыг бодвол хавьгүй жижигхэн даруухан атлаа юугаараа ч юм, их л олон талаараа илүүтэй санагдав.

Нүүрэн талдаа:

9 сарын 4 Анхны тоглолт.

Лили Уоллес! Тоби Темпл!

гэсэн асар том зарлал хадсан үзэгдэв.

Зуун футын үсгээр түүний нэрийг бичсэнийг харсан Тоби өдийг хүртэл амьдралдаа үүнээс илүү сайхан юм үзээгүй мэт санагдав.

-Хараач хөөе! хэмээн бишрэлтэй гэгч нь шивнэв.

0' Хэнлон зарлалын зүг толгой дохиж,

-Дажгүй шүү! Хэнбугай нь бодож олсон юм бол! Лили Уоллес! гэснээ инээд алдан,

-Санаа бүү зов, Тоби. Эхний тоглолтын дараа чиний нэр үргэлж түүрүүнд нь бичигдэх болно гэлээ.

Зочид буудлын дарга Паркер гэгч дунд эргэм насны үлбэгэр шар царайтай эр Тобитой хүндэтгэлтэйгээр угтан мэндлээд өөрөө биечилэн өрөөнд нь хүргэж өгөөд,

-Ноён Темпл таныг "Оазис"-т минь тухлан буудаллахыг зөвшөөрсөнд хэрхэн талархахаа ч мэдэхгүй байна! Хэрэв танд ямар нэг юм хэрэгтэй болбол юу л хүснэ, гагцхүү над руу даруй утасдаарай! хэмээн нэг амьсгаагаар эелдэг үг урсгалаа.

Тэр үед Тоби энэ бүхэн Клифтон Лоренсын зуучласнаар болж байгаа гэдгийг гүнээ ухамсарлаж байв. Агуу агент эр анх удаа өөрийн үйлчлүүлэгчээ энэхүү зочид буудалд төвхнүүлэх болсон нь энэ. Үүнд урамшсан "Оазис" буудлын эрхлэгч одоо л түүний буудалд жинхэнэ одод тоглох нь хэмээн ихэд билэгшээсэн байна.

Түүний өрөө гурван унтлагын өрөө, зочны том өрөө, гал зуух, баар, тагт бүхий асар том ажээ. Зочны өрөөний ширээн дээр буудлын захиргаанаас бэлэглэсэн шилдэг вино, цэцэгтэй ваар, жимс, бяслаг бүхий тавгийн идээг өржээ.

-Ноён Темпл, та сэтгэл хангалуун байх болов уу гэж найдаж байна хэмээн Паркер хүнтэтгэл үзүүлнэ.

Тоби энэ тансаг бүхнийг хараад олон жил өөрийн амьдарч ирсэн жоом, бясаа нь язганан гүйлдэх сэжиг хүргэм уйтгартай өрөөнүүдийг эргэн саналаа.

-Тийм ээ, бүх юм дажгүй байна!

-Ноён Лэндри цагийн өмнө ирсэн. Таныг гурван цагт сургуулилт хийх заалыг суллуулахаар зохицуулсан шүү.

-Баярлалаа танд.

-Хэрэв танд ямар нэг зүйл хэрэгтэй болбол, мэдэж байгаа биз... гээд эрхлэгч хүндэтгэн мэхэсхийгээд гарч одов.

Тоби зочны өрөөний голд тансаг орчноо бахдан харж зогслоо. Эдүгээгээс эхлэн эцсийн мөчөө хүртэл тэрээр гагцхүү ийм л орчинд амьдрах болно. Түүнд мөнгө, хүүхэн, алга ташилт гээд юм бүхэн байх болно. Хамгийн гол нь нижигнэсэн алга ташилт, тайзан дээр зогсоо түүнд хайр ивээлээ илгээн инээлдэн баясах үзэгчид түүнд хэрэгтэй. Ингээд Тоби нэн түрүүнд зовлонгүй ам хөдөлгөхтэйгээ болсон нь түүнээс илүү өөр юу ч дутагдаж гачигдахгүй болжээ.

Дик Лэндри гэгч ажлын гараагаа бродвейн театруудын нэгэнд бүжгийн жүжигчнээр эхлэн бүх үе шатыг дамжин явсаар бүжиг дэглээч болон ахиж, улмаар одоо найруулагч болтлоо өөдлөн дэвшин нилээд залуу хэрнээ хэдийнэ халзарсан, урт хөлтэй, гоолиг биетэй, ясны бүжигчин хүний цэмцгэр алхаатай эр байлаа. Лэндри үзэгдчид юу хүсдэгийг нарийн мэддэг, ямар ч муу тоглолт, мулгуу одыг сайжруулан хувиргаж чадахгүй гэлээ, мэргэжлийн сургуулилт хийн шуугиант тоглолт бүтээж чаддаг нэгэн аж.

Арав хоногийн өмнө гэхэд Тоби Темпл хэмээгч нэгэн эр байгааг төсөөлөх ч үгүй байсан

Лэндри гагцхүү Клифтон Лоренсын хүсэлтээр ачийг нь санан шинэхэн хошин жүжигчинтэй хатуу чанд сургалт явуулахыг зөвшөөрчээ. Дик Тобитой уулзсанаас хойш 4 цагийн дараа чадварлаг авьяастантай учирснаа ойлгож, залуу эрийн ганцаараа ярин жүжиглэхийг гайхан үзээд ховорхон тохиолддог инээдээрээ тэсгэлгүй тас тас хөхөрч суулаа. Хэргийн учир хошин үгэндээ төдийгүй Тобигийн ганцаардмал, зүрх өвтгөсөн өрөвдөлтэй төрх үзүүлж чаддаг нь харгис хэрцгий энэхүү хорвоод айн чичигнэх энхрий ялдам энэ залуу үзэгчдийн элгийг эмтлэх ажгуу.

Найруулагч эр тайзан дээр харайж очоод Тобиг чангаар тэврэн авч айх өчүүхэн ч зүйл үгүй, бүх юм сайн сайхан болно хэмээн батлан хэлэхийг ихэд хүсчээ.

Тобиг тоглож дуусмагц Лэндри алга ч ташилгүй тайз тийш гүйн хүрч очоод,

-Та үнэхээр авьяастай юмаа! Гайхаптай авьяас гэж тангараглая! хэмээн бахдан хашгирлаа.

-Баярлалаа гээд Тоби сэтгэл хангалуунаар толгой дохиод,

-Клиф, таныг од болгоход минь сургаж дөнгөнө гэж хэлсэн гэлээ.

-Хичээе л дээ хэмээн Лэндри тангараглаад,

-Хамгийн гол нь бүхнийг хийж чаддаг, тал бүрийн авьяастай байх хэрэгтэй. Та тайзан дээр зүгээр зогсчихоод хошин үг урсгаад байх юм бол доод зэрэглэлийн хошин жүжигчин болно. Алив таны дуулахыг сонсоодхоё гэв.

-Тэгснээс дууч бялзуухай хөлсөлж авсан нь дээр байхаа хэмээн Тоби мушигнаад,

-Би чинь амьдралдаа дуулж үзээгүй шүү дээ гэлээ.

-Алив оролдоод үзээч.

Тоби дуулах гэж оролдвол Лэндри сэтгэл ханамжтай толгой дохин,

-Гавьтай юм алга, гэхдээ танд сонсгол байна. Иймээс дуугаа сонгож чадвал хүмүүс таныг синатр гэх болно! Танд тусгайлсан зохиол бичиж егөөч гэж хөгжмийн зохиолчтой тохиролцох хэрэгтэй болох нь. Бусдын дуулдагийг та дуулаад хэрэггүй, одоо бүжиглээдэх гэлээ.

Тоби үг дуугүй үгэнд нь орон бүжиглэх аядав.

-Муугүй ээ, муугүй шүү гэж Лэндри сайшаагаад,

-Мэдээж та бүжигчин болохгүй л дээ, гэхдээ би чадах бүхнээ хийж бүжгийн жүжгийн гоцлол бүжигчин болгож орхиноо гэв.

-Яах гэж тэр вэ? Ийм жүжигчид үй түмээрээ байдаг шүү дээ хэмээн Тоби гайхан асуухад нь,

-Хошин жүжигчид ч адил гэж Лэндри хэлснийг нь няцаагаад,

-Харин би таныг жинхэнэ эстрадын жүжигчин болгоно гэлээ.

-Тэгвэл ажилдаа ханцуй шамлан орцгооё! гэж Тоби урамтай гэгч нь хариулжээ.

Ингээд тэд ажилдаа шуранхайлан орцгоож, О'Хэнлон, Рейнжер хоёр сургуулилт бүрд байлцан жүжгийн бүх л эхийг бичин шинэ үзэгдлийг зохиож байлаа. Тобид ганц минутын ч чөлөө зав байсангүй, тэрээр хамаг булчин нь хөшин шархирч эхэлтэл ажиллаж, даруй таван фунтын жингээ хаян булчин шөрмөс нь зангирсан гуалиг биетэй болжээ. Тоби өдөр бүр дууны хичээл заалган сургуулилсаар арай л зүүд нойрон дундаа дуулах нь холгүй, шинэ номер давтан, өөрт нь зориулан бичсэн дууг суран цаг нарыг умартан сургуулилсаар байлаа.

Тэрээр бараг өдөр болгон шахуу үйлчлэгчээс Элис Теннер утасдлаа гэсэн зурвас хүлээн авахдаа хүүхэн түүнд "Чи хараахан бэлэн биш байна!" гээд дүр өгөхгүй зовоож байсныг нь эргэн санана.

Одоо тэгээд яав, тэр хэдийнэ зорьсондоо хүрч, Элисээс алд дэлэм зөрүүтэй болж чаджээ. Түүнийг чөтгөр аваасай билээ! Тоби үйлчлэгчийн өгсөн зурвасуудыг нь хогийн саванд чулуудсаар, зав чөлөөгүй сургуулилтаа үргэлжлүүлсээр нэг мэдэхэд анхны тоглолт хийх үдэш нь болжээ.

Од болон гялалзана гэдэг үргэлж нэгэн нууцтай холбоотой байдаг. Цахилгаан мэдээ нэгэн зэрэг шоу бизнесийн нууц сувгаар түгээчих вүү гэлтэй энэхүү шинэ мэдээ Лондон, Париж, Нью-Йорк, Сидней хүрэн бүх л театр шөнийн клубуудээр агшин зуур тархжээ.

"Оазис" зочид буудлын тайзнаа Тоби Темплийг тоглож эхэлснээс хойш ердөө л таван минутын дараа гэхэд тэнгэрийн хаяанаас нэгэн шинэ од гийж эхэлснийг бүгд ойлгосон буй заа.

Анхны тоглолтыг нь үзэхээр ирсэн Клифтон Лоренс дараагийн тоглолт, тэр ч бүү хэл шөнө дундын шоу-г нь хүртэл үзэхээр үлдсэн байна. Клифтон түүний төлөө бусад үйлчлүүлэгчээ эс тоомсорлон тухлан суугаад нь Тоби ихэд сэтгэл ханамжтай байлаа. Шоу өндөрлөмөгц Тоби, Клифтон хоёр зочид буудлын кафед бүхэл шөнийн турш хууч хөөрөлдөн суув.

-Та хичнээн их алдартнууд цугласныг харав уу хэмээн Тоби асуугаад,

-Тэднийг бүгдээрээ нүүр хувиргах өрөөнд орж ирэхэд нь би золтой л ухаан алдчихаагүй шүү! гэлээ.

Клифтон балчир хүүхэд мэт сэтгэл нь хөөрөх Тобиг харан инээмсэглэнэ. Алдар хүнд, амжилтандаа аль хэдийнэ бялуурсан бусад үйлчлүүлэгчдээс нь эрс ялгаатай нь үнэхээрийн таатай санагдана. Тоби яг л хөх нүдэлсэн, сэвсийсэн үстэй, муурын зулзага мэт энхрий амьтан юм!

-Тэд хүний авьяасыг цаг ямагт ойлгодог улс шүү хэмээн

Клифтон тайлбарлаад, -"Оазис" буудлын захиргаа ч мөн адил. Тэд чамтай шинэ гэрээ

байгуулаад шан хөлсөө долоо хоногт зургаан зуун тавиас мянган доллар хүртэл нэмэх санаатай байна билээ гэлээ.

Тоби барьж байсан халбагаа гэнэт алджээ.

-Долоо хоногт 1000 доллар ий! Клиф, арай үгүй байлгүй дээ!

-Надад бас "Тандерберд", "Эль Ранчо" зочид буудлын туршуулууд санал дэвшүүлсэн шүү.

-Өө бүр! хэмээн Тоби хөөрөн хэлбэл,

-Амаа ангайж алмайрсны хэрэггүй. Энэ чинь ердөө л сорилт гээд Клифтон инээмсэглэж, - Хуучин түүх л дээ, Тоби минь. Миний хувьд бол чи авьяастай алдартай, чи ч гэсэн өөрийгөө цууд гарна гэдгийг мэдэрч байгаа. Гэхдээ хүмүүс чамайг жинхэнэ од хэмээн үзэж байна уу, үнэн хэрэгтээ оройд нь хүрч алдаршсан бил үү?! гээд Лоренс босож,

-За үг олдож үхэр холдлох нь ээ. Нью-Йоркийн нислэгт амжих хэрэгтэй байна. Маргааш Лондон руу ниснэ гэлээ.

-Лондон гэнэ ээ? Хэзээ эргэж ирэх вэ?

-Хэдэн долоо хононо оо гэснээ доош тонгойгоод,

-Хонгор залуу минь намайг сонсож бай. Чи энд дахиад хоёр долоо хононо. Үүнийгээ дасгал сургууль гэж бод. Орой бүр тайзан дээр зогсохдоо тоглолтынхоо ур чадварыг хэрхэн хурцлахаа бодохыг хичээгээрэй. О'Хэнлон, Рейнжер хоёрын үлдэх эсэхийг асуусан. Тэд чамтай өдөр шөнөгүй ажиллахад бэлэн байна лээ, үүнийг сайтар ашигла. Харин Лэндри амралтын өдрөөр ирж бүх юм зүй ёсоороо явагдаж байгаа эсэхийг шалгах болно гэв.

-За за. Баярлалаа, Клиф хэмээн Тоби толгой дохив.

-Өө тийм, золтой мартчихсангүй хэмээн хайнгадуу хэлээд халааснаасаа жижигхэн хайрцаг гарган ирж Тобид сарвайлаа.

Хайрцаг дотор уран нарийн хийцтэй, од хэлбэрийн бриллинтан гоёмсог чагтан товч байжээ.

Тоби жаахан ч болов чөлөөт цаг гарахад нь зочид буудлын асар том усан санд амарч өнгөрөөнө. Шоуд хорин таван бүсгүйчүүд чөлөө завгүй ажиллах агаад тэдний тэн хагас нь бие биесээ уруу татан ямар ч эрийг едөөн дуудах биеийн омбогор, томбогор бүрээ илтэд тодруулсан усны өмсгөл өмсөн наранд биеэ ээн тарвалзацгаадаг аж. Урьд нь бүсгүй хүнтэй ая эвээ ядах юмгүй олчихдог байсан Тобид, өдгөө бүр ч гайхалтай хялбар болов. Шоуны-охидын хамтлагынхан урьд өмнө Тобигийн тухай огт дуулаагүй гэлээ ч одоо түүний нэр зочид буудлын өмнө түмний нүднээ өлгөөтэй байгаа нь хангалттай байлаа. Тэрээр од болон гялалзаж, бүсгүйчүүл агуу эртэй энгэр зөрүүлэн хоног өнгөрөөх гэж арай л үс гэзгээ зулгаалцан зодолдох нь холгүй байх болжээ.

Хоёр долоо хоног гайхалтай сайхан зүүд мэт харвасан сум шиг өнгөрлөө. Энэ хугацааны турш

Тоби үд дундын хэрд босч шүтэн бишрэгчид, гарын үсэг цуглуулах, хоббитнуудын шаван зовоодог ресторанд цайлчихаад, хоёр цаг сургуулилт хийсний дараа усан сангаас урт хөлт хонгор бүсгүйчүүлээс урхидан өрөөндөө авч орон бүх л өдрийн турш ор хөнжлийн зугаа эдэлж өнгөрөөж байжээ.

Тоби зугаа болгон өнгөрүүлсэн бүсгүйчүүлийнхээ нэрийг тогтоож авах гэж огт хичээдэггүй, эл бүсгүйчүүд түүний хувьд ердөө л "бэби", "бүжинхэн" нь болж харин бэлэн зэлэн бие хаа, урт чилгэр гуя, хасыг нь зөвхөн дурсан санадаг ажгуу.

Ингээд Тоби долоо хоног ажиллах хугацаа үлдээд эхний өдрийн тоглолтын дараа нүүр хувиргах өрөөндөө нүүрээ цэвэрлэн сууж байтал рестораны зохион байгуулагч бараалхан,

-Ноён Эл Карузо таныг хамт хооллохсон бол уу хэмээн асуулгаж байна хэмээн хүндэтгэлтэйгээр хэлэв.

Эл Карузо гэгч Лас Вегасын нөлөө бүхий хүмүүсийн нэг, дам сонсоход хоёр гурван зочид буудлын эзэн хүн юмсанж. Мөн мань эрийг мафийнхантай холбоо сүлбээтэй гэх сураг сонсогдож байсан ч Тобид юуны хамаа байх билээ. Хамгийн гол нь Карузод таалагдах ахул тэрээр Лас-Вегаст амьдралынхаа сүүлчийн мөч хүртэл өл залгах ажилтай байж чадахсан.

Тоби яаравчлан хувцаслаад ресторан руу хурдлав.

Карузо тайрдас шиг тагжгар биетэй, тавь гаран насны, буурал үстэй, цагаан санаатай шинжийг илтгэсэн гялалзсан хүрэн нүдтэй, бас ч үгүй гүзээлж яваа нэгэн агаад Тобид бяцхан Сант-Клаусыг санагдуулжээ. Тоби түүний суугаа ширээнд дөхөж очиход ноён Карузи өндийн босч гар сунган найрсагаар инээмсэглэн,

-Намайг Эл Карузо гэдэг. Таны тоглолтыг үзээд шагшин гайх санаа хэлэхийг хүссэн юм, Тоби. Бидэнтэй хамт суугаач гэлээ.

Карузогийн ширээний ард булчин шөрмөс нь зангирсан өргөн ханхар цээжтэй, хар костюмтай хоёр эр сууж байв. Мань хоёр эр баргар царайлан кока-кола уун ганц ч үг ган хийлгүй сууцгаасан тул Тоби тэдний нэр усыг нь мэдэж чадсангүй. Тэрээр эхний шоугаа тоглчихоод ресторанд орж ирсэн тул өлөн гэдэс нь өвчүү цоройтойгоо наалдах шахам өлсөж байжээ. Карузог сэм ажвал хэдийнэ хооллочихсон бололтой байсанд агуу хүнтэй уулзах ярилцахаас урьтан хоол үмхлэх гэж ирсэн юм уу гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг хүссэнгүй.

-Залуу минь чи надад таалагдаж байна. Үнэхээр таалагдаж байна гээд Карузо эелдэгээр инээгээд, зальжин хүрэн нүдээ жийтаалгав.

-Баярлалаа, ноён Карузо! Таны энэ үг надад ихээхэн урам хайрлаж байна.

-Намайг зүгээр л Эл гэж дууд.

-За, эрхэм ... Эл.

-Тоби, чамд их ирээдүй байла. Олон хүмүүс нэг шөнийн дотор алдарын оргилд хүрчихээд,

эцэст нь үтэр түргэн ор сураггүй болцгоочихдог. Харин хамгийн авьяастай нь мөнхөд үлдэж хоцордог жамтай. Чи бол авьяастай хүн юмаа.

Тоби хамаг биеэр нь нэг л таатай дулаан гүйхийг мэдрээд Карузогоос ажиллах гэрээний талаар, Клифтон Лоренстой ярилцсан эсэхийг асуух гэснээ больж өөрөө энэ гэрээг гардахыг хүсчээ. Карузод түүний тоглолт таалагдаж л байж таараа. Тэгэхээр Эл Карузо шан хөлсний талаар өөрөө эхлэн ам нээг, харин дараа нь наймаалцаж болох юм.

-Чамайг сармагчин дүрслэж байхад чинь би золтой нь шээс алдчихаагүй шүү. Ийм инээдтэй жүжиг амьдралдаа үзээгүй юм байна гэж Эл Карузог хэлэхэд нь Тоби,

-Танаас ийм үг сонсох нь надад ихээхэн хүндлэл хэмээн үнэн сэтгэлээсээ хариулав.

Тэсгэлгүй инээд алдсан тагжгар бүдүүн Санта-Клуасын хацар дээгүүр нулимс урсаж эхлэхэд тэр торгон цагаан алчуур гарган нүдээ арчаад, бие хамгаалагчид руугаа эргэн,

-Мань хүнийг би сайн эр гэж хэлээ биз дээ? гэвэл өнөө хоёр эр нэгэн зэрэг толгой дохилоо.

Эл Карузо Тоби рүү эргээд,

-Чамтай яагаад уулзах гэснээ одоохон тайлбарлаад өгье! гэв.

Түүний ажил амьдралын гайхалтай мөч, азтай агшин л эхлэх нь энэ дээ. Тобиг энд илүү ашигтай нөхцөлөөр наймаалцах гэж байхад Клифтон Лоренс Европоор ялихгүй юмнуудтай гэрээ байгуулах гэж мачийж явах ч гэж дээ. За яахав, Лоренсыг эргэж ирэхэд нь би гэнэтийн бэлэгтэй угтах нь ээ.

Тоби урагш тонгойн сэтгэл татам инээгээд,

-Эл таныг сонсьё гэлээ.

-Милли чамд дурлачихаж.

Тоби гайхсандаа нүдээ анивчин, өөрөө л буруу дуулчихлаа гэдэгтээ бүрэн итгэлтэй байлаа. Чингээд,

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ? хэмээн аягүйрхэн бөвтнөв.

Эл Карузо нөхөрсөгөөр инээгээд,

-Милли чамд дурлачихжээ. Тэр өөрөө хэлсэн юм гэлээ.

Милли гэнэ ээ? Энэ чинь хэн гэгч билээ? Карузогийн эхнэр юм болов уу? Охин нь юм уу?

Тоби асуухаар ам ангайтал Эл өрсөн,

-Сайхан хүүхэн. Би түүнийг дөрвөн жил гаруй тэжээж явна гэснээ бие хамгаалагчид тийш

эргэн, -Тийм бил үү? Дөрөв байх аа? гэлээ.

Нөгөөдүүл нь үгийг нь батлан мөн л толгой дохилоо.

-Би энэ бүсгүйд хайртай, Тоби. Түүний төлөө юугаа ч хайрлахгүй.

Тоби хамаг бие нь жихүүцэн, царай нь цонхийгоод ирэхийг мэдэрлээ.

-Ноён Карузо...

-Милли бид хоёр гэрээтэй, би түүний араар тавихдаа зөвхөн эхнэртэйгээ учрах ёстой, харин тэр намайг мэхлэх юм бол үнэнээ хүлээх ёстой.

Мань эрийн нүүрэнд дахин инээмсэглэл тодорсон ч энэ удаа нэг л хачирхмаар хамаг цус нь царцчих вуу гэлтэй хөхөмдөг хөшингө өнгө тодорчээ.

-Ноён Карузо...

-Түүний араар минь тавьж учирсан анхны эр нь чи гэдгээ мэдэж байна уу, Тоби гээд мань эр дахин батлуулахаар цааш эргэн,

-Тийм биз? гэлээ.

Нөгөө хамгаалагч эрчүүд бас л үг дуугарсангүй, зөвхөн толгой дохилоо.

Тоби ам нээхээр зориглон,

-Би Бурханыг нэрийг барин тангараглая, Миллиг таны найз бүсгүй гэж би огт мэдээгүй шүү хэмээн чичигнэсэн хоолойгоор эхэлснээ, -Мэдсэн бол түүнд ойртох нь бүү хэл, хуруугаа ч хүргэхгүй байх байсан шүү, ноён Карузо... гэлээ.

Айж сандран зүдэрч байхад нь Санта-Клаус дахиад л дарвайтлаа инээгээд,

-Эл гээч. Намайг Эл гэж дууд.

-Эл. . . Эл ээ сонсооч, би. . . дахин түүнтэй уулзахгүй гэж тангараглая. Хэзээ ч уулзахгүй. Надад итгээрэй, би...гээд Тоби агшин зуур хамаг биеэр нь хөлс дааварлаад ирэхийг мэдрэн сөөнгөтөн дуугарахчаа аядав.

Ийнхүү дүлэгнэн айж сандрах залууг Карузо гайхан хараад,

-Хөөе, чи намайг сонсож байна уу, үгүй юу? гэлээ.

Тоби шүлсээ гүдхийтэл залгиад,

-Мэдээж, мэдээж хэлсэн болгоныг чинь сайн ойлгож байна. Бүү санаа зов гэв.

-Би чамд хонгор бүсгүй минь өөрт чинь дурлачихлаа гэж хэлээ биз дээ. Хэрэв зээ Милли л

чамайг хүсч байгаа бол, би түүний хүссэн болгоныг биелүүлнэ. Гагцхүү миний танхил охин жаргах ёстой. Ойлгов уу?

-Би...

Тобигийн нүд эрээлжлэн, толгой нь эргээд явчихлаа. Өөдөөс нь харан суугаа агуу эр өшөө авах нь гэж бодож байтал Карузо өөрийн амраг бүсгүйгээ түүнд санал болгож байдаг. Тобигийн сэтгэл уужран тайвширч золтой л инээд алдчихсангүй.

-Ээ Бурхан минь, Эл! Мэдээж шүү дээ! Бүх юм таны хүслээр болно.

-Бүх юм Миллигийн хүссэнээр байх ёстой.

-Өө нээрээ тийм л дээ, тэгэлгүй яахав. Милли. Чухамдаа Миллигийн хүслээр шүү дээ.

-Чамайг ёс жудагтай хүн гэж мэдсэн юмаа! гэснээ Эл Карузо дагуул эрчүүлдээ хандан,

-Би Тоби Темпл, ёс жудагтай эр гэж хэлсэн бил үү? гэхэд нь,

Тэд мөн л үг сүггүй толгой дохин, команд авсан мэт нэгэн зэрэг аягатай кока-колагаа уруулдаа хүргэх үзэгдэв.

Эл Карузог явахаар өндийхөд хамгаалагч эрчүүд дагалдан нүд ирмэхийн зуур годхийн үсрэн босож хавтага мэт хажууд нь зэрэгцэн зогсоцгоов.

-Би өөрөө хуримыг зохион байгуулна гэснээ,

-"Марокко"-гийн дайллагын танхимыг авна. Чи өчүүхэн ч санаа зовох хэрэггүй, би бүгдийг зохицуулна гэлээ.

Түүний хэлсэн эл үгс Тобид тэртээ алсаас сонсогдох мэт. Тэрээр итали эрийн хэлсэн бүхнийг сонссон атлаа ухаж ойлгож чадсангүй.

-Түр хүлээгээрэй. Би чадахгүй л... хэмээн Тоби эсэргүүцвэл Эл Карузо хүнд нударгаа мөрөн дээр нь тавиад,

-Чамайг аз дайрчээ. Хэрвээ Милли намайг бид бие биедээ үнэн сэтгэлээсээ хайртай гэж ятгаж дөнгөөгүйсэн бол би чамайг амраг бүсгүйг минь хоёр долларын янхан шиг эдэлсэн гэж бодоод бүх юм өөрөөр дуусах байсан юм. Ойлгов уу? гэх нь тэр.

Тоби өөрийн эрхгүй давхийн цочиж, дагуул эрсийг харвал тэд толгой дохилзож харагдав.

-Чиний хамгийн сүүлийн тоглолт бямбад байсан, тэгэхээр хурим ням гаригт болно хэмээн Карузо мэдэгдэв.

Тобигийн хоолой ам нь хатаад явчихлаа.

-Би. .. юу л даа, Эл... надад дахин гэрээ... би...

-Яахав хүлээж байг. Би Миллигийн хуримын даашинзыг өөрөө авч өгнө. Тавтай нойрсоорой, Тоби... гээд мань эр сахиусан тэнгэрийн хайр ивээлээ хүртээх адил инээмсэглээд гарч одов.

Милли гэгч хэн байсныг мэдэхгүй байгаа нь юутай гачлантай.

Маргааш өглөө нь Тобигийн бүх айдас ул мөргүй алга болжээ. Санамсаргүй явдал түүнийг цочирдуулав. Мафийн домог болсон Аль Капонегийн үе өнгөрсөн! Хэн ч Тобиг албадан гэрлүүлж дөнгөхгүй. Эл Карузо ерийн нэг шалихгүй гангстер биш, мань эр зочид буудлын намбалаг эзэн. Тоби өчигдөр үдшийн тухай бодох тусам энэ бүхэн улам хөгтэй санагдав.

Тэрээр итали эртэй ярилцсан хөгтэй яриагаа мартсангүй. Мэдээж Эл Карузо түүнийг айлган сүрдүүлэхийг Тоби хэзээ ч зөвшөөрөхгүй, тэр гайхан шагших үзэгчиддээ: "Би ширээ тийш дөхөн очтол Карузо зургаан хүн дүрст мичтэйгээ сууж байх нь тэр, та нар төсөөлж байна уу? Тэд шүдээ хүртэл зэвсэглэсэн байсан" гэж хуучлана даа. ЁСТОЙ ДОГЬ! Гайхалтай зохиол болох нь! Сайн жүжиг хийж болох нь!

Тоби долоо хоногийн турш усан сан, казиногоос, элдэв бусын хүүхнүүдээс аль болох хол байхыг хичээлээ. Тэрээр Карузогоос огт эмээсэнгүй, түүний Милли гэгчтэй гэрлэж, голио азаа үзэхийн ч хэрэг алга.

Тэрээр ням гаригийн өдөр тийшээ Лас-Вегасаас ниснэ хзмээн төлөвлөж байсан бол, одоо тэрээр бямба гаригийн үдэш машин захиалан зогсоол дээр авчруулаад, сүүлчийн тоглолтын өмнө чемодан саваа ачаалчихаад тоглолт дуусмагц Лос-Анжелес руу арилж өгнө. Хэсэг зуур Лас-Вегасыг мартагнах хэрэгтэй болж дээ. Хэрэв Эл Карузо тоглоогүй бол Клифтон Лоренс зовлонгоос ангижрахад минь туслах нь лав.

Сүүлчийн тоглолт шуугиан болсон амжилтанд хүрчээ. Үзэгчид урьд хожид үзээгээгүйгээр харайн босч, нижигнэтэл алга ташина. Тоби тайзан дээр зогсож байхдаа үзэгчдийн хайр энэрэл хөөрөн бахдах сэтгэлийн цалгиа нь түүнийг урин дулаанаар бүрхэн авахыг мэдэрчээ. Тэрээр үзэгчдийн хүсэлтээр хэдэн хошин гараагаа давтан тоглочихоод мэхийн ёслон яаран гарч одов. Энэ гурван долоо хоног түүний амьдралын хамгийн гайхалтай хэзээ ч мартагдашгүй мөч байлаа. Сар хүрэхгүй хугацаанд тэрээр шалихгүй амьтан, ой гутам үйлчлүүлэгч, зэрэмдэг амраг гээд энэ бүхнээс төрөл арилжин алдарт хүн, агуу од болтлоо хувирчээ. Түүгээр ч үл барам Эл Карузогийн амраг бүсгүйтэй энгэр зөрүүлээд хүртэл дөнгөжээ. Үзэсгэлэнтэй бүсгүйчүүл түүнтэй шөнийг хамт өнгөрөөх эрх олж авах гэж нанчилдах шахаж, үзэгч олон Тобиг бахдан, том зочид буудлууд ашигтай гэрээ байгуулахад үргэлжид бэлэн байх болжээ. Тоби зорьсондоо хүрч, энэ нь зөвхөн эхлэл гэдгийг сайн мэдэж байв.

Тэрээр түлхүүрээ шургуулан хаалга нээвэл өрөөнөөс танил дуу гарч,

-Орооч, хүү минь, ор ор! гэх дуулдав.

Тоби алгуурхан босго даван алхаж орвол ширээний ард Эл Карузо дагуул эрчүүдтэй сууж

байх нь тэр. Тобигийн ар нуруугаар хүчтэй хатгуулан хамаг бие нь салганан чичрэв.

Эл Карузо инээд алдан,

-Тоби чи енөөдөр үнэхээр гайхалтай байлаа шүү гэв.

Тоби бага зэрэг тайвшран,

-Үзэгчидийн минь гавьяа гэв.

Карузогийн хүрэн нүд гялалзан,

-Энэ зөвхөн чиний гавьяа. Чамайг их авьяастай юм гэж би хэлээ биз дээ гэв.

-Баярлалаа, Эл.

Тэдний шилний хонхрын хармагц явах болно доо.

-Чи дэндүү их ажиллаж байна шүү гээд Карузо сурсан зангаараа бие хамгаалагчид руугаа эргэн толгой дохиод, -Ийм хөдөлмөрч хүнийг хэзээ ч үзээгүй гэж би хэлээгүй билүү? гэхэд нь нөгөө хоёр нь дуулгавартайгаар толгой дохилоо.

Карузо Тобигийн дал мөрийг пад пад хийлгэн алгадаад,

-Сонсооч хөө, Милли чамайг утасдахгүй байна гэж урам хугарч байх шиг байна шүү. Чамайг өглөөнөөс орой хүртэл сургуулилж байгаа гэж би түүнд хэлчихсэн гэлээ.

-Үнэндээ тийм л дээ. Надыг ойлгож байгаад тун их баярлаж байна, Эл хэмээн яаравчлан өгүүлэв.

Карузо өршөөнгүй янзаар инээх аядаад,

-Тэгэлгүй яахав! Хэрүүл уруул хийхийг хэн хүсэх вэ, чи яагаад хурим хэзээ болохыг асуухгүй байна? гэхэд нь Тоби,

-Би өглөө утасдья гэж бодсон юм гэв.

Эл Карузо инээд алдаснаа гэнэт огцом дуугаар,

-Лос-Анжелесаас асуух гээ юу? гэлээ.

Тобигийн сэтгэл түгшин,

-Эл, та юу яриад байна аа? гэсэнд,

Карузо зэмлэх янзтай толгой сэгсэрч,

-Чемодан саваа хамаж авчихсан юм биш үү гээд Тобигийн хацрыг шоглон чимхэж авснаа, -

Миллиг гомдоосон хэнийг ч болов ална гэж би чамд хэлээ биз дээ гэлээ.

-Хүлээгээрэй! Бурхны нэрийг барьж тангараглая, би...

-Тоби чи сайн залуу ч гэлээ, даанч дүйрчихсэн хөлдүү толгойтой амьтан юм байна, тийм үү?

Тоби юу гэж хэлэхээ сайн мэдэхгүй баясгалантай царайлсан бондгор Сант-Клаусыг гөлийн ширтэв.

-Чи надад итгэж болно гэж Эл Карузо чин үнэнээсээ хэлээд,

-Би чиний анд чинь. Тэгээд ч чамд гай зовлон бүү тохиолдоосой гэсэндээ чиний төлөө санаа тавихыг хүсч байгаа юм. Мэдээж Миллигийн л төлөө. Гэвч ухаантай хүмүүст итгэхийг хүсэхгүй байгаа бол, би яах ёстой билээ? Илжигийг яаж сургадагийг мэдэх үү? гэхэд нь, Тоби таг дуугуй толгой сэгсрэв.

-Эхлээд тууний хөлдүү тархин дундуур нь шийдмээр цохиод авах хэрэгтэй.

Тоби айсандаа хоолой нь бачуураад ирэв. -Чи аль гараараа бичдэг вэ? гэж итали эр гэнэт асуулаа. -Б-ба-баруун гэж Тоби арай ядан шулганав. Карузо сэтгэл хангалуунаар толгой дохиод, хүн дүрст мичнүүддээ хандан,

-Баруун гарыг нь хугал гэж тушаалаа. Гэнэт ид шидээр бий болов уу гэлтэй тэдний нэгний гарт нь бороохой үзэгдэн бие хамгаалагчид Тоби руу дөхөн ирлээ. Булаг мэт өчүүхэн төдий бүргилж байсан айдас нь тааралдсан бүхнээ хаман урсгах үерийн ус мэт оволзож эхэллээ.

-Бурхныг бодож, та нар надыг ингэх ёсгүй гэх өөрийнх нь дуу хоолой тэртээ алсаас хэлэх мэт бөглүү сонсогдов.

Гангстер эрчүүдийн нэг нь гэдсэнд нь хүчтэй цохисны дараагийн хоромд хүнд бороохой баруун гаран дундуур нь тас буун, яс нь үйрчих шиг болов. Тоби шалан дээр хяргуулсан өвс мэт нугдасхийн унаж, өвдсөндөө мурилзан хавчигнаж хашгирах гэтэл дуу нь гарч өгсөнгүй. Дүүрэн нулимстай нүдэнд нь Эл Карузо дээрээс нь инээн харж зогсох үзэгдэв.

-За, одоо чи үгэнд орох уу гэж намуухан дуугаар асуухад ярих ч тэнхэзгүй Тобиг арайхийн толгой дохиод нь, -Сайн байна гэхихээд бие хамгаалагчиддаа хандан, -Түүний өмдийг тайл гэж Эл Карузо дахин тушаал буулгав. Дагуул эрсийн нэг нь доош тонгойн өмдний цахилгааныг нь тайлаад бороохойгоо барьж авахад нөгөө нь Тобигийн нуудгай эрхтэнг нь барин нааш цааш нь савлуулав.

Карузо хэсэг зогссоноо Тобигоос нүд салгалгүй, -Азтай залуу минь, сонсооч! Чиний шодой чинь давгүй эд байх чинь вэ, хөө! гэлээ.

Тоби амьдралдаа айж үзээгүйгээрээ айн сандарч,

-Ээ Тэнгэр . . . гуйя. . . бүү тэгээрэй. . . үүнийг минь. . . хэмээн хяхтнан дуугарлаа.

-За юу гэж дээ, би чамайг амьд яваа насандаа өчүүхэн ч гомдоохгүй. Миллитэй сайн харьцаатай байх аваас чи миний найз нөхөр минь шүү дээ. Хэрэв ганц л удаа түүнд гар хүрэх эсвэл бүдүүлэг үг хэлбэл... Би юу яриад байгааг ойлгож байна уу?

Хугархай гаран дээр нь гутлын өсгийгөөр гишгэлэхэд Тоби тэсгэлгүй чарлалаа.

-Үг хэлээ ололцсондоо би их баяртай байна. Хурим маргааш нэг цагт болно гэж итали эр инээд алдан хэллээ.

Эл Карузогийн дуу улам бүдгэрсээр Тоби ухаан балартан харанхуй хар ангал руу жингүйдэн унах шиг болсноо тэсэх хэрэгтэй гэдгийг ойлгон,

-Би . . . чадахгүй. Миний гар. . . гэж шивнэвэл,

-Санаа бүү зов. Одоо эмч ирээд шохойдоод, өвчин намдаах тариа хийгээд өгөмз. Миний залуус маргааш чамайг авахаар ирнэ шүү. Чамайг бэлэн байна гэж итгэж болох уу, аан? гэлээ.

Тоби тэсгэлгүй өвдөх зовиураа тэсвэрлэн, маасагнаж байгаа тагжгар Сант-Клаусыг харснаа юу болоод байгааг гүйцэд ухаараагүй байтал Карузо дахин хөлөө өргөх үзэгдэв.

-Т-тэгэлгүй яах вэ? Би бэлэн . . . гэж Тоби ёологноод, ухаан алдлаа.

Бүлэг 11.

Гойдын сайхан тансаг хурим "Марокко" зочид буудлын дайллагын танхимд болон зочдын тал хувь нь эстрадын жүжигчид, зочид буудлын эзэд, шоуучин охид, мөн гол зочин Эл Карузо, архи дарс ч амсдаггүй боловсон хувцасласан нөхдийн хамт иржээ. Энд тэндгүй амьд цэцгийн баглаагаар чимэглэн, найрал хөгжим хангинаж, идээ ундаанд дарагдан хотойсон зоогийн ширээ, усан оргилуурт нь ус биш шампан дарс оргилж байв. Эл Карузо ёстой юуг ч марталгүй бүхнийг зохицуулжээ.

Зочид шатан дээрээс хальтчин унаад гараа шохойдуулсан сүйт хархүүд харамсал илэрхийлцгээнэ. Гэвч хуримлагч хоёр үнэхээр гайхалтай хосууд, тэдний хурим нь шагшин сайрхахаас ч аргагүй тансаг болжээ.

Өвчин намдаах эмэндээ манарсан Тоби юу болоод байгаага ч ойлгохгүй байв. Эмний үйлчилгээ байнга сулран өвчин дахиад гарыг нь өвтгөн химлэхэд уур хилэн, үзэн ядалт нь буцлан энэ бүх тансаг байдлыг нөмрөн харанхуйлна. Тоби хурсан олонд өөрт учирсан урьд хожид сонсогдоогүй энэ хүчирхийллийн түүхийг илэн далангүй хашгиран дуулгахыг ихэд хүснэ.

Тэрээр сүйт бүсгүйгээ хорсолтой харцаар ширтэв. Одоо л Тоби түүнийг саналаа. Хориод насны, алтан шаргал үстэй, гуалиг биетэй, сайхан бүсгүй ажээ. Мань бүсгүй түүний хошигнохыг сонсон бусдаас илүүтэй чангаар тас тас хөхрөн инээж Тобид аль болох ойртохыг хичээж байсан сан. Гэвч хачирхалтай нь Милли олон охид бүсгүйчүүдээс цор ганцаараа түүнтэй унтахаас татгалзан Тобигийн аазгайг бүр ч ихээр хөдөлгөж байжээ.

Тийм ээ, тийм яг л ийм юм болсон.

-Би чамаас болж солиорох нь гэж Тоби нэгэн удаа үнэнээ хэлэн улайгаад,

-Би чамд таалагдахгүй байна уу? гэж асуувал бүсгүй хариуд нь,

-Мэдээж, таалагдаж байна. Гэхдээ би найз залуутай гэж Милли хэлсэн билээ.

Тоби тэр үед бүсгүйн үгийг эс сонсон өрөөнд нь мэхлэн орж, юм ууцгаан, элдэв хөгтэй түүх ярилцан Миллигийн оронд орох тэр мөчийг хүртэл түүний юу хийж байгааг ч анзаарахгүй тас тас хөхөрч байснаа,

-Тоби хэрэггүй, чамаас гуйя. Миний найз залуу уурлана гэж бүсгүйг гуйхад нь Тоби,

-Түүнийг март. Түүнтэй чинь учраа олж дөнгөнө гээд,

-Харин одоо бүсгүй хүнийг хэрхэн хайрлах ёстойг чамд үзүүлье гэжээ.

Ингэж тэд халуун янагаар тэврэлдэн шөнийг өнгөрөөгөөд өглөө нь Милли гэнэт эгшин уйлахыг нь Тоби сонсоод, уужуу сэтгэл гарган бүсгүйг тэвэрч,

-Хөөе, бэби минь, юу болоов? Чамд таалагдсангүй юу гэв.

-Үгүй дээ, яагаад гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ. Гэвч. . .

-Тэгвэл юунд нулимс унагана вэ? Би чамд хайртай шүү гэвэл Милли тохой дээрээ өндийн түүний нүдийг эгцлэн ширтээд,

-Үнэн үү, Тоби минь? Чи надад үнэхээр хайртай юм уу? гэж

асуужээ.

-Хэрэв худал залж байгаа бол, намайг хараал идэг.

Бүсгүйг тайвшруулан таагүй байдлаас нь ангижруулмагцаа түргэхэн салах хэрэгтэй.

Бүсгүй үнэн сэтгэлээсээ үсийг нь илбэн таалж, амандаа дуу гүнгэнэх Тобиг ажиглан жаргалтай гэгч нь инээгээд,

-Чамайг харсан тэр мөчөөс эхлэн би чамд дурласан байх шүү гэхэд нь Тоби,

-ЁСТОЙ гайхалтай! Алийв, өглөөний цай захиалья гэжээ.

Бүх түүх ердөө л энэ. . . Хожмоо тэрээр энэ бүсгүйн тухай огт бодоогүй мартаж орхиж, гэтэл ганц шөнийг хамт өнгөрөөсөн тэнэг янханаас болж түүний хамаг амьдрал нь балрах ч гэж дээ. Хуримын цагаан даашинзтай Милли түүн рүү инээмсэглэн дөхөж ирэхийг Тоби арай гэж биеэ барин харж, дотроо хуял тачаал нь оргилсон тэр өдрийг болон өөрийгөө харааж зүхнэ.

Лимузингийн урд суудалд суугаа эр бахдан жуумалзаж,

-Босс оо, танаас өөр хэн ч ингэж чадахгүй шүү, хөөрхийлөлтэй амьтан, юу болсныг ойлгохгүй байх шив! гэв.

Эл Карузо эелдэгээр инээв. Бүх юм сайхан бүтлээ. Түүний шулам-эхнэр нь Миллигийн тухай мэдмэгц мань эр хайртай нууц амрагаасаа ангижрах хэрэгтэй болсноо мэджээ.

-Түүнд Миллитэй хэрхэн харьцаж байгааг чинь намайг хянаж байх болно гэдгийг дахин сануулчихаарай гэж итали эр намуухан хариулав.

Шинэхэн хосууд Бенедикт-Кэньоны бяцхан байшинд төвхнөжээ. Тоби эхэндээ дургүй хүргэсэн гэр бүлээс хэрхэн салахаа хэдэн цагаар эргэцүүлэн бодож суудаг байв. Миллиг өөрөөр нь салах өргөдөл яаж өгүүлэх вэ? Түүнийг нууц амрагаар солин, хардлагын жүжиг тогловол тэр салахыг шаардах болов уу? Эсвэл эхнэрээ зүгээр л хаячихаад Карузогийн янзыг нь үзэж, яахыг нь харах уу? Гэвч Дик Лэндритэй ярьсан тэр нэгэн ярианаас өмнө Тоби ямар нэг зүйл сэдэхээр шийдсэн байжээ.

Тэд "Бель-Эйр" буудалд хооллоцгоож байв. Хурим болсноос хойш нилээд хэдэн хоног өнгөртөл Лэндри түүнээс,

-Чи Эл Карузотой ямар харьцаатай байна вэ? гэж асуув. -Юу гэж? хэмээн Тоби гайхвал,

-Түүнтэй бүү орооцолд. Цаадах чинь алуурчин шүү. Итгэж болох хүмүүсийн ярианаас сонсовол Карузогийн дүү хархүү хийдийн арван есөн настай нэгэн бүсгүйтэй гэрлэжээ. Жилийн дараа тэрээр эхнэрээ нууц амрагтайгаа байхад нь дээрээс нь орчихсон тухайгаа бүгдийг нь Элд ярьж гэнэ.

Айн мэгдсэн Тоби Лэндригээс нүд салгалгүй сонсон, -Тэгээд юу болсон бэ? гэж асуулаа.

-Карузогийн хөлсний этгээгдүүд нууц амрагийг нь барьж аван хүлээд, эрхтэнийг нь мах цавчдаг хутгаар тас огтлож аваад керосин асган түүний нүдэн дээр нь шатаачихаад мань залууг цустай нь хутгаад арилаад өгтөл нөгөөх нь үхсэн гэнэ лээ.

Тоби "Өмдийг нь тайл. . ." гэж зандарч байсан Карузогийн тушаалыг, биеийг нь тэмтчин байсан хүнд нударгыг нь эргэн саналаа. Хамаг биеэр нь хуйтэн хөлс дааварлаж, хоолой нь бачуурчээ. Одоо тэрээр аймшигт үнэн мөнийг сонсоод гарах гарц үгүй гэдгийг яс махандаа шингэтэл ойлгожээ.

Жозефина арван настай байхдаа эхийнхээ зодуур, Бурханы үргэлжийн ял шийтгэлээс гарч нуугдан хоргодох арга хайсаар нэгэн шинэ ертөнцийн үүд хаалгыг нээн олжээ. Энэ бол ид шидийн, гайхалтай нууц орон аж. Охин хэдэн цагаар ч хамаагүй кино театрт амьсгаа даран сууж, дэлгэц дээрх үйл хөдлөлийг ажиглана.

Сайхан хүмүүс ер бусын тансаг байшинд амьдран, ганган хээнцэр хувцаслаж, үлэмжийн аз жаргалтай байх аж! Жозефина хэзээ нэгэн цагт Голливуд орон яг л тэдэн шиг амьдрана гэж эрс шийджээ. Охин ээж нь хожим түүнийг мэдээд уучлах болно гэж найдна.

Ээж нь киног чөтгөр шулмын хорлол гэж үздэг учраас Жозефина кинонд хулгайгаар яван баячуудын гэрт уригдах хүүхдийг нь зугаацуулахдаа олсон мөнгөөрөө тасалбар худалдаж авдаг ажээ.

Өнөөдөр хайр дурлалын тухай кино гарч Жозефина кинонд дурлан сэтгэл нь татагдаж, шимтэн урагш бөхийн суужээ. Дэлгэц дээр: "Продюссер Сэм Уинтерс" гэсэн бичиг хөврөв.

Бүлэг 12.

Сэм Уинтерсын хувь заяа нь түүнийг студи биш, харин бүх өвчтөнүүд хүзүүнд нь дүүжлүүрийн олс гогдох нь шахдаг галзуугийн эмнэлгийг толгойлж байгаа мэт санагдах болжээ. Өнөөдөр чухамдаа яг л тийм өдрүүдийн нэг, гай газар дороос яаруу галт тэрэгний хурдаар ар араасаа үргэлжилсээр. Студид нь бүр дөрөв дэхь удаагаа түймэр гарч, "Миний нөхөр-Баасан" киноны ивээн тэтгэгч нь гол дүрийнхээ жүжигчинд үхтэл доромжлуулсандаа гомдон цаашид киног санхүүжүүлэхгүй болсноо дуулгаж, авьяаслаг найруулагч Берт Фэйрстоун киноны талаас нь хаян төсвөөс таван сая доллар тасдан авч, кинон дээр ажиллахаас татгалзаж, хэдхэн хоногийн дараа зураг авалт эхлэх гэж байтал жүжигчин Тесси Брэнд гэрээгээ цуцалчихжээ. Сэмийн өрөөнд студийн аж ахуйн эрхлэгч орж ирлээ.

-За яав, хохирол их гарав уу? гэж Сэм асуув.

-Ноён Уинтерс зэ, зургийн талбай тэр чигээрээ хэрэггүй болсон. Арвантавдугаар талбайг дахин хийх хэрэгтэй, арван зургадугаар талбайг сэргээнэ, энэ бүхнийг хийхэд дор хаяж гурван сар болно байх.

-Гурван сар хүлээх арга байхгүй! гэж Сэм зандраад,

-Алив утсаар яриад Голдвины талбайг түрээслээдэх. Нэг дэх гэхэд бүгдийг дуусгах хэрэгтэй. Боллоцоотой хүн бүхнийг цуглуулж, амралтын өдрөөр ч гэсэн ажилцгаа.

Тэрээр авьяаслаг жүжигчин Жорж Бэнкрофтой адилхан нүдэнд дулаахан аж ахуйн эрхлэгч Рейлиг харвал сайхь эр,

-Хэн нэг нь таныг таалахгүй байгаа нь гарцаагүй боллоо, ноён Уинтерс хэмээгээд,

-Та "үймээн дэгдээгч"-дийг шалгасан уу? гэв.

"Үймээн дэгдээгчид" гэдэг нь халагдсандаа удирдлагадаа гомдон тунирхсан ажилчдыг хэлдэг юмсанж.

-Ажилтнуудын хувийн хэргийг хоёр ч удаа шалгаад ноцтой юм олоогүй гэж Сэм хариулав.

-Биднээр даажигнаад байгаа хүн ажлаа сайн мэддэг болтой Тэр цагийн механизм бүхий гар хийцийн шатаах бөмбөг хэрэглэж байна. Цахилгаанчин эсвэл механик хүн байхаа.

-Баярлалаа, бүгдийг дахин шалга гэж хэлье хэмээн Сэм толгой дохив.

-Таитаас Рожер Тэпп ярья гэнэ.

-Холбоодох гэж Сэм тушаалаа.

Тэпп бол Таитад зураг авалт хийж байгаа гол дүрд нь Тони Флетчерийн тоглож байгаа "Миний нөхөр-Баасан" телевизийн киноны продюссер билээ.

-Юу болоов? гэж Сэмийн лавлахад,

-Чөтгөр ав гэж, чи үнэмшихгүй дээ, гэвч биднийг санхүүжүүлж байгаа нөгөө компанийн ерөнхийлөгч гэр бүлийнхээ хамт амрахаар энд иржээ. Тэгээд өчигдөр гэнэт зургийн талбайд Тонигийн яг тайзан дээр байхад хүрч ирсэн. Гэтэл Тони солиорох шахан тэднийг доромжилж эхэллээ шүү.

-Юу гэж байх юм?

-Нэн даруй түүний арлаас зайл хэмээн тушаасан.

-Тэнгэр өршөө гэж!

-Яг үнэн! Тэр яг л Бурхан тэнгэр аятай сайрхсан гээч! Гэтэл Хеллерийн шар нь гозойгоод сохор зоос ч өгөхийг хүсэхгүй гэсэн!

-Хеллерт очоод уучлал гуй. Бүү алгуурла. Яг одоо оч. Тониг мэдрэлийн гажигтай гэж хэл, хатагтай Хеллерт цэцэг илгээ, тэднийг зоогонд урь. Би Флетчертэй өөрөө ярина.

Сэмийн чарлаанаар эхэлсэн яриа хагас цаг гаруй үргэлжилэв. Тэрээр уурлан хашгичиж,

-Яртай муу ухна минь, чи сонс гэж... гэж эхэлснээ эцэст нь,

-Би ч чамд хайртай, Чамайг талархан дэмждэг шүү. Боломж гармагц чиний тоглолтыг үзэхээр очно. Бурхныг бодож хатагтай Хеллертэй арцалдахгүйг хичээгээрэй гэсэн үгээр дуусгажээ.

Нэг асуудлыг зохицуулж дуусмагц Сэм "Амьдрал мөнхөд үргэлжилнэ" гэсэн киноны зургийг гурван сар хагас шахам авч, төсвийг сая доллараар хэтрүүлчихээд байгаа агуу, залуу найруулагч Берт Фэйрстоунтай ярилцав. Найруулагч эр одоо кинонд ажиллахаас татгалзчихаад жүжигчид, туслах дүрийн зуун тавиад хүн хэд хоног юу ч хийлгүй зүгээрийг хийж байгаа аж.

Берт Фэйрстоун гуч эргэм настай, Чикагогийн телевизийн кинонд ажиллан, болох болохгүй гавьяа шагнал бүгдийг нь хүртсээр эцэст нь Голливудад хөл тавин бараалхаж чаджээ. Фэйрстоуны эхний гурван кино гавьтай сонирхол татаагүй ч гэлээ дөрөв дэхь кино нь галзуутай амжилтанд хүрч, Берт студиудын захирлуудын дунд овоохон эрэлттэй болон ихэд үнэ хүрсэн байна.

Сэм түүнтэй уулзсан анхны уулзалтыг тун сайн санадаг байлаа. Берт Фэйрстоун хялгасан сахлаа ч хусаж үзээгүй, арван таван настай балчир хүүхэд шиг л харагдаж байв.

Цонхигор, ичимхий царайтай, хараа муутай улаан нүдээ эвэр хүрээтэй хар шилээр нууж явдаг байв. Сэм залууг ихэд өрөвдөнө. Берт Голливудад хэнийг ч танихгүй учраас Уинтерс түүнд цайллага, үдэшлэгийн урилга олох гэж эрвийх дэрвийхээрээ хичээ дэг байжээ. Тэд "Амьдрал мөнхөд үргэлжилнэ" киноны тухай хэлэлцэж байхад Фэйрстоун Сэмийг багшаа гэж хүндэтгэж явдгаа хэлэн, цаг ямагт түүний үгийг сонсон бүгдийг нь зөвшөөрч, ноён

Уинтерсын зөвлөлгөөгүйгээр ганц ч гэрээнд гарын үсэг зурахгүй гэдгийг Сэмд батлан хэлж байжээ.

Гэвч энэ нь Фэйрстоуны кино найруулагч болох хүртэл үргэлжилсэн аж. Гэтэл одоо Гитлерийг түүнтэй харьцуулахад арай л дөнгүүр сайн санаатай хүн байсан мэт санагдах болов.

Ягаахан хацартай нусгай хүүхэд ганцхан шөнийн дотор төрөл арилжин, хэнд ч дийлдэшгүй хүчит луу болон хувирч, хэнтэй ч харилцахгүй, Уинтерсын саналыг эс ойшоон, сайшаасан кино зохиолыг хүртэл дахин хянаж үзэхийг шаардан өөрийнхөөрөө зүтгэж, хэдийнэ сонгосон газарт нь зураг авахаас хүртэл татгалзан данхайж ёстой буруу сэхнэ гэгч болжээ.

Сэм биедээ баймгүй аяглах залуу найруулагчийг долоон уулын цаагуур далд оруулан хөөн зайлуулахыг хүсэх авч Фэйрстоуны сүүлийн киноноос ахиухан ашиг хүртсэн Нью-Йоркийн компанийн захирал Рудольф Хергешорн түүнд тэсэх хэрэгтэй зөвлөжээ.

Гэвч Фэйрстоуны ичгүүр сонжуургүй аяг нь өдөр ирэх тусам улам сагаж, удирдлагуудын зөвлөлгөөний үеэр мань эр хэлтэс тасгуудын туршлагатай дарга нарын үг хэлэхийг сонсон байснаа эцэст нь тэднийг толгой түрүүгүй загнаж гарахад Сэм шуд зуун тэвчиж суужээ.

Фэйрстоуныг нэг хэсэг Эзэн хаан Хуандий хэмээн нэрлэж байснаа төдөлгүй захирагдагсад нь нүднээс далдуур Чикаго-гийн Нусгай-Гөлчгий гэж хочлох болов. Бас хэн нэг нь түүний тухай,

-Энэ чинь манин юм. Өөрөө өөртөөгөө энгэр зөрүүлбэл хоёр толгойтой чөтгөр төрөх байх шүү гэж хүртэл хэлсэн нь бүгдийн чихийг дэлсчээ.

Тэгээд одоо Фэйрстоун киноны тэхий дундаас зураг авалтыг зогсоогоод байлаа. Сэм уран сайхны хэлтсийн захирал Делвин Келентэй уулзан,

-Алив хурдал, юу болоод байгаа юм бэ? хэмээн тайлбар шаардахад,

-Сонсооч, нөгөө Нусгай-Гөлчгий чинь...

-Эелдэг байз үз! "Ноён Фэйрстоун" гэх хэрэгтэй!

-Өршөөгөөрэй та. Ноён Фэйрстоун шилтгээний засал чимэглэлийг өөрийн эскизээр хийлгэх гэнэ. Та тэднийг урд нь баталчихсан шүү дээ.

-Давгүй зурагнууд байсан даа. Тэгээд юу болоов?

-Бид бүгдийг нь бяцхан. . . үгүй ээ, ноён Фэйрстоуны хүссэнээр хийтэл, өчигдөр орой ирж үзчихээд шилтгээн хэрэггүй болсон гэж хэлсэн. Хагас сая ногооныг шууд...

-Би түүнтэй ярья хэмээн Сэм хэлжээ.

Берт Фэйрстоун хорин гурав дугаар зураг авалтын талбайд сагс наадаж байв. Тэнд сагсны талбайг татан, самбар хүртэл зоон тохижуулжээ.

Сэм хэсэг зуур ажиглан зогслоо.

Энэ тоглоом студээс цагт хоёр мянган доллар гарздах ажээ.

-Берт ээ!

Фэйрстоун эргэн Сэмийг харан инээгээд хайнгадуухан гар даллав. Энэ үед нь түүнд бөмбөг дамжин ирэхэд Берт бөмбөгийг залан эсрэг тал руу шаламгай довтлон самбар руу шидчихсэнийхээ дараагаар Сэм рүү очив.

-Ажил ямар байна даа? гэж юу ч болоогүй аятай хэнэг ч үгүй асуулаа.

Сэм түүний хүүхдийнх шиг инээмсэглэл гэрэлтүүлэх царайг нь хараад Берт Фэйрстоун яах аргагүй гажигтай шүү. Авьяаслаг суут ч байж магад, гэхдээ шизотой гэдэг нь эргэлзээгүй бололтой. Ийм хүнд таван саяын кино зураг авахуулах гэж найдаж байх ч гэж дээ! хэмээн гэнэт боджээ.

-Шинэ засал чимэглэлтэй холбоотой асуудал гараад байна гэж сонслоо. Алив яаж хийхийг шийдэцгээе гэхэд нь,

-Шийдээд байх юмгүй. Засал огт тохирохгүй гэж Фэйрстоун залхуутай гэгч нь инээвхийлэв.

-Чөтгөр ав гэж, юу гэсэн үг вэ? Бүгдийг чиний хүссэнээр, чиний зургаар хийсэн! Юу нь болохгүй байгааг одоохон тайлбарлаж хайрлана уу?!

Фэйрстоун эргэлзэн нүдээ анивчиснаа,

-Тийм ээ, бүх юм дажгүй болсон байна лээ. Би зүгээр л бодлоо өөрчилсөн юм. Надад шилтгээн хэрэггүй. Тэр чинь салах ёс хийх тайзны фон биш гэж би бодсон юм. Миний юу хүсээд байгааг ойлгож байна уу? Би Эллен, Майк хоёрыг далайд хөвж одоход бэлэн байгаа хөлөг онгоц дээр хагацаахыг хүссэн юм гэх нь тэр. Сэм хирдхийн цочиж, Фэйрстоуныг гайхан хараад,

-Берт ээ, манайд хөлөг онгоц байхгүй шүү дээ гэвэл,

-Тэгвэл хийх л хэрэгтэй болж дээ, Сэм ээ. Надад зориулаад.

Харилцуурт шор гэх чимээ дуудан залгагч бүсгүй Сэмийг Нью-Йорктой холболоо.

-Харин тийм ээ, наад нусгай чинь намайг ч гэсэн дээлэндээ багтахгүй болгож дөнгөдөг юм хэмээн Рудольф Хергешорн үгсэн зөвшөөрөөд, -Гэвч хэнээр ч сольшгүй эр дээ. Кинонд ямар ч од тоглоогүй байхад үзэгчид зөвхөн Берт Фэйрстоуны нэрээр л гүйлдэн ирцгээдэг юм гэлээ.

-Төсөв хэдээр өссөнийг та ойлгож байгаа...

-Мэдэж байнаа. "Амьд яваа насандаа дахиж энэ зулбасгатай ажиллахгүй гэж хэлж дуусалгүй,

тэр надад яаралтай хэрэг болоод байна" хэмээн түүнийг сураглаж явсан Голдвинь паян байдаг шүү. Тэгэхээр Фэйрстоун бидэнд зураг авалт дуустал хэрэг болно.

-Энэ бидний алдаа. Байдаг бүхнээ түүний гарын салаагаар урсгуулаад зүгээр суугаад байж болохгүй гэж Сэм зөрөхөд нь,

-Сэм ээ, сонс, авсан кино зураг нь чамд таалагддаг уу? гэв.

Сэм Уинтерс худал хэлж чадсангүй.

-Уг нь гайхалтай кинонууд...

-Тэгвэл түүнд хөлөг онгоц хийгээд өгчих.

Арав хоногийн дараа хөлөг онгоц бэлэн болж Берт Фэйрстоун дахин ажилдаа орлоо. Ямар ч кино "Амьдрал мөнхөд үргэлжилнэ" кино шиг орлоготой байгаагүйсэн.

Одоо Тесси Брэндьг хэрхэн ятгахаа бодох л үлджээ. Шоу-бизнесийн хүрээнд нэрд гарсан дуучин үгүй байхад нь Сэм Уинтерс дуучин бүсгүй Тесситэй гурван кинонд тоглуулах гэрээ байгуулж гарын үсэг зуруулж чадсанаар "Пан Пасифик" компанийг аз дайрчээ. Бусад студиуд бүсгүйн агенттай гэрээ байгуулах нь гэх шуугианаар Сэм Нью-Йорк руу нисч очин Тессигийн концертын тасалбарыг худалдан авч үзээд тоглолтын дараа нь тайзны араар шурган явж очиж дуучин бүсгүйг оройн зоогонд урин өглөөний долоон цаг хүртэл ярилцжээ.

Тесси Брэнд ер бусын царай муутай ч гэлээ, торох юмгүй тодорч гарсан авьяастай нэгэн. Амьдралдаа ганц удаа дууны хичээл заалгаж үзээгүй Бруклины оёдолчны охин сандарсандаа чичирсээр тайзан дээр анх удаа "гарч ирэн дуулж эхлэхэд үзэгчид түүнийг хөл алдан угтжээ. Тесси зургаан долоон хоногийн өмнө сүйрэн дампуурч буй бродвейн хөгжимт жүжигт орлон тоглогчоор ажиллаж байжээ. Хаалтын тоглолт болохын өмнө дадлага туршлагатай гэнэн хонгор жүжигчин бүсгүй өвдчихсөн тул дуулж чадахгүй хэмээн хэлэн үйлийн үргүй алдаа хийжээ. Ингээд Тесси Брэндийн анх удаа тайзан дээр гаргах нь тэр. Гайхагдаад байх гойд юмгүй царай муутай бүсгүй өөрийн сэтгэл зүрхээ дуундаа шингээн дуулахад үзэгчид үлэмж ихээр гайхацгаажээ.

Санамсаргүй тохиолдлоор бродвейн продюссер Пол Варрик үзэгчдийн дунд байж таарчээ. Тэрээр Тессид удаах хөгжимт жүжгийн гол дүрийг өгөхөд бүсгүй гайхалтай жүжиг болгон хувиргаж чаджээ. Шүүмжлэгчдэд царай муутай бүсгүйн ховорхон тохиолддог хүчтэй хоолойг шагшин магтах чимэг үг олдсонгүй. Бүсгүй тайзан дээр гарч ирснээс хойш хэдхэн хоногийн дараа эхний пянзаа бичүүлээд, төдөлгүй хоёр сая хувь цомгоо гаргахад сар хүрэхгүй хугацаанд зарагдаж дуусчээ. Тесси гараа хөдөлгөж амжаагүй байхад эргэн тойрон алтаар хучигдан, бүсгүй Хатан хаан Мидас нэр зүүжээ. Бродвейн продюсерууд, дуу бичлэгийн компаниуд түүнд асар их мөнгө цутгаж хөрөнгөжүүлж байхад Голливуд ч гэсэн юу дутлаа гэж хоцрох билээ. Шүүмжлэл даахгүй Тесситэй ойртон танилцсан студийн төлөөлөгчдийн зарим урам бага зэрэг хугарчээ. Гэвч орлогын хэмжээ нь өгүүлж барамгүй нь чин үнэн.

Сэм Тесситэй таван минут ярилцаад түүнтэй хэрхэн харьцах ёстойгоо ойлгожээ.

-Би дэлгэц дээр аймшигтай царай муутай харагдахаас үнхэлцгээ хагартал айдаг гэж дуучин бүсгүй үнэнээ хэлээд,

-Би дэндүү царай муутай, кинон дээр бүр ч. . . Студийн эрээ цээрээ алдсан амьтад намайг гоо үзэсгэлэнтэй болгож харагдуулж чадна гэж тангараглацгаах юм, гэвч энэ бүхэн дэмий үг гэж бодох юм гэлээ.

-ЁСТОЙ үнэн гэж Сэм толгой дохилоо. Тесси түүнийг гайхан ширтэв.

-Тесси тэднийг биедээ хуруу ч хүргүүлж болохгүй, тэд таныг сүйд хийнэ шүү.

-Үнэн үү?

-"МГМ" -ынхэн Дэнни Томастай гэрээ байгуулаад, Луи Мейер түүнийг хамрынхаа хэлбэрийг засахыг шаардаж байсан. Дэнни гоо заслын хагалгаа хийлгэхийг хүсэхгүй байгаагаа хэлээд нэн даруй гэрээгээ цуцалсан. Гадаад үзэмжиндээ биш, хамгийн гол нь авьяастайдаа байгаа гэдгийг тэрээр сайн мэдэж байсан. Тесси Брэнд та бол хэзээ ч давтагдашгүй, хосгүй нандин, гэхдээ бага зэрэг царай муутай хүүхэлдэй.

-Надад хэн ч ингэж хэлж байгаагүй гээд Тесси санаа алдаад,

-Та жинхэнэ эр хүн юмаа. Та эхнэртэй юу?

-Үгүй.

-Та салхинд гарах дуртай юу?

-Дуучин бүсгүйтэй л биш шүү гээд Сэм инээснээ,

-Надад сонсгол байхгүй гэлээ.

-Танд сонсголын хэрэг байхгүй. Та надад таалагдаж байна

шүү гэж Тесси үнэнээсээ хэлэв.

-Манай студитэй хэд хэдэн киноны гэрээнд гарын үсэг зурчихаж болмоор таалагдаж байна уу? гэж Сэмийн сэтгэл хөдлөн асуухад Тесси зөвшөөрөн толгой дохилоо.

-Гайхалтай. Маргааш таны агенттай уулзъя.

Тесси Сэмийн гарыг илбэн,

-Хэзээ ч юм наадаж зугаацахыг хүсэхгүй гэдэгтэй итгэлтэй байна уу? гэлээ.

Тесси Брэндын эхний хоёр кино санаанд багтамгүй амжилтанд хүрчээ. Эхний киногоороо Академийн шагналын жагсаалд нэр нь дэвшигдэж, хоёр дахь киногоороо "Оскар"-ын алтан баримлыг хүртжээ. Үзэгдчид дуучин бүсгүйн ер бусын дуу хоолойг сонсох гэж кинотеатрын

кассын өмнө урт дараалалд зогсоцгоох болов. Тессид үзэгчдийг уяруулах, инээлгэх, жүжигчний жинхэнэ авьяас, дуулаачын чадвар гээд бүгд тэгш заяажээ. Бүсгүйн муухай царай нь өөлөх юмгүй олон сайхан бүсгүйчүүдийн дундаас үзэгчид Тессиг онцгойлон ялгахад төвөггүй байдаг болжээ. Тесси Брэнд царай муутай, шоовдор хүмүүсийн жинхэнэ мөрөөдлийнх нь бэлэг тэмдэг нь болж чадав.

Тесси анхны киноныхоо гол дүрд тоглосон жүжигчинтэй гэрлэсэн хийгээд дахин кинонд зураг авахуулах болмогц нөхрөөсөө салан, дахин хоёр дахь киноныхоо манлай дайчин эрийн дүрд тоглосон жүжигчинтэй гэрлэжээ. Дам сонсоход энэ гэрлэлт нь төд удалгүй салсан ч гэлээ Голливуд нь янаг амрагийн холбоо сүлбээний шавхагдашгүй ундарга ажээ. Иймэрхүү шуугиант явдлууд миний хэрэг биш гэж үздэг учраас Сэм өөрийн зүгээс төдийлөн анхаардаггүй байв. Эл явдлын учрыг нь олж хужрыг нь тунгаах гэхэд мань эр хэзээд эндүүрсэн байдаг аж.

Сэм Тессигийн агент Барри Херманы утсанд залган,

-Барри, юу болоо вэ? гэхэд нь,

-Өнөө шинэ зураг авалт л байхгүй юу. Тесси дургуйцээд байна гэжээ. Сэмийн уур нь дэлбэртлээ буцлаад ирлээ.

-Хөөе Барри, чи сонс! Тесси продюссер, найруулагч, зохиол бүгдийг зөвшөөрсөн. Тайз засал бэлэн, зураг авалт хэзээ хэзээгүй эхлэх гэж байна. Ухрах зам байхгүй. Тэр татгалзаж болохгүй. Би...

-Тэр татгалзаагүй.

-Тэгвэл түүнд юу хэрэгтэй болоо вэ? гэж хэрхэхээ мэдэхээ байсан Уинтерс асуулаа.

-Бүсгүй шинэ продюссертэй болохыг шаардаад байна.

-Юу гэнэ ээ? ! гэж Сэм дуу алдан бахирахад,

-Ральф Дастин бүсгүйг ойлгохгүй байна гэв.

-Дастин-америкийн шилдэг продюссеруудын нэг, мань эр түүнтэй ажиллахыг зөвшөөрсөн нь Тессигийн аз нь шовойсон хэрэг биш үү.

-Чиний зөв өө, Сэм, яа аад ч юм бэ тэд нэг нэгнийгээ таашаахгүй юм. Дастин хэвээр үлдэх л юм бол. Тесси зураг авахуулахаас татгалзана байх.

-Гэхдээ түүнд гэрээ бий шүү дээ, Барри.

-Мэдэж байна аа, анд минь, надад итгэ. Тесси үнэн голоосоо гэрээнийхээ болзлыг биелүүлэхийг хүсч байгаа. Гэвч бүсгүй цухалдаж эхэлмэгцээ сандран, текстээ мартчих юм.

-Би эргээд ярья гэж Сэм хорсолтойгоор хэлээд харилцуураа шидчихэв.

Хараал идсэн гичий! Дастиныг яагаад ч халж болохгүй! Энэ царай муутай амьтанд дөрлүүлсэн бух шиг хөтлүүлж байх юм гэнээ, арай ч дээ!

Сэм Ральф Дастиныг дуудаадах гэж нарийн бичгийн дарга бүсгүйдээ хүслээ.

Дастин гэгч дунд эргэм насны нүдэнд дулаахан эр, кино зохиолчоор ажлын гараагаа эхлэн нэг л мэдэхнээ продюссер болжээ. Түүний кино зургууд нь өө сэвгүй нарийн мэдрэмжээрээ бусдаасаа илтэд ялгарна.

-Ральф аа, юу гэж хэлэхээ. . . гэж Сэм яриагаа эхэлтэл.

-Тайлбарлах гээд хэрэггүй ээ, Сэм ээ. Би чамд энэ зураг авалтанд ажиллахгүй, миний зүгээс хангалттай боллоо гэж хэлэх гэж ирсэн юм гэлээ.

-Чөтгөр ав гэж юу болоод байгаа юм бэ?! хэмээн Сэмийг уурсан асуувал,

-Манай од бүсгүйн шилэн хүзүү нь татчихаад байна гээд Дастин мөрөө хавчисхийгээд,

-Гэдэн нь хөдлөсөн бүсгүйд таалагдахгүй байна гэлээ.

-Орныхоо хүнийг олчихсон гэж хэлэх гээ юу?

-Ээ Бурхан минь, өдийг хүртэл чи чинь хаана байсан юм бэ, Марс дээр байсан юм биш биз? Сонин уншаагүй юм уу даа?

-Тэр чинь хэн гэгч эр вэ?

-Эр биш ээ.

Сэм алгуурхан толгой өргөн,

-Юу гэнэ ээ?

-Хувцас загварын зураач. Барбара Картер. Сонсоогүй юм уу?

-Чи үнэмшээд байгаа юм уу?

-Миний бодлоор, дэлхийн хойд туйлд чи ганцаараа төөрсөн байгаа юм биш үү, хэн ингэж санах билээ дээ.

Уинтерс толгой сэгсчин,

-Тессиг завхай эм гэж бодохгүй байна! гэхэд,

-Сэм ээ, амьдрал гэдэг чинь дайллагын ширээ, Тесси аль хэдийн цатгалдсан бололтой гэв.

-Чөтгөр ав, хэн ч намайг дөрвөн саяын кино зургийг үзээрийн муухай дэлт бүргэдэд даалгахыг хүлээн зөвшөөрөхгүй.

-Үүнд л чиний алдаа байна гээд Дастин жуумалзав.

-Яагаад тэр билээ?

-Тесси, бүсгүйчүүл бизнест эрчүүдтэй адил тэгш эрхтэй байна гэж хэнээрхээд байх юм. Чиний бяцхан-од чинь, жинхэнэ эмэгтэйчүүдийн тэгш эрхийн төлөө тэмцэгч болжээ.

-Наадах чинь миний санаанд огт багтахгүй нь ээ.

-Дураараа л бол, гэхдээ миний зөвлөлгөөг сонссон нь дээр, зөрүүдлээд байх аваас кино чинь дэлгэцэн дээр гарч чадахгүй шүү гэжээ.

Сэм Барри Херманд утасдан,

-Тессид Ральф Дастин гэрээгээ цуцалсан гэж хэл гэлээ.

-Тесси үүнийг чинь сонсоод харин ч их баярлана. Сэм шүдэн завсраараа исгэчүүлэн,

-Наад бүсгүй чинь тэгээд хэн нэгэн продюссерыг хэдийнэ олчихоо юу? гэсэнд,

-Үнэнийг хэлэхэд тийм ээ хэмээн Херман зулгуйдан хариулаад,

-Тесси шинэ авьяастан, асар их авьяастай бүсгүйг нээж олчихоод, тан шиг чадварлаг захирлын удирдлаган дор ажил даа ороход бэлэн байгаа, Сэм...

-Зар сурталчилгааг багасгаж болно гэж Уинтерс яриаг нь таслаад,

-Энэ сүүлчийнх нь болзол уу? гэлээ.

-Тийм л болов уу. Өршөөгөврэй, Сэм. Барбара Картер гоолиг бие хаатай, зүс царай сайтай, Сэмийн тодорхойлсноор бол бүсгүй ер нь гоо хүүхэн ажээ. Сэм Уинтерс өрөөн дотуур нь гунхалзан алхалсаар буйдан сандалд шигдэн суугаад урт гоолиг хөлөө эвлэгхэн гэгч нь солбин суух бүсгүй үг дуугүй ажиглан суулаа. Түүнийг ам нээн бага зэрэг сөөнгө дуугаар ярьж эхлэхэд нь бага зэрэг ярвайсан нь, магадгүй Сэм түүнээс ямар нэгэн завхай зайдан шинж хайн шиншилсэнтэй холбоотой ч байж магад.

Бүсгүй том саарал нүдээрээ түүнийг анхааралтай харснаа,

-Би эвгүй байдалд ороод байна, ноён Уинтерс ээ. Надад итгээрэй, би хэн нэгнийг ажлаас нь салгахыг огт хүсээгүй юм, гэтэл бүгд... гээд аргагүйдсэн аятай гараа савлан,

-Брэнд авхай намайг киноны продюссер болохыг зөвшөөрөхгүй бол кинонд тоглохгүй гээд байх юм. Таны бодлоор бол би яах ёстой вэ? гэлээ.

Хормын төдийд Сэмийг түүнд юу хийх ёстойг нь тайлбарлаад өгөх дур нь гозгоносон ч гэсэн, биеэ барин,

-Танд, мэдээж хувцас хадгалах газарт ажиллахаас гадна шоу-бизнесийн ямар нэг туршлага бий юу? хэмээн эгдүүцэнгүй бүсгүйгээс асуувал,

-Билет шалгагч хийж байхдаа олон кино үзсэн гэлээ.

-Гайхалтай! Хэлэх үг алга! Брэнд авхай чухам яагаад таныг уг киног найруулж чадна гэдэгт итгээд байгаа юм бол?!

Сэм яг л нууц баадууг нь чангалсан бололтой Барбара Картер гэнэт урамшин ярьж эхэллээ.

-Тесси энэ киноны тухай надад олонтоо ярьсан.

Хэзээний "Брэнд авхай" гэхээ больчихсон, Тесси гэх нь тэр!

-Би кино зохиолд оновчгүй хэсэг их байна гэж хэлбэл Тесси надтай санал нэгдсэн юм.

-Та өөрийгөө академийн шагнал хүртсэн зохиолч, галзуутай амжилтанд хүрсэн олон арван кино болон бродвейн дуурийн зохиолчоос илүү ухаж ойлгож байна гэж бодож байна уу?

-Өө үгүй л дээ, эрхэм Уинтерс, би зүгээр л эмэгтэйчүүд арай л илүү учрыг олох байх гэж бодсон юм гээд саарал нүдний харц нь гэнэт ширүүсэн, дуу нь чангаран, -Чухамдаа эрчүүл та нар үргэлж эмэгтэйчүүдийн дүрийг бүтээж байгаа нь танд хачирхалтай юм гэж бодогдохгүй байна уу? Зөвхөн бид л эмэгтэйчүүдийн жинхэнэ сэтгэлийг нээж чадах биш үү! Би юу гэх гээд байгааг та ойлгож байна уу?

Сэм бүр залхаж гүйцжээ. Тэртээ тэргүй энэ хүүхэнтэй гэрээ байгуулан гарын үсэг зурах болсноо мэдээд өөрийгөө үзэн ядах авч, студийг захирч байгаагийн хувьд зураг авалтыг тогтоосон хуваарын дагуу явуулахаас өөр аргагүйджээ. Хэрэвзээ Тесси Брэнд түүний хайртай хэрэмхэн нь эл киног найруулах болбол Сэм түүнд цөмөх самрыг нь худалдаж авч өгөх л үлджээ. Тесси Брэндийн тоглох кино хорь гучин саяын орлого оруулах хийгээд зураг авалт өнөө маргаашгүй эхлэх гэж байхад Барбара Картер зохиолд ямар нэг өөрчлөлт хийж амжихгүй тул гай болох нь юу л бол.

-Та намайг сэнхрүүлж чадлаа шүү гэсээр мань эр егөөдөөд,

-Танд туслахад бэлэн байна. Баяр хүргэе гэлээ.

Маргааш өдрийн "Голливудын мэдээ", "Вэрайти" сонинуудын эхний нүүрэнд Барбара Картер, Тесси Брэндийн шинэ киноны продюссороор томилогдсон тухай мэдээлжээ. Сэм эгдүүцэн сонинг хогийн сав руу чулуудахыг завдтал сонингийн доод хэсэгт нь байсан:

"Тоби Темпл "Тахо" зочид буудалд тоглолт хийх гэрээнд гарын үсэг зурлаа"

гэсэн мэдээлэл түүний анхаарлыг татлаа.

Тоби Темпл. Сэм хэлхийсэн дүрэмт хувцас эгэлдрэглэсэн мохошгүй урам зоригтой залуу хошин шогчийг бодон санаашран инээмсэглээд хэзээ нэг цагт Голливудад очдог юм бол

Тобитой уулзана гэж амласнаа эргэн саналаа.

Бүлэг 13.

Тоби зүрхнийхээ угаас Миллиг урьд урьдынхаас илүүтэйгээр үзэн ядах сэтгэл төрөх болжээ. Түүнийг нүдэнд орсон хог мэт үзэж зэвүү нь хүрдэг бүсгүйтэй нь албадан гэрлүүлснээр Миллиг өөрийн гараар багалзуурдан алах уур хилэн Тобигийн дотор буцлан оргилоно.

Милли гайхалтай эрхэм сайн, үнэнч гэргий байсан ч Тоби энэ бүхнийг ойлгосонгүй. Бүсгүй эр нөхрөө эрхэмлэн тахиж, бүхнийг түүний таалалд нийцүүлэхийг хичээнэ. Милли орон гэрээ өөрийн үзэмжээр сайхан тохижуулан ахуй амьдралаа эрхлэн Тобигийн сэтгэлд нийцүүлэхийг аль байдгаараа хичээх тусам тэрээр эхнэрээ улам бүр жигшинэ. Тоби эхнэрээ Карузод хов хүргүүлэхгүй гэсэн дээ нэг ч үг, ганц ч үйлээрээ гомдоолгүйгээр, Миллитэй өөлөхийн эцэсгүй эелдэг харьцахыг хичээнэ. Гэвч амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл Тоби яс нь шажигнан хугарч тэсэхийн аргагүй өвдөж, мафийн эрийн зэрлэг царайлан,

-Хэрэв чи Миллиг хэзээ ч юм гомдоовол. . . хэмээн сүржин гэгч анхааруулсныг нь үргэлж санах ёстой болжээ.

Тоби хэдийгээр эхнэртээ гаргаж чадахгүй ч гэлээ энэхүү хорсол зэвүүцлээ үзэгчдэд гарган өширхөнө. Хэн нэг нь хундага харшуулах юм уу эсвэл тоглолт дундуур нь бие засах газар руу явахаар босох аваас тэр хүн бусдын элэг доог, инээдэм наадмын бай болдог байлаа. Тоби хүүхдийн гэмгүй царай гарган, учиргүй том цэнхэр нүдээрээ ширтэн хүмүүсийг басамжпан даажигнахад үзэгчид элгээ хөштөл хөхрөлдөн түүнийг бүр ч их эрхэмлэн хайрлана. Тэрээр ерийн нэг ирээдүйтэй хошин жүжигчинээс эхлэн эстрадын жүжигчдийг хүртэл байлдан дагуулсан алдарт жүжигчин болон бусдынхаа атаархалыг төрүүлэх болжээ.

Клифтон Лоренс Европоос буцаж ирээд асрамжлуулагч эрийнхээ санамсаргүй гэрлэлтийн тухай дуулаад ихэд гайхжээ. Энэ нь нэг л хачирхалтай санагдаад Тобигоос өөрөөс нь асуутал мань эр өөдөөс нь эгц ширтэн мөрөө хавчисхийлгээд,

-Энэ тухай яриад байх хэрэг байна уу, Клиф ээ? Би Миллитэй учирсан, дурласан, ингээд л гүйцээ гэжээ.

Лоренсод Тоби нэг л үнэнээ хэлэхгүй байгаа мэт санагдан мөн агент эр Тобиг энэ удаа Лас Вегасын "Тандерберд" зочид буудалд тоглох гэрээ байгуулсандаа ихэд баярлажээ.

-Овоо ашигтай хэлцэл. Сарын хугацаатай гэрээтэй. Долоо хоногт 2000 доллар гэсэнд Тоби,

-Нөгөө аялан тоглолт яах билээ? гэв.

-Түүнийг март. Лас-Вегаст арав дахин илүүг төлнө, тэгээд ч чухал хүмүүс чамайг үзэх болно.

-Вегас чөтгөр шулам руугаа тонилог. Би аялан тоглолтоор явмаар байна.

Клифтон гайхсандаа хэлэх үгээ ололгүй,

-Лас-Вегас чинь ... хэмээн түгдчихэд нь,

-Би аялан тоглолтоор явна гэж хэлэх Тобигийн дуунд огтын шинэ хөг цухалзжээ. Урьдын Тоби, өнөөгийн энэ залуу хоёрын зан харьцаанд нь ижил төстэй юм юу ч үгүй болсон аж. Тоби уур хилэндээ багтарч ядан биеэ барихад нь сайхан сэтгэлт гэмгүй цэнхэр нүдэлсэн залуугаас аймшигт өшөө хорсол ханхлах шиг болдог ажээ.

Энэ өдрөөс хойш Тоби гэрт орж гэгээнд мөргөлгүй олон хотуудаар аялан явах болсон хийгээд энэ нь түүнийг гэр хэмээх шоронгоос ангижрах цорын ганц арга нь болжээ. Тоби шөнийн клуб, театр, эстрадын танхим гээд хаа сайгүй тоглон гэрээгээ дуусмагц дахин тоглох гэрээ байгуулахыг Лоренсод тулгана. Энэ бүхэн зөвхөн Миллигээс хол байхын тулд байв.

Тэрээр хот бүрд газар сайгүй үзэсгэлэнтэй, тачаангуй, бэлэн зэлэн бүсгүйчүүлтэй тааралдаж, тэд Тобиг хаа л бол хаа тоглолтын өмнө эсвэл дараа нь нүүр будгийн өрөөнд, зочид буудлынх нь хүлээлгийн танхимд сахин хүлээцгээнэ.

Гэвч Тобигийн чихэнд Лэндригийн ярьсан өнөөх хөнгөлүүлэн цус нөжтэй нь хутган хаясан эрийн тухай яриа, Карузогийн: "Сонс, азтай залуу минь! Чи ч дажгүй шодойтой юм. . .Би чамайг Миллитэй сайн харьцаатай байвал энэ яваа насанд чинь гомдоохгүй. . . гэх дуу чихэнд нь байнга цуурайтах тул Тоби хүүхнүүдээс аль болох делөн холуур явна.

-Би эхнэртэй хайртай хэмээн мань эрийг ичингүйрэн тайлбарлахад шүтэн бишрэгч эмэгтэйчүүд түүнийг гүнээ хүндэтгэн, Тоби шалиг завхай эр биш юм, тэр гайхалтай гэр бүлтэй хүн гэгдэх болж алдар хүндийг нь гайхан шагшицгаана.

Гэвч гоо үзэсгэлэн төгөлдөр залуу бүсгүйчүүд амар заяаг нь үзүүлэхгүй, тэднээс зугтах тусам улам бүр шургуу хөөцөлдөцгөөх ажээ. Тобигийн хуял тачаал нь улам бүр бадарч, заримдаа бүр дасгал сургуулиа хийж чадахгүй болтлоо давсаг хавиар нь хатгуулан бие бялдрын зовлон амсах болгонд мань эр өөртэй нь энгэр зөрүүлэх гэж тэсгэл алдаж байсан бүсгүйчүүдийг бодон хувь заяандаа гомдоно. Тэрээр сексээс өөр юу ч бодож чадахаа больжээ.

Ховорхон үзэгдэх Тобиг гэртээ ирэхэд халуун янаг, энхрийхэн эхнэр Милли нь тэсэн ядан хүлээж байдаг байлаа. Гэвч өөрт нь учруулсан бүгдийнх нь төлөө үзэн ядаж эхнэрээ харангуут түүний хамаг хүсэл тачаал нь салхинд замхрах мэт ор сураггүй алга болно. Тэрээр эхнэртээ биш харин Карузод ая тал засан долгиносондоо Миллитэй энгэр зөрүүлэхийг өөртөө албадах тул эхнэрийнхээ хүсэл мэдрэмжийг үл харгалзан араатан аятай харгис хэрцгийгээр өширхөн эдлэхдээ түүний өвдсөндөө ёолон орилохыг нь сонсон бах таваа хангана. Тоби хайр сэтгэл дахин амссангүй. Тэрээр үзэн ядах гэгч зах хязгааргүй их дэлайд улам улам живсээр байлаа.

1950 оны зургаан сард Хойд Солонгосын дайчид 38 дугаар паралелиар Өмнөд Солонгос руу довтолж Ерөнхийлөгч Трумен америкийн дайчдыг оруулах тушаал өгчээ. Дэлхий дахин Солонгос дахь дайны талаар огт сонирхохгүй байсан бол харин Тобигийн хувьд энэ нь сүүлийн үед болсон хамгийн сонин содон мздээ байлаа.

Есдүгээр сарын туршид "Вэрайети"-гийн нүүрнээ Боб Хоуп хэсэг жүжигчдийн хамт Сөүл дэх нутаг нэгт цэрэг дайчдынхаа байлдааны урмыг сэргээх сайн санааны аялан тоглолт хийх гэж байгаа тухай зар түглээ. Тоби уг зарыг олж үзмэгцээ даруй харилцуураа шүүрэн авч Клифтон

Лоренстой холбогдон:

-Би Солонгос руу явмаар байна, Клиф! гэжээ.

-Яах гэж?! Чи хэдийнэ гуч шүргэж яваа. Хонгор минь, итгэж үз. Тэд зугаацахаар явж байгаа юм биш. Би.. .

-Намайг зугаацах нь гэж санаа юу! гэж Тоби харилцуур руугаа хашгичаад,

-Тэнд манай залуус алхам тутамдаа амь насаараа дэнчин тавьж байна! Би хэрхэн тэдэнд туслах вэ, хэдхэн зугаатай агшин ч гэлээ тэдэнд хүргэхсэн гэжээ.

Лоренс. Тоби Темплийн ийм байхыг нь урьд хожид огг үзээгүй аж. Агент эрийн сэтгэл хөдлөн шалдаа бууж,

-За яахав, чи үнэхээр эх оронч загнаж байгаа бол бүгдийг зохицуулахыг хичээе хэмээн Клифтон ам алджээ.

Цагийн дараа тэрээр Тобид утасдан,

-Би Хоуптай ярилцлаа. Мань эр баяртайгаар зөвшөөрсөн шүү. Гэвч хэрэв чи бодлоо өөрчилбөл... гэтэл,

-Хэзээ ч үгүй шүү хэмээн Тоби эрс татгалзаад харилцуураа шидчихжээ.

Клифтон Тоби Темплийн талаар удтал бодов. Тэр өөрийн хүмүүжүүлэгчээр үнэхээр бахархжээ. Гайхалтай залуу! Чухамдаа Лоренсод түүний агент болох аз тохион алдарт хүргэх замд нь туслаж байгаа нь юутай сайхан хэрэг вэ!

Тоби Тэгу, Пусан, Чонжуд тоглолт хийн, цэрэг эрс инээд баясалд умбаж байлаа. Миллигийн тухай бодол нь хаашаа ч юм бэ нэг тийшээ сарнин ор сураггүй алга болжээ.

Чингээд аялан тоглолт нь дуусгавар болов. Гэвч Тоби харьж буцахын оронд залуучууд нь түүнийг цаг ямагт баяртайгаар угтдаг Гуам орохоор морджээ. Тэндээсээ цэргийн эмнэлгийн шархтнуудад зориулан тоглохоор Токиогийн эмнэлэг оржээ.

Ирсэн гийчин буцдагийн үлгэрээр Лос-Анжелес руу харьж буцах цаг нь ирлээ.

Өрнөдийн улсуудаар хийсэн арван долоо хоногийн урт хугацааны тоглолтын дараа дөрөвдүгээр сард Тобиг эргэж ирэхэд Милли түүнийг нисэх буудалд угтан авч түүнд дуулгасан эхний үгнь,

-Хонгор минь! Бид хүүхэдтэй болно! гэсэн үгс байлаа.

Тоби зогтусан хирдхийж эхнэрээ ширтэв. Милли түүний сэрдхийх харцыг нь баярласандаа цочирдож байна хэмээн андуурчээ.

-Сайхан байна уу? хэмээн баясан дуу алдаад,

-Одоо чамайг тоглолтоор явахад би гэртээ ганцаараа үлдэхгүй нь. Хүү төрнө гэж найдаж байна, чи хүүгээ аваад бэйсболын тэмцээн бас...

Тоби эл бүх тэнэг явдлыг хүлцэн тэсэх аргагүй боллоо. Эхнэрийнх нь үгс тэртээ хол хаа нэгтээгээс бүдэг бадаг сонсогдоно. Тэрээр сэтгэлийнхээ гүнд хэзээ нэг цагт эл гяндангаас ангижрах боломж олдох агшин ирнэ хэмээн цаг үргэлж итгэж байжээ. Тэд гэрлээд хоёрхон жилийн нүүр үзэж байгаа ч гэлээ энэ хугацаа түүнд өнө удаан үргэлжилж буй мэт санагдана. Одоо Милли түүнийг суллана гэдэг гонжийн жоо. Хэзээ ч үгүй. Хүүхэд ирэх жилийн зул сараар төрөх нь. Тоби Өмнөд Солонгос явах ээлжит тоглолтод явуулж өгөхийг Клифтонд ятгаж чадсан боловч гэнэт Карузод түүний жирэмсэн эхнэрээсээ холдохсон гэсэн хүсэл нь таалагдахгүй байх вий хэмээн эмээв. Ингээд Лас-Вегас руу утасдахаас өөр домгүй болжээ.

Харилцуурт танил, баясгалантай баргил хоолой сонсдон,

-Сайн уу, залуу! Утасдсан чинь сайн болж гэлээ.

-Би ч гэсэн тантай ярихдаа баяртай байна, Эл,

-Удахгүй үрийн зулай үнэрлэж эцэг болох нь гэж дуулдсан! Чи болох ёстой шүү, сэтгэл чинь хөдөлж байгаа биз!

-Хэлэх ч үг олдохгүй нь хэмээгээд Тоби харамсан түгшсэн өнгөөр үргэлжлүүлэн,

-Тэгээд ярьж байгаа минь энэ, Эл ээ. Милли зул сараар төрөх гэж байдаг, гэтэл. . . гэснээ туйлын болгоомжтой байх хэрэгтэй гэдгийг үл умартан,

-Яахаа ч мэдэхээ байлаа. Мэдээж, ийм үед Миллитэй хамт байх хэрэгтэй байдаг, гэтэл намайг Гуам руу дахин явж цэргүүдэд тоглооч гэж гуйгаад байна гэлээ.

Удаан гэгч нь дуугүй боллоо.

-Хэцүүхэн асуудал байна даа гээд Карузо санаа алдав.

-Нөхдийнхөө найдлагыг алдмааргүй байна, гэхдээ Миллиг ч ганцаар үлдээж болохгүй нь.

-Тийм шүү...

Дахиад чимээ тасарлаа.

-Залуу минь, би ингэж бодлоо л доо. Бид бүгд Америкт хайртай, тийм биз? Тэр хөвгүүд бидний өмнөөс тулалдаж байгаа, тийм үү?

-Мэдээж. Гэвч яаж...

-Миллид муу юм тохиолдохгүй гэж Карузо батлаад,

-Амаржих гэж байгаа нь ганц Милли биш. Чи Солонгос руу яв гэх нь тэр.

Хагас сарын дараа зул сарын баярын өмнөх үдэш Тоби нижигнэсэн алга ташилтаар үдүүлэн тайзнаас бууж ирэхэд нь түүнд Милли амьгүй хүүхэд төрүүлээд, өөрөө цус алдан нас нөгчлөө гэсэн цахилгаан утас авчирч өгчээ.

Ийнхүү Тоби эрх чөлөөтэй болох нь тэр ээ.

Бүлэг 14.

1952 оны 8 дугаар сарын 14 нд Жозефина Цински арван гурван нас хүрлээ. Мөн өдөр төрсөн Мэри Лу Кеньон охиныг өөрийн баярт урьсан боловч эх нь Жозефинаг явахыг нь тас хориглон,

-Эд чинь буруу үзэлтэй улс. Чи гэртээ үлдэж, Гэгээн номлолыг судалсан нь өлзийтэй гэжээ.

Гэвч Жозефинад гэртээ үлдэх өчүүхэн ч хүсэл байсангүй. Охин цаг үргэлж заналхийлэлд дарлагдаж тамын зовлон амсах нь юутай хэцүү байдгийг эх нь ойлгоосой хэмээн ихэд хүснэ. Жозефинаг орой үдшийн цагаар хөрш айлын хүүхдийг нь харж өгөөд олсон таван доллараа нуусан газраасаа сэм аван гарч явахыг нь хатагтай Цински анзаарсангүй. Охин дэлгүүр орон цагаан өнгийн гайхалтай сайхан усны хувцас худалдан авч Мэри Лугийн гэрийг чиглэн эрс шийдэмгий алхлаа. Жозефина цагийг сайхан өнгөрөөнө гэдгээ зөнгөөрөө мэдэрчээ.

Мэри Лу Кеньон хотын хамгийн үзэсгэлэнтэй харшид амьдарна. Өрөө тасалгааных нь хананд үнэлж баршгүй уран хээтэй хивс, гайхалтай зура. энд тэндгүй өлгөөтэй, байшинг нь тэр чигээрээ хуучны ховор тавилгаар тохижуулжээ. Харшийн гадаа талбайд нь зочдод зориулсан хүлээн авалтын сууц, адууны жүчээ, теннисний талбай, онгоц буух талбай, хоёр усан бассейны нэг том нь Кеньоны гэр бүлийнх, нөгөө ар талд байх арай бага шиг нь зарц үйлчлэгчдийнх ажээ.

Мэри Лу барааг нь ховорхон олж хардаг Дэвид гэдэг ахтай юмсанж. Тэрээр урьд өмнө арван фут юм уу гэмээр өндөр нуруутай, хөл бөмбөгчний ханхар өргөн цээжтэй, зальжин цовоо саарал нүдтэй ийм үзэсгэлэнтэй залууг огт үзээгүйсэн. Мань эр америкийн шигшээ багийн хагас хамгаалагч болон Родсын цалин авдаг ажээ. Жозефина үе тэнгийн ганган бүсгүйчүүлийн дундуур Дэвидийг хайн нүд гүйлгэвэл хаа ч үзэгдсэнгүй. Урьд нь залуу эр охинтой хэд гурван үг солихыг оролдоход Жозефина чихээ хүртэл улайн үг дуугарч чаддаггүй болчихдог байв.

Баяр сайхан болжээ. Ширээг тойрон арван дөрвөн охид хөвгүүд сууцгаан шарсан үхрийн мах, дэгдээхэй, зууш ундааг хормын төдийд үгүй хийн ховдоглоцгооно. Зоогийн ширээг сэрүүн тавцан дээр засан зарц, үйлчлэгчид зоог зөөн чөлөө завгүй гүйлдэцгээнэ. Дараа Мэри Лу, Жозефина хоёр цугласан бэлэг сэлтийг сонирхон үзэв.

-Явья, усанд шумбая хэмээн Мэри Лу санаа гаргалаа.

Бүгд хувцас солих өрөө рүү уралдацгаав. Усны шинэ хувцсаа өмсөн үймэлдэхийг хараад хэзээ ч ийм жаргалтай байгаагүйгээ Жозефина санав. Найз нөхөд нь эргэн тойронд нь бужигналдсан ямар гайхалтай өдөр гээч вэ.

Жозефина тэдний нэг адил ийм сайхан тансаг орчинд баяр баясгалангаа хуваалцаж байна! Энд ямар ч муу муухай нүгэл хилэнц байхгүй! Энэ өдрийн цаг хугацаа зогсон жаргалтай сайхан өдөр нь хэзээ ч бүү дуусаасай хэмээх цорын ганц хүсэл охиныг эзэмдэнэ.

Охин гадагш гаран усан сан руу явах зуур гэнэт бүгд түүнийг ажиглан охид нь далдуур

агаархацгаан, хөвгүүд нь зальтайгаар сэм сэмхэн харцгаахыг нь анзаарчээ.

Чавхайн томбойх хөх нь усны нимгэн хувцасны цаанаас түрэн мэдэгдэж, нас бие гүйцсэн бүсгүй хүнд баймаар гоолиг нарийн бэлхүүс, урт чилгэр хөл гээд сүүлийн хэдэн сард Жозефинагийн бие галбир нь гайхалтай өөрчлөгджээ.

Жозефина нөхөд тийш очин ус руу үсрэн орлоо.

-Алив "Марко-Поло" тоглоцгооё! гэж хэн нэг нь хашгирлаа.

Энэ тоглоомд Жозефина үнэхээр дуртай төдийгүй нүдээ анийлган бүлээн усанд шумбах нь түүнд таалагддаг ажээ.

Тоглоомын дүрэм ёсоор охин,

-Марко! хэмээн хашгирах ёстой агаад бусад нь,

-Поло! гэж хариулцгаав.

Ингээд Жозефина баригдсан нэгнээ "халтаахай" болгохоос нь өмнө өрсөн тэдний хашгирах дуунаар усанд самарч эхлэв.

Тоглоом эхэллээ. Сисси Тоннинг тоглоомыг манлайлж байв. Охин өөрт таалагддаг Бэб Жексоны араас хөөвөл тэрээр булт үсрэн алга болтол гэнэт Сиси Жозефинаг барихаар завдлаа.

Охин хамаг хүчээрээ нүдээ анийлгаад инээд наадам усны цалгиаг сонсоод,

-Марко! гэж хашгирвал бусад нь хөгжилтэйгээр,

-Поло! хэмээн дуу нийлүүлэн хариулцгаав.

Жозефина усанд самран хэсэг зуур хөвлөө.

Хэн ч үзэгдсэнгүй.

-Марко! гээд дахин хашгиртал,

-Поло! хэмээн хоолой нийлүүлэн хашгирах сонсдов.

Жозефина хэн нэгнийг барихаар оролдсон боловч алдаж орхилоо. Энэ тийм ч чухал бишээ, бусад нь гавшгайлан тоглоомоо үргэлжилжлүүлж л байг, гагцхүү энэ өдөр мөнхөд үргэлжлээсэй бипээ.

Гэнэт Жозефинагийн дотор нь палхийгээд өчүүхэн төдий хөдөлгөөн, усны цалгиа, шивнэн ярихыг анзааран сонсоод дотор нь палхийжээ. Тэрээр гишгүүр тийш дөхөж очин дээш гарч,

-Марко! гэж хашгирлаа.

Хариу байдаггүй, таг чиг. Жозефина яахаа мэдэхээ болин самгардав.

-Марко! гэвэл,

Таг чимээгүй. Тэд даажигнахаар шийджээ! Түүнд хариу дуу гарахгүй гэж тохиролцжээ! Жозефина инээмсэглэн нүдээ нээв. Тэр доод гишгүүр дээр цор ганцаар зогсон усны хувцасны нь урд талд улайран, хөлийг нь даган нарийхан цусан судал урсаж байлаа. Бусад нь усан сангийн дээр таг дуугүй зогсоцгоон түүнийг ширтэнэ. Жозефина айн дээш өлийн хараад,

-Би. . .

Хэлэх үгээ олж ядан ичгүүртэй явдлаас бултахаар ус руу бушуухан гэгч нь үсэрлээ.

-Бид усан санд ийм юм хийдэггүй гэж Мэри Лу хэлбэл,

-Гэхдээ польшууд бол ч хийж дөнгөнө дөө гэж хэлээд хэн нэгний хи-хи инээх сонсдов.

-Яг үнэн. Биеэ нэг л бузарлагдчихсан юм шиг санагдаад явчихлаа.

-Ийм усанд хэн сэлэхийг хүсэх вэ дээ? Жозефина дахиад л нүдээ анин холдон явах хөлийн чимээг сонсов. Тэд бүгд яваад өгсөн ч гэлээ тэрээр нүдээ нээн,

байрнаасаа хөдлөхөөс ч айж байлаа. Олиггүй муухай цусан судлыг зогсоохын тулд гагцхүү хөлөө аль болох чангаар хавчихыг л оролдоно. Өнөөдрийн өдрийг хүртэл тэрээр сарын тэмдэгтэй учраагүй явсан нь охинд гэнэтийн явдал болжээ. Байж боломгүй юм. Найз нар нь мөдхөн эргэн ирж, даажигнан тоглосноо хэлэн урьдын адил түүнтэй нөхөрлөн, өнөөдрийн аз жаргал нь эргэн ирнэ. Үгүй, үгүй тэд заавал эргэж ирээд энэ бүхэн тоглоом байсныг хэлэх болно.

Эсвэл хэдийнэ эргээд ирчихсэн юм биш үү?! Тэрээр урьдын адил нүдээ тас аниад,

-Марко... хэмээн шивнэлээ.

Охины сулхан шивнээ нь үд дундын аагим халуунд уурших мэт ор сураггүй алга болжээ.

Жозефина нүдээ анин, усанд хөдөлгөөнгүй хэдий хэртэй зогссоноо мэдсэнгүй.

"Бид усан санд ийм юм хийдэггүй... Гэхдээ польшууд бол ч хийж дөнгөнө дөө..."

Чамархай тушаад нь алхаар нүдэх мэт чангаар цохилон, хоолой нь бачууран, ходоод гэдэс хавиар шөрмөс нь татчихлаа.

Жозефина явж болохгүйг сайн ойлгож байв. Тэр нөхөд нь эргэн ирж түүнийг тоглон даажигнаснаа хэлэхийг нь хүлээнэ.

Гэнэт шор шор хийх хөлийн чимээ гарах сонсдоход одоо л бүх юм сайхан болно гэдгийг Жозефина ойлголоо. Нөхөд минь эргээд ирж! Охин өлийн харлаа. Шатан дээр Мэри Лугийн ах Дэвид сагсгар халаад барьчихсан зогсож байв.

-Би тэдний өмнөөс уучлал гуйхаар ирлээ хэмээн нухацтай гэгч нь хэлээд түүнд халаадаа сарвайв.

-Май. Уснаас гар, үүнийг нөмөрчих.

Жозефина тэр даруй мөсөн хөшөө болон хувирчээ. Тэрээр зовхио унжуулан зөвхөн үтэр түргэн хорвоог орхихыг л хүсч байлаа.

Бүлэг 15.

Энэ өдөр Сэм Уинтерсийн ажил овоо урагштай байв. Тесси Брэндийн тоглосон шинэ кино нь жүжигчин бүсгүй мандаасан хэргээ наминчлан эрвийх дэрвийхээрээ зүтгэсний хүчинд овоохон амжилтанд хүрчээ. Мөн Барбара Картер оны шилдэг продюссероор тодрох нь нүднээ илт болжээ. Хувцасны загвар зураачид кино найруулахаар гүйлдээд эхэлбэл яах билээ? !

"Пан-Пасифик"-ийн телевизийн "Миний нөхөр-Баасан" киног эс тооцвол мөн давгүй амжилттай байж хамгийн өндөр рейтинг хүртжээ. Телекомпаниуд Сэмтэй богино хэмжээний кино хийлгэхээр таван жилийн гэрээ байгуулцгаав.

Сэм үдийн унданд явахаар зэхэж байтал Люсиль орж ирээд,

-Дөнгөж сая засал чимэглэлийн өрөөнд өнөөх галдан сүйтгэгчийг баривчилсан гэнэ, одоо нааш нь авчирч явна! гэлээ.

Сайхь эр Сэм руу харан буйдан сандалд таг дуугүй сууж, студийн хоёр хамгаалагч түүний ард нь зогсоцгооно. Хэрэгтэн эрийн нүд хорсолтойгоор гялалзана. Сэм хэсэг зуур гайхан цочирдсоноо улмаар биеэ эзэмдэн,

-Яаж байгаа чинь энэ вэ? Бурхныг бодож хэлээч, яах гэж "ингэдэг билээ? гэж асуувал,

-Яагаад гэвэл чиний новшийн өглөг тэтгэлэгийг хүртэхийг хүсэхгүй байна хэмээн Даллас Берк шазуур зуун хариулаад,

-Чамайг, энэ студийг, чиний бүх л бөөс хуурстаа баригдсан бизнесийг, бүгдийг үзэн ядаж байна. Энэ бүхнийг би өөрөө босгосон юм, өөрөө, чи тийм сүрхий хүн үү. Та нар бүгд миний ачаар баяжиж хөлжөө биз дээ! Кино найруул гэхийн оронд намайг эндээс зайлуулахыг оролдож, шал мангуу хулгайн сэдэв худалдаж аваад сууж байгаа биз! Чи надад утасны лавлах ч гэхнээ худалдаж авч өгсөн бил үү, Сэм ээ. Би ямар ч өгүүлэл тавиагүй, надад ажил л хэрэгтэй байна! Чамаас болж би үхэн үхлээ өчүүхэн амьтан хэвээр явах нь! Үүнийг чинь би хэзээ ч өршөөхгүй! гэлээ.

Даллас Беркийг аваад явснаас хойш Сэм мань өвгөний тухай, найруулсан гайхалтай кинонуудынх нь тухай удтал бодон хөдөлгөөнгүй суув. Өөр бизнес эрхэлсэн бол Берк нэр хүндтэй агуу баатар, захиргааны төлөөлөгч байж тусгай тэтгэвэртэйгээр чөлөөндөө гарах байсан даа. Гэвч тэрээр зөвхөн кино урлаг хэмээх ид шидийн ертөнцийг сонгосон аж.

Бүлэг 16.

50-аад оны эхээр Тоби Темплын алдар хүнд улам бүр өсч Филадельфи, Чикаго, Бостон, Нью-Йоркийн дээгүүр зэрэглэлийн шөнийн клубуудад элсэн, ойн баяр, буяны үдэшлэг, хүүхдийн эмнэлэгт тоглох гэхчилэн урилга бүрийг уриалагхан хүлээн авч дуртай цагтаа хаашаа ч хамаагүй явна.

Алга ташилт, цэцэгс, шүтэн бишрэгчидгүйгээр амьдарч чадахгүй Тобид үзэгчдийн хайр талархал ус, агаар мэт хэрэгтэй болжээ. Дэлхий дахинд болж буй чухал үйл явлууд нь Тобигийн хувьд түүний хошин шогийн өөнхийн шинэ сэдэв болж байлаа.

Эйзенхауэрийг ерөнхийлегчид сонгосон, Сталин нас нөгчсөн, Монтгомерийн хар арьст эмэгтэйн автобусанд үүсгэсэн дуулиан, амьд хүний наймаачид, ерөнхий сайдуудын тухай, улс төрийн байдал. . . гэхчилэн. Энэ бүх мэдээлэл Тобигийн шинэ жүжгийн баялаг нөөц нь болж байв.

Нүүрэндээ инээмсэглэл тодруулсан гэнэн нүдтэй, гэмгүй царайлсан энэ эрийг үзэгчид рүү ёжтой хошигнол чулуудахад сэтгэл нь хөөрсөн хүмүүс тэчъядан хашгирах ажээ. Тэрээр ганц ч хором зогсолтгүй хошин үгээр булж байхад үзэгчид нулимсаа гартал инээн бахардах шахна. Шүтэн бишрэгчид нь Тобиг эрхэмлэн хайрлах тэдний хайр ивээл нь түүнд улам улам ахин дэвших эрч хүчийг сэлбэх бөлгөө.

Гэвч Тоби энэ бүхэнд сэтгэл ханасангүй, үргэлжид шинийг, сэтгэл татам сонирхолтойг эрэлхийлнэ. Тэр сайхан үдэшлэгээс, алдартай танхимд тоглохоос илүүтэйгүүр хамгаас үзэсгэлэнтэй бүсгүйг үнсэхгүй хоцрохчих вий гэхээс цаг ямагт айна. Сэтгэлгүй эхнэртэй тулгагдан гэрлэн хал үзсэнээсээ хойш эмс хүүхнүүдтэй үүрдийн холбоо тогтоохоос татгалзан хонгор бүсгүйчүүлийг эгээ л бээлий аятай солих болсон ажгуу. Тоби цэл залуухан байхдаа 3-р зэрэглэлийн газруудад хэсүүчлэн тоглож байснаа үе үе санана. Тэр үед лимузин хөлөглөн, орд харшид жарган, үзэсгэлэнтэй хүүхэн дагуулсан алдартай хошин жүжигчдэд атаархаж үхэх шахдаг байжээ. Гэтэл одоо хамаг хүсэл мөрөөдөл нь биелэсэн ч гэлээ өөрийгөө ганцаардаж байгааг гэнэт мэдэрчээ. "Чи оройд нь гарсан тэр цагт эргэн тойрон юм бүхэн эл хуль хоосон оргино" хэмээн хэн нэг нь дэмий ч нэг хэлээгүй боллолтой.

Хувь заяа нь Тобиг манлайд нь гаргажээ. Тэрээр ээжийнх нь зөн совин биелэж байгааг, эл бүхнийг нь эх нь үзэж амжаагүйд тэрээр ихэд харамсдаг ;жээ.

Тобигоос өөрцгүй эхийг нь санан дурсаж буй цорын ганц хүн эцэг нь байлаа. Аль өнгөрсөн зууны эцсээр баригдсан нурж унах нь шахсан тоосгон байшинд насжисан эцэг нь амьдарсаар. Хана туурганд нь өвгөрөл, үхэл, өвчин гаслангийн үнэр танар нэвт шингэжээ.

Тобигийн эцгийнх нь тархинд нь цус харван цог жавхаагүй нүдэлсэн, өрөвдөлтэй нэгэн тахир дутаа амьтан болон хувирчээ. Өдгөө мань өвгөн ховорхон ирэх хүүгийнхээ эргэлтээр сэтгэлээ сүлэн гол зогоон амьдарч байлаа. Тоби ногоон хивс дэвссэн сүүмгэр хүлээлгийн танхимд өөрийг нь таалан ширтэх сувилагч, өвчтөнүүдийн дунд зогсоно.

-Би өнгөрсөн долоо хоногт Хэролд Хобсоны шоу дээр таныг олж харлаа. Та ёстой гайхалтай

байсан шүү! Ийм ухаалаг хошигнол таны санаанд яаж орж ирэв ээ? !

-Надад биш ээ, зохиолчидод гээч хэмээн Тобиг хариулахад түүний даруухан зангаж байгааг бахдан бүгд хөхрөлдөцгөөв.

Гудмаар тэргэнцэрийн хяхтнах дуу сонсдон асрагч эр сахал самбааг нь цэмцийтэл хусан, үсийг нь самнасан тахир татуугийн тэргэнцэртэй эцгийг нь түрэн айсуй. Тэрээр хүүгээ эргэж ирсэнд нь зориулан гоёлын костюмаа хүртэл өмсөн гоёжээ.

-Хөөе, энэ чинь сайхан эр Бруммель байх шив! хэмээн Тобиг дуу алдахад бүгд эрхэм Темплийг атаархан харцгааж, агуу жүжигчинтэй яс махны тасархай байтугай ураг төрөлтэй байх хувь заяа тохиогоогүйд харамсан шүүрс алдацгаана.

Тоби аавдаа дөхөн очиж бөхийн халуун дотноор чанга тэврэв.

-Хэний толгойг эргүүлэх гээв, аав аа? гэж асуугаад асрагчийг заан,

-Сонсооч энэ залуу таныг тэргэнцэрээр зөөх биш, харин та түүнийг түрэх юм биш үү гэлээ.

Хурсан олон хөхрөлдөцгөөн, "Би өчигдөр Тоби Темплтэй уулзсан, тэр хэлэхдээ. . . Би дэргэд нь яг ингээд, чамтай зэрэгцэн зогсож байгаа шиг хажууд нь зогсчихоод, амьдаар нь харж, хоёр чихээрээ сонссон. . ." хэмээн сайрхахыг хүсэн хэлсэн хошигнолыг нь тогтоохыг хичээцгээнэ.

Тоби дунд нь зогсоод тэдний хувийн амьдрал, эрүүл мэнд, үр хүүхдийг нь алагчлан шоолон басамжилж байхад тэд энэ бүхнийх нь төлөө түүнийг улам ихээр хайрлацгаана.

Тоби эцэст нь харамсан санаа алдаад,

-Надтай учирсан хамгаас эрхэм үзэгчид та нарыг ингээд орхиод явмааргүй ...

Энэ бүхнийг нь тэд санан бусаддаа хахаж цацлан инээд наргиа болгон хөөрөлдөх нь...

-За одоо би эцэгтэйгээ хэсэг зуур хамт баймаар байна. Тэр надад нилээд хэдэн шинэ хошин яриа бэлэглэнэ гэсэн юм.

Бүгд хөхрөлдөн баярлацгаан түүнийг бахдалтайгаар гарч явцгаав.

Тоби эргэлтийн өрөөнд эцэгтэйгээ хоёулхаа үлдлээ. Энд ч гэсэн үхлийн үнэр ханхлах ажээ. Чухамдаа энэ газар хэнд ч хэрэггүй, бусаддаа лай ланчиг болон улмаар үхэх тавилантай хүмүүст зориулагдсан ажгуу.

Тэднийг, зөнөж өвгөрсөн эцэг эх нь хэрэггүй болон баян орд харшынхаа зочдын өрөө, гал зуухнаас зайлуулан агуулдаг мухрын жижигхэн өрөөнөөс энд авчирчээ. Үр хүүхэд, хамаатан садангууд нь орсон гарсан зочин гийчингээс ичихдээ эцсийн эцэст энэхүү байшин руу илгээдэг юмсанж.

"Энэ бүхэн таны л төлөө гэдэгт итгэ, аав минь (ээж, ах Жорж, эгч Бесс минь)Та тэнд үе

тэнгийн олон сайхан хүмүүстэй уулзаж сайхан нөхөрлөх болно. Миний юу гээд байгаа ойлгож байна уу?

Өөрөөр хэлбэл энэ нь: "Бид таныг бусдад хэрэггүй болсон хөгшидтэй хамт үхэх газар руу тань илгээж байна. Хувцас хунар, ширээний бүтээлгийг балиартуулах, нэг л үүх түүхээ зуун найман удаа давтан ярьж, орондоо бие засахыг чинь харсаар залхаж гүйцлээ" гэж байгаа хэрэг ажээ.

-Чамайг ирсэнд би их баяртай байна хэмээн эцэг нь удаан гэгч нь түгдчин бувтнаад,

-Надад чамд дуулгах шинэ мэдээ бий. Өчигдөр Арт Рейли өнгөрчихлөө гэв.

Тоби гайхан түүнийг ширтээд,

-Энэнд чинь сонин сайхан нь юу байна даа? гэж асуувал,

-Одоо би түүний өрөөнд нүүж орох болно. Ганц хүний өрөө байгаа юм хэмээн эцэг нь тайлбарлав

Эндхийн хөгшидийн жаргал нь нэг өдөр ч гэхнээ амьд байж, өчүүхэн ч гэлээ тух тохь, баяр баясгаланг эдлэх явдал юмсанж. Тоби амьд явснаас үхсэн нь дээр баймаар олон хүнийг энд харсан гэлээ ч тэд амьдрал хэмээгч олсноос хамаг хүчээрээ амь тавин чангаан зууралдаж байдаг нь гайхалтай.

Явах цаг нь болжээ.

Тоби эхний л боломж гармагц эргэж ирэхээ амлан эцэгтээ мөнгө үлдээн, сувилагч асрагч, албан хаагчдад үлэмж шан хөлс өгч эцгийг нь харж хандана гэсэн ам өчигийг нь аваад явлаа. Уйтгарт байшингийн босгыг давмагц Тоби бүхнийг умартжээ.

Бүлэг 17.

Арван долоон нас хүрсэн Жозефина Цински Техас мужийн Одесс хотхондоо оч гэрэлтсэн том хүрэн нүд, гоолиг нарийн бэлхүүс, тэгш сайхан хөл, товгор хөх, наранд туяаран гялалзах урт хар үс гээд өөгүй сайхан үзэмжээрээ хамгийн үзэсгэлэн төгөлдөр бүсгүй болжээ.

Гэвч түүний орон зай зөвхөн эгэл хүмүүсийн дунд гэдгийг ухаарсан бүсгүй өдгөө нефтийн эздийн хүүхдүүд болон, хуучин найз нартайгаа харилцаагаа тасалжээ. Сургууль төгссөнийхөө дараа тэрээр зуны "Алтан Деррик" кино театрт үйлчлэгчээр ажиллах болов. Тэр нь задгай театр учир машинаасаа ч буухын хэрэггүйгээр кино үзэх боломжтой аж. Мэри Лу, Сисси Топпинг найз нөхдийнхөө хамт энд байнга ирдэг ч гэсэн Жозефина тэдэнтэй эелдэгээр мэндлэхээс биш, яриа дэлгэхийг огтхон ч хүсдэггүй байлаа.

Үгээр хэлэхийн аргагүй нэг л хачирхалтай хорон уйтгар гуниг түүний сэтгэлийг тарчлаана. Бүсгүй ядуу дорой энэ хотыг орхин явахыг хүсэх авч хаа хүрч, юу хийхээ даанч нэг төсөөлөхгүй байлаа. Залуучууд цаг үргэлж Жозефинаг хоргоон эргүүлж танилцахыг хүсэх агаад тэдний дундаас Уоррен Хоффман гэгч ээжид нь ихэд таалагдах болжээ.

-Уоррен сайн нөхөр болж чадна. Тэр ямагт сүм хийдээр явдаг, гаршсан чадамгай ус түгээгч, цалин ч сайн авдаг, чамд үнэхээр үхэж байна шүү.

-Хоффман хэдийнэ хорин тав хүрсэн, бас дэндүү тарган юм гэвэл ээж нь толгой сэгсрэн,

-Ядуу польш бүсгүй хуяг дуулга агссан баатар эрд санаархаж хаа нэгтгээгээс хайгаад ч нэмэргүй. Ингэж өөрийгөө хуурахын хэрэг юу байна хэмээн үглэнэ.

Жозефина долоо хоногт ердөө л ганц удаа Уоррен Хоффмантай кинонд явах гэж байдаг чадлаараа өөрийгөө албадана. Мань эр ганц агшин ч гэлээ бүсгүйн гарыг тавилгүй хөлстэй, эвэршсэн том гартаа атган суухыг нь Жозефина эс анзааран дэлгэц рүү шимтэн, кино ертөнцөд бие сэтгэлээрээ уусан суудаг ажээ. Үзсэн харсан нь нэг л сайхан ид шидийн ертөнц мэт санагдан, өссөн төрсөн эгэл ертөнц нь түүнд сонирхолгүй сэтгэгдэл төрүүлнэм.

Өөрийнх нь дотоод ухамсрынх нь хаа нэгтээ алсад чухам хүү Голливуд түүний хүсээд байгаа тэр л гоо үзэсгэлэн, баяр баясгалан, инээд баясал, аз жаргал бүхнийг өгнө гэдгийг Жозефина мэдэрч байлаа. Зөвхөн азтай гэрлэлт бүсгүйд хүссэн амьдралыг нь бэлэглэн одоогийн орог саарал, барагтайхан амьдралаас нь салгаж чадна. Гэвч хүсэхэд хясах гэгчээр баян чинээлэг харчуул хэдийнэ хээ нийлсэн баян бүсгүйчүүлтэй учран дэл сул хүнгүй болжээ.

Жозефина, Дэвид Кеньоны тухай цаг үргэлж бодох бөгөөд хэдэн жилийн өмнө Мэри Лугийнхаас түүний гэрэл зургийг сэм хулгайлсан агаад түүнийгээ ханын шүүтгээндээ нуун, сэтгэл хямарсан үедээ гарган ирж зургийг харах бүрдээ Дэвид усан сангийн хашлага дээр зогсоод: "Би тэдний өмнөөс уучлал гуйхаар ирлээ" гэснийг нь эргэн санана.

Дэвид халаад авчирч өгсөн тэр нэгэн аймшигт өдрөөс хойш Жозефина түүнийг ганц удаа эцэг эх, охин дүүгийнхээ хамт машинаар явж байхыг нь харсан байна. Бүсгүй хожим нь тэд Дэвидийг үдэж өгөхөөр галт тэрэгний буудал явж байсныг нь олж мэджээ. Тэр Англи руу

Оксфордын их сургуульд суралцахаар мордсон нь тэр ажгуу. Энэ нь дөрвөн жилийн тэртээ 1952 онд болсонсон. Дэвид Зул сарын баяраар, зуныхаа амралтаар ирдэг байсан ч хувь заяа нь тэднийг учруулсангүй, харин охид бүсгүйчүүл түүний тухай хов жив дуулган Жозефина сайхь залуугийн тухай сураг ажиг үргэлж сонсож байлаа. Эзэмшил газар, эцгийн өвөөс гадна Дэвидийн эмэг эх нь түүнд таван сая долларын итгэлийн фонд үлдээжээ.

Атаархмаар тэр хархүү оёдолчны охинд заяахгүй нь лавтай.

Жозефина Дэвидийг Европоос эргэж ирснийг нь мэдээгүй байв. 7-р сарын нэгэн бямба гаригийн үдэш бүсгүй кинотеатртаа ажиллаж байлаа. Одессын хүн амын тэн хагас нь аагим халуунаас зугтан хоргодох газар хайн, цангаагаа тайлах гэхдээ гурав дөрвөн литр ундаа, содтой ус, өч төчнөөн порц зайрмаг захиалж, Жозефинад амсхийх зав үл олдно. Кино театрын эргэн тойрон хурц өнгийн неон гэрэл анивчин, машин тэрэг гахалдан зогсож буй нь худаг дээр цугласан үзэгдэж харагдаагүй төмөр араатан амьтад лугаа үзэгдэх бөгөөд сюрреалист чиглэлийн зураачийн уран зөгнөл гэлтэй.

Бүсгүй тоогоо алдсан чизбургер, кока-коланы захиалга аваачиж өгчихөөд халааснаасаа хоолны цэсээ гарган, цагаан өнгийн спорт загварын машин руу алхлав.

-Оройн мэнд! Та юу захиалах вэ? гэж цоглог дуугаар асуув.

-Сайн уу, танихгүй бүсгүй минь!

Танил дуу, тэр тусмаа Дэвид Кеньоны дуу мөн болохыг нь таньмагц Жозефинагийн зүрх нь галзуутай цохиллоо. Залуу эрийн цээнд хүрч урьд өмнө байгаагүй өөртөө итгэлтэй, бүр ч үзэсгэлэнтэй болжээ. Түүний дэргэд үзэсгэлэнтэй, дэгжин, үнэтэй торгон цамц өмссөн Сисси Топпинг зэрэгцэн суугаад 7 сарын бүгчим үдэш бус арван сарын хүйтэн орой яваа мэт ийш тийш жихүүцэн харна.

-Сайн уу, Жози. Хонгор минь чи ийм халуунд ажиллах албагүй шүү дээ.

Жозефинагийн хүслээр болдогсон бол энд машин сүлжин ёрдойн гүйж явснаас кинотеатрын танхимд суух эсвэл Дэвид Кеньонтой машинаар зугаалж явсан нь хамаагүй дээрсэн.

Гэвч бүсгүй дуугаа өндөрсгөлгүй дуулдах төдийхөн,

-Та нар шиг малнуудтай яасан ч нийлэхгүй гэлээ.

Дэвид инээмсэглэн байх нь бүгдийг ойлгосон бололтой.

Тэднийг явмагц Дэвидийн үг бүрийг эвлүүлэн эргэн саналаа.

"Сайн уу, танихгүй бүсгүй минь... Надад гахайн давтсан мах, пиво... үгүй хэрэггүй, кофе дээр биз. Бөгчим халуун үдэш хүйтэн ундаа болох уу? Хэрэггүй... Чамд энд ажиллах таалагдаж байна уу? За яахав, болбол чек биччих үү... Хариултыг нь өөрөө аваарай... Чамтай уулзах сайхан байна шүү, Жозефина" Бүсгүй шууд ойлгоогүй нууц далд утга санааг тайлахыг хичээлээ. Мэдээж Сиссигийн дэргэд өөр яах ч билээ, Дэвид шиг хүн Жозефинатай хэрхэн

нийцэх вэ дээ! Тэрээр бүсгүйн нэрийг санаж байгаа нь тун ч гайхалтай!

Бодолдоо дарагдсан бүсгүй кинотеатрын гал зууханд угаагуурын дэргэд зогсож байтал залуу мексик тогооч эр Пако гэнэт гарч ирээд,

-Жозита юу болоов? Чи нэг л хачин харагдах чинь! гэв.

Хорин настай, хар үстэй, гоолиг биетэй, үргэлж эелдэг зөөлөн инээд, цовоо хошигнолоороо хорт санаа, хэрүүл уруулыг сарниулан арилгаж чаддаг залуу эр бүсгүйд ихэд таалагддаг байжээ.

-Тэр хэн бэ?

-Хэн ч биш ээ, Пако гээд Жозефина толгой сэгсрэв.

-За, за. Цаана чинь өлөн зөлмөн зургаан машин галзуурах нь байна, гүйчих!

Маргааш өглөө нь Дэвид утасдаж буйг Жозефина харилцуур авахаасаа өмнө мэдэрчээ.

-Илүү үг хэлсэнд уучлаарай, хэлье гэж бодоогүй шүү, чи сайхан бүсгүй болжээ гэж залууг мэндлэхийн оронд хэлэхэд нь Жозефина хагартлаа баярлажээ.

Дэвид орой нь түүнийг хоолонд урихад нь найз нөхөдтэйгээ мөргөлдчих бий гээд холын нэгэн жижигхэн ресторанд орох байх гэж бодтол харин ч бүр эсрэгээр танил нөхөд нь ширээ тойрон зогсон мэндлэх түүний клубт очих нь тэр. Дэвид хэн нэг нь Жозефинатай явж байгааг харчих вий хэмээн ичиж зовох нь бүү хэл харин аз жаргалтай тун ч бардам байлаа. Бүсгүй түүний эелдэг сайхан зан, гоо үзэмж, түүний дэргэд байх туйлын аз жаргалтайг ойлгон дурлажээ.

Хорвоо ертөнц дээр ийм гайхалтай сайн хүмүүн байх юм гэж бүсгүй огт бодож байсангүй. Ингээд өдөр бүр ажлаа тараад Дэвидтэй уулзах болов.

Цаг хугацаа өнгөрсөөр, тэд улам олонтоо уулзан хамт байцгаан Дэвид өөрийн аж явдлаа, гэр орныхоо дутагдлыг Жозефинатай хупзалцах болжээ.

-Ээж намайг ажил үүргийг гартаа авахыг хүсч байна, гэвч би өөрийн амьдралаа үүнд зарцуулах эсэхээ сайн мэдэхгүй байна гэжээ.

Кеньоныхон нефтийн цооногоос гадна нефть цэвэрлэх худаг, мал аж ахуй эрхэлдэг эдлэн газар, зочид буудлын сүлжээ, хэд хэдэн банк, томоохон даатгалын компанитай юмсанж.

-Чи зүгээр татгалзаж болохгүй гэж үү, Дэвид ээ?

-Чи миний ээжийг мэдэхгүй л дээ гээд санаа алдав.

Жозефина ийм өндөр залууг хэрхэн төрүүлж чадсан юм бол гэмээр Дэвийн эх болох жижигхэн, эмзэг биетэй эмэгтэйтэй уулзаж явсан удаатай. Тэрээр гурван удаа төрснийхөө

дараагаар зүрхний өвчин нь хүндэрч сандаргадаг байжээ. Энэ бүх л хугацаанд эх нь өөрийн өвчин зовлонгоо эс тоон тэднийг хорвоод мэндлүүлэх хэмээн чармайхдаа өөрийн амь насаараа дэнчин тавин байж төрүүлж өсгөсөн гэдгээ үр хүүхдүүдээ огт хэлдэггүй учраас тэрээр гэр бүлдээ маргашгүй хүндэтгэл хүлээдэг байна.

-Би өөрийн сонгосон замаар явмаар байвч ээжийгээ зовоохыг хүсэхгүй байна. Үнэнийг хэлэхэд доктор Ли түүнд бидэнтэй амьдрах хугацаа тун бага үлдсэн гэдгийг сануулсан хэмээн Дэвид өгүүлэв.

Харин Жозефина Голливуд орон од болохыг мөрөөдөж байгаагаа хэлмэгц залуу бүсгүйг таг дуугүй ширтэж байснаа эцэст нь,

-Би чамайг явахыг зөвшөөрөхгүй гэж нухацтайгаар хэлэв. Бүсгүйн зүрхээр учиргүй хатгуулжээ. Тэд орой болгон уулзан улам бүр дотносно. Дэвид язгууртнуудыг даган дуурайхыг өчүүхэн ч хүсдэггүй тул Жозефинагийн гарал угсаа ямар байх нь түүнд огт хамаагүй зүйл байв.

Ажил нь тарах дөхчихсөн тул Дэвид бүсгүйг машиндаа хүлээж суулаа.

Жозефина, Пако хоёр сав суулга цэвэрлэн гал зууханд зогсоо зайгүй ажиллана.

-Болзоондоо яарч байна уу, аан? гэж Пако асуув. -Чи яаж мэдээв? гэвэл,

-Чи толинд нэг хараадах, царайнаас чинь гэрэл цацарч байна! Тэрхүү азтай залуудаа миний мэндийг хүргээрэй! Хүмүүсийг их аз дайрах юм даа! гэлээ.

-Тэгнэ ээ, Пако гээд сэтгэл нь хөдөлсөндөө бүсгүй өлмий дээрээ өлийн мексик эрийн хацар дээр нь үнслээ.

Гэтэл хормын төдийд моторын уухилах дуу чангаар хүржигнэн цардмал замаар дугуй хавиран хяхтнах нь тэрээ. Бүсгүй Дэвидийн цагаан өнгийн спорт загварын машин нисэх мэт хурдлан давхин одохыг л харж амжив.

Юу болсныг ухаарч чадаагүй Жозефина бүсгүй ***** гадас мэт хөдөлгөөнгүй зогсон, шөнийн харанхуйд машины улаан гэрэл хэрхэн уусан алга болохыг яаж ч чадахгүй харсаар хоцорчээ.

Шөнийн 3 цагт Жозефина унтаж чадахгүй орондоо хөрвөөж байтал моторын дуу гарахад нь огло харайн босч гадагш харвал жолооны ард ухаан алдтал согтсон Дэвид сууж байх нь тэр. Тэрээр унтлагын хувцас дээрээс халаадаа сандчин нөмрөөд гүйн гарав.

-Суу гэж Дэвид чанга гэгч нь тушаав.

Жозефина урд хаалгыг онгойлгон суудалд гулган суулаа. Хэсэг зуур таг дуугүй байснаа Дэвид ам нээн согтсондоо биш сонсогдох төдий хахирган дуугаар уур хилэн буцалсан, хорсол жигшилтэй үгээр дайрч гарлаа.

-Би чамайг хорих албагүй л дээ. Чи хүссэн бүхнээ дураараа хийх ёстой, гэвч надтай уулзаж учирч байхдаа, миний найз бүсгүй биеэ зөв авч явахыг шаардах эрхтэй гэж бодож байна! Тэгээд ямар ч тохиолдолд үзээрийн муухай мексик эрийг үнсэхгүй, ойлгов уу! гэлээ.

Жозефина арчаагүй дорой тээнэгэлзсэн харцаар түүнийг ширтээд,

-Би яагаад Паког...үнсэв гэвэл... Түүнийг тэгж хэлэхэд... би өөрийгөө үнэхээр аз жаргалтай байгааг мэдэрсэн...Тэр миний найз...

Дэвид гүнзгий гэгч нь санаа алдаад хилэгнэсэн зүрхнийхээ хөөрлийг дарав.

-Би одоо чамд нэгийг хэлье. Үүнийг хэн ч мэддэггүй юм.

Жозефина таг дуугүй яахаа мэдэхгүй суулаа.

-Надад Бет эгч минь бий. Би түүндээ ухаангүй хайртай.

Мэри Лутай тоглохоор очихдоо язгууртны цагаан царайтай, цайвар шаргал үстэй, гуалиг, үзэсгэлэнтэй бүсгүй Беттэй хэд хэдэн удаа уулзсанаа Жозефина бүүр түүрхэн саналаа. Түүнийг нас барахад Жозефина 8-тай, Дэвид 15-тай байсансан.

-Түүнийг нас барсныг санаж байна гэж Жозефина өгүүлэв.

-Бет амьд.

-Гэвч... би... бүгд өнгөрсөн гэж...

-Тэр одоо галзуугийн эмнэлэгт байгаа. Манай цэцэрлэгч-мексик эр түүнийг хүчиндчихсэн юм. Бетийн унтлагын өрөө миний өрөөний эсрэг талд байрладаг байсан. Би түүнийг хашгирахыг сонсоод өрөө рүү нь харайн орсон. Цэцэрлэгч эр Бетийн хувцсыг урж тасдан түүн дээр... гээд Дэвид гашуун дурсамжийг бодон санаа алдаад, -Би ээжийг ирэхээс өмнө, цагдаа дуудаагүй байхад нь түүнтэй зодолдсон. Шоронд суулгасан тэр шөнө цэцэрлэгч эр өөрийгөө боомилсон. Гэвч Бет маань ухаан солиорч галзуугийн эмнэлэгээс хэзээ ч гарахгүй болсон доо. Хэзээ ч шүү. Жози, би эгчдээ хайртай, тун ч их санах... Тэр шөнөөс хойш надад... Би тэвчихгүй...

Жозефина түүний гарыг атган,

-Надад үнэхээр харамсалтай байна, Дэвид. Би ойлгож байна. Чи энэ бүгдийг ярьсан нь яамай даа.

Энэ явдлаас хойш Жозефина, Дэвид хоёр улам ихээр дотносжээ. Жозефина эхийнхээ шашинд улайран сүсэглэдэг тухай ярихад нь Дэвид инээмсэглэн,

-Манай нэг ах бас яг тийм. Тэгээд түвдийн хийд рүү яваад өгсөн хэмээснээ,

-Ирэх сард би хорин дөрөв хүрнэ. Манай гэр бүлийн хуучин уламжлалаар Кеньоны бүх

эрчүүд хорин дөрөвтгэйдээ гэрлэдэг ёстой гэлээ.

Жозефинагийн зүрх баярлан догдоллоо. Маргааш нь Дэвид театрын билет авчихаад бүсгүйг хүлээж байснаа,

-Хаашаа ч яваад яах вэ. Ирээдүйнхээ тухай ярих хэрэгтэй байна гэжээ.

Үүнийг сонсоод Жозефина Бурхан түүний залбирлыг хариулж байна гэдгийг ойлгожээ. Дэвидийн нүднээ хайр гэрэлтэн байх үзэгдэв.

-Дьюи-Лейк орох уу гэж бүсгүй санал гаргалаа. Бүсгүй бүх л амьдралынхаа туршид санан дурсаж үр хүүхэддээ ярин, энэ ид шидийн шөнийг ой ухаандаа үүрд хадгалахсан хэмээн ер бусын сайхныг мөрөөджээ.

Тэд Одессоос дөчин милийн тэртээд орших Дьюи-Лейк хэмээх бяцхан нуурыг чиглэн явлаа. Орой дээр нь одод гялтганан, саран авхай зөөлөн сүүн гэрлээрээ бүхнийг гийгүүлнэ. Үй түмэн амьд бие амьдран дурлан, залбиран, зовж шаналан, үхэж үрэгддэг орчлон ертөнцийн үл таних дуу авиа сонсогдон нуурын ус цагаан толбо мэт цайран үзэгдэв.

Жозефина, Дэвид хоёр шөнийн чимээг чагнан машиндаа хэсэг чимээгүй сууцгаав. Бүсгүй жолооны ард бодолд авган санаашран суугаа Дэвидийг нүд салгалгүй ширтэнэ. Жозефина түүнийг энэ мөч шиг хэйрлаж байсангүй тул Дэвидэд өөрийнх нь хайр ямар агуу вэ гэдгийг ойлгуулан ер бусын бэлэг барихыг хүсчээ.

Ингээд бүсгүй гэнэт юу хийх ёстойгоо ойлголоо.

-Явж усанд сэлье хэмээн тэрээр шивнэв.

-Надад усны хувцас байхгүй шүү дээ.

-Тэр хамаагүй.

Залуу Жозефина руу харж нэгийг хэлэх гэтэл бүсгүй машинаас годхийн гарч эрэг тийш гүйх зуур даашинзаа тайлан хаялаа. Араас нь Дэвид ирж явах чимээ сонсогдов. Жозефина бүлээн усанд түргэн гэгч нь шумбан орлоо. Агшин зуур Дэвид хажууд нь ирчихээд,

-Жози... гэв.

Тэрээр эргэн харвал дурлалдаа шатан тэсэн ядах залуугийн тэвэрт орчихлоо. Нуурын ус тэдний биеийг зөөлөн илбэн, ямар нэг хатуу халуун зүйл цавь тушаа нь тулахыг Жозефина мэдэрчээ.

-Болохгүй, Жози болохгүй хэмээн хүсэлдээ шатсан сөөнгө дуугаар залууг шивэгнэхэд бүсгүй,

-Болно, Дэвид, болно ... гэсээр түүнийг илбэн таална.

Тэд эрэг дээр хэрхэн гарснаа ойлгосонгүй, газар дэлхий, одот тэнгэр, хилэн хар харанхуй

шөнийн тэнгэр дор нэг цул болон бие биедээ уусчээ. Удаан гэгч нь бие биесээ тэврэн хэвтсээр, Дэвид түүнийг нилээн оройхон гэрт нь хүргэж өгөв. Жозефина гэнэт хуримын тухай юу ч дурсаагүйг саналаа. Гэвч өнөөдрийн эдэлсэн жаргал нь ямар ч хуримын ёслолоос ч илүүтэй байлаа, тэрээр маргааш ирээд эхнэрээ болохыг гуйх болно.

Маргааш нь Жозефина үд болж байхад сэрээд баясгалантайгаар инээлээ. Гартаа хуучин боловч гоёмсог сүй тавих ёслолын дашинзыг болгоомжтой гэгч нь барьсан ээжийгээ орж иртэл эл жаргалтай инээмсэглэл нь бүсгүйн нүүрэнд тодорсоор байжээ.

-Даруйхан Брубейкерийнд очоод 12 ярд капрон аваад ир. Хатагтай Топпинг өөрийн дашинзаа авчирлаа. Бямба гариг гэхэд Сиссидээ амжиж дашинз хийлгэх гэнэ. Тэр Дэвид Кеньонтой гэрлэх гэж байна гэх нь тэр.

Дэвид Жозефинаг гэрт нь хүргэж өгөөд даруйхан ээжтэйгээ ярилцахаар шийджээ. Жижигхэн танхил ч гэлээ үзэсгэлэнтэй хэвээр байгаа ээж нь хэдийнэ орондоо оржээ.

Дэвидийг гэрэл муутай унтлагын нь өрөөнд ороход эх нь нүдээ нээн инээмсэглээд,

-Сайн уу, хүү минь. Чи өнөөдөр оройтлоо гэв.

-Би Жозефинатай уулзаад, ээжээ. Тэрээр юу ч хэлсэнгүй, ухаалаг саарал нүдээрээ Дэвидийг цоо ширтэнэ.

-Би түүнтэй гэрлэмээр байна гэж Дэвидийг хэлэхэд эх нь зугуухан толгой сэгсэрч,

-Хүү минь, чамайг ийм алдаа хийхийг тэвчихгүй гэлээ.

-Та Жозефинаг огт мэдэхгүй биш билүү. Тэр...

-Түүнийг үзэсгэлэн гэй сайхан бүсгүй гэдгийг мэдэж байна, гэхдээ Кеньонд тохирох эхнэр лав биш. Сисси Топпинг чамд аз жаргал амсуулна. Хэрэв зээ чи түүнтэй гэрлэвэл, би тун ч жаргалтай байх болно.

Дэвид эхийнхээ турьхан гарыг нь атган,

-Ээж ээ, би танд их хайртай, гэвч бүгдийг өөрөө шийдэх ёстой гэж бодож байна гэлээ.

-Тийм гэж үү! Чи хэзээ ч алдахгүй биз? хэмээн намуухан асуулаа.

Дэвид таг дуугүй эхийгээ харан сууна.

Тэрээр үргэлжлүүлэн,

-Үргэлж чиний санаснаар байж болно гэдэгт найдаж болох уу, Дэвид ээ? Өөрийн ухаантай байгаа гэдгийг чинь мэдмээр байна? Аймшигтай алдаа хийхгүй...

Дэвид гараа огцом татаж авав.

-Өөрийн зөв гэдэггээ чи үргэлж итгэлтэй байна уу, хүү минь? хэмээн эх нь бүр ч намуухан дуугаар асуулаа.

-Ээж минь, бурхныг бодож!

-Чи багагүй дүрсгүйтсэн шүү, Дэвид. Цаашид бүү зовоогоорой. Жирэмслэлтээс үлдсэн энэ хүндрэлийг би тэсэхгүй нь...

Дэвидийн царай цонхийн цайгаад ирлээ.

-Чи мэднэ шүү дээ, би юу ч . . . яаж ч чадахгүй байгааг. Чи өсөж, эрийн цээнд хүрч хойшид гэр орноосоо хөндийрч холдохгүй эр хүн шиг биеэ авч явах цаг чинь болж!

-Би. . . би түүнд хайртай хэмээн тэрээр зовж шаналан байж хариулав.

Эх нь таталт өгч эхлэн Дэвид эмч дуудах хэрэг гарчээ. Бүгд нам тайван болсон хойно эмч толгой сэгсрэн,

-Дэвид минь, ээжийн чинь амьд явах хугацаа тун бага үлдсэн байх вий гэж эмээх юм гэлээ.

Ингээд Дэвид эхийнхээ төлөө шийдвэр гаргалаа.

Дэвид Сисси Топпингийнх руу очин,

-Би өөр хүнд дурласан. Гэтэл ээж минь үргэлж биднийг...

-Би ч гэсэн тэгж бодож байсан юм, хонгор минь .

-Надад итгэ, би аймшигтай юм ярьж байна гэдгээ ойлгож байна. . . гэвч чи надтай гэрлээд, харин . . . дараа нь ээжийг өнгөрсөн хойно салахыг зөвшөөрөх үү?

Сисси дээш өлийн намуухан дуугаар,

-Хэрэв чи үүнийг хүсч байгаа бол тэгье, Дэвид ээ гэжээ.

Тэрээр сэтгэлийн бөөн тээг арилан дотор нь онгойхыг мэдэрчээ.

-Баярлалаа, Сисси. Юу гэж хэлэхээ ч мэдэхгүй. . . хэрхэн талархахаа...

-Хуучин анд нөхдийн хэрэг юу билээ? гээд Сисси инээв.

Дэвидийг гармагц бүсгүй тэр даруй эх рүү нь утасдаж,

-Бүгд ёсоороо боллоо гэсэн ганц өгүүлбэр хэлжээ.

Жозефинад өөрөө дуулгаж, учирлан тайлбарлахаас нь өмнө хуримын зарыг сонсохыг Дэвид тэсвэрлэхгүйсэн. Түүнийг бүсгүйн гэрт ирэхэд хатагтай Цински үүдээ нээв.

-Би Жозефинатай уулзах гэсэн юм гэж Дэвидийг хэлэхэд эмэгтэй түүнийг ад шулмын хилэгнэсэн харцаар цоортол ширтсэнээ,

-Гэгээн Христ дэлхий дээрх муу хүн зонтой учран тэднийг устгах болно, нүгэлтнүүд үеийн үед үүрд хараал идэж явах болно гэж шүдэн завсраар заналтайгаар исгэчүүлэн хэллээ.

-Би Жозефинатай уулзах гэсэн юмсан хэмээн Дэвид тэвчээртэйгээр давган хэллээ.

-Тэр явчихсан! Үүрд явчихсан гэж хатагтай Цински хэдэрлэв.

Бүлэг 18.

Грейхаунд-Одесс-Пасо, Сан-Бернардино, Лос-Анжелесын чиглэлээр яваа замын тоосонд дарагдсан автобус Голливудын автобусны зогсоол дээр өглөөний 7 цагт хүрч ирлээ. Хоёр өдрийн зүдэргээтэй урт аяллын дараа Жозефина Цински нэрээ өөрчлөн Жилл Касл гэгдэн Голливудын үүд хаалгыг татаж буй нь энэ. Гадна өнгөндөө бүсгүй урьдын адил харагдах авч дотоод сэтгэл нь тэс ондоо болжээ. Урьдын аз жаргал, инээд баясал... гээд бүх л баяр баясгалан нь үүрд булшлагджээ.

Хуримын тухай Жозефина дуулмагцаа агшин зуурын төдийд долоон уулын цаагуур далд орон, ор сураггүй болох ёстойгоо мэджээ. Тэр хаа хүрч, юу хийхээ ч мэдэхгүй атлаа хамаг новшоо чемодандаа замбараагүй гэгч чихэж гарлаа. Түүний тархи толгойд нь гагцхүү зугтах, энэ газраас аль болох түргэн зугатах хэрэгтэй гэсэн ганцхан бодол тасралтгүй эргэлдсэн аж.

Бүсгүй унтлагын өрөөнийхөө босгыг даван гарахын өмнө хананд өлгөсөн кино жүжигчний хөргийг харсан даруйдаа толгой хоргодох газар хаанаас хайхаа ойлгов. Хоёр цагийн дараа гэхэд бүсгүй хэдийнэ Голливудыг зорин автобусанд суугаад явж байжээ. Одесс хотхон, түүнтэй холбостой юм бүхэн ой ухаанаас нь нэн даруй мартагдан бүүдгэрч, сууж буй автобус нь түүнийг шинэ хувь заяанд нь хүргэж өгөхөөр хурдлан давхина. Өдгөөгөөс эхлэн түүний амьдрал ер бусын аз жаргалтай байх болно.

Жозефина Цински мөнхөд нойрссон.

Жилл Касл мандан бадарна!

Бүлэг 19.

Вашингтон-пресс клубынхан Ерөнхийлөгчийн урилгаар ирдэг хүндэт зочдын цайллагын үдийн хоолыг жил бүр даадаг уламжлалтай ажээ. Энэхүү хүндэтгэлийн хүлээн авалтанд дэд ерөнхийлөгч, сенатор, сайд нарын танхимын гишүүд, Дээд шүүхийн төлөөлөгчид гээд тасалбар худалдаж авах чадалтай нөлөө бүхий хүмүүс, мөнгө олох сүйхээтэй эсвэл хулгайлж дөнгөх хэн хүнгүй ирдэг ажээ. Уг ёслолын ажиллагааг нь дэлхий дахинд шууд цацдаг тул Америкийн шилдэгийн шилдэг жүжигчид хөтлөгчийн үүргийг гүйцэтгэнэ.

Тэр үед гэнэт Тобигийн аз нь шовойжээ. Юу вэ гэвэл хүүхдийн эцэг тогтоолгох зарга, мухар олгой нь үрэвсэж хагалгаанд орсон, АНУ-ын ерөнхийлөгчтэй нүүр тулсан гэх өөр хоорондоо авцалдаагүй гурван шалтгааны улмаас супер од болох нь тэр.

Энэ жилийн хөтлөгч хийлгэхээр Нэгдсэн Улсын нэгэн алдартай хошин жүжигчинг товлосон байжээ. Гэтэл мань эр долоо хоногийн дараа хүүхдийн эцэг тогтоолгохоор өгсөн арван таван настай хохирогч охины заргын хариуцагч болон шүүгдэх болж, тэрээр өмгөөлөгчийнхөө зөвлөснөөр тодорхой бус хугацаагаар эх орноосоо нэн даруй зугтан дайжих хэрэгтэй болжээ. Зохион байгуулах хорооныхон товлосон бас нэгэн хөтлөгч болох телевиз, киноны алдарт кино одод ханджээ. Тэрээр Вашингтонд ирсэн боловч маргааш өдөр нь агент нь утасдан жүжигчиний мухар олгой үрэвсэн эмнэлэг явсныг дуулгаж гэнэ. Хүлээн авалт болоход ердөө л зургаан цаг үлдсэн тул зохион байгуулагч гишүүд орны хөтлөгчийг хайх ажилд шуранхайлан орцгоов. Цуутай жүжигчин болгон зураг авалттай завгүй эсвэл товлосон хугацаанд Вашингтонд ирж амжихааргүй хол байлаа. Боломжийн хэмээгдэн товлосон хүн бүхэн бүтэлгүйдэн зөвхөн Тоби Темпл гэсэн нэр л үлджээ. Гишүүдийн нэг нь толгой сэгсрэн,

-Темпл бол шөнийн клубэд тоглодог. Дэндүү цадиггүй амьтан. Ерөнхийлөгчийн дэргэд зоргоор нь тавьж хэрхэвч болохгүй! гэхэд нь,

-За хаанаас даа, бид түүнээс амаа татахыг гуйгаад, материалыг нь хянан эмхэлчихвэл бүх юм ёсоороо болно гэж зохион байгуулах хорооны өөр нэг гишүүн эсэргүүцэв. Ахлагч босч толгой дохин,

-Харчуул минь, оргүйгээс охинтой нь дээр гэгчээр тэгэхээс яах вэ. Мань эр Нью-Йоркод байгаа, цагийн дараа гэхэд энд ирчихнэ. Ямар чөтгөр нь өнөөдөр хүлээн авалт товлдог байна аа! гзлээ.

Ингээд Тоби Темплийг залахаар тогтоцгоов. Тэрээр хүлээн авалтын танхимд хурсан олныг хараад, яг одоо хэн нэг нь энд бөмбөг дэлбэлбэлчихвэл Нэгдсэн Улсын засгийн газар толгойлох удирдагчгүй үлдэх нь гэсэн эсэргүү бодол төржээ.

Ерөнхийлөгч гол ширээний тэргүүнд сууж, түүний араар овоо хэдэн нууц албаны төлөөлөгчид зогсжээ. Үдийн зоогонд бэлтгэн үймэлдэцгээж хэн ч Тобиг ерөнхийлөгчид танилцуулахыг санасангүй. Гэвч энэ нь түүнд юуны ялгаа байх вэ, удахгүй ерөнхийлөгч түүнийг сайн таньдаг, тэр ч бүү хэл тун удаан санах болно гэдэгт мань эр огт эргэлзсэнгүй. Тэр зохион байгуулах хорооны төлөөлөгч Даунтай уулзсанаа, түүний хэлснийг эргэн саналаа.

-Таны тоглолт бидэнд их таалагддаг шүү, Тоби. Та хүмүүсийг элэглэхдээ их наргианч байдаг. Гэсэн хэдий ч. . . гэснээ мань эр хоолой засан, -Харин өнөөдөр энд их эмзэг ноёд, хатагтай нар цугласан байгаа. Мэдээж тэд таны гэм хоргүй хошигнолд гомдохгүй л дээ, гэвч юу хэлэх гээд байна вэ гэвэл, энэ танхимд юун тухай яриа чих дэлснэв тэр бүрийг сурвалжлагчид даруй олзлон аваад дэлхий дахинд цацах гэмтэй. Мэдээж бидний хэн нь ч ерөнхийлөгч, конгрессын гишүүдийг гомдоохыг хүсэхгүй. Эцэст нь хэлэхэд зочдыг хөгжөөж болно, гэвч хэн нэгнийг бүү уурлуулаарай даа! гэжээ. -Надад итгэ гээд Тоби инээмсэглэжээ.

Үйлчлэгчид аяга тавгаа хурааж дуусмагц нь Даун микрофон руу очиж,

-Ноён ерөнхийлөгч өө, хүндэт зочдоо! Та бүхэнд манай хөтлөгч, хошин урлагын нэрт залуу жүжигчинг танилцуулахдаа баяртай байна. Ноён Тоби Темпл! гэлээ.

Найрсгаар хүлээн аван алга ташилт нижигнэж Тоби микрофоныг чиглэн очоод үзэгчдийг гүйлгэн харчихаад АНУ-ын ерөнхийлөгч тийш эргэв.

Ерөнхийлөгч "ясны дипломатч" гэсэн нэрэндээ огт дүйцээгүй энгийн, хээгүй гүдэсхэн нэгэн байлаа.

Тэрээр "Бидэнд юу хэрэгтэй байна вэ гэвэл бие биетэйгээ зүрх сэтгэлээрээ харьцах явдал. Бүгдийг компьютерт найддагаа зогсооё, төрсөн биеийнхээ авьяаст найдаж эхэлцгээе. Би бусад улсын гадаад явдлын яамдын сайд нартай уулзалт хийх мөчдөө толгойгоор нь биш, бүсэлхийнээс доохнуур бөгсөн биетэй нь ярьж дасах хэрэгтэй юм гэдгийг би мэдэх болсон" хэмээн нэгэн удаа ард түмэндээ хандан үг хэлэхдээ гэнэ алдсан удаатай.

Ийнхүү алдсан үг нь орон даяар түгэн таржээ. Тоби анх удаа ерөнхийлөгчтэй нүүр тулж байгаадаа баярлан,

-Ноён Ерөнхийлөгч өө, дэлхий дахиныг өөрийн бөгсөөрөө номхотгож байдаг хүнтэй нэг танхимд учирч байгаадаа сэтгэл хөдөлсөнөө юу гэж илэрхийлэхээ мэдэхгүй нь! гэж бахархсан өнгөөр хэлчих нь тэр.

Эргэн тойрон хирдхийн цочирдож таг дуугүй болцгооход ерөнхийлөгч тэсгэлгүй пар хийтэл инээд алдлаа. Үзэгчид ч түүнийг дагалдан хөхрөлдөцгөөн танхимд алга ташилт нижигнэлээ. Санасандаа хүрсэн Тоби барьц ахиулан сенатор, Дээд шүүхийнхэн, хэвлэл мэдээллийнхэн рүү дайралт хийсэн ч тэд огт гомдож цухалдсангүй.

Эл зоогт гадаад орны яамдын сайд нар хүрэлцэн ирсэн байжээ. Тоби тэдэнд хандан төрөлх хэл дээр нь чадварлагаар элэглэн хошигноход сайдууд толгой дохин сайшаан хөхрөлдөцгөөв.

Үзэгчид суудлаасаа босон талархаж мань эр бүхий л үдшийн турш алга ташилтаар шагнуулан, тэр ч атугай ерөнхийлөгч суудлаасаа босон, өөрөө Тоби дээр хүрч очин,

-Гайхалтай, ёстой гайхалтай! Даваа гаригийн орой бид Цагаан ордонд даруухан оройн зоог барих юм, хэрэв зээ. . . би тун их баярлахсан.

Маргаашийн өдрийн бүх л сонингуудад Тоби Темплийн ялгуусан амжилтын тухай бичигцгээн, түүний тэнд хэлсэн хошин үгс амнаас ам дамжин тархах болов. Тэрээр Цагаан ордонд уригдан мөн л дориухан шуугиан дэгдээжээ. Нэр хүнд бүхий театр, клубуудээс урилга заллага тасралтгүй хөврөн Тоби английн хатан хааны өмнө, сайн санааны тоглолтонд, Лондонгийн "Палладиум" театрт, Урлагийн үндэсний хорооны хуралд суун, Ерөнхийлөгчтэй гольф тоглохоор Цагаан ордонд байнга уригдан хооллох болжээ. Тэр хуулийнхан, губернатор, томоохон корпорацийн ерөнхийлөгчидтэй учран ширүүхэн элэглэх тусам тэд улам бүр Тобиг хайрлах болов.

Урилга заллага баян далай мэт цалгилж энэ бүхэн өнгө мөнгө бизнестэй огт хамаагүй байгаад Клифтон Лоренс Тобигоос багагүй сэтгэл хөдлөн баярлана. Тобитой учирсан нь сүүлийн жилүүдэд тохиосон хамгийн чухал учрал байсан агаад Лоренс Тобиг өөрийн хүү мэт үзнэ. Тэрээр бусад үйлчлүүлэгчдээс илүүтэй цаг хугацаа, эрч хүчээ зөвхөн Тобид зориулна.

Мань эр шоу бизнесийн хүрээнд ховорхон тохиолдох өгөөмөр, нинжин сэтгэлийг эрхэмлэн хүч хайрлалгүй ажиллан өөрийн авьяас билгээрээ тодорч улам бүр гялалзах болов.

-Лас Вегасын сайн сайн зочид буудлууд араас чинь хөл мэдэн хурдалцгааж байна хэмээн Лоренс шинэ сонин мэдээ дуулгаад,

-Дурын үнэ хөлсөөр шүү. Тэдэнд мөнгө чухал биш, гагцхүү чамайг л хүсч байна. Мөн "ХХ зуун Фокс" "Юниверсал", "Пан Пасифик"-ууд зохиол явуулан гол дүрд нь чамайг тоглохыг гуйж байна. Эсвэл Европ даяар аялан дурын теде-студиудэд шоу-бизнес хийж болох юм, үлдсэн хугацаандаа Вегаст тоглох төлөвлөгөө гаргая гэлээ.

-Телешоугаар хэдийг олж болох вэ, Клиф?

-Долоо хоногтоо цагийн эстрад концерт тогловол дор хаяж тэднээс арван мянгыг авч дөнгөнө. Хоёр гурван жилийн гэрээ хийчихнэ. Чи тэдэнд үнэхээр хэрэгтэй байгаа бол, тэд хэлсэн бүгдийг хийнэ.

Тоби хөл нь газар хүрэхгүй хөөрөн баярлаж буйдан дээр халхайн суулаа. Тоглолт бүр 10000, жилийн турш тоглоно. Мөрөөдлийн ертөнцдөө хүрэхэд гурван жилд сая гаруй доллар! Тоби Клифтоныг ширтэв. Гэмгүй царайлан суух агент эрийг хараад Тоби мань эр дотроо хэрхэн баярлан хөөрч байгааг нь тун сайн ойлгож байлаа.

Тэрээр Тобиг телевизийнхэнтэй гэрээ хийхийг хүсч байгаа. Яагаад үгүй гэж? Клифтон Тобигийн хүнд хүчир ажлыг зохицуулсныхаа харамжинд 120000 доллар хүртэх болно. Лоренс ийм шан хүртэх ёстой бил үү? Тоби дахин хэзээ ч бохир заваан толгой хоргодох газар эрэн бэдэрч, согтуу үзэгчид өмнөөс нь хоосон лонх шидлэхийг, хямдхан янхан хүүхнээс хүртсэн заг хүйтэн өвчнөө эдгээх эм тан хайн үхэн хатан гүйхээргүй болжээ. Энд тэндгүй арвагнан гүйлдэх жоомтой өрөө тасалгаа, идэхийн эцэсгүй хуршсан хоол, нэр нь ч үл мэдэгдэх хот дамжин шөнөжингөө эцэс төгсгөлгүй аялах ямар байдлыг Лоренс яахан мэдэх билээ? Үгүй, тэр хэзээ ч ойлгохгүй.

Хэн нэгэн шүүмжлэгч Тоби Темпл нэгэн шөнийн дотор од болсон хэмээснийг нь сонсоод

Тоби удтал инээжээ. Мань эр Клифтон Лоренс руу харан толгой дохиод,

-Өөрийн телешоу хийе гэлээ.

Долоон хоногийн дараа "Консолидэйтэд бродкастинг"-тэй гэрээ хийжээ.

-Телекомпанийнхан дутсан санхүүжилтыг аль нэг кино студээр гаргуулахыг хүсч байна гэж Клифтон Лоренс Тобид хэлснээ,

-Дашрамд хэлэхэд би зураг авах гэрээ байгуулчихаж дөнгөх учраас энэ санал надад таалагдаж байна гэлээ.

-Ямар студитэй?

-"Пан-Пасифик".

-Сэм Уинтерс үү? гээд Тоби царай барайлган асуув.

-Яг зөв. Бизнесийн хүрээнд түүнээс илүү захирал үгүй гэж би үздэг. Тэгээд ч түүнд кино зохиолын эрх байгаа нь бидэнд чухал байна! "Залуу эр Өрнийг зорьсон нь".

-Би түүнтэй хамт армид алба хаасан юмсан.

-Сайн байна. Тэр надад өртэй. Мань хүнийг шахна аа!

Клифтон Лоренс, Сэм Уинтерс хоёр халуун орны модны үнэр ханхалсан агаараар амьсгалан "Пан Пасифик" студийн бүгчим оргисон спорт зааланд сууцгаана.

-Амьдралаа гэж! гэснээ агент эр санаа алдаад,

-Мөнгө хэнд хэрэгтэй юм бэ?

-Үнэ хаялцан наймаалцахдаа чи яагаад энэ үгээ хэлдэггүй билээ, Клиф! хэмээн Уинтерс мушигнан инээв.

-Анд минь, чамайг хэт эрхлүүлэхгүй гэсэндээ л тэр.

-"Консолидэйтэд бродкастинг" Тобитой гэрээ байгуулсан гэж би сонссон.

-Тэгсэн. Урьд өмнө ховорхон санал болгодог байсан тийм өндөр үнээр.

-Шоуныхаа дутсан санжүүжилтыг хаанаас авах гэж байна даа?

-Чи яагаад энэ тухай асууна вэ, Сэм?

-Бид туслаж чадахсан. Тэр ч байтугай би зураг авалтын талаар тохироход ч бэлэн байна. Дөнгөж саяхан "Залуу эр Өрнөдийг зорьсон нь" кино зохиол худалдаж авсан. Тоби гол дүрд нь яг таарна гэж бодож байна.

Лоренс хөмсөг зангидан,

-Чөтгөр ав! Би урьд нь мэдээгүй нь харамсалтай! "Метро-Голдвин-Мейер"-тэй хэдийнэ тохирчихсон гэв.

-Гарын үсэг зурчихсан уу?

-Бараг л... Би амлачихсан. . .

20 минутын дараа гэхэд Клифтон Лоренс Тоби Темплийг: "Залуу эр Өрнөдийг зорьсон нь" киноны гол дүрд тоглуулахын

зэрэгцээгээр "Пан Пасифик" студи түүний телешоуг санхүүжүүлэхээр тохирчээ.

Тоби Темплийн гэрээнд мань эр сургуулилт дээр байх албагүй гэсэн зүйл орсон агаад түүний орлон тоглогчоор уригдсан жүжигчин шог жүжиглэл, бүжгийн номерт нь тоглон Тоби зөвхөн бичлэг хийх сургуулилт дээр ирэх ёстой байлаа.

1956 оны 9 -р сард Тоби Вайн-стритын шоуны бичлэг хийж буй театрт хүрч ирэн дүн нурууг нь үзэхээр эхний эгнээнд тухлан суулаа. Жүжиг дуусахын алдад тэрээр тайз руу харайн гарч орлон тоглогчийн оронд зогслоо. Гэтэл заалын уур амьсгал жигтэй сонихноор өөрчлөгдөж, тоглолт тэр чигээрээ амь орж гялалзсан агаад энэ үдэш 40 сая телевиз үзэгчид дэлгэцнээсээ нүд салгаж чадсангүй.

Телевизийнхэн чухамдаа дур татам Тоби Темплийн дүрийг дэлгэц дүүрэн үзүүлэхэд олон түмэн амьдаар нь үзэхсэн гэж туйлаас мөрөөдөж . . . Шоу нь галзуутай амжилтанд хүрч хамгийн өндөр рейтинг хүртжээ. Өдгөөгөөс эхлэн зуун зууны туршид Тоби Темпл ерийн нэг од биш супер од болон хувирав.

Бүлэг 20.

Голливуд жинхэнэдээ Жиллийн хүсэн мөрөөдөж байснаас илүүтэй хүчтэй сэтгэгдэл төрүүлэв. Бүсгүй хэдэн өдөр дараалан жуулчдын хамт Голливудын дурсгалт газрууд, кино оддын амьдардаг дүүргээр аялажээ. Жилл хэзээ нэг цагт Бель-Эйрт эсвэл Беверли-Хиллзэд амьдрах болно гэдэгтээ итгэж байлаа. Харин бүсгүй одоогоор ягтаа тулсан тавилгатай арван хоёр унтлагын өрөө бүхий дотуур байрны үзэмж муутай хоёр давхар модон байшингийн нэг өрөөнд нь суух болжээ. Өрөөний хөлс нь тийм ч үнэтэй биш нь бэл муутай Жиллд зол болон гэрээсээ авч гарсан 200 доллараа жаахан ч атугай хэмнэхэд нэмэр болж байв.

Эл байр нь Голливудын зүрх болсон Голливуд-стрит, Вайн-стритээс холгүй, хэдхэн минут алхаад хүрчих Бронсонд байрлана. Эндхийн арван хоёр оршин суугчид нь олны юм уу туслах дүрд ч гэхнээ хавчуулагдан дүрээ үлдээчих санаа өвөртөлсөн, зарим нэг нь кино урлагийн бизнесээ орхин чөлөөндөө гарцгаасан нь Жиллийн сонирхлыг ихэд татжээ. Ноорхой халаад, үрчгэр костюмтай, үсэндээ бигуж ороон, төдий хуучин биш ч гэлээ өнгөө алдан элэгдсэн гуталтай "хөгшчүүл" хийх юмгүй өдөржин гадуур хэсүүчлэмз. Орой үдшийн цагаар тэд нурж унах шахсан тавилгатай нийтийн өрөөнд цуглацгаан шинэ соргог дуулсан мэдсэнээ солилцон, хов зөөн хошуу худалдацгаадаг аж. Бүгд Жиллд зөрөлдөөнтэй ч гэлээ чин сэтгэлийн зөвлөгөө өгцгөөнө.

-Хонгорхон минь кино урлагт шургалж орох хамгийн сайн арга бол өөрийг чинь таалах Т-ЭН-ыг олох хэрэгтэй гэж саяхан телевизээс халагдсан яравгар бүсгүй ятгана.

-Т-ЭН гэж юу юм бэ? гэж Жиллийг гайхан асуухад нь, -Туслах найруулагч юм хэмээн бүсгүй хүлцэнгүйгээр тайлбарлаад,

-Тэр л чухамдаа тоо бүртгэгчийг хөлсөлдөг юм гэжээ. Жилл тоо бүртгэгч гэж хэн болохыг асуухаас зовлоо. -Миний саналыг мэдье гэж байгаа бол хэн нэгэн хүүхэмсэг найруулагчтай танилцах хэрэгтэй. Туслах найруулагч зөвхөн өөрийн зурганд авна, гэтэл найруулагч юунд ч хүргэж чадна! гэсээр дал гаруй настай, шүдгүй эмгэн хөндлөнгөөс оролцов.

-Дэмий донгосох гэж! Тэд чинь бүгд л азарган тахианууд хэмээн урьд нь нилээдгүй догшин дүрд тоглож байсан болов уу гэмээр халзан жүжигчин хошуу нэмлээ.

-Ялгаа юу байна?! Хамгийн гол нь нүүр тал олон шургалж орох, орсон хойноо бол өөр гэсээр найруулагчийн тушаалд санаахаархаж буй нүдний шилтэй, буурьтай нэгэн залуу үг хавчуулав.

-Нийтийн хэсгээс эхлэвэл яасан юм бэ? гэж Жилл хулган асуугаад,

-Бүртгүүлэх төв товчоонд ... гэвэл,

-Энэ тухай бодохын ч хэрэггүй. Чамд гоц гойд авьяас, мэргэжил үгүй бол зуун жил хүлээсэн ч бүртгэхгүй.

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ?

-За даа, жишээлбэл чи хөл гаргүй, өрөөл татуу бол ердийн хөлсний 21 доллар хагасын оронд 33 доллар 58 цент, бас чи өөрийн өмсгөл хувцастай эсвэл морь унаж чаддаг бол 28 доллар 33 цент хүртэнэ. Хөл бөмбөг, бейсбол тоглож чаддаг бол өрөөл татуучуудад өгдөг хөлсийг өгнө, за тэгээд заан эсвэл тэмээ унавал 55 доллар 94 цент авна даа. Сайн санаанаас зөвлөхийг минь сонс, нийтийн дунд хутгалдахын хэрэггүй. Болж өгвөл туслах дүр олж тоглохыг бод.

-Ялгаа юу байгааг ойлгох юм алга хэмээн Жилл үнэнээ хэлэв.

-Туслах дүрд тоглож байгаа жүжигчин заавал ч үгүй ам ангайн хэд гурван үг хэлдэг ёстой, нийтийн дунд тогловол үг хэлэхийг зөвшөөрдөггүй юм. Дуу оруулагч нар түүнийг хийнэ.

-Юуны түрүүнд агенттай болох хэрэгтэй.

-Би түүнийг чинь хаанаас олох болж байна?

-"Актере кино"-ноос хаягийг олж болно. Кино жүжигчин Гильдия уг сэтгүүлийг эрхэлдэг юм. Миний өрөөнд нэг дугаар бий. Одоохон аваад ирье.

Агентуудын нэрсийн жагсаалтыг удаан шүүсний эцэст 12 жирийн агентыг сонгожээ. Алдар цуутай агентуудтай холбоо барих боломж Жиллд тун хомс гэдгийг бүгд нэгэн дуугаар зөвшөөрлөө.

Хаяг бичсэн хуудас барьсаар Жилл агентын эрэлд мордов. Зургаан агент нь бүсгүйтэй үг солихоос эрс татгалзаж, долоо дахь агентын оффис руу орж явахдаа халз мөргөлджээ.

-Өршөөгөөрэй, би намайг төлөөлөх агент хайж явна гэсээр Жилл түүнд хандан өгүүлэв.

Мань эр бүсгүйн хөлөөс толгой хүртэл нэвт шувт ширтээд,

-Цомгоо үзүүлээдэх гэв.

-Ямар цомог? хэмээн Жилл гайхширан асуув.

-Байх л ёстой доо, хот орж ирээд хагас цаг бололгүй наашаа ирсэн юм биш биз? Цомоггүй бол юу ч бүтээж чадахгүй. Олон төрөл маягаар зургаа авахуулаадах. Болж өгвөл нүцгэн биеэ, цээж, бөгсөө. Сонирхол татахуйцаар шүү!

Жилл "Дэвид Селзник студиоз"-оос холгүй Сильвер-ситид зурагчин олж, мань эр ажлын хөлсөнд 35 доллар аваад, долоо хоногийн дараа Жиллд зургийг нь өгвөл үнэхээр сэтгэл татам сайхан гарчээ. Бүсгүй жинхэнэ гоо үзэсгэлэнтэй харагдана. Дуран авай бодолд автсан, уурлан хилэгнэсэн, уяран гунигласан, жавхаалаг гээд бүхий л зан чанарыг нь тусгаж . . . Зурагчин зургуудыг гялгар уутанд савлаж өгөөд,

-Эхний нүүрэнд нь биеийнхээ харьцааг бичээрэй гэжээ.

Биеийн харьцаа! Энэ чинь дараагийн алхам!

Хоёр долоо хоног өнгөрчээ. Жилл жагсаалтан дахь бүх агентуудтай уулзахыг хичээн өдөржин гэлдрэхэд тэдний хэн нь ч түүнийг сонирхсонгүй. Нэг нь тэр ч бүү хэл,

-Чи өчигдөр бас энд ирсэн биш үү гэлээ.

-Үгүй, би наашаа ирээгүй л дээ хэмээн Жилл толгой сэгсрэв.

-За тэгвэл чамтай адилхан бүсгүй байжээ. Та анзаарч хараарай. Хамгийн хэцүү нь бүгд л Элизабет Тейлор, Лана Тернертэй эсвэл Эва Гарднертай адил харагддаг юм. Хаа нэгтээ өөр хотод очиж ажил хайхыг бод. Хөөрхөн хоншоор, сонгодог гэмээр гайхалтай бие хаатай чамайг булаалдаад авна. Харин Голливудад ийм бүсгүйчүүл захаас аваад үй түмээрээ байдаг юм. Нэг л хэвийн царайлаг сайхан охид бүсгүйчүүл сургуулийн жүжигт тоглох, гоо бүсгүйн тэмцээнд шалгарах эсвэл ганц удаа ч гэхнээ кинонд тоглох гэж өөр өөрийн ертөнцөөс сүрэг сүргээрээ наашаа ирцгээдэг юм! Надад итгэж үз, бүжинхэн минь, чи өчигдөр энд ирсэн! гэлээ.

Хувь заяа нэгт хөршүүд нь эрвийх дэрвийхээрээ бүсгүйд туслан шинээр жагсаалт гаргаж өгөх авч эдгээр агентуудын контор нь ядуу доройхон тул хотын захад байрлах агаад уулзалтын үр дүн өнөө л хэвээр байлаа.

-Туршлагатай болсон хойноо ир дээ, жаалхан минь. Чи давгүй хөөрхөн юм, хоёр дахь Гарбо болохыг хэн байг гэхэв, гэхдээ түүнд чинь зориулах зав даанч алга. Кинонд дүр аваадах, тэгвэл би агент чинь больё хэмээнэ.

-Хэн нэг нь надад ажил өгөхгүй бол би хэрхэн дүр авах юм бэ?

-Хамаг учир үүнд л байна даа. Амжилт хүсье.

Ингээд Жиллд Голливудын цэцэрлэгт гудам дахь кафед суух зуур нэгэн бүсгүйн ярьсан сүүлчийн ганц агентлаг үлдлээ.

"Даннинг Эйженси" нь Ла-Сенегагаас холгүйхэн их хотын "нойрмог" дүүрэгт байрлах ажээ. Жилл уулзалт товлохоор утасдвал нэгэн эмэгтэй 6 цагт ирэхийг хүсчээ.

Тэрээр урьд нь зочдын өрөө байсан ажлын бяцхан өрөөнд ороод явчихав. Өрөөний тавилга нь цаасанд дарагдсан, хол-цорч элэгдсэн хуучны бичгийн ширээ, энд тэндгүй онги татаг-дан ханзарсаныг нь шархны туузаар наан торгоосон хиймэл илгэн бүрээстэй буйдан, гурван сүлжмэл сандлаас өөр юмгүй ажээ. Хажуугийн өрөөнөөс өндөр биетэй, хүнд жинтэй, цэцэг өвчний ул мөр болсон цоохор царайтай, нэгэн эмэгтэй гарч ирээд,

-Хэлло, юугаар туслах вэ? гэлээ.

-Би Жилл Касл байна. Ноён Даннингтай уулзахаар тохирсон юм гэв.

-Хатагтай Даннингтай хэмээн эмэгтэй залруулаад,

-Би байна гэлээ.

-Өршөөгөөрэй! Би бодохдоо. ..

-Зүгээр дээ гээд эмэгтэй элэгсэгээр инээмсэглэв.

"Тун давгүй шүү" гэж Жилл бодоод гэнэт сэтгэл нь хөдлөөд ирлээ.

Эмэгтэй агент гэж түүний санаанд урд нь яагаад орсонгүй вз! Зовлон гунигийг амсалгүй тойрч гардаг хэн байлаа! Эл бүхнийг амссан хэн бүхэнд залуухан бүсгүй танихгүй их хотод цор ганцаардах ямар хэцүүг ойлгохсон доо! Магадгүй, хатагтай Даннинг ойлгон туслах юм билүү, хэн байг гэхэв!

-Та цомгоо аваад иржээ дээ, үзэж болох уу?

-Бололгүй яах вэ? гээд Жилл цомгоо сарвайв.

Эмэгтэй хуудсыг эргүүлэн нэг бүрчлэн үзээд,

-Та зураг дээр сайхан гарчээ хэмээн хүлээн зөвшөөрөн толгой дохин өгүүлэв.

-Баярлалаа гэхээс өөр юу ч хэлэхээ мэдэхгүй Жилл арай ядан амандаа бувгналаа.

Даннинг усны хувцастай Жиллийн зургийг үзээд,

-Боломжийн сайхан биетэй юм. Та хаанаас ирсэн бэ? гэлээ.

-Техас мужийн Одессоос.

-Голливудэд ирээд удаж байна уу, Жилл?

-Бараг хоёр сар.

-Олон агентуудаар орсон уу?

Хормын төдий Жиллд худал бурах санаа гялсхийснээ эмэгтэйн нүднээс түүнийг ойлгох өрөвч сэтгэлийн өнгө илрэхийг олж хармагц,

-Бараг 30 гаруйгаар орсон хэмээн үнэнээ өчив.

Хатагтай Даннинг тачигнатал хөхөрч,

-Эцэст нь Роуз Даннинг дээр иржээ! За яахав, муу нь юу байх билээ? Мэдээж би тийм ч олны танил биш ч гэлээ, миний үйлчлүүлэгч нар ажилгүй суудаггүй юм.

-Гэхдээ би кино шийнд тоглож байгаагүй. . .

Эмэгтэй өчүүхэн төдий гайхсангүй толгой дохин,

-Тэгсэн бол аль хэдийнэ агенттай болчихсон, над дээр ирэхгүй байсан биз. Би залуу

авьяастнуудыг хайн, ажил олж өгдөг юм. Алдартай агентууд тэднийг таньмагц олзлон авцгаадаг гэлээ.

Өчнөөн олон хоногийн дараа сая л нэг Жиллд итгэлийн бүдэгхэн гэрэл тэртээ алсад сүүмэлзэж эхлэв.

-Та.. . та миний агент болно гэж үү?

-Надад олон үйлчлүүлэгч бий ч, тан шиг сайхан тийм ч олон биш. Юуны өмнө танд тоглох урилга олж өгнө. Үүнээс өөр арга байхгүй, тийм биз?

Жиллийг үнэн сэтгэлээсээ баярлах сэтгэл нөмрөн авав. Роуз Даннинг үргэлжлүүлэн,

-Хараал идсэн энэ хотод зовлон их бий. Тан шиг багачуулд хэн ч боломж олгохыг хүсдэггүй юм. Бүх л студиуд шинэ авьяастнуудаар ангаж цангаж байдаг атлаа тэднийг кино

зурагтаа авдаггүй нүгэлтэй улс. Таныг яах ёстойгоо би мэдэж байна. Тесси Брэндийн шинэ кино, Тоби Темплийн тоглож буй Савангийн дуурьд тоглуулах нь зүйтэй юм байна гэлээ.

Жиллийн толгой эргэн,

-Намайг үнэхээр. . .

-Тэгэлгүй яах вэ, авна. Хэрэв би зуучилбал шүү. Тэд надад муу бараа байдаггүйг сайн мэддэг юм. Мэдээж, энэ бүхэн өчүүхэн юм, гэвч юунаас эхлэхийг чи ойлгож байгаа биз гэлээ.

-Өө, хэрэв энэ бүхэн бүтвэл танд их баярлалаа. . . хэмээн Жилл шулганав.

-Миний санаж байгаагаар надад хаа нэгтээ савангийн дуурийн зохиол байх ёстой сон.

Роуз Даннинг чүү чамай өндийн босч сандлаа түлхэн Жиллийг араасаа дага хэмээн дохиод хажуугийн өрөө рүү алхлаа.

Тэд хоёр ортой, цонхны доод буланд нь төмөр шүүгээ тавьсан унтлагын өрөөнд орлоо. Даннинг хөлөө чирэн майжганасаар шүүгээ рүү дөхөн очиж онгойлгоод зохиол гарган Жиллд өгөөд,

-За энэ. Найруулагч нь миний сайн найз. Хэрэв бүх юм сайхан болбол, чи ажилгүй үлдэхгүй ээ гэлээ.

-За би хичээнээ! гэж Жилл чин сэтгэлээсээ амлахад сайхь эмэгтэй инээмсэглээд,

-Би таныг мэдэхгүй таг харанхуйгаар зуучлаж чадахгүй. Та хэдэн мөр уншаад үзэхгүй юу? гэлээ.

-Мэдээж, тэгэлгүй яахав.

Роуз Даннинг орон дээр суун зохиолыг нээснээ,

-Алив, энз үзэгдлээс эхэлье гэв.

Жилл эхийг түргэн гэгч гүйлгэн уншлаа. Зохиолыг гэртээ аваачиж эсвэл дор хаяж хагас цаг ч гэхнээ бэлдвэл арай л дээр байхсан. Гэвч туунд боломжийн гэх сэтгэгдэл төрүүлэхийг ихэд хүснэ.

-Бэлэн үү!

-Тийм-тийм, бараг л бэлэн.

Жилл нүдээ анин өөрийгөө гол дүрийн баатраар төсөөлж эхлэв. Баян хатагтай яг л түүний тоглож өссөн охидын эх шиг. Эл хатагтай нар амьдралынх нь бүх баялаг өөрт нь заяах ёстой, бусад өөрт нь үйлчлэх албатай юм шиг сурчихсан, яг л Сисси Топпинг мэтийн улс байдаг сан. Жилл гүн амьсгаа аваад уншиж эхэллээ.

-Питер, бидэнд ярих хэрэг байна.

-Яг одоо юу? гэж Роуз хажуугаас нь өлгөв.

-Их ч удаан тэслээ. Тэгээд ч өнөөдөр Рино руу ниснэ

-Тэгнэ вий, бүр үүндээ тулаа юу?

-Андуурч байна. Питер би энэ онгоцонд суух гэж бүхэл бүтэн таван жил мөрөөдлөө, тэгээд ч энэ удаа санасандаа хүрнэ гэв.

Роуз Даннинг Жиллийн гуяан дээр гараа тавиад,

-Тун сайн байна, үргэлжлүүл гэж сайшаан толгой дохисон боловч гараа авсангүй.

-Чи эрийн цээнд хүрэхгүй өдийг хүртэл мориор тоглож суух чинь хэцүү байна. За яах вэ, одооноос эхлээд би чиний наадгайд оролцохгүй.

Жиллийн гуян дээрх эмэгтэйн хуруунууд жигтэй хөдлөх нь нэг л хачирхалтай санагдаад явчихлаа. Эзэгтэй тайтгаруулан,

-Тун сайн. Үргэлжлүүл гэв.

-Хойшид чиний тухай сонсох хүсэл алга. Ойлгов уу? Хуруугаа улам хурдан хөдөлгөн хэвлий дээгүүр нь жирэгнүүлснээ улам бүр доошлуулав. Жилл зохиолыг хаагаад Роузыг гайхан ширтэхэд, эмэгтэйн царай улайн, нүд нь харанхуй будан татвуу гэлтэй сүүмийлээ.

-Цааш нь унш хэмээн сөөнгөтөн бөвтнөв.

-Ча.. . чадахгүй нь... Хэрэв та... Энхрийлэл улам шургуу болоод,

-Наадах чинь эр эмийн явдлын хэрүүл учраас сэтгэл хөдлөлийг чинь гаргуулах гэж байна. Чиний өдөөгдөж байгаа эсэхийг л мэдрэх гэсэн...

Гар нь улам хүчтэй хөдлөн Жиллийн салтаа завсраар нь шурган орлоо.

-Үгүй! гээд бүсгүйн бие жихүүцэн чичигнэснээ үсрэн бослоо.

Эмэгтэйн амнаас шүлс гоожих үзэгдэв.

-Надад тааламжтай ханд, би чамд туслаж чадна. Хонгор минь, нааш ир хэмээн аргадан гиншив.

Роуз гараа сарвайн Жиллийг тэврэн авахаар зүтгэхэд бүсгүй ухасхийн гарч зугтлаа. Гудамжинд гарч очоод Жиллийн толгой эргэн арай ядан хана түшин авахад тархи толгой нь янгинан өвдөх нь гагцхүү Жозефина Цински бүсгүйд байдаг өвчин шаналгаа ажээ.

Хагас жилийн турш Жилл Касл шоу-бизнесийн "хаяа" сахин амьдрагч, хамаг амьдралаа үрэн кино урлаг, телевизэд шурган орчих гэсэн "горьдогсод" овгийн үндсэн гишүүн болон түр зуурын ажил хийн гол зогоож явлаа.

Эрт овгийнхон түүдэг галаа тойрон суугаад баатарлаг домог туульс хөөрөлддөг асан бол "горьдогсод" овгийнхон Шваба эмийн санд цуглан шоу-бизнесийн гайхамшигт домог, шинэ сониноо хуучлан хүүрнэлдэж хүйтэн кофе ууцгаан хэд хэдэн цагаар сууцгаана.

Тэд хэдийгээр аз нь шовойж, од нь гийхгүй ч гэлээ ямар теле киноны гол дүрийг солих гэж байгаа, ямар продюссер хэн гэгч найруулагчийн орноос босч ирсэн, аль телестудийн захирал тушаал ахих гэж байгаа гэхчилэн шинэ соргог мэдээллийн тэхий дунд нь хутгалдан явцгааж чих дэлсэж амжицгаадаг аж. "Горьдогсод" мөрөөдөлдөө хүрэхийн тулд яаж ийгээд студийн харуул хяналтынхны нүдийг хариулсхийн орж явцгаах тэр цагт Бурхан алтан бүрээгээ бүрээдэн өмнө нь хэрэм мэт тусгаарлаж байсан хана туурга бутран нурж, Сэм Уинтерс шидэт дохиураар дохин, тэд гайхан шагшрах үзэгчдийн өмнө од болон хувирахыг мөрөөдөцгөөнө, Шваба эмийн сандаа кофе балган өөрсдийн мөрөөдлөөрөө бие биесээ бүлээцүүлэн ид шидийн хаалганы босгон дээр үргэлжийн мөнхөд бэлэн зэлэн зогсоцгооно.

Тэд супермаркет, гарааш, гоо сайхан, машин угаагч гээд эсэн бусын ажил эрхэлцгээн хамтран амьдарч, өөрт таарсан өрөөсөн дугуйтайгаа гэрлэцгээн, заримдаа салж сарницгаах авч хорвоогийн шар наран, бор хоног тэднийг элээн санчигнаасаа бууралтан, хоногийн эргэлтэнд шинэ үрчлээ үүсэн нүүр хувиргагчид илүү төвөг удах болсноо үл анзаарна. Тэд гүйлгээгүй бараа мэт голдогдсон амьдралаа шинээр эхлэн үр хүүхэд төрүүлэн, кино шийнд тоглоно хэмээн хий мөрөөдөнө.

Арай залуу царайлаг бүсгүйчүүл нь "ор хөнжлийн ажил" гэгчийг эрхэлнэ.

-Хөнжилдөө хэдэн минут хэвтээд хорин янчаан олж дөнгөж байхад өглөөнөөс орой хүртэл нуруу бөгтийлгөн ажиллахын хэрэг юу байна! Агент утасдаж ажилд дуудахгүй бол хэмхэрч дуусах нь ээ!

Жилл энэ мэтийн явдлыг огтод сонирхсонгүй, хамгийн гол нь ажил олох хэрэгтэй. Хөөрхий польш бүсгүй Дэвид Кэньоны эхнэр болж чадахгүйгээ одоо л сайн ойлгожээ. Харин кино од Жилл Касл чадах бүхнээ хийнэ, "хэрэвзээ санаандаа хүрч чадахгүй бол эргээд Жозефина Цински дүрдээ хувирах хэрэг үү".

Тэрээр үүнийг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй, яасан ч үгүй.

Торьдогсод овгийнхны нэг Хэрриет Маркус бүсгүй Жиллийг кино урлагт алхуулан анхны дүрд тоглуулжээ. "Юниверсал" студид авч буй "эмнэлгийн" тухай теле киноны найруулагчийн 2-р туслах Маркусын үеэл эгчийн нөхрийнх нь ах Жиллийг туслах дүрд тоглуулж өгөхийг зөвшөөрчээ. Жилл өвчтөний орны дэргэд зогсон даралтыг нь үзэж байгаад тасагт орж ирсэн эмч,

-Тэр яаж байна, сувилагч аа? гэж асуухад,

-Дээрдэхгүй нь гэж айх юм, эмч ээ гэж хэлэх сувилагчийн дүрд тоглох болжээ.

Даваа гаригийн өглөө Жиллд хэлэх үгийг нь хувилсан хуудас цаас өгөөд маргааш өглөө зургаан цагт нүүр хувиргах өрөөнд хүрч ир хэмээв. Бүсгүй бүтэн өдрийн турш бэлджээ. Түүнд бүхэл бүтэн зохиол өгөөгүй нь юутай харамсалтай вэ!

Жилл дүрийн сувилагч эмэгтэй ямар хүн болохыг төсөөлөхийг хичээлээ. Нөхөртэй юу? Ганц бие бүсгүй юу? Эсвэл эмчид нууцхан дурлаа юм болов уу? Өвчтөнтэй хэрхэн харьцдаг бол?

Жилл ганцхан өгүүлбэрийг харамссан, сэтгэл зовсон, зэмлэсэн янз бүрээр давтан, нойргүй хоносон ч гэлээ өчүүхэн төдий ядрахыг мэдэрсэнгүй.

Тэрээр Хэрриетын машиныг түр аван студийн үүдэнд ирэхэд үүр дөнгөж хаяарч байсан тул харанхуй байлаа. Жилл хаалгачид нэрээ хэлбэл тэрээр жагсаалт шүүн үзээд,

-Долоон номерын зураг авалтын талбай. Чигээрээ хоёр хороолол, дараа нь баруун тийш эргэ хэмээн дохин замчлав.

Түүний нэр жагсаалтанд орчихож! Студид өөрийг нь хүлээж байх нь! Ид шидийн зүүд шиг бүх юм бүтлээ. Зургийн талбай руу явах замдаа Жилл ямар янзаар тоглохоо найруулагчтай зөвлөхөөр шийджээ.

Бүсгүй машинаа зогсоолд тавиад зургийн талбай руу ороход талбайг тэр чигээр нь гзрэлтүүлсэн, оператор ажилчид өөр хоорондоо нэгэн сонин этгээд хэлээр ярилцах аж. Жилл ганц ч үгийг нь эс ойлгон ийш тийш гайхан харвал энд тэр чигээрээ шоу-бизнесийн үнэр ханхлаж буйг бахдан анзаарав. Энэ түүний ирээдүй, түүний ертөнц! Жилл бусадтай адилгүй гэдгээ найруулагчид үзүүлж чадахсан! Тэрээр бусдын адил ерийн нэг жүжигчин биш, бие даасан хувь хүн өмнө нь зогсож байгааг ойлгох болно.

Найруулагчийн 2-р туслах Жиллийг өөртөө нь адил бусад олон жүжигчдийн хамт хувцасны өрөө рүү аваачин, бүсгүйд сувилагчийн хувцас өмсгөөд нүүр хувиргаж буй зургийн талбай

руу аваачив.

Жилл мань туслахад нэрээ ч хэлж амжилгүй "өвчтөний ор" руу яаравчлахад найруулагч нь ухаантай, өвчтөнөө энэрэх өрөвч сэтгэлтэй, мэс засалч эмч Род Хэнсонд ямар нэгэн юм тайлбарлаж байлаа. Жиллийг ойртон очих тэр үед сайхь жүжигчин,

-Миний бодлоор, немц овчарка ч наад новшоос чинь арай дөнгүүр текст хэлж мэднэ шүү. Зохиогч яагаад өчүүхэн ч төдий бодгаль чанар надад гаргаж өгсөнгүй вэ, чөтгөр ав гэж! хэмээн хилэгнэх дуулдав.

-Род оо, манай цуврал гараад аль хэдийнэ таван жил болсон, булгаар илэхэд уйлаад, булаар жанчихад инээх гэгчээр чи тэртэй тэргүй үзэгчдэд таалагдах болно!

-Бүгд бэлэн, гэж оператор хажуунаас нь оролцов.

-Баярлалаа, эхэл гэж найруулагч толгой дохиод Хэнронд хандан,

-Алив ангаахай минь, үзүүлээд өг. Хожим ярилцья! гэлээ.

-Бурхан минь гэж, тэсэх арга алга! гэж үглэсээр жүжигчин эр цааш явлаа.

Найруулагч ганцаар үлдэн Жиллд түүний ажлын хүндийг ойлгож буйгаа илэрхийлээд, хэрхэн тоглохоо асуух алтан боломж гарах нь тэр.

Бүсгүй түүнд дөхөж очоод найрсгаар инээн,

-Намайг Жилл Касл гэдэг. Сувилагчийн дүрд тоглоно. Энэ дүр их давуу талтай гэж бодох юм, надад нэг санаа. . . гэтэл найруулагч хайнгадуу толгой дохиод,

-Орны дэргэд очоод зогс! гэчихээд цааш холдон оператортой ярьж эхлэв.

Жилл түүний араас гайхан хоцров. Хэрриетийн үеэл эгчийн нөхрийн ах Жиллд дөхөн ирж,

-Тэнгэр минь, чи чинь дүлий юм уу? Ор руу очооч! хэмээн намуухан дуугаар хэлэх сонсогдов.

-Би зүгээр юм асуух. . .

-Бүү тэнэглэ, алив хурдал, тийшээ оч хэмээн ууртайгаар исгэчүүлэхэд нь Жилл ор руу очин тонгойлоо.

-Бүгд бэлэн үү! Чимээгүй! гэж найруулагчийн туслах нийтэд зарлаад,

-Сургуулилт хэрэгтэй юу, найруулагч аа? гэж асуув.

-Энэ өчүүхэн хэсэгт үү?! Шууд ганц удаа авна! Дохио өг. Бүгд бэлд. Авлаа, мотор гэж захирамжлав.

Жилл дохио өгөхийг сонсоод чихэндээ ч итгэсэнгүй хэн нэгний,

-Эхэллээ! хэмээн хашгирах сонсогдлоо.

Бүгд Жиллийг хүлээн ширтэцгээв. Бүсгүй камераа ганц хором унтраагаад зоригоо чангалан бэлтгэж, тайз чимэглэлийг шүүн тунгаах хормын төдий боломж . . . гэсэн бодол тархинд нь цахилгаан мэт харван орж ирлээ.

-Бурхан минь! гэж найруулагч гэнэт хашгираад, Сувилагч аа! Энэ чинь хүүрийн газар биш, эмнэлэг. Өвчтөнөө өтлөж үхэхээс нь өмнө судасны цохилтыг нь хэмжээдэх! гэлээ.

Жилл эргэн тойрны хурц гэрэлтүүлгийг түгшин харснаа "өвчтөн"-ий гарыг өргөн судасыг нь тэмтрэв. Хэрэв хэрхэхийг нь зааж өгөх хүсэлгүй байгаа бол өөрийнхөөрөө тоглохоос яах вэ. Өвчтөн нь эмчийн аав нь гэж бодъё. Тэд маргалдаад эцэг нь осолд орж, хүүд нь эл золгүй мэдээг дуулгажээ. Жилл ойртон яваа Род Хэнсон тийш харц өргөлөө.

-Тэр яаж байна, сувилагч аа?

Жилл эмчийн нүднээс сэтгэл зовсон байхыг олж хараад. Эцэг нь тэсэхгүй болсон үнэнийг дуулган уучлал гуйхад оройтсоныг...Гэхдээ энэ бүгдийг цочролд оруулалгүй тун болгоомж той. . .

-Зогс! Зогс! Бүгдийг чфтгөр аваасай, энэ новш ганц өгүүлбэр тогтоож чадахгүй байгаа юм уу? Та нар түүнийг хаанаас олоо вэ, амьтны хүрээлэнгээс үү? гэж гэнэт найруулагч бархирлаа.

Жилл ичсэндээ нүүр нь халуу оргин улайгаад дуу гарах харанхуй тийш хандан,

-Би. . би үгээ мэднэ гэж хоолой чичигнүүлэн бувтнаснаа,

-Ердөө л. . .

-Чөтгөр ав гэж, мэдэж байгаа юм бол амаа хамхиад байлгүй хэлээд аль?! Гурав үхээд, гурав сэхэж болохоор хугацаа өнгөрлөө. Түүнийг залбирлын асуултаа асуунгуут нь шууд хариулаадах! Ойлгов уу? !

-Би ердөө л нэг зүйл асуух гэсэн. . .

-Алив дахиад эхэл. Дохио!

-Бүгд хэвийн, бид бэлэн.

-Мотоор!

-Эхэллээ!

Жиллийн өвдөг чичирлээ. Тэнгэр минь гэж, зураг авалт хэрхэх нь түүнд хамаагүй гэж үү? ! Сайн тоглох нь түүний хүсэл мөрөөдөл биш үү. Хурц гэрэлтэй чийдэнгийн төөнөм халуунд

толгой нь эргэн цардсан хувцас, нуруу гараар нь хөлс урсаж эхэллээ.

-Эхэллээ! Сувилагч!

Жилл өвчтөний дээрээс тонгойн судсыг нь тоолж эхлэв. Дахин нэг бүдрэх юм бол, түүнд дахиад хэзээ ч дүр олдохгүй. Бүсгүй Хэрриетийн тухай, бусад нөхдийнхөө тухай, тэд юу гэх бол гэдгийг эргэцүүлэн бодлоо. Эмч орж ирэн түүнд дөхөж ирээд,

-Тэр яаж байна, сувилагч аа? гэв.

Жилл тэдний эгнээнд элс эж, зн зэрэгцэж чадахгүй нь гэж үү дээ?! Түмний элэг доог болох нь энэ үү? Голливуд хэмээгч бяцхан хотхонд хов жив агшин зуурын төдийд тархдаг номтой.

-Дээрдэхгүй нь гэж айж байна, эмч ээ? Нэг ч студи түүнийг тоож үзэхгүй. Энэ түүний кинонд тоглож байгаа эхний бөгөөд эцсийн боломж. Бүх юм өнгөрлөө, бүх амьдрал нь баларчээ.

-Энэ хүнийг даруйхан сэхээн амьдруулах руу аваач хэмээн эмч тушаав.

-Сайн байна! Дууслаа гэж найруулагч бүгдэд зарлав. Энд тэндгүй үймэн ажилчид тайз чимэглэлийг асар хурдан солихыг Жилл ухаарч амжаагүй байтал дараагийн зураг авалт бэлэн болжээ. Тэрээр эхний дүрдээ тоглочихлоо, дараагийнхад хэрхэн шургаж орох билээ. Бүх юм дууссан гэдэгт нэг л итгэж өгсөнгүй. Найруулагчийг хаа байгаа газраас нь олж кинонд тоглох боломж олгосонд талархах ёстой юм болов уу? Гэтэл мань эр зураг авалтын талбайн цаад захад хэсэг хүмүүстэй ярилцан зогсож байв.

Найруулагчийн 2-р туслах хүрч ирэн гар бариад, -Сайн байна, хонгор минь! Дараагийн удаа үгээ сайтар цээжилдэг юм шүү гэв.

Түүний анхны кино, цомогт орох эхний бичлэг!

"Энэ өдрөөс эхлэн байнга ажиллана" гэж Жилл боджээ. Гэтэл дараагийн туслах дүрийг жилийн дараа "Метро-Голдвин-мейер" студийн кинонд өгчээ. Энэ хугацаанд тэрээр газтай ус худалдаж, бусдын хүүхэд харах, түр зуур такси барихаас эхлээд нилээдгүй олон ажил сольж амжив.

Мөнгө нь тарчигхан болмогц Жилл Хэрриет Маркустай хамт буурь сэлгэн нүүж, хоёр унтлагын өрөөтэй бага шиг байранд орсон ч, Хэрриет шөнийн цагаар ховорхон байх тул ихэнхдээ ганцаар байх ажээ. Маркус их дэлгүүрт загвар өмсөгчөөр ажилладаг, богино хар үстэй, хар нүдтэй эрэгтэй хүүхэд шиг биетэй хошигнох дуртай бүсгүй байлаа.

-Хэрэв чи Хобокенд төрсөн бол хошин шогийн мэдрэмжгүй байна гэж үгүй гэж хэлэх дуртай ажээ.

Эхлээд Жилл түүний өөртөө итгэлтэй тайван байдалд тээнэгэлздэг байснаа удалгүй орчлонгийн бүсгүйчүүлийн хорхой хүрэм гадаад төрхний цаана хайр сэтгэл гэгч нуугдаж байдагийг ойлголоо. Маркус үргэлж дурлаж явдаг нэгэн. Хэрриет нэг удаа,

-Чамайг Рольфтой танилцуулнаа. Бид ирэх сард гэрлэнэ гэж сониноо дуулгажээ.

Гэтэл долоо хоногийн дараа Рольф Хэрриетын машиныг аваад ор сураггүй болжээ. Хэрриет түүнийг алга болсноос хойш хэдхэн хоногийн дараа Тони гэгч залуутай учирчээ. Тэр нь экспорт-импортын компанид ажилладаг аж. Хэрриет түүнд ухаангүй дурлачихаж гэнэ.

-Тони дээгүүр ажилтай хүн хэмээн Хэрриет нууцлан шивнэв.

Гэвч тун удалгүй итгэж боломгүй явдал учирч, аманд нь алим гударч чихсэн Тонигийн хүүрийг голоос татаж гаргажээ.

Хэрриетын удаах учралт залуугаар Алекс гэгч залуу тодров.

-Чи тийм сайхан залууг хараагүй шүү хэмээн Хэрриет найз бүсгүйдээ шинэхэн амрагаа танилцуулав.

Үнэндээ ч Алекс сайхан хувцас, үнэтэй машин унан, олон цагаар морь унан наадах дуртай, үгүйсгэхийн аргагүй сайхан залуу байлаа.

Жилл Хэрриетын учир начиргүй янаг амрагийн явдалд цухалдахад,

-Чамд юу ч гэхэв дээ. Харчуул намайг үргэлж соронздоод байх юм. Эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг гэдэг биз дээ. Миний ээж дүйрчихсэн амьтан байсан юм гэжээ.

Хэрриетийн сүйт харчуулын цуваа тасарсангүй. Ник, Бобби, Жон, Раймонд гээд л Жиллийн нүдний өмнө үргэлжилж бүр сүүлдээ бүсгүй тоогий нь алджээ. Хэрриетийн иймэрхүү амьдрал хэдэн сар үргэлжилсний эцэст, мань бүсгүй хүүхэдтэй болсноо дуулгав.

-Миний бодлоор энэ Леонардын хүүхэд болов уу. . . үнэнийг хэлэхэд, харанхуйд тэд бүгд нэг л хэвийн адилхан байдаг юм.

-Тэгээд Леонард хаа байгаа юм бэ?

-Омахад, эсвэл Окинавад ч юм уу. Би ер нь газарзүйд муу.

-Одоо тэгээд яах бодолтой байна?

-Мэдээж, төрүүлнэ.

Жирэмслээд хэдэн долоо хоногийн дараа Хэрриетийн гоолиг бие нь мэдэгдэхүйц өөрчлөгдөн гэдэс нь томорч ажлаа орхихоос өөр замгүй болжээ. Жилл дэлгүүрт ажиллан хоёр биенээ тэжээж байтал нэг удаа Жилл ажлаасаа тарж ирээд,

"Хүүхэд маань Хобокенд төрөөсэй гэж би үргэлж хүсч байсан. Гэр рүүгээ буцпаа. Тэнд гайхалтай залуу намайг хүлээж байгаа гэж мөрий тавьж даанч чадахгүй нь. Чамд их баярлалаа. Өдгөөгөөс эхлэн гэлэнмаа Хэрриет" гэсэн зурвас олжээ.

Ингээд орон гэр нь гэнэт эзгүйрчээ.

Бүлэг 21.

Тобигийн амьдрал хамгийн сайхан үедээ байлаа. Тэрээр дөчин хоёр нас хүрч бүх дэлхий түүний авьяас бил-гийг өвдөг сөхрөн хүлээн зөвшөөрнө. Тоби хаантай хошигнож, ерөнхийлөгчтэй гольф тоглож явсан ч гэлээ сая сая эгэл жирийн шүтэн бишрэгчид нь ихэс дээдэс, эрхтэн дархтанг элэглэхээс үл эмээгч Тоби тэдний л адил гэдгийг ойлгон ихэд хайрлах аж.

Тоби ярилцлага өгөх бүрдээ эхийнхээ тухай бишрэн ярьж, ярих болгондоо улам улам нандигнан шүтэн сүсэглэнэ. Тэрээр тэнгэрт хальсан эхтэйгээ өөрийн амжилтыг үүнээс өөр хэрхэн хуваалцах билээ?

Тоби Бель-Эйрд өвөрмөц загвартай, найман унтлагын өрөөтэй, Английн гар хийцийн сийлбэр бүхий асар өргөн шаттай, агуу сайхан харштай болжээ. Тэнд кино зал, тоглоомын талбай дарсны зоорь, хашаанд нь усан сан, няравын амьдардаг сууц, зочдод зориулсан тансаг сүүдрэвчтэй ажгуу. Үүний зэрэгцээ Тоби Палм-Спрингст тансаг харш худалдан авч хэдэн сайн уралдааны морьд, мөн гар хөлийн үзүүрт зарагдах гурван үйлчлэгчтэй болжээ. Тэрээр бүгдийг нь нэгэн адил Мак хэмээн нэрлэх агаад тэд үүрэг даалгаврыг нь үг сүггүй биелүүлэн гүйлдэж, өдөр шөнийн аль ч цагт хагсааг нь тайлчих бүсгүй олж ирэх, аялалаар Тобитой цуг явж массаж хийн, эзнийхээ хүслийг гүйцэтгэн түүнийг ихэд хүндэтгэнэ.

Тоби дөрвөн нарийн бичгийн даргатай, тэдний хоёр нь уул овоо шиг бөөгнөрдөг захидал харилцааг хариуцна. Харин хувийн нарийн бичгийн дарга нь хорин настай, хонгор шаргал үстэй, гайхалтай бие хаатай, танхилхан бүсгүй байлаа. Тоби алтан цагаа хэмнэхийн үүднээс түүнийг оготор банзал өмсч дотоожгүй явахыг шаардана.

Тобигийн анхны кино нь асар их амжилт авчирлаа. Сэм Уинтерс, Клифтон Лоренс хоёр киноны нээлтэнд ирцгээн, дараа нь амжилт юугаа тэмдэглэцгээн ресторанд орцгоов.

Тоби гэрээ байгуулсныхаа дараахан Сэмтэй уулзмагц,

-Миний утасдахад хариулсан бол би арай хямд тохирох байсан сан хэмээн ний нуугүй хөгжилтэйгээр хэлээд Сэмтэй уулзахыг чармайн оролдсоноо дуулгавал,

-Аз минь харьчихаж хэмээн Сэм харамсан санаа алджээ.

Ресторанд сууж байхдаа Уинтерс, Клифтонд шивнэн,

-Хар амиа бодвол би Тобитой гурван киноны гэрээнд гарын үсэг зурахсан гэв.

-Маргааш утасдамз гэж агент эр хэлээд цагаа хяламхийн харснаа,

-Миний явах цаг боллоо хэмээн өргөсөн дээр суусан мэт өндөлзөв.

-Чи хаачих нь вэ? гэж Тоби асуухад,

-Үйлчлүүлэгчтэй уулзана. Чамаас гадна надад өөр үйлчлүүлэгч бийг чи мэднэ шүү дээ гэлээ. Тоби түүнийг нэг л хачирхалтай харжээ. Шүүмжлэгчид Тобиг кино урлагт гялалзсан амжилт гаргана гэдгийг ам уралдан магтацгаана.

Тоби бүх шүүмжлэлийг уншиж үзээд Лоренс руу утасдвал, -Баяр хүргэе, анд минь,"Рипортер", "Вэрайти"-г уншсан уу? гэж асуув.

-Тэглээ. Бүх дэлхий тэр чигээрээ амтат бяслаг, харин би тарган цаггалан харх! Үүнээс сайхан гэж юу байх вэ?

-Удахгүй чи юм дуулах болно гэж би чамд эс хэллүү? Бүгд санаснаар боллоо! гэж Лоренс сэтгэл хангалуун өгүүлэв.

-Клиф, чамтай ярих юм байна. Хүрээд ирж чадах уу?

-Таван цагт завтай болно. Тэгээд. . .

-Үгүй, яг одоо.

-Үйлчлүүлэгчидтэйгээ уулзах ёстой гэж агент эр тээнэгэлзэн хариулах дуулдав.

-За яах вэ, чи завгүй байгаа бол болихоос доо. Тоби харилцуураа тавиад хэдэн минут болсны дараа Клифтоны нарийн бичгийн дарга руу утасдвал,

-Ноён Лоренс, тан руу явсан, эрхэм Темпл гэлээ. Лоренс буйдан тийш очин лагхийтэл суугаад,

-Бурхан минь Тоби, надад чамтай уулзах цаг зав үргэлж гарна гэдгийг чи мэднэ дээ! Чамайг өнөөдөр надтай уулзах юм гэж санаанд орсонгүй, мэдсэн бол хаанаас уулзалт товлох вэ.

Тоби Клифтоныг тэсэн ядан хүлээснээ нуун, үг дуугүй харан суулаа. Лоренс ханиалгаад цааш үргэлжлүүлэн,

-За юу болоов? Чи миний хамгийн хайртай үйлчлүүлэгч гэдгээ мэдэх үү?

Клифтон чухамдаа чин үнэнийг хэлж, тэр л Тоби Темплийг бүтээж, алдарт хүргэсэн төдийгүй яг Тоби шиг түүний амжилтаар бахдан аз жаргалд умбадаг байна.

-Тийм гэж үү? гэж жүжигчин эр инээхэд Лоренсын сэрэмжлэн харах нь өөрчлөгдөн тайвширахыг ажиглаад,

-Би нэг л эргэлзээд байх боллоо гэх нь тэр.

-Чи юу гэх гэв?

-Чи дэндүү олон үйлчлүүлэгчтэй, би ер нь адаг хавьцаа нь явах шиг санагдах юм.

-Энэ ч үгүй шүү! Хичнээн хугацаа зарцуулж. . .

-Бусад үйлчлүүлэгчдээ хесэрт хаяж зөвхөн надтай ажлаасай билээ гэж би хүсч байна, Клифтон оо.

-Чи тоглож байна уу? хэмээн мань эр инээмсэглэхчээ аядав.

-Үгүй, нухацтай хэлж байна.

Клифтоны инээмсэглэл нь арчигдан, ул мөргүй алга боллоо.

-Боломжийн нэр хүндтэй надад тэлээ хурга аятай арван үйлчлүүлэгчийн хэргээр хөөцөлдөж явдаггүй цаг үргэлж дэргэд минь байх хувийн агент хэрэгтэй байна.

Клифтон Тобиг хянамгай гэгч нь ширтээд,

-Алив уух юм хийгээч гэлээ.

Тобиг баар руу явах зуур агент эр гүн бодолд автав. Энэ бүхэн чухамдаа Тобигийн хар амиа бодсоноос эсвэл ихэрхүү зангаас нь огт болоогүй гэдгийг агент эр сайн мэднэ. Лоренс үйлээ үзэж, үсээ тоолтол ганцаардахдаа эмс хүүхнүүд, найз нөхдийг үнэт бэлэг сэлтээр даллан дууддаг Тоби шиг хүнтэй учирч яваагүйсэн. Хэсэг нөхдийн хүрээнд уулзалт зохиоход Тоби л төлбөрийг хийдэг.

Мөн Тоби нэг удаад хэдэн ч хүүхэнтэй энгэр зөрүүлж хагсаа юугаан тайлчихдаг гэсэн дам сураг хүртэл Клифтоны чихийг дэлссэн. Энэ мэтчилэн Тоби бусдаар хүрээлүүлэн олны дунд байхыг хичээн ганцаардлаас үнхэлцгээ хагартал айдгийг, гагцхүү тайзан дээр алга ташилт, үзэгчдийн хайр талархлыг мэдрэх тэр л агшинд ганцаардал Тобиг орхидог гэдгийг нь сайтар мэднэ.

Тоглолтын завсар зайлхайгаар тэрээр хөгжимчин, хуурмаг долдойдогчид, найруулагч, шоу-герлз, азгүй хошин шогчид гээд түүний таашаалд нийцсэн бүгдийг хиймэл дагуул мэт өөрийгөө тойрон эргэлдүүлнэ.

Гэтэл одоо мань эр Клифтон Лоренсыг зөвхөн өөртөө эзэмдэхийг хүсч байх нь ээ.

Клифтоны чамгүй олон үйлчлүүлэгчээс орох орлого нь Тобиг байж боломгүй үнээр шөнийн клуб, телевизийн кинонд тоглуулахаар гэрээ байгуулснаас хүртэж буй орлогоос ялимгүй их ч гэлээ агент эрийн хувьд мөнгө гол биш байлаа. Тэрээр Тобид хайртай, тэд бие биедээ хэрэгтэй гэдгийг мэдэх тул түүний саналыг зөвшөөрөхөөр шийджээ. Тобиг гарч ирснээс хойш түүний амьдрал эгээ л судсанд нь шинэхэн цус юүлэх мэт хэрхэн өөрчлөгдсөнийг мань хүн эргэн дурслаа.

Олон жилийн турш тэрээр хуучинсаг амжилттайгаа амь бөхтэй зууралдан амьдарч байлаа. Гэтэл одоо Лоренс Тобиг хэрхэн олж авснаа, хошин шог, инээд баяслыг, чин үнэнч нөхөрлөлөө агшин зуур бодоод авав. Тобиг уух юм аван орж ирэхэд Клифтон хундага авч дээр гэгч өргөөд,

-Бидний төлөө, анд минь. Чиний, миний төлөө! гэв.

Энэ үе нь хүмүүс Тобиг зугаацуулан наадуулахыг нь тэсэн ядан хүлээцгээж, мань эр цаг үргэлж бүгдийн анхаарлын төвд оршин байсан амжилт бүтээлийн оргил нь байлаа. Жүжигчин хүн Шекспир, Шоу, Мюльерийн үгээр, дуучин хүн Гершвин, Рожер, Портерын тусламжаар гарч ирдэг бол харин хошин жүжигчин ганцаар үзэгчидтэй нүүр тулан учирч өөрийн авьяасдаа найддаг ажгуу.

Тобигийн наргиантай хошигнол агшин зуур Голливуд даяар тархдаг болов.

Нэг удаа олон кино оддыг эмчлэгч нэртэй эмч үдийн зоогон дээр цугларагсадад зориулан уйтгартай урт онигоо ярьж эхлэхэд залхсан Тоби,

-Эмч ээ, та биднийг зугаацуулах гэснээс авран эмчилэх нь дээр юм! хэг^ээн аргадан гуйжээ.

Тобигийн христийн шашны үнэн шүтлэгт нэгэн найз нь эмнэлэгт хэвтэж гэнэ. Мань эрийн тасагт үзэсгэлэнтэй залуу гэлмэнмаа гэнэт орж ирээд орны нь дэргэд очин,

-Нимгэхэн, өө сэвгүй ямар зөөлөн юм вэ гээд уруулыг нь илэн таалахад,

-Баярлалаа, дүү минь гэж өвчтөн эр сандчин хариулав.

Гэлэнмаа дэрийг нь засахаар доош бөхийхдөө товгор том мээмээрээ өвчтөн эрийн нүүрийг шүргэж эхлэв гэнэ. Хөөрхий эрийн хуяал тачаал өөрийн эрхгүй хөдлөхөд журамт гэлэнмаа хөнжлийг нь гэнэт харсанаа ичсэндээ золтой нь ухаан алдчих сангүй,

-Ээ Бурхан минь, юу болох нь энэ вэ? гээд дуу алдан халаглав.

Сайхь эр сандран бүтээлгээ хуу татвал шодой нь хатуурч боссон үзэгдэв.

-Өр-өршөөгөөрэй, бүсгүй минь. Би би. . . хэмээн ээрэн шулганахад,

-Өршөөл гуйхын хэрэггүй. Үнэхээр гайхалтай эд юм гэж гэлэнмаа батлан хэлээд улам бөхийн доошилсоор толгой нь өвчтөн эрийн салтаан завсар шурган ороод алга болчихож гэнэ.

Хэзээ хойно хагас жилийн дараа мань эр Тоби түүнийг даажигнан янхан хүүхэн илгээснийг нь мэджээ.

Тоби нэгэн удаа цахилгаан шатнаас гармагцаа эргэн харж, студийн хамгийн яравгар ихэрхүү зантай, дээд тушаалын захирлаас,

-Уилл ээ, чи хүчингийн хэргээс яаж өөрийгөө авч гарав аа? Шүүгчдийг худалдаж авсан уу? гэж асуужээ.

Цахилгаан шатны хаалга хаагдан ихэмсэг эр жигшин зэвүүцэн харах олон зорчигчдын дунд ганцаар үлджээ. Мөн нэгэн удаа шинэ гэрээний нөхцөлийг тохирох цаг болсон Тоби сургуультай ирвэс прокатлан авч Сэмийг зөвлөгөө хийж байхад орж очин,

-Миний агент чамтай уулзах гэнэ гэснээ ирвэсийг гуд татан өрөөнд нь оруулчихаад өөрөө харайн гарч хаалгыг нь хаачихаж гэнэ.

Тэнд цугларагсдын лав л гурав нь энэ шоглоомыг даалгүй зүрх нь хаагдах шахаж, сар шахам болоход тасалгаанаас нь араатны шээс шинхэг ханхалсан гэдэг.

0'Хэнлон, Рейнжер нараар толгойлуулсан арваад зохиолчид Тобид алба хаших авч тэрээр цаг үргэлж тэдний бүтээлийг голон гомдоллодог байв. Нэгэн удаа мань эр зохиолчдын зөвлөлгөөн дээр сармагчин хөтөлсөн баян хуурчийг урин тоглуулахад эл ичгүүртэй доромжлолыг бүгд ширтэн сууцгаасан хэдий ч 0'Хэнлон, Рейнжер бусад зохиолчид Тоби Темплийн авьяас билгээр тэдний зохиол бүтээл нь алт болон хувирдагийг мэдэх тул шүд зуун тэсвэрлэцгээсэн байна. Түүнээс илүү хошин жүжигчнийг хаанаас ч олохгүй нь илт.

Цэцэн билгээрээ улам алдарших тутам мань эр ажилчид, найз нөхөддөө алтан цаг, алтан асаагуур, хувцас хунар худалдан авч, Европоор аялах зардлыг нь хүртэл даадаг болжээ.

Тобигийн үнэнч шударга зангийн тухай олон түүх газар сайгүй байнга сонсогдоно. Нэг удаа Тоби зохиолчидын туурвил бүтээлийг нь шүүн хэлэлцэж байтал залуу шог зохиолч цаг шахам хоцорч ирээд нүглээ наминчлан хүлцэнгүйгээр,

-Өршөөгөөрэй. Өнөө өглөө хүү маань машинд дайруулчихлаа гэж бувтнажээ.

Тоби түүнийг хөлөөс толгой хүртэл ширтээд,

-Текст авчирав үү? гэж асуужээ.

Хурсан хүмүүс цочролд орон гайхацгаалаа. Зөвлөлгөөний дараа хэн нэг нь эгдүүцэн 0'Хэнлонд,

-Хорвоо дээр үүнээс өөдгүй новш эрээд олохгүй шүү. Хүний зовлонг үл ойшоогч! гэж шүд зуун хэлжээ.

Гэтэл Тоби шилдэг мэдрэлийн мэс засалчийг дуудан осолд орсон хүүд хагалгаа хийлгэн, эмчилгээний бүх зардлыг нь төлж, хүүгийн эцгийг өглөгч зангийх нь тухай ам алдвал ажлаас хална хэмээн айлгаж орхисныг мэдээгүй ажээ.

Зөвхөн ажил хэрэг нь Тобигийн ганцаардлыг мартагнуулж баяр баясгаланг авчирна. Хэрэв тоглолт амжилттай болбол тэрээр магнай тэнүүн маасалзаж хорвоод ховорхон ганзага нийлэх анд мэт аашилснаа, ажил нь урагш муутай бол чөдөр галзуу туссан мэт хавь орчныхныгоо түйвээх шахдаг байлаа. Тоби юм бүхнийг өмчлөх дуртай агаад нэгэн сайхан өдөр Рейжерийн толгойг илбэн байж,

-Энэ минийх. Зөвхөн минийх байх болно хэмээн өрөө даяар зарлан тунхаглажээ.

Зохиолчид түүнд ус агаар мэт хэрэгтэй ч гэлээ хэн нэгнээс хамааралтай байхыг хүсдэггүй тэрээр тэднийг үзэн ядах ажээ. Цалин пүнлүү авах өдөр нь мань хүн чекээр онгоц хийн өрөөн дотуур нисгэн наргина. Өчүүхэн төдий өө сэв гармагц тэднийг дор нь халчихдаг байв.

Нэгэн хамтран зүтгэгч нэг нь алхайн наранд ээж суухыг хараад Тони тэр дор нь халчих нь тэр.

-Яаж байгаа нь энэ вэ? Энэ чинь их сайн зохиолч шүү дээ хэмээн мэл гайхсан О'Хэнлоныг асуувал,

-Тэр үнэхээр л ажиллаж байсан бол наранд биеэ ээн алмайрч суух завгүй байхсан гэж Тоби хариулан амыг нь тагласан удаатай.

Тун удаагүй байтал хэн нэгний эхийг таагүй хэрэгт орооцолдсон тухай. Тобид очиж хов хүргэсэн бас нэгэн золгүй амьтан мань эрийн араас шил даган ажлаасаа хусагджээ.

Дориухан амжилтанд хүрсэн жүжигчин түүний шоуд уригдаж ирсэн байвал Тоби,

-Та гайхалтай байлаа. Долоо хоног бүр шоуд минь морилон ирэхийг хүсч байна! гэж бахдалтай гэгч нь хэлчихээд дараа нь продюссертоо хандан,

-Та намайг сонсч байна уу? гэж ёгт утгаар асууна.

Продюссер энэ хүнийг дахин урих ёсгүй гэдгийг үг сүггүй ойлгодог гэнэ. Тэрээр бусдын амжилтыг үл тэсвэрлэх атлаа нэгэн удаа сургуулилтаасаа тарж яваад урьд нь алдар нэрээ цуурайтуулан мандаж, өдгөө тоглох нь багассан Винни Теркелийн нүүр хувиргах өрөөг тогтоон харжээ. Виннид анх удаа телевизийн жүжигт тоглох дүр өгөөд мань эр урьдын адил алдарт хүрнэ хэмээн найджээ. Тоби үүдийг нээн орвол мал болтлоо согтсон жүжигчин буйдан дээр хөлбөрч харагдав. Найруулагч Тобид дөхөн ирээд,

-Орхи наадхаа. Тэр өнгөрсөн хүн гэж шивнэв.

-Яагаа вэ?

-Чи Винниг эс мэдэх биш дээ. Бид сургуулилж эхэлтэл мань эр ам нээнгүүт бүгд хөхрөлдөн үймэлдээд хөгшиний гэдэнг хөдөлгөчих юм хэмээн нарийхан чичигнэсэн дуугаар шивнэв.

-Тэр энэ дүрд тоглоно гэсэн, үнэн үү?

-Бүх жүжигчдийн л адил хүсэлгүй яах, вэ гээд нөгөө эр мөрөө хавчив.

Тоби Винни Теркелийг гэртээ аваачин бүх л шөнийн турш түүнгэй ноцолдож хонов.

-Сонсооч хөө, энэ чиний амьдрал дахь хамгийн чухал дүр. Чи бүгдийг салхинд хийсгэе гэж бодохгүй л байгаа биз дээ.

Архины лүү, тамхины танзанд нэвчсэн Винни нүүрээ өрөвдөлтэйгээр муригнуулан толгой сэгсчээд,

-Би бүгдийг тавиад туучихсан. Одоо яаж ч чадахгүй болсон гэлээ.

-Хэн тэгж байна?! Чи энэ дүрд хэн ч чадахааргүйгээр тоглож чадна.

-Гэхдээ тэд надаар тохуурхацгаасан гэж өвгөн гомдоллов.

-Мэдээж шүү дээ, яагаад гэдгийг мэдэх үү? Бүх л амьдралдаа чи тэднийг хөгжөөж явсан. Үзэгчид чамаас чухам үүнийг л хүлээдэг шүү. Хэрэвзээ өөрийнхөөрөө баттай зогсож чадвал ялан дийлж чадна! Чи бүгдийг байлдан дагуулах болно.

Бүхэл өдрийн турш тэрээр Винни Теркелийг итгэл найдвар төрүүлэн урам оруулахыг тэвчээр заан оролдоод, орой нь найруулагч руу нь утасдлаа.

-Теркелийг хувьд бүх юм хэвийн болсон. Та санаа зовох хэрэггүй гэж дуулгав.

-Би өөр бодолтой байгаа, тэгээд ч түүнийг солих болно гэж найруулагч эр архирчээ.

-Наад бодлоо еөрчил. Түүнд эцсийн удаа боломж олгоодох!

-Тэгж азаа сорихын хэрэг алга. Архины лүү дахиад л нэвширтэл гударч орхино биз!

-За тэгвэл хоёул тохирьё. Дахиад нэг үзээд алд. Хэрэв ерөнхий сургуулилтын дараа өөдтэй үр дүн гарахгүй бол би түүний оронд шан харамжгүй тоглож өгье гэж Тоби саналаа хэлэв.

Хэсэг чимээгүй болсноо найруулагч,

-Хөөе, чи үнэхээр хэлж байна уу?! хэмээн гайхан бөвтнөв.

-Надад бүрэн найдаж болно!

-Тохирлоо. Виннид маргааш өглөө 9 цагт сургуулилттай гэж хэл хэмээн найруулагч аманд орсон шар тосоо алдчихгүйн тулд яаран хариулав.

Жүжиг тавигдаж дуусан телевизээр гаран, тэрээр агуу амжилтанд хүрч үзэгчдийн талархлыг хүлээжээ. Шүүмжлэгчид Винни Теркелийг онцлон магтацгааж, мань эр телевизийн байдаг бай шагнал бүхнийг хүртэж, түүний өмнө амьдралаа шинээр эхлэх боломж нээгдэв. Винни Тобид талархлын бэлэг тэмдэг болгон үнэтэй бэлэг илгээтэл,

"Чи өөрөө амжилтанд хүрсэн" гэсэн зурвасын хамт буцаж ирсэн байлаа.

Тоби Темпл гэж ийм нэгэн хүн байжээ. Гайхалтай нь хэдэн сарын дараа Тоби, Винни Теркелийг өөрийн шоуд хэсэг зуур үзэгчдийн анхаарлыг татах шог ший тоглохыг хүсэн урьжээ.

Тоби түүнд цагийг нь олоогүй шог үг албаар хэлүүлэн, хөгшин жүжигчинг басамжлан элэг доог хийж, үзэгчдийн сонирхлыг бууруулжээ.

Тоби Темпл бас ийм нэгэн зан гаргаж чадах аж.

Нэгэн удаа телевизийн компаниудын захирлуудтай зөвлөлгөөн хийж байх үед нэгэн захирал ганц ч үг ганхийлгүй суусаар гарчээ. Дараах нь Тоби Клифтонд гомдоллон,

-Миний бодлоор би түүнд таалагдсангүй бололтой.

-Хэнд тэр вэ?

-Зөвлөлгөөн дээр байсан тэр залууд?

-Ингэлээ гээд чи яах билээ? Шалихгүй амьтан! Гучин гурван орлогч захирлууд цаана нь байна!

-Тэр надад ганц үг хэлсэнгүй. Би түүнд огт таалагдаагүй юм шиг байна хэмээн Тоби сэтгэл догдлон хэллээ.

Тобиг ихэд шаналж байгааг хараад Клифтон үг сүггүй суусан мань залуугийн эрэлд гарчээ. Тэр дуг нойрны цагаар мань захирал руу утасдаж халуун хэвтрээс нь босгов. Юу болсныг сонсоод өнөө залуу халаглан,

-Би юу?! Би түүнийг дэлхийн шилдэг хошин жүжигчин гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэмээв.

-Хонгор минь, та тэгвэл надад нэг тус болооч. Түүн рүү утасдаад сая хэлснээ хэлээдэх.

-Юу?!

-Тоби руу утасдаад тэрээр танд таалагддаг гээд хэлээдэх.

-За тэгье, өглөө заавал утасдана.

-Даруйхан ярьсан нь өлзийтэй дээ.

-Шөнийн 3 цаг болж байна шүү дээ!

Залуу эр гайхаш тасран Тобигийн утсанд залгавал тэрээр эхний жингэнэх дуунаар харилцуураа авлаа.

-Сайн уу!

Захирал залуу сандран түгдчиж,

-Би... би.таныг гайхалтай авьяаслаг жүжигчин гэж хэлэхийг хүссэн юм гэжээ.

-Баярлалаа анд минь гэх хариу сонсогдоод Тоби харилцуураа тавьсан байна.

Тоби заримдаа шөнө дунд сэрэн найз нехдөө покер тоглохыг урих ч юм уу, эсвэл 0'Хэнлон, Рейнжер нар руу утасдан зөвлөлгөөн хийх тушаал буулгана. Зарим үед Тоби дуг хийлгүй бүхэл шөнийн турш Мак, Клифтон Лоренсын кино компанийг байрыг харж суудаг байлаа.

Хүмүүс эргэн тойронд нь сандчин үймэлдэх тусам Тобигийн ганцаардал бүр ч их болсоор байв.

Бүлэг 22.

1963 оны 11 сар гарч, цагийн эрхээр намрын налгар дулаан өдрүүд ээх элчгүй сүүмгэр өдрүүдээр солигдон, өглөө хот бүхэлдээ хүйт даасан мананд бүрхэгдэж өвлийн анхны бороо орж эхэллээ.

Жилл Касл өглөө бүр заншил ёсоор Шваба эмийн санд очих авч "горьдогсод" өчигдөр, уржигдар, өнгөрөгч долоо хоногийн тухай улиг болсон хов ярилцан хэн яагаад тоглох дүрээ алдсан тухай, киноны ширүүхэн шүүмжлэлийг, азгүй жүжигчдийн өчүүхэн баяр баясгаланг шүүн хэлэлцэн бахаа ханган тав-лацгаана. Жилл тэдний өрөөсөн дугуй болчих вий гэхээс айдас төрөх болжээ. Бүсгүй урьдын адил ам жилтанд хүрнэ гэсэн итгэл төгс байсан ч гэлээ хуучин хершүүдээ харахаар хүн болгон бас л түүн шиг итгэл найдвар өвөрлөж явсныг нь ойлгожээ. Тэд бодит ертөнцөөс тасран хүсэл мөрөөдлөө хэзээ ч биелэхгүйг эргэцүүлэн бодохгүй мөрөөдсөөр амьдрах гэж үү?

Бүсгүй чадах ядахаараа тэдэнд туслан зөвлөж ганц нэг доллар эсвэл хоног төөрүүлэх газар олж, энэ цуглааныхны хувьд хэн бүхэн зовлонгоо тоочин хуваалцах шүтээн-эх нь мэт болжээ. Төдийлөн таалагдах хүнтэй учраагүйгээс ч тэр үү ажилдаа хэт улайрсандаа ч юм уу тэрээр эрчүүлтэй тун ховор уулзана. Жилл хуримтлуулсан бүх мөнгөө, хэрхэн тансаг сайхан амьдарч байгаагаа бахадсан уртын урт захидлын хамтаар ээж рүүгээ илгээх аж. Хатагтай Цински эхэн үедээ охиноо нүглээ наминчлан гэртээ эргэн очиж, Христийн сүйт бүсгүй болохыг залбиран гуйсан дэлгэрэнгүй захидал бичдэг байснаа Жиллийн тоглосон дүр, гуйвуулсан мөнгөний тоо нэмэгдэж эхлэхэд охиноороо бахдах сэтгэл бага зэрэг төрж эхлэв. Цаашид охиныхоо жүжигчин болох чин хүслийг эсэргүүцэхээ болин харин шашин шүтлэгийн сэдэвт кинонд тоглохыг шаардах болжээ.

"Хэрэв чи найруулагчдаа хатуу зарчимч шүтлэгтэй гэр бүлд өсөж хүмүүжсэн гэдгээ дуулгавал чамд даруй дүр өгнө" хэмээн захидал бичих бопжээ.

Одесс жижигхэн хот, тэгээд ч хатагтай Цински урьдын адил нефтийн эздийн эхнэрүүдэд ажиллаж, охиныхоо амжилтыг гайхуулан яваа гэдгийг Жилл сайн мэдэж байлаа. Дэвид Кеньон эрт орой хэзээ нэг цагт Жиллийн амжилтыг олж дуулах болно. Бүсгүй туслах дүрд тоглодог бусад жүжигчдийн адил гол дүрийн жүжигчиний дэргэд байгаа мөчдөө зургаа татуулахаар студийн зурагчины гарыг цайлгадаг бяцхан арга мэхэнд суралцаж, нэг хувийг нь ээждээ явуулаад нөгөөг нь альбомдоо хадгалах болжээ. Жилл захиа болгондоо алдарт хүрч нэрд гарахад ердөө л ганц алхам үлдлээ хэмээн битүүхэн үг цухалзуулна.

Цас унадаггүй Калифорнид зул сарын баяраас 3 долоо хоногийн өмнө Голливудын цэцэрлэгт гудамжаар Санта-Клаусын баярын жагсаал явагдаж, энэ өдрөөс эхлэн орой бүр Санта-Клаус гоёмсог тэргээр аялан зугаалах энэ баярыг Голливудын оршин суугчид тэсэн ядан хүлээнэ. Хаа сайгүй гадаа гэрт, машин унаанд хүртэл зул сарын сүлд дуулал хангинах авч эндхийн цаг агаар даанч нэг өвлийг санагдуулахгүй байлаа. Кино од, алдарт жүжигчид хурсан үзэгчдийг баясгахын тулд биш гагцхүү телевизийнхэн жагсаалыг сурвалжлан улс орон даяар тэднийг гаргаасай гэсэндээ Санта-Клаусын баярын жагсаалд оролцохоор хүч үзэн тэмцдэг гэнэ.

Жилл Касл буланд ганцаар зогсон алдартангуудын зогсох цэцэгсээр хучигдсан тавцанг бахдалтайгаар харна. Энэ жилийн ёслолын сайдаар Тоби Темпл тодорчээ. Баяссан жагсагчид өөрсдийн шүтээн од рүү харан мэндлэн орилолдоцгооно. Тоби, Жиллийн инээмсэглэхийг агшин зуурын төдий олж хармагц эл инээмсэглэл төдхөн оргүй алга болжээ.

Өмнүүр нь хамтран тоглож асан жүжигчид явж өнгөрөхдөө Жиллд гар даллан,

-Сайн уу, Жилл ээ! Амьдрал ямаршуу байна даа! хэмээн мэндчилэв.

Цуваанд яваа нилээд хэдэн хүн түүн тийш эргэн харахад Жилл шоу-бичнест хөл тавьсныг хүмүүс мэдэх боллоо гэсэн гайхалтай нэгэн мэдрэмж төрлөө.

Хэн нэгэн ардхан талаас нь сайхан баргил хоолойгоор,

-Өршөөгөөрэй. . . Та жүжигчин юм биш биз? гэж асуув.

Жилл эргэн харвал өндөр нуруутай, цайвар үстэй, 20 орчим насны, наранд борлосон, яралзсан цагаан шүдтэй, үзэсгэлэнтэй нэгэн залуу зогсож байв. Тэр хуучин жийнс, тохойндоо арьсан нөхөөстэй хөх өнгийн хүрэм өмсчээ.

-Тийм ээ хэмээн бүсгүй толгой дохив.

-Би ч гэсэн гээд залуу мушилзаад,

-Гэхдээ эхлэн тоглогч л доо гэлээ.

-Би ч мөн адил эхлэгч гээд Жилл хариу инээмсэглэв.

Мань залуу хөгжин,

-Таныг аяга кофенд урьж болох уу? гэв.

Ален Престон эцэг нь Мормопскийн сүмийн тэргүүн хийдэг асан Солт-Лейк хотоос иржээ.

-Би бүх л амьдралаа шашин шүтлэгтний дунд өнгөрөөсөн. Бага нас минь тийм ч хөгжилтэй байгаагүй, надад итгээрэй гэж тэрээр Жиллд хуучлав.

"Яг ижилхэн хувь заяатай бэлгэшээмээр уулзалт байх шив" гэж Жилл боджээ.

-Би сайн жүжигчин л дээ гэж Ален уйтгартайгаар хэлснээ,

-Даанч нэг өрөвдөх сэтгэлгүй хот юм. Бүгд намайг үзэн ядаад байх шиг! гэлээ.

Тэд кафег хаатал суун бие биесээ олон жилийн тэртээгээс мэдэх хуучин андууд мэт удтал ярилцлаа. Ален түүнийг гэртээ очихыг урихад Жилл эргэлзэх юмгүй зөвшөөрчээ. Тэрээр Голливудын цэцэрлэгт гудамжнаас холгүй Хайленд-авенюд тавилга бүхий өрөө хөлслөн амадардаг ажээ.

-Эндхийг угаадасны цооног гэж нэрлэхэд таарна гэж мань эр Жиллд хэлээд,

-Чи энд амьдардаг солиотнуудыг харсан ч болоосой! Бүгд шоу-бизнесийн од болцгооно гэж итгэцгээсэн улс! Хэмээн эгдүүцэн өгүүлэв.

"Яг л бидэн шиг юм. . . гэсэн бодол Жиллд толгойд харван орж ирлээ.

Алены өрөө ор, шургуулгатай шүүгээ, сандал, яйжганан салж унахаа шахсан ширээ гээд их л цомхон ажээ.

-Мөрөөдлийн ордонд нүүж очихыгоо л хүлээж сууна гэж Аленыг санааширахад,

-Яг л над шиг гээд Жилл инээмсэглэв. Ален гэнэт бүсгүйг тэврэн авгал тэрээр айсандаа хөшиж орхин, хамаг бие нь царцах шиг боллоо. -Гуйя, хэрэггүй.

Сайхь эр түүнийг анхааралтай гэгч нь ширтээд толгой дохихыг Жилл хараад гэнэт ичин аягүйрхэв. Тэр ягтаа тулсан ядуу оромжинд үл таних зртэй юу хийж байгаа нь энэ вэ?! Үүний хариу тун энгийн: Жилл тэсэхийн нөхцөлгүй ганцаардаж байгаага ойлгон, хэн нэгэнтэй ярилцахын хэнээрэл хүсэлд авган, эр хүний элэгсэг үг, сайшаан дэмжихыг сонсон, гарын тэврэлтийг мэдрэхийг хүсчээ. Тэр хэн нэгэн түүнд итгэх эсэхийг мэдэх хэрэгтэй байлаа. Жилл өөр амьдрал, тэс өөр ертөнцийн иргэн Дэвид Кеньоныг эргэн нэг санав. Гэвч Бурхан минь, Дэвидийг хүсэх хүсэл нь хэвээр, эл дур тачаал нь бие сэтгэлийн зовлон болжээ. Аленыг дахин тэврэн авахад нүдээ анивал үл таних эр гэнэт Дэвид болон хувирчээ. Чухамдаа түүнийг Дэвид үнсэн таалж, хувцсыг нь тайчин, ор руу аваачин түүнийг эзэмдэж. . .

Жилл бүхэл шөнийг Алентай өнгөрөөсний дараа хэд хоноод мань эр түүний бяцхан өрөөнд нүүж ирлээ.

Түүнтэй хэл амаа тун амархан ололцож нэгэн дээвэр дор байх нь бусдаас хамаагүй хялбар ажээ. Жилл хойч ирээдүйгээ бодох талаар түүнд сануулахад,

-Сонсооч, "Самар дахь болзоо"-г санаж байна уу? Юу болохыг тааж мэдэх гээд яахав. Хувь тавилан чамайг хайж байхад, өөрийгөө зовоон толгой гашилгахын хэрэг юу байна гэжээ.

Жиллийг ажилдаа явснаас хойш Ален орондоо удтал хөлбөрч хэвтгээд, зргэж ирэхэд нь буйдан дээр заларч, шар айраг шимэн ном уншихаас өөр гар хөдөлгөлгүй өнжиж сохор зоос ч олж ирдэггүй байлаа.

-Чи ёстой дүйрчихсэн мангуу амьтан. Тэр чамаар тэжээлгэн суганд чинь хавчуулагдан амьдарч, чиний вискиг шимэн уух л гэж байна. Даруйхан түүнээс сал! гэж Жиллийн найз бүсгүй түүнийг ятгажээ.

Гэвч Жилл түүний үгийг авсангүй. Тэр Хэрриет болон найз бүсгүйчүүл нь гагцхүү дөтлөн айсуй ганцаардлын аймшигаас дайжин зугтаах гэсэндээ сэтгэлгүй харчуултай улайран хүзүү толгой холбодгийг нь анх удаа ойлгожээ.

Жилл амь зуулга хийх ажлаа алдлаа. Зул сарын баяр болоход цөөн хоног үлдэн үзэх зоос ч

үгүй болжээ. Тэр ээждээ зул сарын бэлэг заавал явуулах ёстойсон.

Чухамдаа Ален хүнд бэрхшээлээс гарах гарц олсон нь тун хачирхалтай. Мань эр хаа хүрэхээ ч хэлэлгүй гэрээсээ гарч яваад эргэж ирэхдээ,

-Бид ажилтай болоо гэв.

-Ямар ажил?

-Мэдээж кинонд тоглох! Бид чинь жүжигчид шүү.

Жилл итгэл горилон түүнийг ширтлээ.

-Чи үнэн хэлж байна уу?

-Тэгэлгүй яахав! Нэг найруулагч андтайгаа санамсаргүй уулзлаа, зураг авалт маргааш эхлэнэ. Бидэнд дүр өгнө гэсэн. Өдөрт зуун янчаан өгнө гэнэ дээ.

-Гайхалтай! Зуун доллар! Ийм их мөнгөөр ээждээ өвлийн пальтоны сайн чанартай английн цэмбэ, гоёмсог арьсан цүнх авч өгч чадах нь! хэмээн Жилл хөөрөн баярлав.

-Тэд одоохондоо хөл дээрээ хараахан босоогүй байгаа. Тайз, тоног төхөөрөмж авах бэлтэй болтлоо гараашид зураг авч байгаа гэнэ.

-Болохгүй нь юу байх вэ, дүр бол дүр гээд Жилл мөрөө хавчив.

Гарааш нь цагтаа цалгин цэцэглэн хөгжсөн өдгөө хамгийн ядуу тарчигт тооцогдох болсон Лос-Анжелесын емнө зүгт орших нэгэн дүүрэгт байрлах ажээ.

Бараан царайтай тайрдас шиг тагжгар эр үүд нээж өгөөд Алентай гар барин, шийдэмгийгээр толгой дохиод,

-Босгыг минь алхсанд баярлалаа, анд минь! Сайн эр! гэснээ Жиллийг шүлэнгэтэн харж исгэрээд,

-Энэ бүсгүй юу? Давгүй шүү, анд минь! гэлээ.

-Жилл ээ, энэ Питер Терральо, энэ Жилл Касл хэмээн Ален тэднийг танилцуулав.

-Сайн байна уу гэж Жилл амандаа бувгналаа.

-Пит найруулагч хэмээн Ален хажуугаас нь тайлбар өгөв.

-Найруулагч, продюссор, хуучны цонх угаагч, юу эсийг хийв дээ, орцгоогооч.

Сайхь эр тэднийг дагуулан хоосон гараж дундуур явсавр урд нь зарц нар байрлаж байсан гэмээр хоёр унтлагын өрөө бүхий байр руу орлоо. Үүд нь нээлттэй тасалгаанаас хэн нэгний

дуу гарахад Жиял дөхөн очоод дотогш шагайн хар-аад нүдэндээ ч итгэсэнгүй. Тасалгааны голд асар том ор байрлуулан орон дээр чармай шалдан хоёр бүсгүй негр, мексик хар цагаан эрчүүдийн хамт хэвтэцгээж байлаа. Хурц тольдуур өрөөг бүхэлд нь тод гэрэлтүүлнэ. Нэг бүсгүй мексик эрийн дээрээс бөхийн амьсгаадан тачаадаж,

-Алив, азаргахан минь, бүү залхуур, чавхайтал босгоодох! хзмээн гийнаж эрийнхээ эрхтэнг оролдож байгаа үзэгдэв.

Жиллийн ухаан балартаад ирэхийг мэдэрмэгц хамаг хүчээ дайчлан үтэр түргэн эргэн зугтах гэтэл хөл нь хадуулсан өвс мэт сулдайн тамир тасарчээ.

Ален түүнийг хөсөр унахаас нь өмнө амжин тэвэрч аваад,

-Юу болоо вэ? ! гэж хэлэх дуулав.

Гэвч Жилл үг дуугарч чадсангүй. Гавлын яс нь цуу татах мэт толгой нь янгинаж, хэвлий руу нь зуу зуун хутга шаагаад авах шиг хүчтэй хатгуулна.

-Энд хүлээж бай гэх Алены дуу бүдэг бадагхан сонсогдов.

Тэр төдөлгүй эргэж ирээд гожгор шилтэй улаан эм, устай авчран Жиллд хоёрыг сарвайн,

-Уучих, даруй зүгээр болно гэжээ.

Жилл ам руугаа эм гудчин хийх зуур чамархайн орчим тэсэхүйеэ лугшин өвдөхийг мэдрэв.

-Усаар даруулаад залгил.

Бүсгүй тун дуулгавартай байлаа.

-Одоо энийг гээд Ален бас нэгэн шахмал эм өглөө.

Тэрээр өөрийн мэдэлгүй хэлсэн бүгдийг ёсчлон гүйцэтгээд эмийг уугаад шилтэй уснаас залгиллаа.

-Чи жаал хэвтэх хэрэгтэй байна гээд Ален Жиллийг хажуугийн эзгүй өрөө рүү хөтлөв.

Яг л зүүд нойрон дунд хөвж яваа мэт хөдөлсөөр Жилл орон дээр хэвтэв. Эм үйлчилж эхлэв бололтой бүсгүйн бие хөнгөрөвч, цөс амтагдан ам нь гашуу оргино.

Толгойн өвчин намдаж эхлэхэд Ален дахин нэг эм авчирч згөхөд нь Жилл усаар даруулан бас л ууж орхижээ Хамаг өвчин нь намдаж, юутай сайхан тайвширал гээч вэ! Гэвч Ален нэг л хачирхалтай тавгүйтэн татваганаж сандчин ийш тийш холхиж байлаа.

-Тайван суугаач! хэмээн Жилл тушаангуй хэлэв.

-Суулаа

Жилл яагаад ч юм гэнэт хөөрөн хөгжиж биеэ барин зогсож чадахгүй болтлоо тас тас хөхөрч эхэллээ. Түүний хацрыг нь даган нулимсны сувдан хэлхээ тасралтгүй бөмбөрнө.

-Юун ... юун эм байсан бэ?

-Толгойн эвчин намдаах эм, бүжинхэн минь.

Тасалгаанд Терральо орж ирэв.

-Яаж байна? Бүх юм зүгээр үү?

-Б-ү-гд, зүгээр гэсээр Жилл арай ядан хэлэхчээн аядлаа.

Терральо Аленыг харан толгой дохиод,

-Таван минут шүү! гэж тушаагаад гарч одов.

Ален Жиллийн дээрээс бөхийн түүний хөх, гуяыг илэн таалаад банзалыг нь сөхөн салтаа руу нь гараа шургууллаа. Өгүүлж барамгүй сэрэл нь өдөөгдөн хөдлөж Аленд эзэмдүүлэх хүсэл нь оволзоод ирлээ.

-Сонсооч, хүүхэлдэй минь. Би чамаас таагүй зүйл хийхийг гуйж байна гэж үү? Бид, чи бид хоёр загас наадуулан жаргана. Тэгээд бидэнд үнэ хөлсийг нь өгнө. Бодооч, зуун ногоон! Энэ бүгд чинийх.

Жилл толгой сэгсрэхийг оролдсон боловч хөдөлж ч чадсангүй.

-Би чадахгүй хэмээн халамцуу аятай бувгнав.

-Яагаад вэ?

Жилл бүгдийг эргэн санахыг хичээн хамаг хүчээ шавхаад,

-Яагаад. . . гэвэл. . . би. . . од бол-болно.

-Би чамайг эзэмдэхийг чи хүсч байна уу?

-Өө тийм ээ! Чи надад т-тун хэрэгтэй байна, Дэвид.

Ален нэгийг хэлэх гэснээ болин, мушигнан инээлээ.

-Тэгэлгүй яах вэ, хүүхэлдэй минь, би чамд ухаангүй дурлажээ! Явцгаая!

Тэрээр Жиллийг гараас нь хөтлөн орноос нь босгов. Жилл хаашаа ч юм хөвж яваа мэт санагдаад, хажуугийн өрөө рүү хэрхэн орсноо ч анзаарсангүй.

-За тэр! гэж Терральо дуу алдаад,

-Бэлдэцгээ! Манайд шинэ хүн ирлээ! Одоо эхэлцгээе! гэлээ.

-Дэвсгэр даавууг солих уу? хэмээн гэрэлтүүлэгчдийн нэг нь асуув.

-Юугаа хийх вэ! Бид ямар "Метро-голдвин-Мейер" биш дээ?

Жилл Аленд улам наалдан,

-Дэвид, энд олон хүмүүс байна! гэлээ.

-Тэд одоо явна гэж Ален түүнийг ятгаад,

-Май уучих гэлээ.

Түүний гарт бас нэгэн эм үзэгдэж Жиллийн ам руу хийгээд араас нь хүчээр шахуу хоолой руу нь ус цуггалаа. Энэ мөчөөс бүх юм манан буданд байгаа мэт маналзаж эхлэв.

"Дэвид" түүний хувцсыг нь тайчин тайвшруулаад, эелдэг ялдам үгс чихэнд нь шивнэнэ. Дараа нь тэд оронд орцгоон нүцгэн халуун биеэрээ түүнд наалдан тэвэрлээ. Хурц гэрэл гялсхийн агшин зуур бүсгүй юу ч харахгүй гялбалаа.

-Амандаа хийчих гэж "Дэвид"-ийн хэлэхэд,

-Өө тийм, одоохон...

Жилл хайртынхаа хүссэн бүгдийг хийхийг хүсч байтал тасалгаанд хэн нэг нь үл ойлгогдох юм бувгнавал "Дэвид" хажуу тийшээ зайлсхийлээ. Жилл хайр гамгүй гялбуулах хурц гэрэлд гялбан нүүр буруулав. Хэн нэг нь түүнийг орон дээр түлхэн ар нуруугаар нь харуулж "Дэвид" түүнийг эзэмдэж эхэллээ. Тэр "Дэвид"-эд ямар их хайртай юм бэ! Гагцхүү өрөөнд дуу чимээ, хурц гэрэл. . . Тэрээр "Дэвид" тэсгэлгүй тэчъядах дур хүслийг нь тайлж өгөхийг дахин дахин. . ."Дэвид Сиссид биш түүнд дурласан. Тэр эргэн ирж тэд гэрлэцгээжээ. Ямар гайхалтай ер бусын бал сар гээч. . .

-Дэвид... хэмээн шивнээд Жилл нүдээ нээв.

Ойролцоо зогсох хоёр эр орон дээр хөдөлгөөнгүй хэвтээ бүсгүйгхаран зогсоцгооно.

-Тэр үхчихгүй биз! гэж Терральо асуувал,

-За юу гэж дээ? гээд Ален чангаар инээд алдае.

-Чи ч сүйхээтэй эр шүү! Эднийг*хаанаас олдог байна? Нүд хужирласан сайхан бүсгүй байна! хэмээн Терральо дуу алдан шагшин магтлаа.

-Чадаж байгаа юманд арга байхгүй! гээд Ален гараа сарвайтал Терральо зузаан хэтэвчээ гарган 2 дэвсгэрт сугалж,

- Май. Ингэхэд чи Зул сарын баяраар манайд ирэх үү? Стелла чамайг ирвэл баярлана даа! гэв.
- Чадахгүй. Зул сарын баярыг эхнэр, хүүхэдтэйгээ өнгөрөөнө. Дараагийн нислэгээр Флорид руу нислээ.
- Кино дажгүй болно биз! гэхэд нь Терральо ухаангүй хэвтээ бүсгүй тийш толгой дохиод,
- Танилцуулга дээр нь юу гэж бичих вэ?
- Жинхэнэ нэрийг нь яагаад бичиж болохгүй гэж? гэснээ Ален мушигнан инээгээд,
- Жозефина Цински гэж бич. Кино Одесст гарахад түүний танилууд олон удаа морилон ирж үзэх болно доо! гэжээ.

Бүлэг 23.

Хүмүүс цаг хугацааг анд нөхөр биш, гагцхүү залуу насыг ховдоглон залгигч хорон санаатай дайсан гэлцэнэ. Сар, жил улиран өнгөрч, од болохыг хүсэгчдийн арвин их цуваа Голливуд тийш автобус, галт тэрэг, онгоц тэр ч бүү хэл мотоциклоор тасралтгүй хөврене. Тэд бүгд урт чилгэр хөл, гоолиг биетэй, гялалзсан нүдтэй, цог жавхлантай инээмсэглэсэн Жиллтэй адил 18 настай байх ажээ. Жил ирэх тусам Жилл ахимаг настны тоонд орох болжээ.

1964 он хэдийнэ үүдийг нь тогшин бүсгүй хорин таван нас хүрчээ.

Порно кинонд хууртан тоглосноо бодохнээ Жиллийн ар шилний нь үс арзасхийн шоу-бизнесийнхнээс хэн нэг нь бүгдийг мэдэж хар дансандаа хөтлөчих вий хэмээн үргэлжийн айдас хүйдэстэй амьдарч байлаа. Гэвч цаг хугацааны эрхээр Жилл бага зэрэг тайвширч, ихэд өөрчлөгджээ.

Жилл нарийн бичгийн дарга, загвар емсөгч, үйлчлэгч, холбоочин худалдагч гээд нэг хэвийн үр ашиггүй олон ажил сольжээ. Санаа нь хярд, сачий нь бэлдгэгчээр оролцон тоглох дүр олж авахаас илүүтэй гавьсангүй. Чухам энэ өдөр толинд харсан Жилл толинд туссан дүрснээсээ,

"Яаравчил! Хурдал!" гэсэн цаг хугацааны илгээмжийг олж уншжээ.

Толинд үл биелэх хүсэл мөрөөдлөөсөө няцан шалдаа бууж, нүүрэнд нь суусан гомдол цөхрөлийн гүн үрчлээг үе үеэр нь хуулан өнгөрсөн рүү буцаад ч ялгаагүй болсон өөрийн дүрийг харлаа. Чилийсэн долоон жилийн тэртээ итгэл өвөрлөн Голливудад ирж байсан залуу бүсгүйн дүр төрхөөс нүүр царай нь аргагүй л ялгагдана. Тэр цагт хатуу цап;йн түгшүүр, эцэс тегсгөлгүй гашуун ялагдал, алдарт хүрч/.х гэсэн дэмий оролдлогоос үүдсэн өчүүхэн төдий ч үрчлээ нүдний нь буланд үүсээгүй хэмрын угалзнаас эрүү хүртэл гүн зураас суугаагүй

байжээ.

"ХХ зуун Фокс" студийн арван наймтай туслах найруулагч Фред Кэппер Жиллд сайн дүр олж өгснийхөө шанд энгэр зөрүүлэхийг шаардахад нь Жилл энэ удаад зөвшөөрөхөөс өөр аргагүйг нь ойлгожээ.

Бүсгүй үдийн цайны завсарлагаар Кэппертэй уулзахаар студид ирлээ.

-Надад хагас цагийн зай байна. Бидэнд саад болохгүйхэн шиг газар хаана сан билээ, жаахан бодоодохье гээд хэсэг зуур гүн бодолд умбан зогссоноо, тэр даруй нүд нь гялалзан, нүүр нь гэрэлтээд, -Дуу бичлэгийн өрөө! Алив, явцгаая! гэжээ.

Ингээд тэд дуу үл нэвтрэх жижигхэн тасалгаанд орлоо.

Фред Кэппер хоосон өрөөг нүд гүйлгэн харснаа гэнэт,

-Ээ новш гэж! Энд урьд нь нэг буйдангийн оронцог байсансан гээд хараал урсган цагаа хяламхийн харснаа,

-Энд амжуулахаас даа. Хонгор минь, хувцсаа тайч. Хорин минутын дараа дууны техникчид ирцгээнэ гэлээ.

Жилл эл залууг үзэн ядахын зэрэгцээгээр ягтаа тулсан янхан болсноо мэдрэн уруулаа хазлан зогслоо. Тэрээр амжилтанд хүрэх гэсэндээ азгүй явдлыг тэсвэрлэн тэвчиж бүр сүүлдээ тэдний юу хүссэнийг нь биелүүлэх болжээ. Жилл палааж, дотоожоо тайчив. Кэппер хувцсаа тайчихыг ч бодсонгүй, ердөө л өмднийхөө цахилгаан товчийг доош буулган чинэрч боссон эрхтэнээ гарган ирээд Жиллийг шүлэнгтэн ширтсэнээ мушилзан инээж,

-Дажгүй өгзөг байх чинь ээ! Алив тонгой! гэлээ.

Жилл тулчих юм хайн ийш тийш гүйлгэн харвал урдхан талд нь "инээдмийн машин" хэмээх дуу бичлэг бүхий төхөөрөмж үзэгдэв.

-Алив, хурдал!

Жилл хормын тедийд зргэлзсэнээ бөхийн гар сунган төхөөрөмжийг тулбал Кэппер ард нь гэрч зогссоноо өгзөгийг нь хоёр тийш нь татсанаа мань эр ёс бус авирлан "бандидах" гэж буйг бүсгүй мэдлээ.

-Болиоч! Тийшээ биш ээ. Би. . . би чадахгүй! -Хүүхэлдэй минь хашгир, энэ чи-нь намайг өдөөж өгнө! гэж Фред ороо нь орсон араатан аятай гийнаад хурц хутгаар чичлэх мэт гантайтал боссон эрхтэнээ улам гүн шургууллаа. Бүсгүй мултрахыг тэсгэлгүй хүсэн тэмүүлэвч Фред олсон ангаа алдахгүйг хичээх зэрлэг араатан шиг бүсэлхийгээр нь тас тэврэн тэчъядан татгас татгасхийн хөдөлж гарав. Тэнцвэр олохоор тэмүүлэх зуур Жилл санамсаргүйгээр дуу бичлэгийн товчлуурыг дарж орхивол өрөө даяар хийрхэн тачигнатал инээх дуу цуурайтлаа. Бүсгүй зориудаар товчлууруудыг зэрэг дартал зохисгүй хошигнол сонсон зугаацан суугаа хүмүүсийн инээд, чарлаан, аальгүйтэн инээх, тачигнатал хөхрөн бархирах сонсогдов.

Цуурай эгээ л хийрхсэн гэлтэй хананд ойж тусаж байхад Жилл өвдсөндөө тэсгэлгүй б>архирлаа. Бүсгүй гэнэт тасалдан чичигнэж, үл мэдэх ёврох мань эрийн тачаалаа тайлахыг нь мэдэртэл, сайхь эрийн заналтай махан биений тасархай биенээс нь сугаран гарч, цуурайтаж байсан инээд алгуурхан намжив. Бүсгүй өвчин намдахыг хүлээн нүдээ анин таг дуугүй зогсоно. Өндийх тэнхэлтэй болмогц азаргалагч эрийг эргэн харвал Фред Кэппер өмдний цахилгаанаа товчлон байгаа харагдав.

-Чи гайхалтай байлаа, муурхан минь! Чиний орилох миний сэрлийг өдөөлөө!

Жилл энэ адгийн новш жилийн дараа гэхэд ямар араатан болохыг нь дотроо төсөөлөн боджээ. Фред цусанд хутгалдсан бүсгүйг хараад,

-Наадахаа арчиж цэвэрлээд зураг авалтын талбай руу оч. Өнөөдрөөс эхлэн ажиллах болно гэлээ.

Эл явдлаас хойш бүх юм хэвийн болж, Жилл "Уорнер бразерс", "Парамаунт", "Юниверсал"

гээд бүхий л студид ажиллах болжээ.

Жилл өөрийн шилдэг дүрээ орон дотор тоглон, эр хүний уран сэтгэмжит мөрөөдлийг нь бодитоор амтлуулж чадах болжээ. Тэрээр дорно дахины эротикийн гарын авлагыг судлан яг л жүжигт сургуулилах мэт учраа бүрдээ бэлтгэж, Санта-Моникагийн цэцэрлэгт гудамж дахь секс-шопоос өдөөн сэргээгч өвсний ханд худалдаж авчээ. Мөн онгоцны танил үйлчлэгч бүсгүй нь Хятад аманд үл мэдэг арцны үнэр бүхий шингэн авчирч өглөө. Бүсгүй түүгээр нь нууц амрагуудынхаа сэрэл хүслийг сэргээн массаж хийх болов.

-Хэвт, тэгээд бие чинь хэрхэхийг чагнаж бай гээд бүсгүй ээлжит амрагтаа шивнээд өнөө шингэнээр цээж, гэдэс, хөл, ар нуруунд нь түрхэн зөөлөн илбэнэ. Жилл тэдний бие сэтгэлийг тайвшруулан урьд хожид хэзээ ч үзээгүй зүйрлэшгүй таашаал, цэнгэлийг амсуулах боловч тэд зөвхөн өөрсдийн таашаалыг хүртмэгц даруй хувцаслан талийж өгнө. Хэн нь ч Жиллийг энхрийлэн эелдэг үг хэлдэггүй ажээ. Түүнд нууц амрагынхаа тэврэлтэнд жаргал эдлэх гээч баяр баясгаланг амсуулалгүй өнгөрнө.

Жиллийн авдаг жижиг дүрүүдийг тэр л продюссер, наруулагч, туслах найруулагчид юутай ч зүйрлэшгүй онгодыг нь оруулж, таашаал амсуулсных нь хариуд өчүүхэн төдий шан болгон өгдөг ажгуу.

Хот даяар Жиллийн тухай, хэн ч эр хүнд түүн шиг таашаал амсуулж чадахгүй хэмээн яригдаж эр сүвтэй хүн бүгд л өөрийн хувиа хүртэхийг хүсэх болжээ. Жилл хэнд нь ч татгалздаггүй авч алхам бүрдээ өөрийгөө хүндлэх өчүүхэн төдий хайр, энэрэлийн оронд өш хонзон үзэн ядалттай хоцроно.

Бүсгүй хэзээ, хэрхэн гэдгийг хараахан тааварлаж мэдэхгүй байгаа ч гэлээ энэ хот түүнд амсуулсан бүхнийхээ хариуг хэзээ нэг цагт амсах болно гэдэгт итгэл төгс байлаа.

Жилл кино, телекиноны олон ч рекламд тогложээ. Тэр "Өглөөний мэнд, ноён Стивенс" хэмээгч нарийн бичгийн дарга, эцэг эхийг нь тайтгаруулан "Цагаа тавтай өнгөрөөгээрэй, би хүүхдүүдийг цагт нь унтуулна" гэх асрагч, "Дараагийн давхар-зургаа" хэмээн зарлах лифтчин, цанын хувцас өмсөөд; "Миний бүх найз бүсгүйчүүл Данхилл"-ыг татдаг хэмээн сээтэгнэх бүсгүй гээд олон дүр бүтээв.

Гэвч юу ч өөрчлөгдсөнгүй Жилл урьдын адил олны дунд нэр алдаргүй хэвээр үлджээ. Тэрээр шоу - бизнест ажиллан "шилдэг" нь болж чадалгүй амьдралаа энэ хэвээр өнгөрөөнө гэдэг санаанд нь огт багтсангүй.

1966 онд эх нь нас нөгчин Жилл оршуулганд иржээ. Гашуудал тайлах ажиллагаанд хатагтай Цинскийн олон жилийн турш бөхөлзөж байсан тэр хатагтай нарын хэн нь ч ирсэнгүй, зөвхөн шашныг үнэн шүтэн бишрэгч арваад хүн оролцжээ Шашны цуглаан түүнд ямар аймшиг төрүүлдэг байсныг, эх нь түүнийг зовоогч шулмын хорлолоос нь салгах гэж чармайж байсныг нь эргэн саналаа.

Жилл гэнэт танил намуухан дуугаар,

-Сайн уу, Жозефина гэхийг сонсоод эргэн харвал тэрээр дэргэд нь зогсож байлаа. Жилл түүний нүдийг ширтээд тэд салж хагацаагүй урьдын адил хамт байсан мэт нэг л хачирхалтай санагдаад явчихлаа.

Он жилүүд түүнд ул мөрөө үлдээж, санчигийг нь мөнгөн сороор буджээ. Гэвч тэр огт өөрчлөгдсөнгүй урьдын Дэвид, түүний Дэвид хэвээр байлаа.

-Гүнээ харамсал илэрхийлье хэмээн залуу шивнэв.

Жилл ч өөрийн мэдэлгүй,

-Баярлалаа, Дэвид гэж хариулав.

Тэд жүжиг тоглож байгаа мэт бүгд тэднийг нүд бүлтийн ширтэцгээнэ.

-Бидэнд ярих юм байна. Өнөөдөр уулзаж чадах уу? хэмээн Дэвид хулган цөхөрсөнгүй аясаар гуйв.

Жилл гэнэт хамт өнгөрөөсөн сүүлийн шөнийг, тэдний хайр дурлалыг, амласан бүхнийг, хүслийнхээ тухай... эргэн дурслаа.

-Тэгье, Дэвид хэмээн бүсгүй зөвшөөрөв.

-Нууран дээр очих уу? Чи машинтай юу?

Жилл толгой дохин,

-Би цагийн дараа очъё гэлээ

Дэвидийг орж очиход Сисси толины өмнө эргэлдэж үдийн

хоолонд урилгаар очихдоо хэрхэн хувцаслахаа шийдэж байв. Мань эр хана налан эхнэрээ өчүүхэн төдий тачаах хүсэлгүй харж зогслоо. Сисси үнэхээр үзэсгэлэнтэй. Гуалиг сайхан бие нь түүний эрхэм эрдэнэ тул тэр бие хаандаа анхаарал тавин хоолны дэглэм барин үргэлж гимнастикаар хичээллэх гоо сайхан биеэ гольфийн дасгалжуулагч, цанын спортын зааварлагч нартай хуваалцан эдлэх боловч Дэвид эхнэрээ огт буруутгадаггүй төдийгүй Сисси тэр хоёр хэдийнэ өөр өөр өрөөнд унтах болсон ажээ.

Тэртээ нэг цагт Дэвид хатагтай том Кеньоныг нас нөгчсөний дараа эхнэр нь түүнд салахыг зөвшөөрнө гэдэгт үнэн голоосоо итгэж байжээ. Гэвч Дэвидийн эх нь урьдын адил амьд мэнд төдийгүй эрүүл саруул, энх тунх байгаа аж. Дэвид ямар гээчийн илбэ жидээр эсвэл юу нь түүнийг ингэтэл нь эргүүтүүлснийг огт ойлгосонгүй өнгөрчээ.

Хуримласнаас жилийн дараа тэрээр нэгэнт шийдэн,

-Салах тухай ярих цаг боллоо гэж эхнэртээ дуулгавал,

-Юун салалт? гээд Сисси Дэвидийн цочирдон гайхсан царайг харснаа тас тас хөхөрч,

-Надад хатагтай Кеньон байх таалагдаж байна, хонгор минь. Чи арай намайг польш янхан эмд чамайг зүгээр нэг бэлэглэнэ гэж бодоогүй биз дээ? гэжээ.

Дэвидийн уур нь галзуутай оволзож зэвүүцэхдээ түүний нүүрэн дундуур нь цохиод авлаа.

Өглөө нь мань эр итгэлт өмгөөлөгчдөө байдлыг тайлбарлавал өмгөөлөгч нь бодолд авган толгой сэгсэрч,

-Салалтыг чинь би хөөцөлдье. Гэвч Сисси өөрийнхөө зүтгэх байхдаа, тэгвэл ч та овоохон мөнгө үрнэ биз дээ гэв.

Сисси салах тухай мэдүүлгийн нэг хувийг авмагц Дэвидийн угаалгын өрөөнд орон түгжиж аваад атга нойрны эм ууж орхижээ. Дэвид хоёр зарцынхаа тусламжтайгаар хүнд хаалгыг эвдэн оржээ. Сисси хоёр өдрийн турш үхэл сэхлийн дэнсэн дээр дэнжигнэж байлаа. Дэвид эхнэрийнхээ хэвгэж буй хувийн эмнэлэгт эргэж очиход,

-Дэвид, өршөөгөөрэй, би чамгүйгээр амьдарч чадахгүй, гүйцээ хэмээн шивэгнэв.

Маргааш нь тэрээр өргөдлөө буцаан авчээ. Энэ бүхэн арваад жилийн тэртээ болсон агаад Кеньоны гэр бүлийн амьдрал өдгөөг хүртэл эв тунжингүй хэвээр. Тэрээр удам дамжсан эзэнт улсынхаа жолоог гартаа атган эрч хүчээ бизнест зориулан, ажил хэргээр хаа яваа газраатаа бүсгүйчүүлтэй бие сэтгэлийн таашаал эдлэх болов. Гэвч тэр Жозефинаг мартаж чадсангүй. Дэвид бүсгүйд захидал бичихийг хүсэх авч Жозефинад түүнийг үзэн ядах үндэслэл байгаа гэж бодохоос ихэд эмээнэ. Дэвид хатагтай Цинскийн нас нөгчсөнийг дуулаад бүсгүйг ядахдаа нэг харахыг хүсэмжлэн оршуулах ажиллагаанд ирсэн бөгөөд харангуугаа түүний хувьд юу ч өөрчлөгдөөгүй, урт удаан хугацаа өнгөрсөн ч Дэвид түүнд урьдын адил хайртай хэвээр байв.

"Бидэнд ярих . . . уулзах.." "Тэгье, Дэвид. . ." "Нуур"

Сисси босоо толины өмнө зогсож байснаа нөхрийгөө орж ирэхийг хараад түүн тийш эргэн харж,

-Дэвид, хувцсаа соль, түргэл! Яаравчлахгүй бол хожимдох нь гэлээ.

-Би Жозефинатай болзсон. Хэрэв тэр зөвшөөрвөл бид гэрлэнэ. Энэ эмгэнэлт хошин жүжгийг дуусгах цаг нь болсон гэж бодож байна, юу гэмээр байна?

Гуалиг шалдан биений нь тусгал толинд харагдан Сисси хэсэг хөдөлгөөнгүй зогссоноо,

-Би хувцаслаж болохсон болов уу хэмээн эцэст нь хүчлэн хэллээ.

Дэвид толгой дохиод гарч одов.

Тэрээр тулалдаанд бэлтгэн зочдын өрөөгөө алхам алхмаар хэмжих мэт ийш тийш тэсгэлгүй холхино. Сисси өдий олон жилийн дараа хэдийнэ ёс төдий болсон гэрлэлттэй зууралдана

гэдэг юу л бол. Тэрээр түүнд хүссэн бүгдийг нь өгөх. . .

Гэнэт моторын дуу хүржигнэснээ дугуй хяхтнах чимээ сонсогдлоо. Сиссигийн машин хашаанаас нисэх мэт годхийн хурдлангарч зам руу срлоо. Дэвид доош гүйн гарч, машинаа асаан шил даран хөөв. "Мазератти" тэртээ хол давхиж, Дэвид яаран урагш зүтгэх авч хүнд "роллс-ройс" нилээдгүй хоцорчээ. Тэрээр хурдаа 70. . . 90. . . хүртэл нэмлээ. Сиссигийн машин үзэгдэх бараагүй тасрав. 100. . . 120. . . юу ч үзэгдсэнгүй. Дэвид багахан шиг өгсүүр газар гарч ирвэл тэндээс "мазе-ратти" өчүүхэн жижиг тоглоом шиг харагдан согтуу аятай зам хэрэн сүлжиж галзуутай давхиж явснаа гэнэт эргэлтэн дээр зам хендлөн гарч хамгаалалтыг даван агаарт нисэх нь тэр.

Машин агаарт хэдэнтээ эргэлдээд талбайд хэмх үсрэн уналаа. Дэвид ухаан алдсан эхнэрийнхээ биеийг шамшийж хэмхэрсэн машинаас дэлбэрдэгийн даваан дээр амжин гаргаж авчээ.

Өглөөний 6 цагт мзс засалч эмч хагалгаанаас гарч ирээд ядарч туйлдсан дуугаар,

-Тэр амьд гарна гэж хэлжээ.

Жилл нар шингэх үеэр нууранд хүрч ирлээ. Тэрээр нуурт дөтлөн очоод усны захад зогсон машинаа унтраачихаад суудлаа налан аз жаргалтай үедээ анзаараагүй үнэр, дуу авиаг бие сэтгэлдээ шингээн суулаа. Энд, Дэвидтэй. Хамтдаа байх ямар сайхан байснаа санахад хүсэл тачаал нь хамаг биеийг нь харангадуулан зовооно. Жилл Дэвидийг харсан тэр мөчид сэтгэлийн нь саарал манан сарнин үгүй болжээ. Тэр түүнд хайртай хэвээр байна гэдэгт Жилл бүрэн итгэжээ. Час улаан наран нуурын толигор санд алгуурхан живэн, харанхуй шөнө газар дэлхийг бүрхлээ. Дэвид түргэхэн ирээсэй! Цаг өнгөрлөө, бас дахин нэг цаг.. Хүйтэн болсон хэдий ч Жилл хөдлөлгүй хүлээн суусаар. Тэнгэрт зэвхий цагаан өнгөтэй аварга саран хөвсөөр гарч ирэв. Жилл шөнийн чимээ анирыг сонсон Дэвид хэзээ медгүй ирэх болно хэмээн өөрийгөө ятгана. Бүсгүй шөнийн турш хүлээгээд тэнгэрийн хаяанаас улаараад ирмэгц машинаа асаан Голливуд руу гэртээ харихаар явлаа.

Бүлэг 24.

Жилл толинд дүрээ шинжин гоо сайхны ширээнийхээ өмнө суун нүдний нь буланд тогтсон мэдэгдэм үрчлээг анзааран дур гүйцэн ярвайлаа. Эрчүүд бууралтаж, хөгширч харвин суухыг үл тоодог бол эмэгтэйчүүд ганцын төдий үрчлээ суувал...

Жилл оо энгэсэгээ түрхэж эхэллээ. Голливудын шилдэг нүүр хувиргагч Боб Шиффер түүнийг чамгүй сайн сургажээ Тэрээр чийгшүүлэгч тос түрхчихээд нүд будах ажилдаа орон доод зовхио тод, дээд зовхио бараан өнгөөр будан хиймэл сормуус наагаад уруулаа будан, шанаагаа бага зэрэг ягаан туяа татуулаад эцэст нь нүднийхээ доод хэсгээрх үрчлээгээ нуун пудр тавиад өө эрэн нүүрээ дахин шинжив Тэр үлэмж үзэсгэлэнтэй харагдана. Одоохондоо л тэр. Хэзээ нэг цагт наадаг тууз хэрэглэх цаг ирэхдээ л ирнэ, Бурхан минь тун удахгүй шүү. Ахимаг насны жүжигчид энэ аргыг хэрэглэдгийг Жилл сайн мэддэг ажээ. Тэд үснийхээ угт скотчийн тасархай наагаад наапданги туузанд утас наан толгойгсо тойруулан үсэндээ далдлан нууна. Үүний туслэмжтайгаар унжсан арьс нь татагдаж эмэгтэйчүүд үнэ ихтэй арьс татуулах хагалгаанаас мултарч дөнгөдөг байна. Гэвч Жиллд энэ мэх хараахан шаар дагдаагүй.

Тэрээр үсээ янзалчихаад толинд сайтар харснаа цагаа хяламхийгаад бослоо.

Жиллид "Тоби Темпл-шоуд" оруулахыг амласан тул шийдээ сонсохоор яаравчлан буй нь энэ.

Бүлэг 25.

Тоби Темплийн шоуны захирал Эдди Берриген гэр бүлтэй тул өөрийн итгэлт андаас гэрийн түлхүүрээ 7 хоногт 3 удаа өгч байхыг хүсчээ. Эдди нэг өдөр нь байнгын нууц аiwpaiaа, хоёр өдөрт нь "шинэ", "хуучин" авьяастан хүлээн авах гэж буй

нь тэр.

Жилл Касл шинэ авьяастанд тооцогдон, энэ бүсгүй хэн хүний зүүдэнд ч оромгүй шидийг үзүүлдэг, юу ч хийхээс буцдаггүй гэсэн цуу үг Берригений чихийг дэлссэн аж. Эдди түүнийг амтлах гэхээс байж ядна. Энэ удаад хэрэгцээт дүр нь гарч иржээ. Ердөө сайхан биетэй бүсгүй, урин дуудан инээмсэглээд хэдхэн үг хэлээд алга болох ёстой гэнэ.

Эдди Жиллийг биечлэн дуудан инээмсэглээд, сэтгэл хангалуун үлджээ. Мэдээж тэр Кэтрин Хенбернийг гүйцэхгүй ч гэлээ, энэ түүнд тийм ч чухал биш ажээ.

-За яах вэ. болох л юм! хэмээн тэр хэлжээ.

-Баярлалаа, Эдди.

-Зохиолоо ав. Маргааш өглөө 10 цагаас сургуулилт эхлэнэ, хожигдов, текстээ цээжлээрэй.

-Тэгэлгүй дээ гэгчхээд Жилл явах гэж яарсангүй.

-Ээ... енөөдөр уулзаж, аяга кофе ууя гэвэл юу гэмээр байна?

Жилл толгой дохив.

-Миний найз Аржайлд дажгүй сууцтай юмсан гэж Эдди үг цухуйлгалаа.

-Хаана байдгийг би мэднэ гэж Жилл хариу мэдэгдэв.

-6-р байр. 3 цагт уулзах уу? .

Сургуулилт амжилттай явагдаж шоу сайхан болох янзтай. Аргентин бүжиг бүжиж, алдартай рок-хамтлаг, илбэчин, алдарт дуучид энэ удаагийн шоуд оролцжээ. Ганцхан Тоби Темпл үзэгдсэнгүй. Жилл Эдди Берригенаас хошин жүжигчин маань өвдчихөөгүй биз хэмээн асуутал тэрээр инээд алдаад,

-Тэр өвдөв үү гэж үү, хаанаас даа! Ноёнтон зугаа цэнгэл эдлэх зуур зарц нар нуруу бөгтийлгөн ажиллах ёстой! Шоу бичлэг хийхэд бямба гаригт үүгээр морилон үзэгдэнэ гэлээ.

Эддигийн зөв байлаа. Тоби үнэхээр бямба гаригт морилон ирж студийг тэр аяар нь бишрүүлэн, эгээ л эзэн хааныг санагдуулав. Жилл тайзны буланд Тоби Клифтон Лоренс, гарын зарц гурван залуу, тоглох инээдмийн жүжигчдийг дагуулсаар зааланд орж ирэхийг харан зогсохдоо өөрийн эрхгүй Жиллийн зэвүү хүрчээ. Тоби Темплийн өвөрт орсон Голливудын аль сайхан жүжигчин бүсгүйчүүл түүний эдийн агуу сайхныг ичиж зоволгүй

бахдан хөөрөлдөцгөөхийг бүсгүй олонтоо сонсжээ. Түүнд татгалзан амтыг нь үзэлгүй өнгөрөх эм сүвтэн үл олддог гэнэ. Жилл Агуу Тоби Темплийн тухай бүгдийг нь мэднэ.

Тэвдүү өвчтэй найруулагч Чарли Деркин Тобид жүжигчдийг таницуулахад ихэнх нь түүний танилууд байх ажээ. Голливуд жижигхэн тосгонтой зүйрлэм ч гэлээ Жилл Касл Тобитой ганц ч удаа нүүр тулж явсангүй. Бүсгүй хул өнгийн даавуун палааж өмсөн, хүйтэн царайтай атлаа дэгжин, үнэхээрийн үзэсгэлэнтэй үзэгдэнэ.

-Хонгор минь чи юу хийж байгаа юм бэ?

-Шог шийнд бэлтгэж байна, эрхэм Темпл. Мань эр дарвайтал инээгээд,

-Миний найз нар намайг Тоби гэдэг юм гэлээ. Ажил ундарч, сургуулилт гайхалтай сайхан болох зуур Тоби Темпл яагаад Жиллийн өмнүүр эргэлдээд байгааг Деркин тэр даруй ойлголоо. Шоуны бусад бүсгүйчүүдийг гүйцээчихээд одоо шинэхэн шөл хүртчих санаатай нүд унагаж байгаа нь тэрээ!

Жиллийн оролцох тоглолт шоуны дунд хэрд байсан ба Тоби түүнд хэдэн мөр наргиантай хошин үг хэлүүлэхийг тушаав. Сургуулилт дууссаны дараа тэрээр бүсгүйд дөхөж очоод,

-Таныг нүүр хувиргах өрөөнд минь морилон хундага юм тогтооно уу гэж уримаар байна! гэжээ.

-Баярлалаа, би уудаггүй гээд Жилл холдон одов. Тэрээр Тоби Темплийг олзлон авснаас захирал эртэй сайн харьцаатай байх нь байнгын ажилтай болно хэмээн чухалд үзээд захирал эрийн болзоонд очихоор яаравчлав.

Орой гэхэд бичлэг дуусчээ. Бүгд цугларч энэ шоу Тоби Темплийн бүх л шоунуудаас хамгийн шилдэг нь болж гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөн дүгнэцгээв.

-Тун гайхалтай сайхан боллоо! Ялангуяа бүсгүйн тоглосон

сансрын нисэгчийн хэсэг тун догь шүү гэж Клифтон хөөрөн өгүүлэв.

-Тийм ээ. Тэр бүжинхэн над их таалагдлаа. Бүсгүй хоосонгүй шүү! гээд Тоби мушигнан инээвхийлэв.

-Сайхан бүсгүй байна лээ хэмээн хүлээн зөвшөөрөх Лоренс бүсгүйчүүдийг амны алчуур аятай нэгийг нөгөөгөөр солин, хоног төөрүүлэн энгэр зөрүүлчихээд маргааш нь өрөвдөх юмгүй хуучин хувцас шиг гарган хаядаг Тобигийн амьдралд хэдийнэ дасжээ.

-Түүнтэй хамт хооллохыг тохиролцоодох, Клиф.

Энэ нь гуйлт биш, харин зарлиг байлаа. Хэдэн жилийн өмнөсөн бол янаг амрагийнхаа явдлыг Тоби өөрөө эрхлэг хэмээн Лоренс татгалзах байсан бол едгөө тэр хаан, энэ түүний хаант улс учраас Тобигийн хүссэн бүгдийг хэн хүнгүй үг сүггүй биелүүлэх ёстой, харин үймээн дэгдээгчийг даруй цөллөгт явуулдаг нь энэ эзэнт гүрний жам гэлтэй.

-Тэгэлгүй яах вэ, Тоби. Одоохон гүйцэтгэе гээд Лоренс толгой дохин тонголзов.

Тэрээр жүжигчин бүсгүйчүүдийн хувцас сольдог өрөө рүү очин үүдийг тогшоод хариу хүлээлгүй орж явчихав. Өрөөнд хагас шалдан шахуу арваад бүсгүйчүүл байх агаад хэн ч Лоренсыг тоож анхаарсангүй. Жилл нүүрний будгаа цэвэрлэчихээд палаажаа өмсөх гэж байтал Лоренс ард нь ирэн,

-Та сайн тоглолоо гэлээ.

Жилл түүнийг үл тоомсорлон хараад,

-Баярлалаа хэмээн товчхон хариулав.

Бүсгүй Клифтон Лоренс өөрийн биеэр дэргэд нь ирчихсэн байхыг хараад ихэд гайхлаа. Тэр Жиллийг Голливудэд орох үүдийг нь нээж өгч өлхөн дөнгөнө дөө. Гэвч одоо. . . одоо мань эр тэр чигээрээ Тоби Темплийн долдойдогч болон хувирсан нь харамсалтай.

-Танд таатай мэдээ дуулгах гэсэн юм. Ноён Темпл таныг оройн зоогонд урьж байна.

Жилл үсээ үл мэдэг сэвсийлгэн самнаад мөрөө хавчиснаа,

-Би ядарч байна, гэртээ харих гэж байгааг түүнд дамжуулаарай. Ханатал унтах хэрэгтэй байна гэхчээд цүнхээ аван хаалга чиглэн алхлаа.

Оройн хоол тэр чигээрээ хар дарсан зүүд аятай өнгөрлөө. Тоби, Лоренс, Деркин гурав "Ла Рю"-гийн дээд зэргийн ширээнд сууцгаажээ. Тоби ухаангүй бухимдана. Үйчлэгч хүрч ирэн,

-Нойн Темпл та юу захиалах вэ? гэлээ.

Тоби Клифтоныг чичлэн заагаад,

-Энэ новшид бүтэн порц хэл аваад ир! гэснээ,

-Би бүсгүйг уриадах гэж ялихгүй зүйл гуйгаа биз дээ. Урих шүү дээ! Харин айлга гээгүй! юмсан.

-Тэр бүсгүй ядарч байна гэж. . . хэмээн Клифтон бөвтнөхөд,

-Ганц ч бүсгүй надтай хооллож чадахгүй болтлоо зүдэрсэн байх ёсгүй! Чи л бүсгүйн уурыг хүргэх дэмий юм донгосчээ гээд Тоби улам чангаар бархирах нь тэр.

Хажуугийн ширээний улс тэднийг гайхан харцгаахад Тоби дур булаам инээмсэглэл бэлэглээд,

-Анд нар минь энэ үдэлтийн зоог гээд Клифтоныг заангаа,

-Мань эр уураг тархиа амьтны хүрээлэнд тахил өргөчихжээ гэв,

Энд тэндгүй хөхрөлдөх дуулдаж Клифтон ч инээхчээ дүр үзүүлсэн ч гэлээ өвдгөн дээрх гарынхаа үеэ цайтал зангидав.

-Түүний ямар мулгууг мэдэхийг хүсч байна уу? гэж Тоби бүгдэд дуулдахаар чангаар асуугаад,

-Польшид түүний тухай онигоо ярьдаг юм билээ.

Инээд хөхрөлдөөн бүр ч чангарч, Клифтон босон харайгаад гараад явчмаар санагдсан ч тэгж зүрхэлсэнгүй. Деркин хажуугаас нь хошуу дүрвэл тун аюултайг нь мэдээд ичиж зовохдоо ийш тийш хулмалзан харлаа. Тоби хүмүүсийн анхаарлыг бүтэн татаад, дуугаа өндөрсгөн дарвайтлаа инээсэн хэвээр,

-Мэдээж Клифтон өөрийн мунхаг төрсөндөө буруугүй гэдэпг итгээрэй. Түүнийг анх мэндлэхэд гэрт нь бөөн хэрүүл шуугиан дэгдэж эх нь түүнийг өөрийнхөө хүүхэд биш гэсэн юм билээ.

Эл явдал хэдийнэ хот даяар таран цуурайтсан нь мэдээж.

Клифтоны нойр нь хулжин Тоби яахлаараа өөрийг нь ингэж доромжлов оо гэж асуусаар орондоо хөрвөөнө. Хариулт нь тун энгийн ердөө л мөнгө. Темпл түүнд саяын дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний орлого өгдөг.

Клифтон мөнгийг элсэнд асгасан ус мэт үрэн таран хийж хөрөнгө зөөр хураахаа ч мэдэхгүй, дадчихжээ. Тэгээд ч өөрт үйлчлүүлэгч үлдээгүй тул Тоби тун хэрэгтэй. Хамгийн аймшигтай нь мань эр үүнийг тун сайн мэддэг. Цаг хугацаа байгаа дээр нь эртхэн арилаад егөхсөн. . . Гэвч тэр хаашаа ч явах билээ дээ, нэгэнт оройтжээ. Тоби өөрт дурласан бүсгүйчүүдийг үл ойшоосон шүүмжлэгчдийг болон түүнийг давахаар чармайн зүтгэх хошин шогчдыг хэрхэн доромжлож байхыг Лоренс олонтоо сонссон. Гэвч тэд шал өөр, дэндүү чадварлаг байсан тул Тобигийн хэзээ нэг цагг толгой дээр нь буун цахиур хагална гэдэгт итгэнэ. Лоренс Тобигийн төлөө ямар ихийг хийлээ дээ! Ирээдүй нь хэрхэхийг сэтгэл догдлон бодож буй нь энээ.

Жилл Тобигийн урилгыг хүлээн авч энгэр зөрүүлсэн бол мань эр маргааш нь ийм нэгэн бүсгүй байсан эсэхийг мартчихсан сууж байсан. Татгалзсан хариу авч сураагүй гэмтэй Тобид Жиллийн хайхрамжгүй байдал түүний хорхойг нь хөдөлгөж, шарыг нь улам ихээр маажин тэчъяадуулна. Тэрээр бүсгүйг дахин нэг удаа зоогонд уривал бас л татгалзсан хариу сонсож, эцэст нь түүнийг сээтэгнэн, тэнэглэж байна гээд хойшид үл хайхрахаар шийдэв. Гэвч Жилл түүнтэй хамт хаа нэг тийшээ хамт явахыг хүсэхгүй байгаа нь Тобигийн амар заяаг үзүүлсэнгүй, бүсгүйн тухай бодол тархи толгойноос нь салж өгөхгүй тарчлаана. Эцэст нь Тоби ажил хэргийн далимд Жиллийг дахин шоундаа тоглуулах талаар Эдди Берригентэй ярилцжээ. Мань эр бүсгүйд утасдан эл саналыг дуулгатал нэгэн киноны оролцон тоглогчийн зураг авалттай байгаа тул амжихгүй хэмээн хариу өгөв. Берриген энэ бүгдийг Тобид илтгэвэл тэрээр галзууртаа уурлаж,

-Шальдир бульдар дэмий ажлаа даруйхан хая гэж хэл! Бид илүү хөлс төлнө! Чөтгөр ав, энэ чинь хамгийн шилдэг шоу мэдэв үү! хэмээн бархирч гарав.

Эдди дахин утасдаж Тобигийн үгийг дамжуулаад, яльгүй хачир нэмэн,

-Жилл ээ, тэр үнэхээр таныг шоундаа оролцуулахыг хүсч байна. Зөвшөөрөх юм биш шүү? гэлээ.

-Өршөөгөөрэй, би одоо "Универсал"-д компанид ажиллаж байгаа яагаад ч орхиж чадашгүй нь хэмээн бүсгүй татгалзан хариулав.

Бүсгүй тоймтой шийд гаргах гэж завдсангүй, Голливудад шургалсан өчүүхэн боломжоо ашиглан дахин ганц дүр авчих юмсан гэж хүсэх Жиллийн хувьд Тоби Темпл төдийлөн ач холбогдолгүй мэт санагджээ.

Маргааш өглөө нь Агуу эрхэм хүн өөрөө утасдаж зулгуйдсан өнгөөр,

-Жилл ээ? Нэр алдаргүй ажлын нөхөр Тоби Темпл байна аа гэжээ.

-Сайн байна уу, ноён Темпл!

-Хөөе, юунд ингэтлээ ёсорхоо вэ? гэснээ шууд,

-Та бейсбол тоглох дуртай юу? Надад лоожийн тасалбар байна гэлээ.

-Баярлалаа, би сонирхдоггүй.

-Би ч адил гэснээ инээд алдаад,

-Би таныг туршсан юм. Хагас сайны үдэш оройн хоолонд уривал юу гэхсэн бол? Би парижийн ресторанаас ахлах тогоочийг нь урвуулж дөнгөсөн юмсан. Тэр...

-Өршөөгөөрэй, эрхэм Темпл, би болзоотой хэмээн Жилл хайхрамжгүйхэн татгалзав.

Тоби харилцуураа хамаг хүчээрээ тас атгалаа.

-Та хэзээ завгай болох вэ?

-Би тун их ажилтай, гадуур явах ч тун ховор доо. Гэвч урьсанд тань баярлалаа.

Харилцуурт тасалдах дуу ёнгинон оролцон тоглох дүрээс хэтэрдэггүй, шалихгүй нэг жүжигчин хүүхэн татгалзаад утсаа

тавьчихлаа. Түүнд шүү! Тоби Темплд! Захын хүүхэн эргэлзэх зүйлгүй Тобитой хүзүү толгой холбогдогдог байхад, хаашаа янзын мангуу янхан түүнийг шилж гоочилдог байна. Тоби галзууртаа уурлан хавь орчныхноо хяргачих шахан бархирч, Эдди Берриганыг нүүр хувиргах өрөөндөө дуудан авчрав.

-Жилл Каслын тухай чи юу мэдэх вэ? хэмээн чангаар

асуувал,

-Юу ч мэдэхгүй! гэж Эдди сандарсандаа дуржигнуулав.

Шоутой зууралдах завгүй байсан ч гэлээ юу болоод буйг гадарласан тэрээр тийм ч дүүрчихсэн тэнэг эр биш болохоор эвгүй байдлаас эвтэйхэн мултарлаа.

-Түүнд олон эрчүүд бий юу?

-Үгүй, тийм байсан бол би заавал дуулах байсан гэжээ.

-Чи түүнийг шалгахыг би хүсч байна гэж Тоби тушаагаад,

-Энэ бүсгүйд нууц амраг байна уу, үгүй юу, чи ойлгож байгаа даа, ер нь юу хийж явдгийг нь мэдээдэх гэлээ.

-Тэгье, эрхэм ээ хэмээн Эдди дуртайяа зөвшөөрөв.

Шөнийг гурван цагт утас хангинан дуугарлаа.

Эдди өндийн суугаад сэхээ авах зуур,

-Чөтгөр ав гэж хараал урсгаснаа гэнэт хэн утасдаж буйг ухааран,

-Би бүгдийг шалгасан. Тэр эв эрүүл юм билээ хэмээн Эдди яаран өгүүлэв.

-Яасан ийсний чинь эрүүл саруул! Тэр хэн нэгэнтэй энгэр зөрүүлдэг гэнэ үү?

-Үгүй ээ, эрхэм ээ. Түүнд хэн ч байхгүй. Би найз нөхдөөсөө асуусан. Бүсгүй шударга хөдөлмөрч жүжигчин учраас бүгд түүнийг хайрлан жижиг дүр өгдөг гэнэ.

Тэрээр эзэндээ бүх зүйл ном ёсоороо гэдэгт итгэл төрүүлэх гэсэндээ ээрч мууралгүй дуржигнуулав. Хэрвээ Жилл түүнийг Тоби Темплээс дээгүүрт тавин Эддитэй энгэр зөрүүлсэн гэдгийг хэзээ нэг цагт мэдвэл Эдди энэ хотод өл залгуулах ажил олно гэдэг санахын ч гарз! Мань эр найз нөхөддөө байдлыг сайтар тайлбарлан тэд үг нэгтэй байхаа амласан байжээ. Хэн ч Тобитой дайсагналцахыг хүсдэггүй тул бүгд амаа үдүүлсэн мэт байх нь эргэлзээгүй.

- Бүсгүй хэнтэй ч зугаацан энгэр зөрүүлдэггүй гэсэн. Тоби уяран зөөлөрч,

-Тэгэхээр энэ ердөө ойворгон зантай эмэгтэй байх нь ээ, тийм үү?

-Тийм ээ, яг үнэн гэж Эддигийн санаа амран зөвшөөрөв.

-Хөөе хөө, би чамайг нойрноос чинь арай сэрээчихээгүй биз?

-Үгүй, үгүй, зүгээр ноён Темпл ээ.

Гэвч Эдди Тоббигийн хүүхэмсэг явдлын тухай энэ яриа хот даяар тархвал дараа нь юу болохыг эргэцүүлэн бодсоор нойр нь хулжжээ.

Тоби, Клифтон Лоренс хоёр Беверли-Хиллзийн төвөөс холгүй орших тансаг зоог, зугаа цэнгэлийн арвин их туршлага бүхий Хилкрест-кантри клуб-: хооллохоор ирцгээв.

Тоби Голливуд-ын хошин шогчид цуглан шог элэглэлээ хурцлан бие биесээ элдэвлэн суудаг "Хошин жүжигчдийн буланд" байнга суух дуртай ажээ. Гэтэл өнөөдөр Тобигийн санааны мухарт тэс өөр бодол эргэлдэж Лоренсыг ширээ рүү чирэн очсоноо,

-Клиф ээ, надад чиний зөвлөгөө хэрэгтэй байна гэж яриагаа эхлэв.

Тагжгар эр өөртэй нь зөвлөхөө байгаад удаж буй Тобиг гайхан харлаа.

-Тэгэлгүй яах вэ, хонгор минь.

-Хэргийн учир нэг бүсгүйд байна хэмээн Тоби санаашран бувгнахад Клифтон бүгдийг ойлголоо.

-Жилл Каслийг санаж байна уу? Шоунд оролцсон залуу бүсгүй хэмээн Тоби хэлэв.

-Өе, тийм, үзэсгэлэнтэй сайхан бүсгүй байсан. Тэгээд юу болоод байна? гэвэл,

-Болзох болгонд татгалзах юм. Бүр сүүлдээ өөрийгөө Айовоос ирсэн хөдөөний болхи эр гэж бодох боллоо.

-Наад бодлоо таягдан хаявал яасаи юм бэ? гэж Лоренс

ихэд болгоомжлон асуув.

-Анд минь, хамаг учир тэгж чадахгүйд байна. Чамд л хэлэхэд энэ охин бярууг дагаж байгаа шигээ өөр хэн нэгнийг ингэтэл хүсч байсангүй! Өөр бусдыг бодох ч сөгөө алга! гэж Тоби ичингүйрэн инээмсэглээд,

-Анд минь би ер нь солиорч байгаа байх! Клиф ээ, чи ч иймэрхүү явдлыг сонирхох биш дээ. Яавал дээр вэ?! гэлээ.

Лоренсод хормын төдийд түүний мөрөөдлийн бүсгүй нь үл шалих дүр олж авахын тулд тааралдсан найруулагчийн туслахтай энгэр зөрүүлэн явдаг гашуун үнэнийг Тобид хэлчихсэн гэх тэсгэлгүй хүсэл төрлөв. Болохгүй. Яагаад ч болохгүй! Тэр Тоби өөрийнх нь үйлчлүүлэгч хэвээр байгаасай гэдгийг туйлаас хүсч байлаа.

-Надад нэг санал байна. Бүсгүй үнэхээр алдар хүндэд дурлаж байгаа болов уу?

-Тэгэлгүй яах вэ, тун их хүсч байгаа.

-Сайн байна. Тэгэхлээр бүсгүйг татгалзах аргагүй болгох хэрэгтэй юм байна.

-Гэртээ үдэшлэг зохиогоод түүнийг урь.

-Би чамд хэлсэн шүү дээ, тэр. ..

-Байз, би яриад дуусгая. Түүнд хэрэгтэй гэсэн студийн захирал, продюссор, хөгжмийн зохиолч гээд бүгдийг нь урь. Хэрэв бүсгүй үнэхээр алдарт хүрье гэж бодож байгаа бол энэ удаад заавал ч үгүй ирэх ёстой болно.

Тоби бүсгүйн утсанд залгаад,

-Сайн уу, Жилл?

-Хэн бэ?

Орон даяар түүний дуу хоолойг мэдэж байхад энэ бүсгүй хэн бэ гэдгийг асуудаг байх нь ээ.

-Тоби байна, Тоби Темпл.

-Өө, та . . . гэж бүсгүй хайхрамжгүйхэн дуугарчээ.

-Жилл, сонсооч, би лхагва гаригт явцуу хүрээнд оройн зоог барина, тэгээд...

Жилл илт татгалзахыг хүсвэл мань эр түүнд үг хэлүүлэх боломж олголгүй цааш нь дуржигнуулан,

-Сэм Уинтерсийг, болон хэдэн студийн захирал, продюссор, найруулагчдийг урьсан. Таныг тэдэнтэй танилцаад авбал гэм-гүй гэж бодож байна. За яах вэ, зөвшөөрөх үү? гэлээ. Жилл агшин зуур эргэлзээд,

-Лхагвад уу? Танайд юм уу? Тэгье, би завтай. Баярлалаа, Тоби гэж хариулжээ.

Энэхүү уулзалт нь хувь заяаг холбох шижим болно гэдгийг тэдний хэн нь ч төсөөлсөнгүй.

Тагтан дээр найрал хөгжимчид тоглон дүрэмт хувцастай зарц нар зууш, хундагатай шампанск зөөн шогшицгооно.

Жилл дөчин таван минут хожимдоод арай гэж морилон ирэхэд Тобигийн сэтгэл хөдлөн, түүнийг угтан авахаар үүд чиглэн яаравчлав. Бүсгүй ердийн цагаан торгомсог палаажтай, долгиотсон хар үсээ задгай тавьсан нь гайхаад барамгүй үзэсгэлэнтэй харагдана. Тоби эрхэм зочноосоо нүд салгаж чадсангүй. Гоо засал, үс гэзгээ янзлах гэж чармайлт гаргаагүй Жилл урьд өмнөхөөсөө илүүтэй сайхан харагдаж байгаагаа мэдэрчээ.

-Би чамайг бүгдтэй нь танилцуулья. Явцгаая. Тоби түүнийг хөтлөн том заалан дахь зочид руу дагуулан явлаа.. Жилл босгон дээр зогтусан зочдыг анхааран ажвал бүгд "Тайм": "Лайф", "Ньюсуик", "Пари магч" сэтгүүлийн нүүрнээс, эвсэл дэлгэцэн дээр олонтоо харсан танил хүмүүс харагдах нь тэр. Кино бүтээн урладаг жинхэнэ Голливудынхан энд цугларчээ. Жиллийн хойч ирээдүйг шийдэж чадах эдгээр агуу хүмүүстэй нүүр тулах энэ мөчийг олонтоо

төсөөлөн мөрөөдсөн билээ. Ийнхүү түүний мөрөөдөл нь гэнэт биелсэнд бүсгүй итгэж ядна.

Тоби түүнд хундагатай шампанск бариулаад олны дунд ярилцан зогсоо нэгэн эр дээр дагуулан очиж,

-Сэм ээ, танилц! Жилл Касл! гэвэл Сэм эргэн хараад,

-Сайн байна уу, Жилл Касл гэж эелдэгээр мэндлэв.

-Жилл, энэ Сэм Уинтерс. "Пан-Пасифик" гэх индиан овгийн ахлагч юм.

-Ноён Уинтерс хэн болохыг би мэднэ гээд Жилл толгой дохив.

-Сээм! Жилл маань жүжигчин, сүрхий чадалтай жүжигчин дээ! Чи түүнд дүр өгөх ёстой. Танай студи гял цал үзэсгэлэн гоогоор чимэг оруулахад гэмгүй дээ.

-Бодож болох л юм хэмээн Уинтерс эелдэгээр инээмсэглэв.

Тоби Жиллийг алдчих вий гэсэн шиг гараас нь чатга атган хөтлөн,

-Муурхан минь, явья. Би чамайг бүгдтэй нь танилцуулна гээд цааш явлаа.

Жилл энэ үдэш студийн гурван захирал, хэдэн алдартай найруулагч, олон арван продюссор, найруулагч, кино ододтой, хамгийн гол нь сэтгүүлч, теле сэтгүүлч нартай танилцажээ.

Зоогон дээр Жилл Тобигийн баруун талд нь суун, тэдний яриаг дуртай нь аргагүй чих тавин чагнаж, шилдэг хүмүүсийн орчинд мөр зэрэгцэн суугаараа бахдана.

-Билли Уайдлерийн шинэ киног үзэв үү? Гайхалтай болсон байна лээ!

-Тийм үү? Мань эрийн Брэкеттэй хамт ажиллаж байх үеийн бүтээл надад илүү таалагддаг байсан. Брэкет өөрийн гэсэн арга барилтай байсан сан бол ч.

-Билли ч авьяастай даа.

-Өнгөрсөн долоо хоногт би Тикэд детектив зохиол явуулсан, тэр ихэд үнэлсэн шүү. Хоёр гурав хоногоос хариу өгнө гэсэн.

-Криши Праманнадагийн нээлтэд оролцох урилга авсан. Түүнийг олон жилийн тэртээгээс мэднэ.

-Киноны төсөв зохиох гээд үз! Бүх тооцоог, инфляцийг хүртэл тооцоод ирэхэд хараал идсэн продюссорууд гурав дөрвөн саяар нь үнээ хөөрөгдөх болно!

"Бурхан минь гэж гурав дөрвөн саяар гэнэ!" хэмээн Жилл тэдний яриаг сонсоод бодлоо.

Жилл Шваба эмийн санд өрнөдөг азгүй "горьдогсдын" бие биеэ тэжээдэг эцэс төгсгөлгүй

ялиг шалиг мэдээллийн тухай эргэн санав. Тобигийн гэрт суугаа эдгээр хүмүүс Голливудийн жинхэнэ ялан дийлэгчид ажээ. Тэдний хэн нь ч Жиллд туслаж дөнгөх байсан атлаа боломж олгохоос татгалзан замд нь хөндөлдөж таванхан минут ч зарцуулаагүйсэн.

Бүсгүй өөрийг нь сонсохоос татгалзсан, шинэ мюзикл нь гаргуун амжилт олсон продюссор хахаж цацлан дуржигнатал ярьж суухыг, мөн ширээний тэртээд өөртөө нь уулзахыг ч хүсээгүй хошин киноны шилдэг найруулагч гол дүрийнхээ жүжигчинтэй хуучлан суухыг олж харлаа.

Энэ хот, эд нар бүгд түүнд худал хэлэн басамжлан доромжилсныхоо шанг хүртэцгээнэ. Жилл одоохондоо эдний хувьд хэн ч биш байг, гэвч хэн гэдгээ үзүүлэх цаг нь ирэх болно. Тийм ээ, заавал ирнэ.

Оройн зоог гайхалтай тансаг болсон хэдий ч Жилл бодолдоо умбасаар ямар идээ зууш өгч байгааг ч анзаарсангүй. Тоби ухасхийн босоод,

-Хөөе, хурдалцгаа, бидэнгүйгээр эхлэх нь байна! гээд Жиллийн гарыг шүүрэн авч хөтлөн, жараад хүн элбэг багтах өч течнөөн буйдан өрсөн том кино заал руу аваачив. Хаалганы нь нэг талд шоколадаар дүүргэсэн онгорхой шүүгээ, нөгөө талд эрдэнэ шишийн автомат шүүгээ байрлуулжээ.

Тоби Жиллтэй зэрэгцэн суугаад юун кино үзэх мантай бүсгүйгээс нүд салгалгүй ширтэнэ. Кино дуусан гэрэл асахад үйлчлэгч нар кофе, амтат бялуугаар дайлцгаалаа. Үүр цүүрээр босон зураг авалтанд явах зочид цагийн дараа цувран тарж эхэллээ. Тоби үүдний танхимд Сэм Уинтерстэй ярилцаж байхад Жилл хэдийнэ пальтогоо өмсчихсөн тэдэн дээр очлоо. -Чи хаачих нь вэ? гэж Тоби гайхаад, -Би өөрөө чамайг гэрт чинь хүргэж өгнө гэлээ. -Яах нь вэ? гэж бүсгүй ялдамхнаар инээгээд, -Би унаатай яваа. Сайхан үдэш байлаа, баярлалаа Тоби хэмээгээд үүдээ чиглэн алхав.

Тоби чихэндээ ч итгэж чадалгүй гайхан алмайрч түүний араас нь харан хоцорчээ. Тэрээр энэ шөнө Жиллийг дээш нь

унтлагын өрөөндөө авч орон, тэр ч бүү хэл ямар аяз тавихаа хүртэл сонгочихсон гайхалтай төлөвлөгөө боловсруулсан байжээ. Түүний оронд өөр нэг бүсгүй алдартай одод энэ үдэшлэгт ирсэн бол тун ч жаргалтай байхсан, гэтэл өрөвдөлтэй ерийн нэгэн жүжигчин бүсгүй. . . Жилл Касл хэнийг голж байгаагаа ойлгодоггүй усан тэнэг амьтан юм! Одоо боллоо! Тоби сэтгэл ханалаа!

Тоби өглөөний эрт Жилл рүү утасдвал автомат хариулагч,

-Сайн байна уу, би Жилл Касл байна. Харамсалтай нь би гэртээ алга. Та утасныхаа дугаар, нэрээ үлдээнэ үү. Би эргэж ирмэгц тан руу залгая. Дохио өгсний дараа ярина уу. Танд баярлалаа гэхийг сонсжээ.

Дохио дуугарч, Тоби харилцуур тас атгаад юу ч хэлэлгүй зогссоноо хөшүүргийг дарлаа. Тэр автомат хариулагчтай ярих юм бол хараал идэг! Гэвч хормын дараа дахин залгалаа.

-Чи хотдоо гайхагдах энхрийхэн дуу хоолойтой юм! Түүнийгээ дугтуйлчихаад зарах хэрэггүй юм байна даа. Хар өглөөгүүр гэрээсээ гүйгээд явчихдаг бүсгүйчүүл рүү би ярьдаггүй л дээ, гэвч чамайг өршөөхөөр шийдлээ. Үдийн хоол хаана идэх гэж байна?

Тасалдсан дуу сонсогдоход нь тэр дэндүү удаан ярьж, чөтгөр авсан тууз нь дуусчихлаа гэж үү дээ? Тоби таг дуугүй болж хэрхэхээ эс мэдэн өөрийгөө дүүрчихсэн мангуу амьтан болохыг ойлгожээ. Дахин залгах хүсэл төрөхөд нь Тоби галзуутай уурласан ч гэлээ тэсч чадалгүй гурван ч удаа залгалаа.

-Өнөөдөр надтай хооллохыг зөвшөөрөх үү? Чиний утасдахыг хүлээж байя гээд утасны дугаараа үлдээн, харилцуураа тавилаа.

Хүлээсэн цаг нь дөхсөн хэдий ч Жилл яриагүй л байлаа. Долоон цаг болоход Тоби тэсгэл алдарчээ. Түүнийг чөтгөр аваг! Хүсэхгүй бол хэрэггүй! Энэ удаа чухам тэнэглэхээ больж үзье! Тоби тэмдэглэлийн дэвтрээ шүүрч аваад хуудас эргүүлж эхэлснээ яагаад ч юм өөр хэн нэгтэй ч яримааргүй санагдаад явчихлаа.

Бүлэг 26.

Энэ түүний амьдралд олдсон хамгийн гайхалтай шилдэг дүр байлаа. Тоби Голливудын дурын хэн нэгэн бүсгүйг нохойн гуяар даллан урхидаж ч чадах атлаа, яагаад түүнийг туйлаас эрхэмлэн хүсээд байгааг нь Жилл ухварлаж чадсангүй. Жилл бүх л өдрийн турш Тобигийн гэрт өнгөрөөсөн үдшийг, нөлөө бүхий хүмүүс түүний төлөө бүхнийг хийхэд бэлэн бөхөлзөн зулгуудаж байсныг нь эргэн саналаа. Тэгэхээр Жилл Тобиг өөрийнхөө төлөө нэгийг хийлгэх арга хайн тун болгоомжтой хөдлөх хэрэгтэй болжээ.

Тоби бүсгүйчүүдийг олзлон ангуучлаад салхи сар, үүлэн борооны ажил хийн, хүссэн цэнгэлээ эдэлмэгц агшин зуур тайтгарах тэднийг үл хэрэгсэн хөсөрт хаядгийг бүгд мэдэх тул Жилл цаг үргэлж түүнийг хэрхэн эрхэндээ оруулахаа бодон тархиа гашилгана. Тэр өдөр бүр утасдсаар арай л долоо хонохоос наахнуур Жилл түүнтэй оройн зоог барихыг зөвшөөрчээ. Үүнд Тобигийн сэтгэл хөөрөн хөл алдан баярлаж явахыг нь зураг авалтын бригадынхан болон жүжигчид хүртэл анзаарчээ.

-Хэрвээ би ийм гайхамшиг байдаг гэж итгэсэн бол гэж Лоренсод чин үнэнээсээ өгүүлээд,

-Тэр бол дурлал хэмээнхэлэхсэн. Жиллийг бодох бүрд өмдний цахилгаан нь зад татчих шахах юм! гээд инээмсэглэв.

Эхний болзоот шөнөө Тоби Жиллийг авахаар очоод,

-"Чейзен" -д ширээ захисан! гэлээ.

Бүсгүй энэ чамин тансаг нь хэтэрсэн ресторанд ороод сэтгэл нь баярлан хөөрнө гэдэгт Тоби бүрнээ итгэжээ.

-Нээрээ юу? гэж Жилл итгэлгүйхэн бувтнавал,

-Эсвэл өөр тийшээ явмаар байна уу? гэж мэл гайхсан Тоби нүдээ анивчин асуулаа.

Бямба гаригийн үдэш байсан ч гэлээ Тоби аль ч ресторанд очсон түүнд ширээ олдоно гэдэгт эргэлзсэнгүй.

-Зүгээр хэлчих, чиний төлөө бүхнийг хийхэд бэлэн байна.

Жилл хэсэг эргэлзсэнээ,

-Та шоолох байхдаа гэвэл,

-Яасан ч үгүй! хэмээв.

-"Томми"-д очье.

Тобиг зарц нарын нэг Макаар иллэг хийлгэн бассейнд хэвтэхийг Клифтон Лоренс харан сууж байлаа.

-Итгэхгүй дээ гэж Тоби хачирхаад,

-Зөвхөн гамбургераарүйлчилдэг муухай оромж руу орох гэж бид хорин минут дугаарлаж зогссон гээч! Хаана байдгийг нь мэдэх үү? Лос-Анжелесын захад. Зарц ажилчдаас өөр хэн ч тийшээ орохгүй. Бүсгүй их хямгач юм шиг? Би франц шампансктай оройн зоогонд хэдэн зууг ч төлж чадна даа, гэтэл надаас ердөө л хоёр доллар дөчин цент зарлагадсан шүү. Би түүнийг шөнийн клубт урьсан, гэтэл бид хаанаа явсныг мэдэх үү? Сант-Моникагийн эргээр зугаалсан. Гутал дүүрэн элс чихээд! Ямар ч тэнэг шөнийн цагаар наран шарлагын газраар хэсүүчлэхгүй дээ, тэгэхнээ явдаг л юм байна гээд халаглан толгой сэгсрээд,

-Жилл Касл. Итгэмээргүй байгаа биз, аан? гэв.

-Яг үнээн гэж Клифтон хүйтнээр зөвшөөрөв.

-Манайд орж аяга тагш юм балгая гэтэл яагаад ч зөвшөөрөөгүй, гэтэл түүнд таалагдана гэж би бодож байдаг, тийм биз?

-Тэгэлгүй яах вэ!

-Бас босгоороо ч алхуулаагүй гээч. Хацар дээр үнсчихээд гэртээ орчихсон. Над шиг эрдэнэсийг яаж байгаа нь тэр вэ, хэлээд өгөөч!

-Түүнтэй дахин уулзах уу?

-Чи юу гэв ээ, галзуурав уу. Мэдээж, уулзана гэдэгт итгэж болно!

Энэ цагаас эхлэн Тоби Жилл хоёр орой болгон уулзах болжээ. Бүсгүйг завгүй, өглөө эрт босно гэхэд нь Тоби арга тасран бүхэл өдрийн турш хэдэн арван удаа утасдана.

Тоби, Жиллийг хамгийн тансаг ресторан, алдартай, хаалттай клубүүдээр урихад, харин бүсгүй хариуд нь даруухан зуушны газар, кафед аваачин Санта-Моникагийн хуучин банзан онгоцны зогсоолоор, үргэлж мөнгөний гачаал амсаж явдаг шинэхэн жүжигчид л орогнодог болов уу гэмээр Лос-Анжелес-ийн мухар гудамж, булан тохойгоор зугаална. Гэвч Тоби Жиллтэй л хамт явж байвал хаашаа ч явсан хамаагүй болжээ. Бүсгүй Тобигоос салж өгөхгүй зовоодог ганцаардлыг нь хөөн зайлуулж чадах цорын ганц хүн нь болжээ.

Мань эр Жиллтэй энгэр зөрүүлэн тачаал тайлмагц энэ бүх ид шид нь алга болчих вий гэхээс эмээх болсон ч гэлээ Тоби түүнээс өөр ямар ч бүсгүйг сонирхсонгүй.

Жилл салахын өмнө Тобиг үнсэхэд түүнийг тас тэврэн авч, -Бурхан минь, Жилл ээ, чамгүйгээр би галзуурах нь байна ! гэв.

Бүсгүй гэдрэн ухран зайлсхийгээд,

-Хэрэв танд зөвхөн энэ л хэрэгтэй байгаа бол хотоос хорин доллараар худалдаж авч болно! гэж хүйтэн өнгөөр эгдүүцэн хэлээд гэр рүүгээ гүйн орж хамрыг нь хавчих шахам үүдээ тас хийтэл хаахад ингээд алдчихаж байгаа юм биш байгаа гэхээс үнхэлцэг нь хагартлаа айсан

Тоби тэнхээ нь тасран хана наллаа.

Бүсгүй шөнийн турш гэгэлзэн нойргүй хоножээ. Гэвч Тоби өглөө нь бриллантан бугуйвч илгээхэд Жиллийн санаа амран, чамин гоё бэлгийг нь үзээд сайтар бодон тунгааснаа,

"Танд их баярлалаа. Би өөрийнхөө үзэсгэлэнтэй сайхныг . . . танд талархая! " гэсэн зурвасын хамт буцаан илгээжээ.

-Чангахан. үнэтэй бугуйвч байсансан! гэж Тоби Клифтонд бардамнан өгүүлээд,

-Харин мань бүсгүй түүнийг буцаагаадилгээчихэж! гэснээ толгой сэгсрэн,

-Ийм гайхамшигийг чи юу гэж бодож байна? хэмээн гайхан асуув.

Клифтон өөрийн бодлоо чин үнэнээр нь хэлэхсэн гэхээс хорхой нь гозгонох авч ердөө л,

-Үнэхээр ер бусын бүсгүй юм, хонгор минь гэж бувтнэлаа.

-Жир бус хүүхэн! гээд Тоби инээд алдаж,

Жиллийг өвөртлөх гэсэн бүтэлгүй оролдлогоос хойш энэ сэдвийг дахин хөндөхөөс зайлсхийх болсон Тоби өөрийн дэвсгэр болгодог бүсгүйчүүлтэй харьцуулаад, Жиллээр бахархан сэтгэлийнхээ гүнд бахдах ажээ. Тобигийн буруутай, таалагдаагүй үйлдлийг Жилл улаан нүүрэн дээр нь шууд хэлнэ.

Тоби түүний гарын үсгийг нь улиг болтол гуйсан бишрэгчийг голд нь ортол гомдооход Жилл,

-Хүмүүсийг шоглон элдэвлэх чамд зугаатай байдаг байх, гэхдээ чи энэ хүнийг дэмий гомдоолоо хэмээн зэмлэхэд Тоби мань хүнийг гүйцэн очоод уучлал эржээ.

Жилл Тобиг бор дарсанд дэндүү шунаж байгааг нь хэлэхэд тэрээр уухаа зогсоож, хувцасны хэв маягийг нь шүүмжлэхэд оёдолчноо хүртэл сольжээ. Ээжээсээ өөр хэнийг ч үл тэвчигч мань эр бүсгүйн хэлсэн бүхнийг хүлээн зөвшөөрөх болов.

Жилл түүнээс мөнгө, үнэт эдлэл авахаас татгалзахад Тоби бүсгүй эд хөрөнгөнд нь биш, түүний эр зоригийг нь бахархаж буйг ойлгов. Тоби Жиллийг оройн зоогонд авч явахаар очин бүсгүйг хувцаслах зуур ширээн дээр нь хзвгэх төлөгдөөгүй тооцооны хуудсуудыг анзаарч сэмхэн халааслаад маргааш нь Клифтонд тэдгээрийг төлөх тушаал буулгав. Тоби, Жиллийн төлөө ямар нэг чухал зүйл хийхийг туйлаас хүснэ.

Ингээд Тоби Жиллийн сэтгэл зүрхийг хэрхэн эзэмдэхээ сая л нэг ухаарав.

-Сэм ээ! Би чамд нэг их тус үзүүлье гэхэд нь энд тэндгүй сонсогддог "бэлэг барин гүйх оддоос болгоомжил" гэсэн явган яриаг санан Сэм бага зэрэг гонсойв.

-Чи Келлерийн киноны гол дүрийн бүсгүйг олох гэж тархиа гашилгаж байгаа, тийм үү? Тэгвэл чамайг аз дайрч гэж бод!

-Би түүнийг мэдэх үү? гэж Уинтер асуув.

-Манай гэрт уулзсан даа. Жилл Касл.

Сэм гоолиг биетэй, хар үстэй царайлаг бүсгүйг эргэн саналаа. Гол дүрийн бүсгүйн дүрд арай хөгшдөх ч гэлээ Тоби Темпл хүсэж байгаа бол Сэм түүнд захирагдахаас яахав.

-Өнөөдөр ирж уулзаг гэж мань эр зөвшөөрлөө.

Жиллийн ирэхэд Уинтерс халамжлан угтаж өөрөө биечлэн хөөцөлдөж, Келлер өөрөө зураг авалтыг гардан, студийн шилдэг оператороор пробны зургийг авуулав.

Маргааш нь Уинтерс авсан материалыг үзвэл хэдийгээр давгүй жүжиглэсэн ч гэлээ залуу бүсгүйн дүрд тоглоход Жилл дэндүү хөгшдөж байгаа төдийгүй гачлантай нь түүнд үзэгчдийн сэтгэл зүрхийг эзэмдэн татах ид шид, шинэ од болон гийх гойд авьяас үл мэдрэгдэв. Уинтерс Тоби руу залган,

-Би өчигдрийн кинопробыг үзлээ. Жилл зураг дээр байгаасаа илүү сайхан гардаг, үг хэллэг тод ч гэлээ лав л гол дүрд тоглож боломгүй юм байна. Гэхдээ хоёрдугаар зэрэгийн дүрд тоглон чамгүй мөнгө олж болно л доо, гэвч од болж яасан ч чадахгүй гэжээ.

Хариу ирэхийг тэсэн ядан хүлээж байсан Жилл босгон дээр Тобиг угтан авахдаа нэг л таагүй байгааг анзаарчээ.

-Кино пробны тухай юм сонсов уу? гэсээр санаа алдахад Тоби хулган толгой дохиж,

-Би Сэм Уинтерстэй ярьсан гээд Сэмийн ярьсныг зөөлрүүлэхийг аль байдгаараа хичнээн өгүүлэв.

Жилл хөдлөх ч үгүй ганц ч үг дуугаралгүй зогсоно. Тэр дүр түүнд л зориулагдсан гэдэгт Жилл бүрэн итгэлтэй байжээ!

Хөөрхөн охин шалгаруулсан уралдаан, их дэлгүүрийн үзмэрт байсан алтан аяганы тухай бодол тархинд нь харван орж ирлээ. Хүсэл харуусалдаа автан элэг эмтрэм гашуун цөхрөл Жиллийг нөмрөн авлаа.

-Хүү минь, битгий гунь! Уинтерс юу хэлэхээ сайн мэднэ! хэмээн Тоби амандаа бувтнав.

Гэвч энэ нь тун ч өрөвдөлтэй тайтгарал. . . Жилл хэзээ ч, хэзээ ч алдарт жүжигчин болохгүй. Өчнөөн олон жил зовж зүдэрсэн нь талаар өнгөрчээ! Өшөө өвөрлөгч Бурхан юуны ч телөө юм бэ Жиллийг цээрлүүлнэ гэсэн эхийнх нь зөв байж гэж үү?

Бүсгүй энэ хотод шинэ амьдрал хүсэн мөрөөдөж итгэл

өвөрлөн ирсэн атал Голливуд түүнийг бузар явдал руу түлхэн доромжилсон.

Тоби түүнийг чанга тэвэрч авахад нь Жилл тэсвэрлэхийн эцэсгүй уй гасланд автан өөрийн

эрхгүй мэлмэртэл уйлж байгаага сая нэг ухаарчээ.

-Чшшш. . . бүх юм сайхан болно хэмээн Тоби шивнэх гэнэтийн энхрийлэл түүнийг бүр ч ихээр уяруулав.

Хөдлөх ч тэнхэлгүй бүсгүй түүнд тэврүүлсэн чигтээ эцэг нь нас барсан, алтан аяганы, гэгээнтний, шанаан тус газар нь лугших өвчин шаналал, агуу алдарт хүрэх цаг мөчийг хүлээх зуур амссан эцэс төгсгөлгүй, гунигт өдрүүдийн тухай ярьсаар, ярьсаар байлаа. Гэвч ямар нэг далдын зөн совин нь түүний өвөр дамжсан олон эрчүүдийнх нь тухай ганц ч үг дурсуулсангүй. Тобид хүйтэн цэвдэг хандаж байсан бүсгүй энэ удаад хагуурхаж чадсангүй. Яг энэ мөчид арчаагүй өрөвдөлтэй бүсгүй Тобигийн сэтгэлийн чанад дахь энхрийлэл, сайхан сэтгэлийн утсыг нь хөндөн хэн ч чадаагүйгээр түүний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн ажгуу.

Тэр алчуур гарган нулимсыг нь арчаад,

-Хүү минь, өөрийнхөө азгүйг гайхаж байгаа бол намайг сонс. Манай хөгшид махны худалдагч байсан, тэгээд...

Тэд үүрийн 3 цаг хүртэл ийнхүү ярилцаж, Тоби анх удаа энэлэн шаналсан бүсгүй хүний зүрх сэтгэл рүү өнгийн харж түүнийг ойлгон, тэд гэнэт нэгэн биеийн тал болцгоох нь тэр.

Тэгвэл элэгсэг сэтгэлийн тайтгарал нь гэнэт араатны тачаангуй хүсэл болон хувирч, бие биеэ шуналтай гэгч нь озон үнсэж, хуял тачаал нь сэргэсэн Тоби бүсгүйг чанга тэврэн авлаа. Тобиг тэсгэлгүй хүсэх Жилл хувцсыг нь тайчиж эхлэхэд эсэргүүцсэнгүй харин ч мань эрд туслана.

Харанхуй дунд бүсгүй нүцгэн биеэрээ наалдан тэвэрч, хоёул ухаангүй хүсэлд автан шалан дээр хэвтэцгээжээ. Тоби гандайтал боссон том эрхтэнээ шургуултал Жиллийн гол руу модоор шаах мэт өвдөн ёолон гиншихэд Тоби илдээ сугалах гэтэл бүсгүй түүнийг хамаг хүчээрээ тас зууран тэвэрч

биедээ улам наалаа. Тэрээр зөөлөн, халуу дуургэх бяцхан ангал руу шуналтай гэгч нь шургалан орж дүүргэн бүсгүйг энхрийлэн таалахад сэтгэлийн шарх нь хэрхэн анин эдгэж буйг бүсгүй мэдэрлээ.

Тэр энхрий ялдам, хайрлан дурласан, хагсаж цангасан атлаа үүлэн борооны явдалдаа догшин, эрчимтэй байх агаад чадал тэнхээ нь улам улам оргилон чангарч тэчъядан омогшино.

Өгүүлж баршгүй жаргал, цэнгэл өрөвдөх сэтгэлгүй тачаал. Жилл,

-Тоби, надад дурлаач! Надад дурла... хэмээн бархирлаа.

Халуу дуугсэн эр хүний дор хэвгэхэд түүний бие нэгэн биеийн тал болон тэд ердөө л хоёул мөнхөд хамтдаа хоёулаа байх болно.

Бүх л шөнийн туршид тэд загас наадуулан цэнгэж, инээж хөхрөлдөж, ярилцан хонолоо.

Тоби Жиллд дурлажээ хэмээн бодож байсан бол өдгөө түүнд галзуурах шахам ухаангүй

дурлаж Жиллийг дайсагнасан заналт ертөнцөөс хамгаалан аятай энгэртээ тэврэн жинхэнэ хайр дурлалыг амтыг мэдрэн, амсан жарган хэвтэцгээв. Тэр Жиллийг харвас үс гээг нь сэгсийн, хацар нь улаа бутрах авч өгүүлж барамгүй үзэсгэлэнтэй харагдана. Мань эр түүнд дурласан шиг хэзээ ч, хэнд ч дурлаж явсангүй ажээ.

-Би чамайг надтай гэрлэхийг хүсч байна хэмээн үүнээс өөр зам үгүй гэдгийг сая л ухаарсандаа түүнд шивнэн хэлжээ.

-Өө Тоби, тэгнэ, тэгнэ гээд Жилл түүнд улам наалдан янаглан хариулав.

Бүсгүй түүнийг хайрлан дурлаж, эхнэр нь болохыг туйлаас хүсчээ.

Олон жилийн дараа Жилл яагаад энэ бүхэн эхэлснийг эргэн саналаа. Тэр Тобигийн агуу хүчийг ашиглан өөрийг нь гутаан доромжилж, бие сэтгэлийг нь шархлуулсан тэдгээр хүмүүст хариу шанг нь өгөхийг эрмэлзсэн байжээ. Жилл өс хонзонгоо авахыг ихэд хүсчээ.

Ингээд тэрээр санасандаа хүрч, мөрөөдсөн бүхнээ хүртэх болов.

Бүлэг 27.

Клифтон Лоренс нэг л гай зовлон учрах гэж буйг зөгнөн дотроо залбирч, Тобигийн зочны өрөөнд баарын дэргэд зогсон үйлчлүүлэгч эрийнхээ ярихыг нь итгэж ядан сонсож зогсоно. Үнэхээр аймшигтай мэдээ дуулгажээ.

-Клиф ээ, би Жиллтэй гэрлэхийг хүссэн, бүсгүй зөвшөөрсөн. Өөрийгөө арван зургаатай болсон юм шиг санагдаад байх юм гэлээ,

Клифтон гайхаш тасарч буйгаа арай ядан нуухыг хичээлээ. Энэ янхан эм Тоби Темплийн толгойг эргүүлэхийг хэрхэвч зөвшөөрч болохгүй, харин болгоомжтой хөдлөхгүй бол бүр ч болохгүй гэдгийг тэр тун сайн мэднэ. Сүй тавьсан тухай мэдээ хэвлэлийн хуудаснаа гармагц хотынхон тэр чигээрээ жаргалтай гэгч нь сайрхацгаах болжээ.

Үгүй дээ, энэ хурим болох ёсгүй! Лоренс золтой л Тоби Жиллээс хорин нас ах гэдгийг нь сануулах хорхой нь гозгонож, үг алдах шахсанаа амаа барин,

-Миний бодлоор яарах хэрэггүй юм шиг бодогдоно. Хүнийг таньж мэдтэл их хугацаа шаардах ёстой. Чи сайн тунгааж бодох хэрэгтэй хэмээн болгоомжтойгоор өгүүлэв.

Гэвч хэлснийг нь Тоби чихнийхээ хажуугаар өнгөрөөн,

-Чи миний хуримын зууч болно! Хуримын ёслолыг хаана хийвэл зүгээр вэ, энд үү, эсвэл Лас Вегаст уу? гэж асуулаа.

Клифтон түүнд үг хэлж хар толгойдоо лай хурааснаас Жиллтэй ярилцаад үзэх нэгэн санаа төржээ.

Агент эр тэр өдөртөө бүсгүйд утасдан офисдоо ирэхийг хүссэнд тэрээр товлосон цагаас бүхэл бүтэн нэг цаг хоцорч ирснээ Тобитой уулзахаар яарч байгаагаа хэлэхэд нь,

-Би таныг удаахгүй гээд Лоренс түүнийг сонжин ширтэв.

Үзэх нүдний нь өмнө хэдэн сарын өмнө танилцсан нөгөөх Жилл биш, харин урьд өмнө байгаагүй өөртөө итгэлтэй, зориг самбаатай, цоо шинэ Жилл зогсож байв.

-Жилл ээ, би мэдэн будилаад байж чадахгүй. Чи Тобид гай болно. Би чамайг Голливудаас үтэр түргэн явахыг хүсч байна гээд хайрцагнаас том дугтуй гаргаж ирээд бүсгүйд сарвайн,

-Энд таван мянга байгаа. Чи дуртай хот руугаа явж, төвхнөтөл бүрэн хүрэлцэнэ гэжээ.

Жилл хэдэн хором түүнийг гайхан ширтсэнээ гэдрэгээ буйдан налснаа гэнэт тачигнатал хөхөрч гарлаа.

-Би тоглоогүй шүү хэмээн Лоренс түүнд эгдүүцэн анхааруулснаа, -Голливудын хамаг эрчүүлтэй унтаж явсныг чинь Тоби мэдвэл чамтай гэрлэнэ гэж бодож байна уу? гэж асуув.

Жилл нүдээ онийлгон Лоренсийг шинжээд чухамдаа мань эр болон түүнтэй ижил өрөөсөн дугуйнууд болох нөлөө бүхий эрхмүүд л түүнд аз сорих боломж өгөлгүй, өгсөн дүрийнхээ шанд төрсөн биеэрээ, сэтгэл зүрхээрээ. . . төлөөс хийхийг хүсч байсан нь түүний амссан бүхний гэм буруутан та бүгд гэж хэлэхийг ихэд хүслээ. Гэвч ингээд ямар ч нэмэргүйг Жилл сайн мэднэ. Тэд хэзээ ч гэмээ ухаарахгүй нь лав. Энэ жигтэй амьтан одоо бас түүнийг мэхлэх гэнэ шүү. Тэр Тобид алтан хушуу хүргэж даанч нэг зүрхлэхгүй, Тоби Лоренсод итгэхэсээсээ бүсгүйд итгэнэ гэвэл арай үнэнд ойр сонсогдох байх даа. Жилл босон оффисоос нь гарч явлаа. Цагийн дараа Тоби Клифтонд утасдан, -Анд минь чиний Жиллд юу гэж хэлснийг мэдэхгүй хэмээн ихэд сэтгэл нь хөдөлсөн аятай хэлснээ,

-Гэвч би чамд өртэй боллоо. Бүсгүй хүлээх хүсэлгүй байгаагаа хэлсэн. Бид даруй гэрлэхээр Лас-Вегас руу нислээ гэв.

Яг энэ мөчид хувийн "Лир" онгоц Лос-Анжелесийн олон улсын буудлаас гучин таван милийн тэртээд нисч явжээ.

Дэвид Кеньон диспетчерийн албатай холбогдон өөрийн байршлыг мэдэгдэв. Тэрээр Жиллтэй уулзах болсондоо сэтгэл хөөрч, хөл газар хүрэхгүй бөөн баяр болон яваа нь энэ.

Автын осолд орсон Сиссигийн шарх сорви овоо эдгэрэн бие

нь тэнхэрсэн ч гэлээ нүүр нь сэг болтлоо шилэнд зүсэгдсэн ажээ. Дэвид түүнийг гоо заслын хагалгаа хийлгэхээр Бразилийн шилдэг мэс засалч руу явуулсан байна. Эхнэр нь тэнд зургаан долоо хоног эмчлүүлэн, эмчийг ам хамжилгүй магтаж байв.

Хорин дөрвөн цагийн өмнө Сисси нөхөртөө утасдаж, дурласнаа, Бразилд үлдэх болсноо мэдэгдэж гэр бүлээ цуцлахыг хүсч байгаагаа хэлжээ.

Ийм амжилтанд хүрнэ чинээ санаагүй Дэвид итгэж чадсангүй.

-Энэ... энэ гайхалтай гэж бувтнаад, -Эмч та хоёр жаргалтай байна гэдэгт итгэж байна гэлээ. - Өө, энэ эмч биш ээ гэснээ Сисси,

-Багахан шиг онцгой тариалангийн эзэн. Тэр чамтай адилхан шүү, Дэвид ээ. Ганц ялгаатай нь тэр надад хайртай гэжээ.

Радио холбоо гэнэт Дэвидийг бодлоос нь салгах гэсэн мэт тас няс хийн амь орж, диспетчер буух зурвасын дугаарыг зааж, газардахыг зөвшөөрлөө.

Дэвид өндрөө бууруулан доошлох тутам Жиллийг хайж олон, дурласан хэвээр байгаа гэдэгээ хэлэн эхнэр нь болохыг гуйна гэж бодохос зүрх нь догдлон галзуутай цохилоо.

Дэвид зорчигчдын гудмаар гарч явахдаа сонингийн мухлагийн дэргэдүүр өнгөрч явснаа,

ТОБИ ТЕМПЛ ЖУЖИГЧИН БҮСГҮЙТЭЙ ГЭРЛЭНЭ гэсэн томоос том тод гарчигийг санамсаргүй олж хараад энэхүү нийтлэлийг хоёр дахин уншсанаа гэдрэг буцан нисэх буудлын бааранд орон гурван өдөр тасралтгүй ууж согтуурчихаад эргэн Техас рүү гэртээ харихаар

ХӨЛГИЙН ЖОЛОО ЗАЛЖЭЭ.

Бүлэг 28

-Ийм тансаг сайхан хуримын аялалын тухай зөвхөн романаас уншиж болно. Тоби, Жилл хоёр хувийн

онгоцоороо Мексикийн өтгөн шугуй, наран шарлагын газрын дунд аглагт орших мартагдах шахсан үлгэрийн мэт үзэсгэлэнтэй сайхан амралтын газар өнгөрөөжээ. Шинэхэн хосууд эргэн тойронд нь үзэсгэлэнт цэцэгсээ дэлгэсэн кактусуудад хүрээлэгдсэн, шөнөд нь шувуудын уянгат жиргээн сонсогдох тусгай сэрүүн лавранд байрлжээ. Арав хоногийн турш тэд дарвуулт хөлгөөр аялан шөнийн клубээр хэсэн шилдэг тогоочийн гарын хоолоор дайлуулан, урсгал устай усан санд сэлэн зогсоо зайгүй цэнгэв. Жилл байдаг бүх эмэгтэй хувцасны дэлгүүрийг хэсүүчилж амжжээ.

Тэд Мексикээс хөдлөн Биарридийн "Отель дю Пале"-д буудаллан Наполеон III—ын ордон үзэн, казино тоглож, загас жараахай барин, шөнийн туршид энэ биесийн жаргал эдлэн үүл борооны ажлыг ханатал хийцгээж байлаа.

Эцэст нь Швейцарь орж, голио онгоцоор уулын оргилд хүрч уулын цанаар гулган, нохой чаргаар зугаалан үдэшлэг цэнгээн хэсэн бүжиж явлаа.

Тоби ийм жаргалтай байж үзээгүйсэн, тэр амьдралд нь аз жаргал баяр баясгалан бэлэглэх тэр л бүсгүйгээ олж авсан мань эр ганцаардахын гашуун зовлон эдлэхээ болилоо!

Тоби бал сар нь өнө мөнхөд үргэлжлэхийг хүсч, Жилл өөрийгөө харь нутагт айлчилж яваа хатан хаан мэт санана. Жилл Касл Голливудад эргэж очих хүсэлдээ автан байж ядан тэчьядаж эхлэв.

Хатагтай Тоби Темпл хэн нэгнээс хариугаа авахыг хүсчээ.

ХОЁРДУГААР ДЭВТЭР

Бүлэг 29.

Унал сүйрэл гэгч нь еерийн өнгө аяс, үнэртэй. Энэ өмхий самхай хорт уур нь азгүйчүүдийг бүрхэн салахгүй наалдаж, нохой хүний айдсыг үнэрлэн мэддэг шиг хүн өөрөө зайлшгүй ирэх аюулыг мэдэрдэг ажээ.

Энэ нь ялангуяа Голливудад хууль мэт үйлчлэх нь олон тохиолдоно

Шоу бизнес болгонд Клифтон Лоренсын төгсгөл болсон нь цухалзаж эхэлсэн ч, агент үүнийгээ бусдаас түрүүн мэдэрчээ.

Жилл, Тоби хоёрын хуримын аялалаас зргэж ирснээс долоо хоног өнгөрсний дараа Клифтон тэдний тухай сураг сонссонгүй. Тэрээр үнэтэй бэлэг илгээж, гурван удаа утасдсан ч шинэхэн амрагууд хариу өгөх талаар санаа тавилгүй өнгөрчээ. Жилл Тобиг түүний эсрэг ямар нэг аргаар турхирах болж, Клифтон ямар ч үнээр хамаагүй эвлэрэх ёстойгоо ойлголоо. Тоби тэр хоёр дэндүү удаан хамт байсан тул хэн нэгэн тэдний дунд яс хаяхыг тэрээр хэрхэвч зөвшөөрөхгүй. Тобиг студид байгаа гэдийг мэдсэн Клифтон өглөө эртлэн ирвэл Жилл үүдээ нээж өглөө. Клифтон үнэлж баршгүй үзэсгэлэнтэй харагдах бүсгүйд магтаалын үг хэлэх боломжоо алдсангүй. Жилл эелдэгээр мэндлэн цэцэрлэг рүү дагуулан аваачиж кофегоор дайлан хуримын аялалынхаа сонин хачинг хөөрлөөд,

-Чамайг Тоби утасдаж амжаагүйг өршөөнө хэмээн найдаж байна. Сар шахам эзгүй, ажил хэрэг ундарч овоорсныг анзаарсангүй гэж Жилл хулчигнан инээхэд нь өстөн дайснаа гэж бүсгүйн эндүүрснээ ойлгосон Клифтон,

-Сонсооч хөө, алив бүгдийг эхнээс нь эхлэе, найз нөхөд болцгооё гэв.

-Баярлалаа, Клиф. Би ч гэсэн үүнийг хүсч байна. Лоренсийн сэтгэл ер бусын хөнгөрөөд санаа нь амарлаа. -Би та нарт зориулан оройн зоог барина. Бямба гаригт "Бистро"-д тусгай тасалгаа захиана. Хамгийн ойрын зуун хүн урина. За ямар вэ, хөө?

Жилл товлосон өдрийг тэсн ядан хүлээж байснаа зоог болохоос гурван цагийн өмнө Лоренсод утасдан,

-Клиф, надад тун харамсалтай байна. Миний бие өвдөөд би зоогонд очих тэнхэл алга. Тоби намайг гэртээ үлдэж амар гэнэ гэжээ.

Клифтон тэвчээр заан,

-Тэгэлгүй яахав, Жилл би ойлгож байна, тун харамсалтай юм болж, гэхдээ Тоби ирнэ биз дээ? гэв. Харилцуурт санаа алдах сонсогдож,

-Үгүй л болов уу, хонгор минь. Тэр надгүйгээр хаашаа ч явахгүй. Та нарыг сайхан цэнгэнэ гэдэгт итгэж байна гэснээ харилцуураа тавьчихлаа.

Тэр гурван мянган долларын тооцоог хэдийнэ хийчихсэн төдийгүй үнэндээ ч Лоренс дэндүү

ихийг төлсөн тул зоогийг хойшлуулахад нэгэнт оройтжээ. Цорын ганц анд, хүндэт зочин нь ирэхийг ч санаархаагүйн учрыг уригдан ирсэн найруулагч, студийн захирал, кино одод гээд Голливудын хэн боловч тун сайн ойлгож байлаа. Өөр санаа даанч нэг толгойд нь орж ирэхгүй болохоор Клифтон арьсаа хамгаалан Тобигийн бие базаахгүй байна гэж зочиддоо хэлжээ. Харин маргаашийн "Херальд экземинаер" сонинд хатагтай, ноён Тоби Темпл нар "Дожерс" стадионд морилон ирсэн тухай гэрэл зурагтай нийтлэл гарсан байжээ.

Түүний хувь заяа нь ихээхэн тэмцлийн үр дүнгээс хамаарах болсныг Клифтон бүрнээ ойлголоо. Хэрэв зээ Тоби түүнийг гаргуунд нь гаргаж хаявал тэр мөхөл рүүгээ мөлхөх болно. Ганц ч үйлчлүүлэгчгүй үлдсэн азгүй агент эртэй Голливудын хэн нь ч ажил хэргээ холбохгүй, Лоренсыг албанд авах нэг ч агентлаг олдохгүй нь мэдээж. Бүгдийг эхнээс нь эхлэх үү? Үгүй дээ, дэндүү оройтож. Цаг хугацаа, нас сүүдэр. . . Жиллийг нигүүлсэнгүй сэтгэлтэй болгох арга хайх хэрэгтэй. Тэрээр бүсгүйд утасдан очиж ярилцаж болох эсэхийг асуувал,

-Тэгэлгүй яахав. Би өчигдөрхөн бид сүүлийн үед ховорхон уулзаж болж гэдгийг Тобид хэлсэн юмсан гэв.

-Арван таван минутын дараа очлоо гэгчхээд бааранд орон хоёр хувь виски залгилав. Ажил дээр хэвийнхээсээ их хүртэнэ гэдэг сайн хэлэгдэхгүй болохыг агент эр сайн мэднэ. Гэвч, чөтгөр аваг, хэнийг хуурч байгаа юм бэ? Юуных нь ажил байх вэ? Тобид өдөр бүр ашигтай санал ирэвч агуу хүнтэй уулзан ажил хэргээ ярилцаж чадахгүй явна. Урьд өмнө бол тэд хэдэн цагаар суун ярилцдаг байж... Клифтон аялал, үдэшлэг, охид бүсгүйчүүл гээд ... урьдын сайхан цагаа эргэн нэгдурслаа. Тэд төрсөн ах дүүс шиг дотно байжээ, гэтэл одоо...

Клифтон дахин нэг хувийг уусны дараа гар нь салганахаа больсныг анзаарав.

Жилл саравчит тагт дээр кофе уун сууж байснаа Лоренсыг харан найрсагаар инээмсэглэв.

"Чи наймаачин эр, түүнийг ятгаж дөнгөх үү? хэмээн агент эр өөрөөсөө асуув.

-Чамтай уулзсандаа баяртай байна, Клиф. Суугаач.

-Баярлалаа...Жилл.

Клиф ширээний эсрэг талд нь байх төмөр хөлтэй сандалд суун Жиллийг ажиг. Тэр зуны цагаан палааж өмсөн, наранд борлосон мөр рүүгээ хар үсээ унжуулжээ. Жилл улам залуу, гэм хоргүй, арчаагүй дорой үзэгдэх ажээ.

Бүсгүй сайхан сэтгэл өвөрлөсөн бүлтгэр нүдээрээ агшин зуур Лоренсыг хараад,

-Өглөөний хоол идэх үү, Клиф? гэж асуув.

-Үгүй баярлалаа, би хооллочихсон.

-Тоби гэртээ байхгүй байгаа.

-Мэднэ. Би чамтай ярих гэсэн юм.

-Юу болоов вэ? Миний туслалцаа хэрэг болоо юу?

-Намайг өршөөж үзээч гэж шалдаа буусан Лоренс амандаа бувгналаа.

Хэзээ ч хэний ч өмнө, юу ч гуйн аргадаж байгаагүй мань эр өдгөө энэ танхил бүсгүйн өмнө бялдуучлан сөхрөх хэрэгтэй болжээ.

-Би...бид тэгэхэд ам мурийсаан. Мэдээж бүгд миний буруу. Тоби удаан хугацаанд миний найз минь, үйлчлүүлэгч минь байсан болохоор би түүнийг хамгаалахыг хүссэн юмаа. Чи намайг ойлгож байна уу?

Жилл Лоренсоос харц салгалгүй толгой дохин,

-Тэгэлгүй яахав, Клиф гэв.

Агент эр хүндээр санаа алдан,

-Тоби чамд хэлсэн үгүйг би мэдэхгүй байна, гэхдээ би түүнийг алдар хүндэд хүргэсэн юм. Хэзээ нэг цагт тэрээр алдарт хүрэхийг би мэдсэн юм. Тэр үед надад олон ч нөлөө бүхий үйлчлүүлэгчид байсан, би тэр бүгдээс татгалзан зөвхөн Тобид туслахыг хүсч билээ.

-Чи түүний төлөө ихийг хийсэн гэж Тоби ярьсан гээд Жилл толгой дохив.

-Нээрэн үү? гэж сэтгэл нь хөдлөн огло харайн босов.

Тэрээр агшин зуур өөрийгөө түргэдэн тэвчээргүй загнасандаа харамсах сэтгэл төрлөө.

-Тэр Сэм Голдвины нэрийг барин утасдаж, чи хууртагдсанаа мэдсэн ч гэлээ хүрч ирсэн гэнэ лээ. Чиний зүгээс тун эелдэг загнасан гэсэн хэмээгээд Жилл инээмсэглэв.

Клифтон урагш тонгойн,

-Би урьдын адил Тобигийн найз хэвээр үлдмээр байна, итгээч. Чи миний талд зогсох нь надад тун чухал байна. Чамаас гуйя, бүү хатуурх. Болсон явдлыг бүгдийг мартаж, хэлсэн бүхнийг минь өршөөгөөч. Би Тобиг хамгаалж байна гэж бодсон нь эндүүрч. Тобид хэрэгтэй бүсгүй нь чухамдаа чи юм гэлээ.

-Би хичээнээ. Түүнд сайн эхнэр нь байхыг хичээнэ.

-Хэрэв Тоби надаас татгалзвал. . . би балрах нь. Хэргийн учир бизнестээ байгаа юм биш. Тэр бид хоёр. . . Тэр надад яг хүү шиг минь байдаг. Би түүнд хайртай өөрийгөө үл хайхран. . . Жилл, болгоож үзээч! Бурхныг бодож. . . хэмээн аргадан гуйснаа хахаж цацан таг дуугүй болов.

Жилл удаан гэгч нь дуугүй суун түүнийг гүн хүрэн нүдээрээ харан сууснаа гар сунган,

-Би хатуурхахгүй. Бүх юм дууссан. Маргааш оройн хоолонд ирээрэй. Тэгэх үү? гэлээ.

Клифтон гүн амьсгаа аваад баясгалантай гэгч инээгээд,

-Баярлалаа ... гэснээ нүдэнд нь ус гүйлгэнэн ирснээ,

-Би . . . би үүнийг хэзээ ч мартаггүй. Хэзээ ч ... итгээрэй . . . гэв.

Маргааш өглөө нь Клифтон офистоо ирмэгц ширээн дээр нь Тоби Темплийн нэрийн өмнөөс ажил хэргийг нь явуулах үүрэгт ажлаас чөлөөлөгдөн, цаашид түүний хэрэг үгүй болсныг мэдэгдсэн баталгаат захиа байхыг олж үзжээ.

Бүлэг 30.

Тоби урьдын адил алдар хүндийн оройд нь суусан хэвээр байлаа. Түүний тоглосон телешоу, кинонууд нь агуу амжилтанд хүрч, Лас-Вегаст тоглох үед Казиногийн орлого хоёр дахин нэмэгдэж байв. Тобиг кинонд, сайн санааны хандивын концертонд, шоунд, цомгийн бичлэгт гэхчилэн ийш тийш нь урин булаалдан гуйж гувшсаар ...

Хотын нөлөө бүхий хүмүүс агуу хүний ая данд нийцүүлэх гэж арга бүгдийг сүвэгчлэн эрвийх дэрвийхээрээ гүйлдэх авч, Тобиг үгэндээ оруулахыг тулд урьдаар Жиллийн нигүүлсэнгүй сэтгэлийг хендэх хэрэгтэй гэдгийг тун удалгүй ойлгоцгоов.

Бүсгүй хаашаа явах, хаашаа явахгүйг нь бие даан мэдэж, нөхөртэйгөө холбоотой асуудал бүхнийг гартаа ягштал атгах болжээ. Жилл Тобигийн эргэн тойронд нь зөвхөн хамгийн баян, хамгийн хүчирхэг, хамгийн алдар цуутнууд л нэвтэрч чадах хориг саад босгосон байна. Техас мужийн Одесс хотоос ирсэн бяцхан польш охин мужийн амбан захирагчтай, дэлхийд алдартай жүжигчидтэй, Нэгдсэн улсын ерөнхийлөгчтэй уулзан зугаацах болжээ. Энэ хот түүнийг басамжлан доромжилж байсан тэр нэгэн цаг нэгэнт өнгөрч, Тоби Темпл байсан цагт хэзээ ч эргэн давтагдахгүй. Жиллийн өш хонзонгийн хар дансанд орсон хэн хүний хохь болон түүнийг гай түй дайрах болжээ.

Жилл Тобид бие хайрлалгүй эзэмдүүлэн цадаж ханасны дараагаар тэд бие биесээ тэврэн орондоо хзвгэж байснаа, бүсгүй түүнд улам наалдан наалинхайтаад,

-Хонгор минь, агент хайж явахдаа нэгэн эмэгтэйтэй учирснаа... ярьсан даа. Тэр хэн билээ...еө тийм! Роуз Даннинг. Тэр надад дүр өгөхийг амлачихаад, зохиолоос уншихыг хүсэн миний дэргэд суусан юм л даа...

Тоби агшин зуур эхнэрээ уйтан нүдээр гярхай гэгч нь ширтлээ.

-Тэгээд юу болсон бэ?

-Мэдээж би гэнэн цагаахан охин байсан юм гэж Жилл инээгээд,

-Текст уншиж эхэлмэгц тэр миний гуян дээр гараа тавьсан. Би жигтэйхэн айсан! Араас минь хөөж байгаа мэт учиргүй зугтсан гэж шивнэжээ.

Аравхан хоногийн дараа Роуз Даннингийн агентлагийг Хотын лицензийн комиссоос бүрмөсөн татан буулгасан байна. Тоби Жилл хоёр Палм-Спрингс дэх гэртээ өнжин Тоби массажны ширээн дээр саглагар зузаан даавуун дээр хэвтэн

Жилл түүний булчинг нь базлан иллэг хийнэ. Тоби гэдрэг эргэн нуруугаараа харан хэвтэхэд Жилл хөлөнд нь шингэн тос түрхэн иллэгэ хийж байтал.

-Клифийн тухайд чи миний нүдийг нээж өгсөн шүү хэмээн Тоби яриагаа эхлээд,

-Тэр үнэхээр бусдын хүчээр амьдрагч байж, намайг сорон мөлжиж, мөнгийг минь шавхаж

байжээ. Мань эр хот даяар хамтрагч хайн гүйж, хэн ч түүнтэй ажиллахыг хүсэхгүй байгаа гэж сонслоо! Тэрээр одоо уямангаар өвдсөнөөс ч долоон дор байгаа даа!

Жилл хормын төдий хөдөлгөөнгүй болсноо,

-Клиф надад тун харамсалтай байна гэлээ.

-Энэ чамд падгүй хэрэг, хонгор минь! Ухаан суух цаг болсон шүү!

Жилл эелдгээр инээн,

-Яаж ч чадахгүйгээс хойш би яах билээ дээ гэв.

Бүсгүй хөлийг нь зөөлөн, тачаангуйгаар илсээр улам улам дээшлүүлэхэд Тобигийн тэсэхийн аргагүй хуял тачаал нь хөдлөн,

-Өө Бурхан минь! хэмээн гийнав.

Жиллийн тостой гар гулган явсаар салтаан завсраар нь, төмсийг нь илэхэд асар том эд нь тэр даруй цулцайн хатуурч годойн бослоо.

-Алив, бяцхан муужгай минь, хурдал гэж Тоби шивнэв.

Оройхон хавьд Тоби эхнэртээ худалдан авч өгсөн "Жилл" дарвуулт онгоцоор зугаалахаар явлаа. Маргааш өдөр нь энэ улирлын эхний шоуны бичлэг хийхээр товлосон байсан тул Голливудад буцаж ирэх ёстой байв.

-Би ер нь олигтой амраагүй удаж! гэснээ Тоби,

-Цаашид ажиллахыг хүсэхгүй байх чинь! гэжээ.

-За яалаа гэж дээ, энэ гайхалтай шоу шүү дээ гэж Жилл татгалзснаа,

-Шоунд оролцох надад их таалагдсан шүү! Бүх юм сайхан байлаа гэснээ хэсэг дуугүй болоод,

-Бараг бүх юм гэж тээнэгэлзэн нэмж хэлэв.

-Чи яав аа! Хэн чамайг гомдоов? гэж Тоби өлийн түүнийг гайхан харлаа.

-Хэн ч биш, хонгор минь. Энэ тухай дэмий ярьчихав уу? Эцэст нь нөхөр нь Жиллийг үг алдуулж дөнгөн, маргааш өдөр нь Эдди Берриген ажлаасаа халагджээ.

Хатан зөгийд үр тогтоохоор эргэлдэж таашаал амссан эр зөгийнүүд одоо бүгд устгагдаж эхэлжээ.

Ингээд Тобид Жилл ямар авьяас билэггүй хэмээн хэлсэн Сэм Уинтерсийн ээлж болов. Бүсгүй түүний эсрэг ил биш, далд явуулга хийн Уинтерсийг магтаж эхлэсэн авч бусдын зохиол илүү

сайн. . . найруулагчид нь Тобиг жинхэнээр ойлгодог. . . Сэм Уинтерс хэзээ ч агуу авьяастныг үнэлдэггүй гэж бусад студийн захирлуудыг арай илүүтэй магтаж байв.

Клифтон Лоренс алга болсон. Тоби ярих ч хүнгүй, Жиллээс өөр хэнд ч.... итгэхээ байж...иймээс Тоби өөр студид ажиллах болсон байна.

Хүний зовлонд эс цадагчид хохь нь дээ! Тобигийн тойрон хүрээлэгчдийн ихэнх нь Жиллийн эрх ямба удаан үргэлжлэхгүй, тэр түүр зуур зугаацагч, нэр зээлдэгч, улиг болсон дэлт бүргэд гэж үздэгээс түүнийг тэвчин өнгөрөөж, эс тоомсорлодог байв. Энэ нь л тэдний том алдаа байлаа. Бүсгүй нөхөрт нь ямар нэг, аргаар нөлөөлж өөрийнх нь эсрэг турхирч чадах хүмүүсийг Тобитой хамт байхыг огт хүссэнгүй. Чухамдаа тэр л битүүхэн явуулга хийн Тобигийн өмгөөлөгчийг нь, рекламн фирмийг нь солиулан, өөрийн сонгосон хүмүүсийг хөлсөлж эхлэв. Гарын зарц Макуудыг нь, аялдан дагалдан үйлчлэгчдийг нь хуйгаар нь огцруулж шинэ зарц авчээ. Одоо энэ нь түүний гэр, тэр бүрэн эрхт эзэгтэй.

Тобигийнд зохиогддог үдэшлэгт хотын шоу-бизнесийн зүтгэлтнүүдээс тун ховорхон уригдах болжээ. Тэнд Америкийн нөлөөтэй хүмүүс жүжигчид, томоохон корпорацийн тэргүүн, уригдсан зочдыг хэн болох, хэрхэн цэнгэн зугаацсаныг нь улс орон даяар тарааж чадах хэвлэлийн төлөөлөгчид ирцгээнэ.

Тоби гэртээ хоёулхнаа үлдвэл илүү жаргалтай байх агаад, эхнэр нь зугаа цэнгэлд дэндүү дурлах болов. Нэг орой гурван

ч үдэшлэгт нэгэн зэрэг уригдаж, бүсгүй явахаар түүнийг эрүүдэхэд Тоби эхнэрийнхээ хөнгөмсөгийг хошигнон гомдоллоход,

-Хайрт минь би үүнийг чиний төлөө л хийж байна шүү гэж Жилл түүнийг тайвшруулав.

Тоби "Метро-Голдвин Мейер"-т зураг авалт хийлгэн өглөөнөөс орой хүртэл ажиллаж завгүй байв. Оройхон гэртээ ирээд цамц, смокингийг нь нямбайлан бэлдсэнийг үзмэгц,

-Хүүхэлдэй минь, ийш тийш явна гэж л битгий хэлээрэй дээ. Бүхэл жилийн турш ганц орой ч гэртээ өнжсөнгүй, чөтгөр ав гэж! гэлээ.

-Өнөөдөр Дэвисийн хуримын ой. Биднийг очихгүй бол тэд аймшигтай гомдоно!

Ядарч туйлдсан Тоби орон дээр лагхийтэл суугаад,

-Би халуун усанд орчихоод ханатал унтмаар байна! гэсэн боловч тэр үдэшлэгт явжээ.

Тоби хаа явсан газартаа үргэлж бүгдийн анхаарлын төвд байж, тэднийг өөртөө татаж, цугларагсад нь агуу их ухаантай хүнтэй цагийг өнгөрөөсөндөө баярлан алга ташин талархана. Тоби эл өдрийнхөө дараа унтаж чадахгүй зовж тарчлан үзэгдчийн алга ташилт нижигнэсэн ялалтаа бодон эргэж хөрвөөнө. Гэхдээ л тэр жаргалтай хүн! Жиллийн ачаар шүү! Ээж нь байсан бол зхнэрийг нь хэрхэн хүндэтгэх бол.

Гурван сард тэд Каннын кинофестивалын урилга хүлээн авчээ.

-Яасан ч үгүй! хэмээн Тоби Жиллийг урилга үзүүлэхэд хариулаад,

-Хайрт минь, би ядарч байна. Ажил гэж толгойтой үснээс их. Халуун ус, телевиз, дулаан ор дэр энэ л миний Канн гэлээ.

Гэвч түүний рекламны агент Жери Гутман сүүлийн кино нь шилдэг шагнал авах боломжтой агаад агуу хүн оролцвол илүү тус болох талтай гэж Жиллийг ятгажээ.

Сүүлийн үед Тоби үе үе ядарч сульдан нойр муутай байгаадаа гомдоллон, шөнөдөө нойрны эм уун, өглөө нь тархи толгой нь хүндхэн босч ирдэг болжээ.

Жилл нөхрийгөө урьдын адил ажиллуулах эрч хүчийг нь сэлбэхээр бензедрин уулгав.

Нойрны эм сольж уусан нь түүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлжээ.

-Би урилгыг хүлээж авсан гэж Жилл нөхөртөө хэлээд,

-Гэвч мэдээж, татгалзаж чадах хойно. Хонгор минь хэцүү юм ер алга гэв.

-Алив Палм-Спрингс явж сар, санаж бодох юмгүй жаргалын нарсыг мандуулья.

-Юу уу? Жилл тээнэгэлзэн асуув.

Тоби гэнэт царцанги царай гарган,

-Би наранд гэж хэлэх гээд хэл минь хальтирчихла?

-Яагаад гэвэл чи үргэлж хошигнодог шүү хэмээн Жилл инээгээд түүний гарыг зөөлөн атгаж,

-Гэлээ ч энэ чинь сайхан санаа байна! Бид хоёулхнаа байхад би их дуртай! гэлээ.

-Би ер нь яачихаад байгаагаа мэдэхгүй байна гээд Тоби санаа алдаад,

-Ямар ч эрч хүчгүй болчихож! Өтөлж байгаа юм байх даа гэжээ.

-Чи хэзээ ч өтлөхгүй! Оронд орохдоо хэрхэн аяглахыг чинь харамз!

-Өө тийм үү? гээд Тоби маасалзаж,

-Миний "азарган тахиа" намайг авсанд орсон хойно ч гэсэн донгодож байна шүү! гээд тэр шилэн хүзүүгээ үрчэн,

-Жаахан дуг хийгээд авья. Үнэнийг хэлэхэд, миний бие тун тааруу байна. Бид өнөөдөр хаашаа ч явахгүй юу? гэв.

-Битгий санаа зов, онцын ажил байхгүй. Би зарц нарыг явуульчихья, өөрөө оройн хоолоо хийнэ. Хоёулаа гэртээ үлдэцгээе.

-Энэ ч дажгүй сайхан санаа байна!

Тоби эхнэрийнхээ араас харан, өөрөөс нь өөр жаргалтай хүн энэ ертөнцөд алга гэдгийг бахдан бодов.

Оройхон Жилл нөхрийгөө оронд нь хэвтүүлэн бүх биеийг нь илэн иллэг хийн ядаргаагий нь тайллаа.

-Сайхан боллоо гэж тэрээр бувтнаад,

-Ёстой гайхалтай!

Чамгүйгээр энэ олон жилийг яаж өнгөрөөснөө би мэдэхгүй юм!

-Гайхмаар юм, тийм үү? гэснээ Жилл нөхөртөө эрхлэн наалдаж,

-Тоби, Каннын фестивалын талаар ярьж өгөөч. Ямар болдог вэ? Би хэзээ ч очиж үзээгүй гэлээ.

-Ердөө л ертөнцийн энд тэндээс ирсэн луйварчид бие биедээ өөрсдийн кинонцороо худалдахыг хичээцгээдэг юм гээд эхнэрээ бодолхийлэн харснаа Тоби,

-Чи үнэхээр энэ тэнэг фестивальд очихыг хүсээ юу? гэлээ.

Жилл яаран толгой сэгсэрч,

-Үгүй. Бид чинь Палм-Спрингс рүү явах гэж байгаа биш үү?

-Чөтгөр ав гэж, бид тийшээгээ дуртай цагтаа явж болно!

-Гэхдээ, Тоби энэ ч тийм чухал биш дээ?

-Би чамд ухаангүй дурласныг чи мэдэж байна уу? гээд Тоби инээмсэглэж,

-Чамаас өөр бүсгүй бол энэ фестивал руу явах гэж намайг чирч гулдрана даа! Гэтэл чи явах гэж тэсэн ядаж байгаа мөртлөө юу ч дуугарахгүй, харин Палм-Спрингс рүү надтай сар явахаар зөвшөөрч байдаг. Чи урилганд татгалзсан хариу өгөө юу?

-Одоохондоо, үгүй. Гэвч... Тэгэх хэрэггүй болсон. Бид Энэтхэг орно гэхэд Тобигийн нүд аяганаасаа бүлтрэх нь үү гэлтэй томорч бүлтийгээд,

-Энэтхэг ий? Би Канн явах л юм бодож байлаа!

Тэдний онгоц Орлигийн нисэх буудалд газардахад Тоби эцэг нь асрамжийн газартаа насан өөд болсон тухай цахилгаан хүлээн авчээ. Гэвч Тоби оршуулах ёслолд амжиж очсонгүй.

Хзрин тэр эцэг эхийнхээ нэрээр нэрлэсэн эмнэлгийн газар байгуулахаар шийджээ.

Францын Каннд бүх дэлхийн өнцөг булан бүрээс шинээр хийгдсэн кинонууд эзэдтэйгээ хүрэлцэн ирж, энэ хот ээлж дараалан Голливуд, Лондон, Париж, Рим болон хувирч, гудамж талбайнууд нь мэргэжилтэн, сонирхогч, ахмад зүтгэлтэн шинэ болон алдарт жүжигчид, астангууд, азгүйчүүдээр болон сурвалжлагч, сэтгүүлчдээр дүүрч арвагнан оволзоно. Тэд бүгд Каннын тэргүүн шагналыг хүртэж дэлхий дахинд алдраа дуурсгахсан гэж чармайцгаана. Канн хотын зочид буудлуудын захиалга дуусч, өрөөгүй үлдэгсэдийг Антиб, Болье, Сен - Тропез, Ментон руу илгээх аж.

Тобигийн хувьд "Карлтон" зочид буудалд люкс өрөө авахад тийм ч төвөг учирсангүй. Энд тэндгүй шүтэн бишрэгчид Жилл тэр хоёрыг угтан авч, фото-сурвалжлагчдын аппарат зогсоо зайгүй шад шадхийн ихэмсэг хосын зургийг аван дэлхийн бүхий л сонинд хэвлэн нийтэлж байлаа.

Тобигийн тоглосон кино шагнал хүртсэнгүй фестиваль дуусахаас хоёр хоногийн өмнө шүүгчид эстрадын урлагт байгуулсан гавьяаг нь үнэлэн Тобиг шагнах болсноо мэдэгджээ. Шагналыг ёслолын хүлээн авалтан дээр гардуулах ёстой байв. "Карлтон" зочид буудлын хүлээн авалтын танхим дүүрэн зочидтой, Жилл нөхрийн хамт хүндэтгэлийн суудалд сууж байлаа. Тобиг юу ч идэхгүй байгааг анзаарсан Жилл,

-Хонгор минь, чи яагаа вэ? гэж шивнэв.

Тоби толгой сэгсрэн,

-Наранд цохиулсан бололтой. Бүх юмс нүдний өмнүүр хөвөөд байна гэв.

-Маргааш чамайг сайхан амраах талаар санаа тавинаа.

Жилл маргааш "Пари Матч", Лондонгийн "Таймс"-ийн сурвалжлагчид ярилцлага өгөх, алдартай продюссор, найруулагчидтай кафенд суухаар тохирсоноо хойшлуулахаар болов.

Зоогийн төгсгөлд Канн хотын дарга босон,

-Ноёд хатагтай нараа, хүрэлцэн ирсэн зочид гийчид ээ! Надад дэлхий дахинаа алдараа дуурсгасан, агуу жүжигчинд шагнал гардуулах асар хүндтэй үүрэг ноогдлоо. Түүний ур чадвар, бидний талархалын бэлэг тэмдэг болсон тусгай шагналыг баяртайгаар гардуулья гээд туузан дээр хатгасан алтан медалийг дээш өргөн,

-Ноён Тоби Темпл! хэмээн зарлав.

Бүгд нэгэн зэрэг суудлаасаа босон алга ташилж нижигнэж эхлэхэд Тоби хөдөлгөөнгүй суусан хэвээр байлаа.

-Босооч хэмээн Жилл хажуугаас нь шуд зуун исгэчүүлэв.

Тоби үл ялиг ганхаад алгуурхан бослоо. Түүний царай нь үхдлийн мэт цонхийн цайжээ. Тэр минут хэртээ зогсон инээмсэглээд микрофон чиглэн явах замынхаа талд хүрээд гэнэт сөхрөн шалан дээр ухаан алдан уналаа.

Тобийг ачааны онгоцоор Париж руу америкийн цэргийн эмнэлгийн сэхээн амьдруулах тасагт аваачлаа. Жилл гучин зургаан цагийн туршид идэж уухаас, илүү үглэн харамссан шүтэн бишрэгчдийн зогсоо зайгүй утасдахаас залхаж, түүний амь насны төлөө тэмцэн байгаа Францын шилдэг эмч нарыг хүлээсээр суулаа.

Бүсгүй хана ширтэн ганцаар юу ч сонсохгүй, юуг ч анзаарахгүй зөвхөн Тоби эдгэх, эдгэх ёстой гэсэн ганц бодолд автан суусаар. Эр нөхөр нь түүний нар юм. Тэр нар хэзээ ч жаргаж болохгүй.

Өглөөний таван цагт ерөнхий эмч Дюкло, Жиллийн суугаа өрөөнд орж ирлээ.

-Хатагтай Темпл. Нөхөр тань хүчтэй цус харвалт өгсөн байна.Тэр цаашид ярьж чадахгүй, хөдөлж чадахгүй л болох болов уу хэмээн айж байна гэх нь тэр.

Бүлэг 31.

Жиллийг нөхөр дээр нь оруулахад түүний өөрчлөгдсөнийг харсан бүсгүй ихэд гайхав. Ердөө л хоёрхон хоногийн дотор өтөлж ядарсан, хатингар өвгөн болон хувирч амьдралын эрч хүч нь түүнийг орхин оджээ.

Гэр хөл гараа хөдөлгөж ч чадахгүй, үгний оронд үл ойлгогдом тасалдсан дуу гарч мөөрөх ажээ.

Эмч нар хагас сарын дараа өвчтөнг Америк руу авч явахыг зөвшөөрөв. Тоби, Жилл хоёрыг Калифорнид эргэж ирэхэд нисэх онгоцны буудалд сурвалжлагчид, тэднийг дэмжигчид болох улаан финүүдээр пиг дүүрэн байлаа. Алдарт жүжигчний өвчин ер бусын шуугиан дэгдээсэн ажээ. Найз нөхөд, шүтэн бишрэгчид Тобигийн биеийг асуун зогсоо зайгүй утасдацгаана. Телевизийнхэн бичлэг хийх гэж гэрт нь сэм орохыг хүртэл оролдож үзжээ. Ерөнхийлөгч, сенатор харамсал илэрхийлэн цахилгаан утас илгээж, өдөр бүрийн шуудангаар Тобиг шүтэн бишрэгчид, өрөвдөн хайрлаж, түүний төлөө залбирагсдын тэвэр дүүрэн захидал, ил захидал ирж байсан ч, их урилга заллага бараа сураггүй болжээ. Жиллийн яаж байгааг нь, хаа нэгтгээ очиж дотно хүрээнд зоог барихыг, зугаалахыг кино үзэхийг хүсч байгаа эсэх талаар Голливудынхнаас нэг нь ч асууж лавласангүй.

Тобигийн хувийн эмч Эли Каплан шилдэг мэдрэлийн мэс засалч хоёр эмчийг дуудсанд тэд нар нь Парижийн эмч нарын оношийг давхар баталжээ.

-Хамгийн гол нь Тобигийн ухаан санаа евчиндөө хэзээч нэрвэгдэж самуурахгүй. Тэр хэлсэн бүгдийг сонсож, ойлгох хэдий ч хариу өгүүлэх хөдлөх үйл ажиллагаа нь гэмтсэн байна. Биеийн байдал нь үүнээс дээрдэхгүй. -Тэгээд ... үргэлж ийм байх уу? Доктор Каплан эргэлзсэнээ,

-Үгүй ч байж магад, яг үнэндээ бидний бодож байгаагаар Тобигийн мэдрэлийн систем нь эмчилгээ авахааргүй болтлоо гэмтсэн байна гэлээ.

-Тэгэхээр тодорхой юм үгүй шив.

-Үгүй. ..

Гэвч Жилл хэрхэхээ сайн мэдэж байлаа. Тэр физик эмчилгээний, сувилагч, хэл зүйн мэргэжилтэн нарыг хөлслөн авч, Тобиг усан бассейнд оруулан булчин шөрмөсийг нь, мэдээгүй болсон гар хөлөнд нь иллэг хийлгэн, ярьж сургахаар өдөр бүр хичээллэх болов.

Хоёр сар өнгөрсөн хэдий ч ямар нэг өөрчлөлт гараагүйг Жилл анзааран Эл Каплан эмчийг дуудав.

-Та түүнд туслах ёстой. Ямар нэг юм бодож олоочээ. Та Тобиг, ийм байдалтай орхиж болохгүй шүү дээ хэмээв. Эл Каплан арга нь барагдсан аятай толгой сэгсэрэв.

-Жилл минь , өршөөгөөрэй. Би танд тайлбарлахыг хичээсэн.

Эмчийг язснаас хойш Жилл ганцаараа номын сандаа удтал бодолд авган тархи толгой нь хүчтэй өвдөхийг эс тоон суужээ. Одоо өөрийгөө бодох цаг бишээ.

Бүсгүйг дээш гарахад Тоби хий гөлрөн хэвтэж байснаа түүнийг орж ирэхэд цэнхэр нүд нь баяр баясгалангаар гэрэлтэж гярхай хурц нүдээр Жиллийг дагуулан ширтэв. Уруул нь өмөлзөн хөдлөх авч үл ойлгогдом мөөрөх дуу гарна. Жилл Каплан эмчийн: "Хамгийн гол нь Тобигийн ухаан санаа. . . нэрвэгдэж самуурахгүй" гэж хэлснийг санав.

Жилл орны ирмэгт суугаад,

-Тоби, чи намайг сонсооч. Чи орноосоо босох ёстой. Чи ярьж, явж чадах болно гэв.

Тобигийн хацрыг даган нулимс урслаа.

-Чи үүнийг хийх ёстой. Миний төлөө хийх болно гэж Жилл шивнэв.

Маргааш нь тэр хөлсөлсөн сувилагч, физик эмчилгээ, хэл заслын мэргэжилтнүүдийг бүгдийг нь халлаа. Энэ тухай сонссон Эл Каплан эмч Жиллтэй уулзахаар яаравчлан иржээ.

-Физик эмчилгээний хувьд та зөв шийджээ, харин сувилагчийг! Тобиг хорин дөрвөн цагийн турш асрах...

-Би түүнтэй хамт байх болно.

Эмч толгой сэгсрэн,

-Та ойлгохгүй л байна даа. Ганцаар хүч хүрэх...

-Хэрэг болбол утасдана.

Хэцүүхэн өдрүүд үргэлжлэн, Жилл эмчийн зааврын дагуу бүхнийг хийхэд тун хүнд байлаа. Тахир татуугийн тэргэнцэрт суулгахаар Тобиг өргөтөл нөхөр нь жин гэх юмгүй, жиггэйхэн хөнгөн санагдахад Жилл ихэд цочирджээ. Усан сангийн дэргэд тусгайлан зассан цахилгаан шатаар доош бассейнд буулган физик эмчилгээний сувилагчийн заавраар иллэг хийж эхлэв. Сувилагч өндгөнд хүрч ядан байгаа мэт дэндүү зөөлөн болгоомжтой хийж байсан бол Жилл хатуу чангаар базан илнэ. Тоби заасан дасгал сургуулилтыг сурахыг хичээх авч ядарч туйлдан тэвчээр нь барагдахад Жилл, -Бага байна, Тоби. Дахиад нэг, миний төлөө.

Ийнхүү хөөрхий эрийн нүдэнд нь нулимс цийлэгнэтэл нь хөдөлгөөнийг дахин дахин хийлгэсээр байв.

Жилл өдөр нь Тобитой ярих сургуулилт хийн,

-... Ооо-ооо-о-о...

-А-а-а...

-Үгүй ээ! О-о-о. Уруулаа дугуйл Тоби. Хэлэх гээд хичээ. О-о-о-о.

-А-а-а-а...

-Үгүй ээ, чөтгөр аваасай чамайг! Чи ярьж сурах ёстой! Алив дахиад. О-о-о-о...

Энэ мэтчилэн бүгдийг эхнээс нь дахин дахин хийж байлаа.

Жилл орой бүр нөхрийгөө хооллон дэргэд нь хэвтэн хатингаршсан гарыг нь хөдөлгөж. бие, хөх, гуя, хэвлий, бэлэг эрхтэнээ илүүлэн,

-Хараач Тоби! Мэдэрч байна уу? Энэ бүхэн чинийх шүү, хонгор минь, зөвхөн чинийх. Би чамайг хүсч байна. Чи эрүүл саруул болон бид дахин бие биеэ хайрлана. Тоби, чи намайг эзэмд, дахин дахин эзэмд хэмээн шивнэдэг байлаа.

Тоби хурц цэнхэр нүд үл салган түүнийг зогсоо зайгүй ширтэн, ээрч мууран үл ойлгогдох авиа гарган уухилна.

-Удахгүй, Тоби, удахгүй.

Жилл ядарч зүдрэхээ умартжээ.

Хөндлөнгийн хүн байлгахгүй гэсэндээ зарц нараа явуулан хоол ундаа өөрөө хийн, хүнсээ утсаар захиалан гэрээсээ ч гарахаа болив. Илүү үгэнд дурлагсад зогсоо зайгүй утасдах нь багасаж, чимээ тасран, сурвалжлапнид Тобийн биеийг сонирхохоо больцгоож эхэллээ. Дэлхий даяар агуу жүжигчинг үхлүүт байгаа гэж мэдэх болжээ. Тоби хэзээ мөдгүй хоногоо хүлээж байсан ч Жилл үүнийг хэрхэвч зөвшөөрөхгүй байв.

Тоби нас нөгчих аваас Жилл хамтдаа булшлагдана гэсэн үг.

Ядарч туйлдатлаа зүтгэх Жилл өглөө 6 цагт эртлэн босж, өдрийн ажлаа Тобиг угааж цэвэрлэхээс эхлэдэг байна. Бүсгүй хулдаас тавьсан ч гэлээ нөхөр нь шээс алдан ор дэвсгэрийн

даавуу, хувцас хунарыг нь байнга солино. Унтлагын өрөө нь тэсвэрлэхийн аргагүй үнэр танартай болжээ. Жилл түмпэнд бүлээн ус хийн нүүр гар биеийг нь арчин шээс шинхэгийг нь угааж цэвэрлээд тальк түрхэж, сахлыг нь хусан, үс гэзгийг нь самнана.

-За тэр ! Чи сайхан харагдаж байна, Тоби. Шүтэн бишрэгчид чинь яг одоо харсан бол доо! За яахав, удахгүй харна. Бас концертын билетийг авах гэж зодолдоно доо. Ерөнхийлөгч ирнэ, бүгд Тоби Темплийг харахыг хүсэх цаг ирнэ гайгүй!

Угаалга дууссаны дараа Жилл өглөөний хоолонд хүүхдийн будаа, агшаасан будаа эсвэл өндөг бэлтгэн залгиж чадахгүй болсон нөхрөө яг л нялх хүүхэд шиг хооллож, зогсоо зайгүй тэр удахгүй эдгэнэ гэж амлан үргэлж ганцаараа ярьж байлаа.

-Чи Тоби Темпл гэж нэг л хэвээр давтан,

-Чамайг эргэж тэнхрэхийг бүгд хүсч байна, бүгд чамайг хайрлаж байгаа. Үзэгчид чамайг хүсч байна, Тоби. Чи тэдний төлөө эдгэх хэрэгтэй гэнэ.

Өдөр хоног үргэлжилсээр, үл хөдлөх нөхрөө угааж, хооллон, ярьж сургахаар оролдсож түүнийг зогсоо зайгүй магтан, бүгд түүнийг хүлээж байгаа гэж дахин давтан ярьж, оройд нь сонин сэтгүүлээс хайчилж авсан гэрэл зургийг нь үзүүлэх болов.

-Энд бид хатан хаантай байна. Энэ үдэшийг санаж байна уу? Тэд чамтай тун сүрхий мэндэлж байсан! Бүх юм эргэж ирнэ. Чи илүү их алдар хүндтэй болно.

Орой болсон хойно бүсгүй нөхрөө дулаан гэгч нь өлгийдөн хучаад дэргэд нь тавьсан буйдан дээр тэрий хадан унаад өгнө. Шөнө дунд тэсэхийн аргагүй үнэр танар ханхлан сэрээхэд нь тэрээр буйдангаас мөлхөх шахуу өндийн босон Тобиг хуурайлан даавуу шуувууг сольсоор байтал өглөөтэй золгон хоол ундыг бэлтгэх цаг болж дахин шинэ өдөр эхлэнэ. Маргааш, нөгөөдөр. . .Эцэс төгсгөлгүй өдрүүд ээлжилсээр. Жилл өдөр бүр Тобиг арай хүч шаардсан хөдөлгөөн хийлгэхийг оролдож мань эрийг "залхуурахад" уур нь хүрч алганы амт өгмөөр ч санагдана.

-Бид бүгдийг чадна. Чи эдгэнэ, хараарай хэмээн ууртайгаар исгэчүүлнэ.

Жилл тэнхээ тасартлаа ядарч, зарим шөнө унтаж чадахгүй нүдний нь өмнүүр хуучин киноны кадрууд хий үзэгдэл мэт сүүдэгнэж, эхлэнэ. Каннын кинофестивал дээр найруулагчид түүнийг, Тобиг тойрон хүрээлээд... Палм-Спрингсийн байшинд нь ерөнхийлөгч ирчихсэн, түүний үзэсгэлэн гоог. . . Шинэ кино нээлтэнд шүтэн бишрэгчид тойрчихоод... Алтан үе. . . Тобиг босон хотын дарга руу очих, уначихлаа... уначихлаа... Удтал хөрвөөсний дараа Жилл арай гэж дугхийнэ. Заримдаа шанаан тус газар тэсэхийн эцэсгүй лугшин өвдөж нойрноос нь сэрээнэ. Жилл заримдаа нар мандаж, босох хүртлээ өвдөхийг тэсвэрлэн таг дуугүй хэвтсээр. . .

Хатингаршсан бие сэтгэлийг асран тойлж, Тоби тэр хоёр эрт галавт мартагдсан сансрын хөлөгт хоёулхнаа амьдарч байгаа мэт болжээ. Жиллийн ертөнц нь гэр орны хүрээнд, энэ өрөөнд, энэ хүнээс хэтрэхээ больж, үүр цүүрээс үдэш болтол өөрийгөө хайрлахгүй зүтгэхдээ. Тоби нь зовж шаналан, тамд очиж, Жиллийг ганцаар орхихыг огт хүссэнгүй.

Тасралтгүй үргэлжлэх долоо хоногууд сар болон сунаж, өөр рүү нь дөхөн ирэх Жиллийг хараад Тоби түүнийг залхаахаар ирж буйг нь ойлгон уйлдаг болжээ.

Тоби арчаагүй сул дорой ямар ч хэрэггүй махан мануухай болсон хэдий ч Жилл нөхрийгөө харан туунд,

-Чи явж чадна хэмээн итгэл төрүүлнэ.

Тэрээр Тобиг өргөж хөл дээр нь зогсоогоод хөлийг нь нэг нэгээр ээлжлэн гишгүүлэн хөдөлгөх нь модоор хийсэн оньсон хүүхэлдэйг элзглэн жүжиглэж байгаа мэт аймшигтай харагдана.

Толгой таллан өвдөх нь улам ихсэн огцом хөдлөхөд чих нь шуугин, тархи толгой нь дүйнгэтэн нүдэнд нь оч гэрэлтэн өвчин нь тэсвэрлэхийн аргагүй болно. Жилл Тобиг илааршмагц заавал эмчээс зөвлөгөө авна гэж өөртөө андгайлжээ. Одоо үзүүлэх цаг нь ч биш, хүсэл ч алга. Хамгийн гол нь Тоби эдгэх хэрэгтэй.

Жилл хувцасны гол болтлоо турж эцэн, царай гэж цорой болон, шанааны яс нь ёрдойж, нүд нь гарихлан ширгэж, гайхалтай сайхан үс нь өнгө алдан бүрзийн бөөгнөрөн унжжээ. Энэ бүхэн түүнд огтын хамаа алга.

Хаалган доогуур нь Каплан эмчийн ярилцахыг хүссэн цахилгаан байсан ч гэлээ Тобиг угаах, бассейнд иллэг хийх, хэл яриаг нь зүгшрүүлэх, угааж, цэвэрлэх, хооллох, цагаан хэрэглэл солих гээд төлөвлөснөө гүйцэтгэх гээд завдсангүй.. .

Тэрээр дөрвөн хелтэй түшлэг худалдан авч, Тобигийн гарыг бэхлээд, өөрөө ядарч унатлаа, хаана юу хийж байгаагаа мэдэхгүй болтлоо гэр дотуураа холхиулан удтал явав.

Ингээд Жилл цөхрөн бүх юм талаар өнгөрч, яагаад ч нэмэр алга гэдгийг сая л ойлголоо.

Бүсгүй Тобиг шөнө дунд өрөөнд нь оруулаад өөрийнхөө унтлагын өрөө рүү хазганан орж орон дээр үхэтхийн унаж мансуурсан мэт нам унтаад гэнэт нойр ханан сэрж нүдээ нээвэл нар хэдийнэ дээр хөөрсөн байлаа. Үд дунд болчихсок Тоби хоол ундгүй, угааж цэвэрлээгүй, орондоо ганцаардан айж хэвтээ байх даа. Жилл босохыг хичээн өндийх гэтэл хөдөлж чадсангүй. Хэмжээлшгүй их ядарсан бие нь өөрт нь захирагдахаа нэгэнт больчихжээ. Долоо хоног, сар тэнхээ барсан хөдөлмөр, юм бүхэн...

Нөхөртөө зориулах тамир тэнхээ үлдсэнгүй, гомдож урам хугарсандаа уйлмаар ч санагдав. Ингээд бүх юм өнгөрчээ.

Жилл нэг л сонин авиа гарахыг сонсон нүдээ нээвэл үүдэнд нь дөрвөн хөлт түшлэгээ салганасан гараараа тас атгаад,

-Жи-и-и-и . . . Жи-и-и хэмээн Тоби сунжруулан дуугарч ганцаараа зогсож байх нь тэр.

Тэр "Жилл!" гэж хэлэхийг чармайж байлаа. Бүсгүй больё гэхнээ чадахгүй цорхиртол уйллаа. Энэ өдрөөс эхлэн Тобигийн бие үлгэрийн юм шиг хурдан эрүүлжин илааршиж эхлэв. Тоби Жиллийн төлөө урьдын адил эрүүл саруул болохыг хүсч байлаа. Тэр урьд нь эхнэрээ хайрладаг байсан бол одоо Жилл түүний сахиусан тэнгэр нь болж бүсгүйд мөргөн залбирмой.

Тоби түүнд хамгаас хэрэгтэй зэвсэг нь байсан тул Жилл эцсийн эцэст өөрийн хувь заяаны төлөө тэмцсэн нь энэ бизээ. Одоо тэдний бие сэтгэл, оюун ухаан нь нэгэн цул бие болжээ. Тобигийн амьдрал түүний гарт байж, Жилли түүнийг аврах бүхий л арга чаргаа хийсэн. Бүсгүй нөхрийнхөө алдсан жинг нь нөхөхийн тулд хоолны дэглэмийг өөрчлөв. Эхэн үедээ дөрвөн хөлт түшлэгээрээ, дараа нь таягтай нар салхинд удаан зугаалан явж хүч сэлбэсээр байлаа. Тоби ганцаар бие даан явж чадсан тэр өдөр тэд хоёр лаа асаан баярын зоог барьжээ.

Ингээд Жилл Тобиг бусдад үзүүлэх цаг нь болсон хэмээн үзээд Каплан эмч рүү залгавал сувилагч бүсгүй түүнийг эмчтэйгээ даруй холболоо.

-Жилл! Би их санаа зовлоо! Хэд хэдэн удаа утасдаад хэн ч утсаа авахгүй юм. Цахилгаан утас явуулсан, хариу ирсэнгүй, тэгээд таныг Тобиг аваад хаа нэг тийшээ явжээ хэмээн бодлоо. Тэр... тэр яаж байна?

-Өөрөө хүрч ирээд хар даа, Эл ээ. Эмч ирээд гайхсанаа нууж чадсангүй, -Байж боломгүй юм. Ёстой . . . ид шид! гэж шагшрав. -Жинхэнэ ид шид ч энэ дээ.

"Энэ амьдралд хүн өөрөө гайхамшигийг бүтээнэ. Бурхан тэртээ тэргүй үргэлж завгүй байдаг хойно доо" хэмээн Жилл бодов.

-Хүмүүс над руу Тоби эдгэж байна уу гэж байнга утасддаг. Та нар хүн хүлээж авахгүй байгаа юм уу? Сэм долоо хоногт хоёр удаа, Клифтон Лоренс...

Жилл Лоренсын тухай таг мартажээ. Гэвч Уинтерс! Энэ ч муугүй! Жилл Тоби урьдын адил супер-од, тэд Алтан хос гэдгийг түмэнд мэдүүлэх арга сүвэгчлэх хэрэгтэй болжээ.

Маргааш өглөө нь тэрээр Сэмд утасдан Тобиг эргэж ирж чадах эсэхийг нь асуулаа. Цагийн дараа гэхэд Сэм үүдэнд нь ирчихсэн Жилл түүнийг довжоон дээр тосч авахад, Сэм хүүхнийг хараад гайхсанаа нууж чадсангүй. Тэр цонхийн ядарч, турж эцээд, нүүр нь үрчлээнд баригдаж, хамаг яс нь хэрзгэнэн ёрдойж даруй арван насаар өтөлсөн байлаа.

-Сэм ээ! Ирсэнд тань баярлалаа. Тоби чамайг хараад баярлах болно гэлээ.

Сэм орондоо хэвтэх жүжигчний сүгтэй учрах юм бодтол гайхалтай сонин гэнэтийн . . . Тоби усан сангийн дэргэд ширдэг дээр хэвтэж байснаа Сэмийг хараад өндийлөө. Гар барин мэндлэхэд эр хүний хүдэр чийрэг чадал мэдрэгдэв. Тоби нар салхинд борогшин борлож эрүүлжин өвдөхөөсөө өмнө байснаасаа илүү харагдаж байв.

-Сэм, чамтай уулзсандаа баяртай байна.

Тобигийн ярих нь бага зэрэг удаан, хүндрэлтэй байсан ч гэлээ тод хурц сонсогдоно. Өвчний ул мөр үл мэдрэгдэн өнөөх л гялалзсан хөх нүдэт, хүүхдийн царай нь хэвээр болжээ.

Сэм Тобиг тэвэрч аван,

-Бурхан минь! Чи бид бүгдийг их айлгалаа! гэлээ.

Тоби инээмсэглэн,

-Бид хоёулхнаа байна, битгий есорхоод бай! Бурхан минь, энэ ч дэндэнэ ээ? Намайг зүгээр л Тоби гээрэй гэв.

Сэм түүнийг анхааралтай харснаа толгой сэгсчин,

-Үнэнийг хэлэхэд юу ч ойлгохгүй юм. Илүү залуучихаж гээч! Голливуд чамайг хэдийнэ оршуулчихсан! гэлээ.

-Намайг үхсэн хойно л тэгж үзээрэй.

-Ёстой гайхамшиг! Өнөөгийн анагаах ухаан ч мөнхийн ус хүртээдэг болоо юу?

-Юуных нь анагаах ухаан! гээд Тоби хайрлан тахиснаа нуулгүй Жиллийг ширтээд,

-Хэн үүнийг бүтээснийг мэдэх үү? Жилл шүү дээ. Ганцхан тэр л чадсан. Энэ гараараа! Бүгдийг хөсөрт орхин намайг хөл дээр минь босголоо гэв.

Сэм цочирдон гайхсан харцаар Жиллийг ширтэв. Мань эр түүнийг өөрийгөө ийнхүү золиослож чадна гэж огт бодсонгүй. Тэгэхээр энэ бүсгүйг дэмий нэг буруушааж байжээ.

-За тэгээд юу хийе гэж байна даа? гэж асуугаад,

-Мэдээж амрах уу? гэв.

-Тоби тайзан дээрээ эргэж очих санаатай байгаа хэмээн Жилл хажуунаас нь оролцоод,

-Тэр дэндүү хөдөлмөрч мөн авьяаслаг тул зүгээр суумааргүй байгаа юм гэв.

-Жиллийн зөв гэж Тоби зөвшөөрөв.

-Сэм чамд ямар нэг санал хэлж болох юм биш үү? хэмээн Жилл томоохон акул барихаар дэгээ шидлээ.

Тэд хоёулаа Уинтерсээс нүд салгалгүй ширтэхэд нь Сэм Тобид дэмий горьдлого төрүүлэн, тээнэгэлзүүлэхийг огт хүссэнгүй. Кино эхлэхийн өмнө жүжигчид, гол дүрийн жүжигчид бүгд даатгуулсан байх ёстой. Нэг ч даатгалын компани Тоби Темплтэй гэрээ байгуулахыг хүсэхгүй.

-Одоохондоо хэлэх юм алга хэмээн Сэм хариулаад,

-Боломжийн санал гарвал даруй мэдэгдэнэ гэлээ.

-Бидэнтэй ажиллахаас айж байна уу? гэж Сэмийн бодлыг уншив уу гэлтэй Жилл еозгүй асуув.

-За хаанаас даа!

Сэмийн худал хэлж байгааг тэр хоёр хоёулаа мэджээ. Голливудын хэн ч Тобид ажил өгч зүрхлэхгүй нь мэдээж. Тоби, Жилл хоер телевизээр залуу хошин шог жүжигчидийн тоглолтыг үзэж суулаа

-Ээ, нохойн баас! гэж Тоби тургиснаа,

-Чэтгөр ав, түүний оронд би байсан ч болоосой. Хотоор гүйж, тохиролцох агент олох хэрэгтэй юм болов уу? гэлээ.

-Үгүй гэж Жилл ширүүхэн дуугараад,

-Өөрийгөө наймаалцахыг хэнд ч бүү зөвшөөр! Ялихгүй юмаар хөөцөлдөх хэрэггүй. Чи бол Тоби Темпл! Тэд өөрсдөө чам дээр ирэг! гэжээ.

-Хэн нэгэн нь хаалга түлхэн орж ирэхийг харахгүй л байна, хүүхэлдэй минь гэж Тоби хүйтнээр жуумалзав.

-Ирэх болно! Чиний төлөө тулалдах болно хэмээн Жилл итгэлгээр хэлснээ,

-Тэд чамайг хараагүй л байгаа! Чи урьдынхаасаа илүү сайхан харагдаж байгаа. Надад чадал бий гэдгийг тэдэнд үзүүлэх хэрэгтэй.

-Порно сэтгүүлийн нүүрэнд гаргахаар шалдан зураг авахуулж болох юм биш үү?

Эл үгс Жиллийн чихний гадуур өнгөрлөө.

-Надад нэг санаа байна. Ганцаарчилсан шоу хий.

-Юу?!

-Ганцаарчилсан шоу гэх Жиллийн дуунд сэтгэл хөөрсөн аяс сонсогдов.

-Би чамд Хантингстоны театрт тоглох эрх авч өгье. Голливудынхан бүгд хушуурна. Тэд хаалга цөмлөн орж ирцгээнэ, чи хараарай!

Тэр шоунд нь нөлөө бүхий эрх дархтангууд, найруулагч, продюссор, кино од, шүүмжлэгчид гээд Голливудын ихэнх нь иржээ. Бүтэн сарын өмнө Байн стритэд билетыг нь заржээ. Тоби Жилл хобрын суусан лимузин үүдэнд нь хүрч ирэхэд сэтгэл нь хөөрсөн шүтэн бишрэгчид нь машиныг нь тойрон бүчив. Тоби өөрсдийнхөө дунд иржээ! Үхэгдсдийн ертөнцөөс эргэн ирсэнд нь түүнийг ихэд хүндлэх ажгуу.

Жилл шоуны хөтөлбэрийг бие даан зохиож, О'Хэнлон, Рейнжер нар хотынхны амьдаар нь оршуулсан хүний тухай гайхалтай текст бичиж, Жилл ганц хүнд зориулан хэзээ ч тусгай зохиол бүтээж байгаагүй яруу найрагч, хөгжмийн зохиолчийг олоод,

-Тоби таныг энэ дэлхийн цорын ганц. . . хэмээн магтав.

Шоуг тавихаар Лондоноос алдарт найруулагч Дик Лэндри нисч иржээ.

Жилл Тобид туслуулахаар авьяаслаг хүмүүсийг цуглуулан урьсан ч гэлээ шоуны үр дүн нь үзэгчдийн хамт ганцаар үлдэх Тобигоос өөрөөс нь ихээхэн шалтгаалах ёстой билээ.

Гэрэл алгуурхан асаж хөшиг нээгдэхэд театр тэр чигээрээ ид шидийг гуйн сүмд мөргөл

үйлдэн залбирах мэт нам гүм ноёрхов.

Тоби Темпл эрч хүчтэй алхлан наранд борлосон хүүхдийн царайндаа нүүр дүүрэн инээмсэглэл тодруулсаар гарч ирэхэд чив чимээгүй байснаа хүмүүс гэнэт суудлаасаа босон хүндэтгэж таван минутын турш нижигнэсэн алга ташилт. бархираан их салхи мэт долгиолоход театрын хана чичирүүлэх шиг боллоо.

Тоби үзэгчдийг чимээгүй болохыг хүлээн тайзан дээр зогсож байгаад тэднийг нам жим болоход,

-Та нар үүнийгээ мэндчилгээ хэмээн хэлэх үү? гэж ёжтой асуув.

Дахиад баясан бахадсан хүмүүс бархирч эхлэв. Тэр үүх түүх ярин хошигнож, бүжиглэж яг урьдын адил гайхалтай байлаа. Үзэгчид Тобиг тайзнаас буулгахыг хүссэнгүй. Тэр амьд домог болон мөнхөрсөн супер од хэвээрээ байлаа. Маргаашийн "Вэрайти" сонинд,

"Тэд Тоби Темплийг оршуулахаар очоод түүнтэй учран золгож, агуу жүжигчинг магтан бахдахаар үлдэцгээжээ. Тэр тэдний хундлэлийг хүлээх гавьяатай. Шоу бизнесийн хүрээнд Тоби Темплтэй эн зэрэгцэх хүн үгүй! Энэ үдэш театр үзэхийн амтыг мэдэрсэн алга ташилт нижигнэсэн хэзээ ч үл мартагдах шоу байлаа!" гэж бичжээ.

"Голливудын сурвалжлага" гэдэг сонинд: "Үзэгчид Тоби Темплийн эргэн ирснийг үзэхээр очсон гэтэл Тоби Темпл хаашаа ч яваагүй гэдгээ батлан харууллаа" гэсэн байв. Бусад сонингуудад Тобигийн авьяасыг бахдан дуулжээ. Энэ өдрөөс эхлэн гэрийн утас нь зогсоо чөлөөгүй хангинаж. өдөр бүр хэдэн театр. . . клуб. . . казинод тоглохыг хүссэн олон арван захиа цахилгаан ирэх болов.

Агентын тухай хэлсэн Жиллийн үг биелэлээ олж, өөрсдөө Тобигийн үүдийг тогших нь тэр ээ.

Тэрээр Чикаго, Вашингтон, Нью-Йоркод тоглолт хийн итгэж боломгүй амжилтанд хүрчээ. Үзэгчид урьдынхаас илүүтэйгээр сонирхож, кино театрын эзэд сэтгэл нь уяран хуучин киног нь дэлгэцнээ дахин амь оруулан гаргаж, телестудийнхэн "Тоби Темплийн долоо хоног" хэмээх нэвтрүүлэгийг хөтөлбөртөө оруулан түүний шоуны бичлэгийг үзүүлэх болов.

"Тоби Темпл" гэсэн хүүхэлдэй, тоглоом, үгийн сүлжээ, онигооны цуглуулга, тэр ч бүү хэл, түүний зураг бүхий марк хүртэл худалдаанд гарав. Кофе, тамхи, шүдний ооны хайрцаг дээр түүний нэр харагдах болжээ. Телестудиуд агуу хошин шогчийн тоглолтыг долоо хоногт нэг удаа үзүүлэх эрхийн төлөө зодол-зодолдоцгоох болов. Тобигийн алдарын наран оройд нь мандаж, түүний цацрагийн гэрэл гэгээ Жилл дээр тусан гэрэлтүүлнэ.

Дахиад л хүлээн авалт, үдэшлэг, сенатор, хаалттай тоглолт. Тэд одоо бүгдэд хэрэгтэй болж ерөнхийлөгч цагаан ордонд зоогт урив. Хаа сайгүй Алтан хос Тоби, Жилл хоёрыг баяртайгаар угтана. Эдэнд тохиолдсон гайхамшигийг сурвалжлагчид зууны хайр дурлалын роман хэмээн тунхаглажээ. "Таймс" сэтгүүл гэр бүлийн зургийг нүүрэндээ гарган, нэгэн сурвалжлагч Жиллийн амь биеэ хайрлалгүй халамжилсан хайрыг нь магтан дуулжээ.

Тоби таван сая доллараар телестудитэй гэрээ байгуулав. Гурван сарын дараа есөн сард долоо хоног тутмын шоу эхлэх болжээ.

-Палм-Спрингс явья, чи амрах хэрэгтэй гэж Жилл санал гаргахад Тоби толгой сэгсрэн,

-Чи цоожтой хаалганы цаана дэндүү удаан суулаа гээдэхнэрээ тэврэн авч,

-Сонсдоо хөө, би гоё сайхан ярьж чадахгүй байна, тайзан дээр доог элэглэл хийж зогсохдоо, юу мэдрэгддэгийг хэлж чадахгүй нь ээ, гэвч. . . надад итгээрэй, . . .чи үүнийг мэдэсэй . . . гэж хүсэх. . . Чамтай учрахаасаа өмнө би амьдарч яваагүй юм байна гэснээ нүдэнд нь нулимс цийлэгнээд ирэхэд Жиллийг анзаарч амжаагүй байхад нь цааш эргэн харлаа.

Тоби Лондон, Парижид, хамгийн гол нь Москвад тоглолтоо хийн Америк даяар алдараа цуурайтуулсан шигээ Европыг байлдан дагуулахаар шийджээ.

Тоби "Жилл" дарвуулт хөлөг дээр шинэ шоу товлон байгаа О, Хэнлон, Рейнжер тэргүүтэй зохиолчидын баг, Сэм Уинтерс гээд олон зочдыг урьжээ. Тэд танхимд суун хөзөр тоглон, ууж наргин, ярилцацгаана. Жилл гэнэт Тобигийн алга байхыг анзааран тавцан руу гарвал Тоби бариулаас барин тэнгис ширтэн зогсож байв. Жилл түүнд ойртон очлоо.

-Бие чинь яаж байна?

-Зүгээр ээ, ус харж зогссож байна.

-Бүх юм сайхан байна, тийм үү?

-Тийм ээ! Би үхэхийг хүсэхгүй байна! Живж үхэхээс дандаа айдагсан гээд агдасхийн татганав.

Жилл гараас нь барьж,

-Чамайг юу зовоогоод байна гэсэнд,

-Зүгээр л би үхэхийг хүсэхгүй байна. Тэнд дээр тэнгэрт их аймшигтай болов уу? Энд би их хүн, бүхний танил Тоби Темпл. Авсанд орохоор яах бол? Би тамын тухай юу гэж боддогийг мэдэх үү? Үзэгчид үгүй, хов хоосон орчин гэжээ.

"Файорс" клуб хүндэт зочин Тоби Темплийг ирсэнийг нь тохиолдуулан зоог барьлаа. Ширээний ард Жилл, Тоби, хошин жүжгийн нилээд хэдэн жүжигчид, Сэм Уинтерс, Тобитой гэрээ хийж буй телестудийн захирлууд байр эзлэн суужээ.

Ёслолын сайд шөнийн телешоуг нээн үг хэллээ

-Тобитой энд дахин уулзаж байгаадаа хэрхэн баярласнаа илэрхийлж чадахгүй нь гэж эхлээд,

-Тэрээр "Форестлонд" хооллохоор явсан бол яах билээ? гэсэнд,

Хүмүүс инээлдэв.

-Тэнд ой гутмаар хоолтой гэдэгт итгэ! Та "Форестлон"-д орж байсан уу? Тэнд өчигдрийн хоносон хоолоо өгдөг гэсэн гэхэд,

Бас л тачигнатал инээх сонсогдов.

-Тоби бид чамаар бахархдаг, энэ бидний чин үнэн үг шүү. Таны биеийн нэгэн хэсгийг шинжлэх ухааны зорилгоор өргөл барихыг гуйсан гэж сонслоо. Энэ хэсгийг тань бумбанд хийгээд Гарвардийн эмнэлгийн коллежид тавих гэтэл тохирох бумба олдохгүй бүгд багадаад зовоож байна гэсэн гэвэл бас л бүгд уухайлан хашгиралдацгаав.

Тоби өөрийн хурц уран үгээрээ хариу цохилт өгөхөөр өндийлөө. "Файорс" клубт болсон цэнгүүнээс илүү сайхан баяр наадам байгаа гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч билээ.

Үзэгчдийн дунд гал зуухны хувьцаа заалны тэртээ мухарт шалихгүй нэгэн хүмүүсийн дунд Клифтон Лоренс сууж байв. Тоби Лоренсыг халснаас хойш агент эр имнүүлсэн мал шиг бүхний нүдэнд илхэн азгүй нэгэн болжээ. Тэр томоохон агентлагт орох гэсэн боловч үйлчлүүлэгч үгүй Лоренс хэрхэх билээ! Клифтон жижгэвтэр агентлагийн үүдээр эргэлдэвч насанд дарагдсан өтөл хүн хэнд хэрэгтэй байх вэ, бүгд л нас залуу цус шингэн хүнийг авах хүсэлтэй ажээ. Эрсний эцэст Клифтон нэгэн шинэ, жижигхэн агентлагт орж чаджээ. Одоо түүний долоо хоногийн цалин пүнлүү нь урьд нэгэн цагт Клифтоны тансаг ресторанд нэг орой зарж байсан мөнгөтэй тэнцэх болжээ.

Мань эр ажилд орсон эхний өдрөө эргэн санав. Агентлагийн эзэд нь гуч ч хүрээгүй жийнсэн өмд өмсөж, хөлдөө холхигносон пүүз өмссөн сахалтай хөвгүүд түүнийг эрхэм өвөө минь гэж нэрлэж дуудна. Тэд өөр хоорондоо Клифтонд үл ойлгогдох хэлээр ярина, тэрний үйлчлүүлэгчид нь рок-одод байжээ.

Энэ харчуулын дэргэд Клифтон дэндүү өтөлснөө мэдрэн, энэ хотод хязгааргүй ямба эдлэж байснаа санахаас цорхиртол уйлмаар санагдана.

Урьдын хөгжилтэй, цовоо цолгиун хүн гонсойн гундсан харагдана. Темпл түүний амьдралын утга учир байжээ. Тэрээр Тобитой өнгөрөөсөн цаг мөчөөс өөр юу ч бодож чадахаа болжээ. Бас Жиллийн тухай! Тэрээр өнгөрсөн бүх явдалд зөвхөн Жиллийг буруутгана. Энэ муу садар янхан гичий, Тобиг бүхний эсрэг турхируулсан. Клифтон түүнийг үнэн голоосоо үзэн ядна

Танхимын буланд суугаад хүмүүс Жилл Темплд алга ташин байхыг харж суусан Клифтоны хажууд суусан нэгэн эр,

-Хүний сүг Тоби жинхэнэ азтай эр юмаа. Энэ хүүхнийг нэг амтлаад үзэхсэн! Орон дотроо үзэж тарж, үсэрч наалддаг хүүхэн байна билээ? гэхэд,

-Хөөх, тийм үү! Чи хаанаас мэдээ вэ? гэж хэн нэг нь эрээ цээргүй асуухад,

-"Пуссикет тиэтр"-т порнокинон дээр харсан. Нэгэн залуугийн шим шүүсийг ч ёстой нэг ховх сорж байна билээ!

Клифтоны хоолой ам нь гэнэт хатан хэлээ арай чамай эвлүүлэн хөдөлгөж,

-Аа.. . та итгэлтэй байна уу? . . . Энэ Жилл Касл мөн байсан уу? гэж асуув.

-Тэгэлгүй яахав, бүрэн итгэлтэй байна. Гэхдээ өөр нэрээр байсан. Жозефина. . . санадаггүй ээ. Нэг л мангар польш нэр байсан юм гэснээ тэрээр Клифтоныг ширтсэнээ,

-Хөөе! Та чинь арай Клифтон Лоренс биш биз? гэж асуужээ.

Сант-Моникагийн цэцэрлэгт гудамжнаас зургаан хорооллын тэртээ порнокино гаргадаг дөрвөн кинотеатр, үйлчлүүлэгч нь тусгай өрөөнд орон порно кино үзэж болохоос гадна арваад массажны салонд хагас шалдан бүсгүйчүүл мэдээж массажнаас бусад үйлчилгээ хийдэг нэгэн үйлчилгээний төвийн бага шиг зайд нь "Пуссикет тиэтр" байрладаг аж.

Харанхуй зааланд бүсгүй хүн хөтөлсөн хоёрыг эс тооцвол эрчүүд голдуу хориод үзэгчид байлаа.

Кино эхлэхэд Клифтон бүгдийг умартан дэлгэц дээрх үйл явдлыг шимтэн үзвэл залуу багш эр, царайлаг, гоолиг биетэй ор хөнжлийн ажилд юу ч чаддаггүй оюутнуудын тухай гарах аж.

Гэвч энэ кинонд Жилл гарсангүй. Тэр энд байх л ёстой! Клифтон хийсэн бүхнийх нь төлөө түүнээс хариугаа авах цорын ганц алтан боломж нь энэ! Тэр Тобиг кино үзүүлэхээр урина. Зүрхэнд нь хүндхэн цохилт болно доо, гэвч тэр амьдрана аа! Ингээд хэнтэй гэрлэснээ мэдмэгц өөдгүй янханг гэрээсээ шууд хөөх болно.

Гэнэт бүсгүй дэлгэц дээр гарч ирэх нь тэр. Тэрээр залуу туранхай үзэсгэлэнтэй, Жилл яг мөн байлаа. Клифтон дэлгэцнээс нүд салгалгүй ширтэнэ. Кино дуусахад "Жозефина

Цински" гэсэн нэр дэлгэц дээр тодхон үзэгдэв. Клифтон огло харайн босч кино механикчийн бүхээг рүү харайн орвол бяцхан тасалгааны буланд нэгэн эр морин уралдааны сэтгүүл уншиж сууснаа,

-Хөөе, анд минь, ийшээ орж болохгүй гэв.

-Би энэ киноны хуулбарыг авмаар байна гэвэл,

-Худалдахгүй гээд нөгөө эр толгойгоо сэгсчин уншиж буй ном руугаа толгой шаав.

-Сонсооч хөө. Хоёр зуун ногоон өгье. Хэн ч мэдэхгүй.

Нөгөө эр хөдөлсөн ч үгүй.

-Хоёр зуу.

Кино механикч хуудсаар эргүүлсээр,

-Гурваар!

-Бэлнээр үү?

-Бэлнээр.

Маргааш өглөө нь Клифтон Тоби Темплийнд ирлээ. Тэрээр сугандаа хайрцагтай кино сугавчилжээ. Үгүй, тэсрэх бодис сугавчилж! Жилл Каслыг газрын хөрснөөс арчихад хангалттай баримт.

Орд харшийн үүдийг Клифтоны урьд өмнө үзээгүй англи эр нээж өгөв.

-Ноён Темплд Клифтон Лоренс ирчихээд түүнтэй уулзая гэж байна гээд хэлээч.

-Өршөөгөөрэй, эрхэм ээ, ноён Темпл эзгүй байгаа.

-Би хүлээнэ гэж Клифтон хатуу чанд мэдэгдэв.

-Энэ боломжгүй л болов уу гээд хаалгач толгой сэгсрэн,

-Ноён, хатагтай Темпл өнөө өглөө Европ орохоор мордсон гэлээ.

Бүлэг 32.

Европоор аяласан тоглолт нь ялгуусан ялалт, баяр бахдалаар дүүрэн байлаа. Лондонгийн шөнийн тоглолтод агуу жүжигчин, эхнэр хоёрыг харахыг хүссэн хүмүүс талбайд пиг дүүрэн цугларчээ. Аржил-стритийн эргэн тойронд нь цагдаагийн хамгаалалт гарч хатан хааны гэр бүлийнхэн морилон ирэв. Тобиг хошигноход үзэгчид инээн хөгжиж, тэрээр хэн нэгнийг гомдоохыг хүссэнгүй.

Парижийн амжилт илүү нижгэр болж алга ташилт чих дөжрөм нижигнэнэ. Жилл, Тоби хоёр ерөнхийлөгчийн ордонд байрлан, ерөнхийлөгчийн лимузинг хөлөглөн хотоор аялав. Өдөр бүрийн сонины эхний нүүрэнд тэдний гэрэл зураг гарч театрт ирэхэд нь цагдаагийн нэмэлт хүч хамгаалж байлаа.

Тоглолтын дараа театрын дарга Тоби, Жилл хоёрыг лимузинд хүргэж өгөхөд тэсэн ядсан шүтэн бишрэгчид нь цагдаагийн хамгаалалтыг сэтлэн дайрч,

-Тоби! Тоби! Энэ Тоби байна! хэмээн бархиран авьяаслаг жүжигчин түүний гайхамшигтай эхнэрийн толгой дээгүүр үзэг, дэвтэр сарвайн дайрцгаалаа.

Цагдаагийнхан хүмүүсийг зогсоож хүчирсэнгүй, тэд дурсгал болгон авахаар Тобигийн хувцасыг урж тасдан тэдэн рүү халджээ.

Аялалынхаа эцэст тэд Москвад айлчлах үлдэв. Зургаан сарын Москва хот дэлхийн хамгийн сайхан хотуудын нэг ажээ. Гоолиг урт цагаан хус, тансаг цэцэгсээр чимэглэсэн өргөн цэцэрлэгт гудамжаар зуны наранд баясан жаргах жуулчид, уугуул иргэд дүүрэн холхилдоно.

Жуулчдын улирал ид явагдаж Оросын жуулчдын "Интурист" агентлагынхан алдар цуутай зочдоо олон улсын нисэх онгоцны Шерметьево буудалаас угтан авч "зил" маркийн лимузингээр зөвхөн нэрт хүмүүст буудаллдаг "Метрополь" зочид буудалд аваачина.

Намын томоохон түшмэл генерал Юрий Романов зочидтойгоо танилцахаар буудалд биечлэн иржээ.

-Бидэнд америк кино үзэх завшаан тун ховор олдох юм, ноён Темпл, гэвч таны киног Орос орон даяар тун сайн мэднэ Үнэндээ алдар суут урлагт хил хязгаар гэж байхгүй л дээ.

Тоби эстрадын театрт гурван концерт тоглохоор төлөвлөсөн бөгөөд нээлтийн тоглолтонд Тоби, Жилл хоёрыг алга ташилтаар угтжээ. Хэл ус нэвтрэлцэхгүй тул Тоби үггүй жүжиглээд, тоглолтын төгсгөлийн үгийг арай ядан оросоор хэлбэл энэ нь үзэгчдийг ихэд хөгжөөн театрыг ёстой нэг доргиох шиг болжээ.

Генерал Романов Тоби, Жилл хоёрыг хоёр өдрийн турш Горькийн цэцэрлэгт хүрээлэн, Москвагийн цирк, Пушкиний музей, Лениний бунхан, "Хүүхдийн их дэлгүүр"-ээр оруулан "Арагви" ресторанд улаан түрс, пирожки, шорлогоор зоог барьжээ.

Сүүлийн концерт тоглох өдөр Жилл дэлгүүр хэсэхийг хүсвэл Тоби татгалзан,

-Хүүхэлдэй минь , ганцаараа яв. Би жаахан амрая гэв.

Жилл нөхрийгөө харан,

-Чи зүгээр үү? гэвэл,

-За зүгээр дээ, чи яав. Жаахан ядарчээ. Яваад бүх Москваг худалдаж аваад ир гэв.

Тоби нэг л барагтайхан харагдсанд Жилл тээнэгэлзжээ. Аялан тоглолтоо дуусмагч сайтар амрах ёстой юм шүү.

-За яахав. Дуг хийгээд ав гээд бүсгүй ганцаар явахыг зөвшөөрчээ.

Жилл гарах хаалга чиглэн хүлээлгийн танхимаар гарч явтал ардхан талд нь,

-Жозефина! гэж түүнийг дуудах сонсогдов.

Эргэн харж завдахаасаа өмнө энэ хэн болохыг бүсгүй мэдэж хорвоо ертөнц ид шидийн өнгөөр гялалзах шиг боллоо.

Инээмсэглэн зогсох Дэвид Кеньон түүнтэй уулзан,

-Чамтай уулзсандаа их баяртай байна гэж тэр шивнэхэд Жиллийн зүрх хариугүй зогсох нь уу гэлтэй догдлов.

-Надтай хундага юм уух уу? гэж Дэвид асуув.

Жилл таг дуугүй толгой дохилоо.

Том зочид буудлын бааранд хүн ихтэй байсан ч тэд тайван нам жим газар ширээ олон тухаллаа.

-Москвад юу хийж байгаа юм бэ? гэж Жиллийг асуувал,

-Засгийн газрын хүсэлтээр. Нефть худалдах гэрээнд гарын үсэг зурах ажилтай явна гэв.

Ядарсан үйлчлэгч дөхөж ирэн захиалга авав.

-Сисси сайн уу?

Дэвид мөрөө хавчин,

-Бид хэдэн жилийн өмнө салсан гэснээ ярианы сэдвээ өөрчлөн,

-Би чиний тухай бүгдийг сонсож мэдсэн. Хар багаасаа Тоби Темплийн шүтэн бишрэгч явлаа.

Яагаад ч юм Тоби гэнэт өтөлж ядарсан хөгшин мэт Жиллд санагдаад явчихлаа.

-Түүнийг эрүүл саруул болсонд тун баяртай байна. Түүний өвдсөнийг сонсоод чамд их санаа зовлоо хэмээх Дэвидийн харцанд уйтгар үзэгдэв.

-Тоби Лондонд, Голливудад гайхалтай байсан шүү хэмээн үргэлжлүүлбэл,

-Чи . . . үзээ юу? гэж Жилл гайхан асуув.

-Тийм ээ, Би тэнд ажилтай явсан юм.

-Яагаад ирж уулзсангүй вэ?

Дэвид түгдчин,

-Улиг болохыг хүсээгүй юм. Чи уулзахыг хүсэхгүй байвал би чинь яах билээ гэлээ.

Үйлчлэгч тэдний захиалга хундагатай дарс авчирч еглөө.

-Чиний төлөө, Тобигийн төлөө гэх Дэвидийн үгэнд цөхөрч гутарсан өнгө тодров.

-Чи үргэлж "Метрополь-д буудаг уу? гэж Жилл асуув.

-Үгүй. Үнэнийг хэлэхэд би их хэцүү... гэснээ Дэвид урхи тавьсныг нь дэндүү хожимдон ухаарснаа мушийн инээж,

-Би чамайг энд бууна гэж мэдсэн юм. Тав хоногийн өмнө явчих байсан л даа. Би чамтай уулзана гэж найдаж хүлээсэн юм.

-Яах гэж тэр вэ, Дэвид?

Тэр хэсэг чимээгүй суулаа.

-Мэдээж, дэндүү хожимдсон ч гэлээ би бүгдийг тайлбарлая, чи бүх үнэнийг мэдэх ёстой.

Ингээд тэр хэрхэн хууртагдаж гэр бүлийн урхинд орон Сисситэй гзрлэснээ, Жиллтэй нуурын дэргэд уулзана гэсэн тэр шөнө эхнэр нь амиа хорлохыг оролдсон тухай...

Зогсоо чөлөөгүй урсах үгийг сонссоод, Дэвидийн үнэн сэтгэлд эргэлзэх зүйл байсангүй. -Би үргэлж чамд хайртай...

Бүсгүй Дэвидийг сонсон чимээгүй суун амтат дарс мэт аз жаргал зүрхийг нь бүлээцүүлэн, салж сэрэмгүй сайхан зүүд биелж байгаа мэт, түүний бүхэл амьдралынхаа турш хүссэн хүсэл биелэх шиг боллоо. Жилл өмнөөс нь харан суугаа эрийг харан тэсгэлгүй хүсэлд автан, илэн таалсан гарыг, хүдэр чийрэг биеийг эргэн дурслаа. Гэвч Тоби түүний бие сэтгэлийн нэгэн хэсэг болж, харин Дэвид...

-Хатагтай Темпл! Бид таныг газар сайгүй эрлээ, гэх хэн нэгний дуу гарахад эргэн харвал генерал Романов зогсож байлаа. Жилл Дэвид руу хараад, -Өглөө утасдаарай гэв.

Сүүлийн тоглолт урд урьдынхаас илүү болж үзэгчид тайз руу цэцэг шидэн, исгэрэлдэж, хөлөөрөө шал дэвслэн байсан нь Европоор аяласан тоглолтыг нь илүүтэй чимжээ. Тоглолтын дараа тусгай цайллага болох ёстой байтал Тоби Жиллд,

-Би хөл дээрээ тогтож чадахгүй нээ, бурхан минь! Чи ганцаараа явчих? Би зочид буудалдаа очоод түр амсхийе гэсэнд Жилл ганцаар цайллаганд явж цаг үргэлж Дэвидтэй уулзан ярилцаж байснаа дурсан суулаа.

"Би Сисситэй хүчээр гэрлэсэн юм шүү. Сисси бид хоёр аль эрт салцгаасан. Би үргэлж чамд хайртай..."

Цайллаганаас шөнийн хоёр цагт Жилл буцаж ирээд, өрөөндөө ортол баруун гар нь утас руу чиглүүлсэн маягтай, шалан дээр ухаангүй хэвгэх Тобиг олжээ.

"Түргэн тусламж"-ийн тэрэг Тобиг дипломат корпусын эмнэлэгт аваачив. Шилдэг мэргэжилтнүүд зөвлөлгөөн хийхээр дуудагдаж ерөнхий эмч Жиллийг тусгай өрөөнд оруулаад гарч явлаа.

"Урьд нь яг ийм юм болсон". Урьдын тэр зовлон зүдгүүрт аймшиг нь гэнэт бодогдон хүйтэн цуст могой биеийг ороох шиг боллоо. Жилл хэдэн цагийн турш хар дарсан зүүдэнд авган өнгөрүүлжээ. Гэнэт үүд нээгдэн оёдол муутай костюмтай, ус түгээгч шиг харагдах нэгэн бүдүүн тагжгар эр орж ирлээ.

-Би доктор Дуров гэдэг хүн байна. Таны нөхрийн эмчлэгч эмч гэж өөрийгөө танилцуулав.

-Тэр яаж байгааг би мэдмээр байна.

-Та суугаач, хатагтай Темпл.

Жилл хэдийдээ харайн боссоноо мэдсэнгүй.

-Надад хэлээч!

-Таны нөхөр цус харваж, өөрөөр хэлбэл церебральновенозын тромбоз болжээ.

-Тэр чинь амь насанд нь аюултай юу?

-Тийм гэж айж байна. Хэрэв тэрээр амьд гарвал, хэзээ ч явж, ярьж чадахгүй болно байх. Тархи нь гэмтэж, танай нөхөр саад дайруулчихжээ.

Дэвид Москвагаас явахын өмнө Жилл рүү утасдан,

-Чамд юу гэж хэлэхээ мэдэхгүй ч гэсэн чамд би байгаа шүү, хэрэг болбол дуудаарай гэдгийг хэлмээр байна. Би бүгдийг хийнэ гэлээ.

Нүхээ алдсан оготно шиг хэрхэхээ мэдэхээ байсан Жиллийн ухаан самуурч байхад энэ тухай

бодох ч сөгөө алга.

"Түргэн тусламж"-аар нисэх буудал руу хүрч, онгоцонд эмнэлгийн дамнуургатай, эмч нар. . . зовлонгийн гинжин хэлхээ үргэлжлэх ажээ.

Тобиг харсан Жилл энэ удаагийн дайрлага түрүүчийнхээс огт өөр болохыг ойлголоо.

Түүний зүрх нь цохилон, дотор эрхтэнүүд нь ажиллаж байгаагаас биш биед нь тариур, гуурсыг антен шиг зоон, амьтай голтой байлгахын тулд үргэлж дусал залгуулсан, нүүр царай нь маасагнан инээж байгаа цамын аймшигтай багтай адил болж, мурийсан талын уруул нь цоровдлогдон буйл нь цухуйн ердөө л амьдын төдий хүүр болон хувирчээ. Эмчлэгч орос эмч эдгэрэх найдлага үгүй болсныг түүнд хэлсэн.

Гэртээ ирсэн даруйдаа Жилл Каплан эмч рүү утасдвал мэргэжилтнүүд зөвлөлдөхөөр цугларч, бүгд эдгэрэх найдлага үгүй гэдгийг нэгэн дуугаар зөвшөөрчээ. Энэ нь нилээд хэдэн хоногийн өмнө тэднийг Москвад байхад болжээ.

Тобиг хорин дөрвөн цагийн туршид асарч сувилан, иллэг массаж хийх нь зөвхөн хүнлэг чанарын үүднээс хийж байгаа нь энэ.

Өдөр ирэх тутам Тоби улам дордон арьс нь шаргалтан, үс нь туг тугаараа хагдран унаж, хөдлөх мэдрэлгүй болсон гар нь үрчийж хатингаршина. Ийнхүү үхэж байгааг харж тэсвэрлэхэд тун бэрх байлаа. Хатингар царайд нь хоёр цэнхэр нүд нь л урьдын адил амьд гялалзана. Мянган бурхан тойруулаад ч босч ирэхээс өнгөрсөн хар амины төлөө тэд хамаг хүчээ тарамдахыг энэ хоёр нүд нь хараад: Тэд юу хүсээв? Дахин аврах гээ юу? Яриулж сургах нь уу? Явуулах гэж оролдох нь уу? Хүн болгох нь уу? хэмээн уйтгартайгаар залбиран гуйх мэт дагуулан харна.

Бүсгүй түүнийг харан дуу шуу ч үгүй бодол болон сууна.

"Тал бие минь зовж шаналан хэвтэж байна..."

Тэд мөнхөд холбоотой.

Жилли Тобиг, өөрийгөө аврахын төлөө бүхнийг өгсөн, гэвч энэ удаад сэхэл авахгүй нь бололтой.

Найз нөхөд нь харамсан гашуудаж тайтгаруулж, . . . утас зогсоо зайгүй хангинана.

Жилл зөвхөн ганцхан дуудлага хүлээж байтал Дэвид утасдав.

-Би чамайг хүлээж байна. Би чадах бүхнээ хийхэд бэлэн гэдгийг чамайг мэдэхийг хүсч. . .

Жилл өндөр, царайлаг сайхан түүнийг төсөөлөн бодоод зэргэлдээ өрөөнд хэвтээ эрэмдэг болсон нөхрийнхөө тухай бодлоо.

-Баярлалаа, Дэвид. Би мэдэж байна, одоохондоо юу ч нэмэр алга, юу ч хэрэггүй.

-Хьюстонд сайн эмч нар бий. Бүр дэлхийн шилдэгүүд. Би тэднийг аваачиж чадна шүү.

Жиллийн хоолой нь зангираад ирэхийг мэдэрлээ. Тэрээр Дэвидийг хүрч ирээд өвчин тахалд баригдсан уйтгар газраас аваад яваач гэж гуймаар санагдавч, чадсангүй. Бүсгүй Тобигоос салахын эцэсгүй гагнагдаж, хэзээ ч нөхрөө орхиж чадахгүй гэдгийгээ мэдлээ.

Амьд байсан цагт нь.

Каплан эмч үзлэгээ дуусгатал номын санд хүлээж сууж байсан Жилл эмчийг хараад бүсгүй ухасхийн босоход нь, Эли Каплан болхидуухан хошигнох аядаж,

-За тэгэхээр, Жилл ээ, би танд сайн, муу хоёр мэдээ дуулгая гэж бөвөгнөв.

-Алив муугаас нь эхлээдэх.

-Тобигийн мэдрэлийн систем хэвийн байдалдаа эргэж орохгүй нь бололтой. Харамсалтай нь энэ удаад дээрдэхгүй нь дэг ээ. Тэрбээр хэзээ ч явж, ярьж чадахгүй.

Жилл түүнийг удтал ширтсэнээ,

-Харин сайн мэдээ нь? хэмээвэл,

Каплан эмч инээмсэглээд,

-Тобигийн зүрх гайхалтай эрүүл юм. Асарч тордоод байвал тэрбээр дахиад хорин жил өлхөн амьдарна шүү гэжээ.

Жилл чихэндээ ч итгэж чадахгүй эмчийг гайхан ширтсээр байлаа. Хорин жил гэнээ! Нөгөө сайхан мэдээ нь энэ үү?!

Тэрээр энэ аймшигт амьтантай өчнөөн олон жилийн туршид зовж талчлан өнгөрөөхөөс өөр гарц байхгүй болсныг төсөөлөн бодов. Амьд байгаа цагт нь Тобигоос сална гэдэг байж боломгүй зүйл. Бүх юм, Дэвид Кенъеон ч өнгөрлөө хэмээн бодов.

Дэвид өдөр бүр утасдан түүний харамгүй их хайр, үнэнч шударга занг нь Жилл гайхан шагшиж, ямар нэг мэдрэмж тэднийг холбоод байгааг хоёулаа мэдэж байлаа.

"Тобиг үхэхээр..." гэсэн далд санаа тархинд нь эргэлдэнэ.

Бүлэг 33.

Жижүүрийн гурван сувилагч ээлжлэн Тобиг асран, яг робот аятай бүгдийг ягштал нямбай гүйцэтгэнэ. Жилл энэ удаад Тобиг асарч сувилах гэж зүдэрсэнгүйдээ тэдэнд их талархаж, түүний өрөөнд орохоос аль болох шалтаг хайн зугтаж байв. Ой гутам зэвүүтэй маасалзан инээх цамын баг бүсгүйд жигшүүр төрүүлэх болжээ. Жилл биеэ албадан хичээсээр нөхөр дээрээ ороход царай нь тэр даруй хувьсхийхийг сувилагч нар анзаарчээ. Жиллийг өрөөнд нь орж очиход түүний гүн цэнхэр нүд нь сэргэн гялалзана. Жилл Тобигийн бодлыг тов тодорхой уншиж чаддаг болжээ.

Хэрэв тэр үг хэлж чадаж байгаасан бол,

-Намайг бүү үхүүлээч. Надад туслаач! Туслаач гэж байгаа нь илт.

Жилл эрэмдэг нөхрөө харан зогсож, "Би чамд юугаар ч туслаж чадахгүй. Чи өөрөө ингэж амьдарч байгаадаа харамсахгүй. Би үхэхийг чинь хүсээд байна" гэж бодлоо.

Сонины хуудаснаа эдгэршгүй өвчинд нэрвэгдэн зовлон эдлэгч, хэн нэгний гэрг бүлийн хөөрхийлэлтэй зовлонгоос ангижирсан тухай үүх түүх олонтоо гардагсан. Тэр ч бүү хэл заримдаа ийм өвчтөндөө үхэхэд нь тусласнаа үнэнээр хүлээн зөвшөөрсөн эмч нарийн тухай ч сонсогдож байсан. Үүнийг эвтанази буюу нигүүлсэнгүй аллага гэж нэрлэдэг аж. Хараал идсэн хоёр цэхэр нүднээс өөр амьд гэхийн шинжгүй болсон Тоби өөрийг нь үргэлж цөхрөлтгүй гуйн ширтэхийг хараад аллага бол үргэлж аллага байх болно гэдгийг Жилл ойлгож байв.

Тэр гэрээсээ хушуугаа ч цухуйлгахаа болин ихэнх цагаа унтлагынхаа өрөөнд цоожтой өнгөрөөх болов. Толгойн өвчин нь дахин сэдэрч, тэрээр хэрхэн анагаах учраа олж ядна.

* * *

Сонин сэтгүүлүүдэд саад дайруулсан хөөрхий жүжигчин нэгэн удаа Тобиг амьдралд эргүүлэн авчирсан түүний үнэнч эхнэрийн тухай зүрх өвдөм нийтлэл хэвлэгдэн гарчээ. Бүх хэвлэлүүд Жилл өөрийнхөө гавьяаг дахин давтаж чадах болов уу хэмээн таамаглацгаана. Гэвч тийм ид шид үгүй, Тобиг дахин хуучин хэвэндээ орохгүй гэдгийг зөвхөн Жилл л мэдэж байв.

Каплан эмч өвчтөн нь хорин жил амьдарна гэдэгт итгэлтэй байгаа. Дэвид яах болж байна? Энэ хар гяндангаас зугатах арга хайх хэрэгтэй.

Энэ бүхэн нэгэн уйтгартай ням гаригт болсон юм. Өглөөнөөс эхлэн бүхэл өдөржин бороо шаагин орж, байшингийн дээвэр, цонхыг нэгэн хэмээр бөмбөрдөх нь Жиллийг галзууруулах шахна. Чихэнд чийртэй пижигнэхийг үл анзаарахыг хичээн Жилл өрөөндөө ном уншиж суутал шөнийн жижүүр орж ирлээ. Цардсан халаад өмссөн Ингрид Жонсон хүйтэн, тоомжиргүй дуугаар,

-Дээд өрөөний халаалт ажиллахгүй байна! гээд,

-Би гал тогоо орж ноён Темплд идэх юм бэлтгэе. Та түүний дэргэд хэдэн минут сууж байхгүй юу? гэлээ.

Жилл түүний хоолойд үл ойшоосон өнгө илт цухалзахыг мэдэрчээ. Эхнэр нь эрэмдэг нөхөр дээрээ орохгүй байгаа нь тэр бүсгүйд ер бусын хачирхалтай санагдаж байгаа бололтой.

-Тэгье ээ гээд Жилл номоо орхин Тобигийн өрөө рүү явлаа.

Хамарт нь танил шинхэгний үнэр ханхийж агшин зуур нөхрөө аврахаар чармайж байсан аймшигтай урт сарууд гэнэт санаанд нь орж ирэв.

Тоби өндөр дэрэн дээр хагас хэвтээ байдалтай хэвтэж байв. Жиллийг хармагц гэнэт нүд нь амь орон гялалзаж, "Чи хаана байв аа? Яагаад ийм удаан ирсэнгүй вэ? Чи надад хэрэгтэй байна. Туслаач? хэмээн ярьж гарлаа.

Энэ нүд яг л дуугарах хоолойтой юм шиг! Жилл жигшүүртэй зэрэмдэг, үхлийн инээд шүглэсэн багийг хараад огиудас нь хүрчээ.

"Чамайг хараал идэг! Чи хэзээ ч, хэзээ ч босохгүй. Чи үхнэ! Би чамайг мажийгаасай гэж хүсч байна!". хэмээн хашгирчээ.

Жиллийг хараад Тобигийн нүдний илэрхийлэл еөрчлөгдөн итгэж ядан цочирдсоноо, аажмаар үзэн ядалт, өс хонзон болон хувирчээ.

Бүсгүй сандран арөөнөөс гарч явлаа.

Маргааш өглаө нь бороо намджээ. Зоориноос Тобигийн тэргэнцрийн оруулж ирэв. Өдрийн сувилагч Фрэнсис Гордон түүнийг наранд суулгахаар цэцэрлэг рүү авч явах нь бололтой. Жилл тэргэнцрийн хяхтнах дуу гарч цахилгаан шат руу явж байхыг нь сонсоод хэдэн минут хүлээснээ доош буун номын сангийн дэргэдүүр явтал гэнэт утас дуугарах сонсогдов. Энэ Дэвид байлаа.

-Чи өнөөдөр ямар байна? гэж тэрээр маш эелдэг асуув.

Жилл анх удаа түүний дууг сонсоод туйлын их баярлажээ.

-Би сайн байна, Дэвид минь!

-Би дэргэд чинь байхсан гэж хүсэх юм, хайрт минь.

-Би ч гэсэн. Би чамд хайртай! Чамайг хүсч байна! Чамайг надыг тэврээсэй гэж хүсч байна. Өө Дэвид...

Зөн совинт зургаадах мэдрэхүй нь Жиллийг эргэн харуулахад хүргэв.

Тоби тэргэнцэртэйгээ сувилагчийн хаашаа ч юм явахдаа орхисон тэр газарт, гудманд яг хаалганы дэргэд байж байлаа. Цэнхэр нүд нь Жиллийг жигшин зэвүүцэн харцаар цоргин

харна. Түүний хацар дундуур нь тас буулгаад авсантай адил халуу оргив. Хоёр цэхэр нүд нь ярьж, хашгирч, түүнийг хүйс тэмтэрнэ гэж заналхийлж байв. Жилл сандран харилцуураа тавиад өрөөнөөс гарч хар хурдаараа дээш гүйн гарах зуур Тобигийн үзэн ядалт түүний араас мөшгөн хөөхийг мэдэрсээр. Тэрээр бүх л өдрийн турш унтлагын өрөөнөөс гарч чадахгүй хоол унд ч идэхгүй аймшигт мөчийг бодон бодсоор буйдан сандалд шигдэн таг дуугүй сууна.

Тоби сонсчихлоо, мэдчихлээ. Бүсгүй түүний нүүрийг дахин харж чадахгүй боллоо.

Зургадугаар сарын дунд үе, хэдийнэ шөнө болсон ч гадаа халуун агаар дүүгэнэ. Жилл сэрүүцэхээр цонхоо цэлийтэл нээлээ. Тобигийн өрөөнд Гэллахер сувилагч жижүүрлэж байв. Сувилагч өлмий дээрээ сэм гэтэн орны дэргэд очин өвчтөнөө харав. Хөөрхийлөлтэй амьтн ганц үг дуугарч чадахгүй байгаа нь ямар харамсалтай вэ! Бүсгүй Тобиг сайн гэгч нь ороон хучаад,

-Унтахыг бод! Би жаахан азнаж байгаад эргэж ирнээ гэж баясгалантайгаар өгүүлсэнд, Мань эр ямар ч хариу өгсөнгүй, тэр ч бүү хэл нүдээ ч нээсэнгүй.

"Эсвэл би түүнийг ойлгохгүй байсан ч дээр юм уу" гэж сувилагч бодоод өвчтөнөө дахин нэг харснаа телевиз үзэхээр зочдын бяцхан өрөө рүү оров. Гэллахер сувилагч од гаригийн тухай нэвтрүүлэгт үнэнхүү хорхойтдог ажээ. Бүсгүй өвчтөндөө саад болохгүйн тулд дууг нь намсгав.

Тоби Темплийн ухаан санаа тэртээ тэргүй алсын алсад байгаа тул сонсоно гэдэг юу л бол доо.

Байшин тэр чигээрээ гүн нойронд авган нам гүм болж, Сансетын цэцэрлэгт гудамжны хөдөлгөөн нь бүдэг бадаг сонсогдоно. Сувилагч сувгаар кино үзэж суув. Хэдхэн футын зайнд хананы цаана хэвтэж байгаа агуу жүжигчин Тоби Темпл кино үзэхгүй байгаа нь ямар харамсалтай юм бэ.

Өглөөний дөрвөн цагийн үед сувилагч аймшигийн киноны ид дунд нь үүрэглэж эхлэв.

Тобигийн өрөөнд үхээрийн нам гүм ноёрхжээ.

Жиллийн өрөөнд шөнийн ширээн дээрх цаг чанга чанга цохилоно. Жилл чармай шалдан, дэрээ тэврэн нам унтахад нь гудамжны дуу чимээ огт үл сонсогдоно.

Жилл яраглан эргэж хөрвөөв. Тэрээр Дэвидтэй Аляск руу хуримын аялалаар явж байснаа асар уудам хөлдүү талд гэнэт цасан шуурганд өртжээ. Хүйтэн жавар хацар нүүрийг нь нүдэж амьсгалахад бэрх боллоо. Бүсгүй Дэвид рүү эргэн харвал тэр алга болж, Жилл ганцаараа цасан цөлд орхигдон, хаашаа явахаа мэдэхгүй болчихов.

Хэн нэгний хүндээр амьсгаадах аймшигтай хягтнах хүржигнэх

сонсогдон сэрээлээ. Жилл нүдээ нээвэл өнөөх дуу түүний өөрийнх нь цээжнээс гарч байв. Хоолой нь зангирч, ой гутам хөнжлөөр хучив уу гэлтэй хүйтэн агаар түүнийг нөмрөн авч,

нүцгэн биеийг нь, хөхийг нь илэн, уруул дээр нь үнсэн хүйтэн өмхий амьсгалаар утна. Зүрх нь галзуутай цохилон, уушиг нь хүйтэнд царцах шиг болов.

Жилл өндийн суухыг оролдсон боловч үл үзэгдэх хүнд зүйл хөдөлж болохооргүй дарах ажээ. Энэ нь аймшигт зүүд гэдгийг мэдсэн боловч өнөөх хүржигнээн дахин сонсогдож, жаахан ч гэлээ амьсгалахыг оролдов. Тэр үхэж байна. Энэ аймшиг түүний үхлийн шалтгаан юм гэж үү? Мөсөн тэмтрүүл биеэр нь хэсүүчлэн явсаар цавины завсраар нь зүтгэлэн бяцхан ангал руу шурган орж, түүнийг чинэрүүлэн дүүргэхэд энэ Тоби мөн болохыг ойлголоо. Тоби гэж үү дээ! Тоби хаанаас яагаад гарч ирсэн нь үл ойлгогдоно.

Жиллийг нөмөрсөн мөсөн аймшиг нь үхэлтэй тэмцэх тэнхэл нэмэн үүд рүү хэрхэн харайн очсоноо санасангүй, гагцхүү эргэн тойронд нь хүйт даан бүсгүйгээс зууралдан байгааг мэдэрчээ. Хаалганы бариулыг базан авч эргүүлэхэд үүд дэлгэгдэж бүсгүй гудамд гүйн гараад цээж дүүрэн амьсгаа авлаа.

Гудамд дулаахан, нам тайван байх ажээ. Жилл бие нь салганан дайвалзаж, шүд нь тачигнан чичирсээр хэсэг зогссоод бие нь тавиран тайвширч өрөө рүүгээ харвал тэнд ер бусын юм үзэгдсэнгүй. Тэгэхээр энэ нь зүүд байсан байх нь. Жилл хэсэг тээнэгэлзсэнээ өрөөндөө эргэж орвол өрөө нь бас л дулаахан, айх юм байсангүй. Тэгэлгүй яахав дээ! Тоби ийшээ хүрч ирж чадахгүй. Сувилагч Гэллахэр нойрноосоо сэрэнгүүтээ өвчтөнөө эргэхээр яаравчлан ухасхийлээ. Тоби хучиж орхисон тэр янзаар тааз руу, юу ч үгүй хоосон, юу ч үл ойлгогдох юмыг ширтэн хэвтэж байв.

Энэ аймшиг нь дахин давтагдаж Жиллийг ихэд цочирдуулав. Тэргэнцрийн дугуй хяхтнуулсаар сувилагч түүнийг авч яваад гарсан хойно Тобигийн өрөө рүү ойртон очиход хүртэл ялгаа үгүй тэр газар сайгүй нуугдан түүнийг хүлээж байгаа нь мэдрэгдэнэ.

Түүний толгойн өвчин нь зовоон дийлдэхээ байж, шанаанд нь нэгэн хэмээр лугшин амар заяа үзүүлэхээ болилоо. Жилл өвчин нь нэг цаг, нэг минут, нэгэн хором ч гэхнээ намдахыг залбиран гуйна.

Тэр түр ч атугай дуг хийх хэрэгтэй!

Жилл Тобигоос аль болох хол байхыг хичээн гал зуухны дэргэдэх үйлчлэгчийн өрөөнд оров. Бяцхан тасалгаа дулаахан, нам гүм, их тохьтой санагдан Жилл орон дээр хэвтэнгүүт нам унтаад өгчээ.

Өнөөх мөс шиг хүйтэн агаар уушгийг нь дүүргэн, цагаан өмсгөл мэт түүнийг өлгийдөн авч жихүүдэс оргин цочин сэрлээ. Жилл орноосоо үсрэн босч, дээшээ гүйв.

Өдөр нь айдас хүйдэстэй өнгөрөхөд, шөнө нь бүр ч дордон зүйрлэхийн эцэсгүй аймшигтай зовиур болон хувирна.

Хар дарсан зүүд мэт нэг л янзын юм үргэлж давтагдах болжээ. Жилл унтлагын өрөөндөө орон Тоби гарцаагүй ирнэ гэдгийг мэдрэн зүүд нойртойгоо тэмцэн орондоо цагираглан хэвлээ. Гэвч ядарсан тархи нь захирагдсангүй, зүүрмэглэж эхлэв.

Дахиад хүйт оргин түүнийг сэрээж Жилл дагжтал чичирч хөнжлөөрөө биеэ ороовол өнөөх хараал идсэн хүйтэн амьсгаа гэтэн айсуй нь мэдэрэгдэв.

Шөнийн гурван цаг болж байхад Жилл ном барьсан чигтээ буйдан дээр унтаад өгчээ. Бүсгүй зүүдлэн аажмаар хөвж эхлэх шиг болон нүдээ нээвэл өрөө пад харанхуй байлаа. Энд нэг л учир байна даа! Бүсгүй хоромхон зуур, ном уншиж суухад гэрэл асаатай унтсанаа саналаа. Гэвч айгаад байх юу байхав, Гэллахер сувилагч орж ирээд гэрэл унтраагаа биз.

Гэнэт гудмаас нэг л хачин чимээ гарахыг Жилл сонслоо. Чахрах-чахрах-чахрах... Тэргэнцэрийн дуу! Тобигийн тэргэнцэр унтлагын өрөө рүү дөхөж явна. Жиллийн ар нуруугаар хүйт даагаад ирлээ. Үгүй-үгүй, энэ ердөө л модны мөчир дээвэр балбаж байна, эсвэл байшин сууж байгаа нь тэр! Гэтэл дотор хүн нь энэ худлаа гэдгийг хэлээд байлаа.

Бүсгүй энэ дуу хоолойг дэндүү олон удаа сонссон.

Чахрах-хяхтнах... яг л түүнийг авахаар ирж буй үхлийн хөгжим гэлтэй. Энэ бол Тоби байх ёсгүй тэр чинь зэрэмдэг болсон хүн шүү дээ! Бүсгүй ухаан солиорчээ. Хяхтнах чимээ улам ойртон хаалганд дөхөж ирлээ. Хэсэг хүлээзнэн чимээгүй болов. Ямар нэг юм уналаа... тар няр хийн тачигналаа... дараа нь нам гүм . . .

Шөнийн үлдсэн хугасыг Жилл буйдан сандал дээр хөдөлж чадахгүй айн дагжсаар өнгөрөөв.

Өглөө бүсгүй гудам дахь ширээн дээр байсан цэцгийн шилэн сав унаж, хагарсан байхыг олж харжээ.

Каплан эмчийг дуудах хэрэгтэй юм.

-Оюун ухаан нь биеэ удирдаж чаддаг талаар юу гэж бодож байна? хэмээн Жилл түүнээс асуув.

Эмч түүнийг эргэлзсэн янзтай хараад,

-Чухам ямар утгаар тэр вэ? гэлээ.

-Хэрэв Тоби орноосоо босохыг тун их хүсвэл. . .

-Ганцаараа юу? Хүний тусламжгүйгээр үү? Биеийн байдал нь ийм байхад уу? гэж эмч итгэлгэлгүйхэн асуугаад,

-Яагаад ч боломжгүй. Эрэмдэг хүн шүү дээ гэлээ.

Гэвч үүнд нь Жилл итгэсэнгүй.

-Хэрэв. . . хэрэв хамаг хүчээ шавхан босохыг оролдвол хэрвээ ямар нэг юм хийнэ гэж төлөвлөх юм бол

Каплан эмч толгой сэгсрэн,

-Мэдээж, тархи биеэ захирна л даа, гэвч булчингийн систем

сааталд орсон бол энэ командыг хийж чадахгүй, энэ нь

яагаад ч үйлчлэхгүй гэлээ.

-Та тархины хүчээр объект хөдөлж чадна гэдэгт итгэхгүй байна гэжүү? хэмээн Жилл өөрийнхөөрөө зүтгэв.

-Сэтгэл судлалын талаас нь уу? Мэдээж энэ талаар олон

туршилт хийгдэж байгаа ч гэсэн багтай нотолгоог хэн ч одоохондоо гаргаж чадаагүй л байгаа.

Гэхдээ үүдний дэргэд шалан дээр хагарсан савны хэлтэрхийнүүд байгаа.

Жилл мөс мэт хүйтэн агаар, тэргэнцэрийн хяхтнаа гээд бүгдийг нь эмчид яримаар санагдавч гэнэт түүнийг галзуурч гэж бодох вий гэхээс айлаа. Гэвч энэ нь үнэхээр ч юм билүү? Тэр үнэхээр өвдөж, ухаан нь самуураад байна уу?

Каплан эмчийг явсны хойно Жилл толинд өөрийгөө хараад мэл гайхав. Цонхийж цайсан царай, ёрдойсон шанаа, хоёр бүлтгэр нүд л харагдана. Эпэ янзаараа байвал тэр Тобигийн урд орох болох нь.

Жилл өнгө алдан сэгсийсэн туг үсээ, үетэн хугарсан хумсаа харлаа. Дэвид минь намайг ийм байдалтай байхыг харвал юу болох вэ? Үгүй дээ, өөрийгөө арчилж, өөд татах хэрэгтэй.

Жилл өнөөдрөөс эхлэн долоо хоногтоо нэг удаа гоо сайханд орж, өдөрт гурван удаа, орой нь найман цагт унтаж байхаар өөртөө тангараг тавьж, ам өчиг өглөө.

Маргааш өглөө нь Жилл гоо сайхны салон орохоор явжээ. Ядарсан бүсгүй үсээ хатаалгахаар суусан даруйдаа зүүрмэглэж өнөөх аймшиг нь дахин эхлэх нь тэр ээ. Бүсгүй орондоо. .. унтаж байна. Хяхтнах дуу сонсогдож, тэр аажим босон түүнд дөхөн ирээд хэрцгийгээр инээн, ясан савраараа хоолойг нь базлаа.

Жилл чангаар бархиран сэрж тэндхийн үйлчлүүлэгчдийг айлгаж орхиод, мөнгөө ч төлөлгуй гудамжинд гүйн гарлаа.

Эл болсон аймшигт явдлаас хойш Жилл гадуур гарахаас, гэртээ байхаасаа хүртэл үнхэлцгээ хагартал айх болов.

Жилл нэг давхар руу яах гэж бууснаа, гал тогоо руу юу авахаар орсноо ор тас мартдаг болжээ. Ой ухаан нь түүгээр даажигнаж эхлэв. Нэгэн удаа Гордон сувилагч түүнтэй юм ярихад Жилл энэ эмэгтэй энд юу хийж байгаа билээ хэмээн гайхан ширтэснээ гэнэт хэн болохыг нь санажээ. Найруулагч зургийн талбайд Жиллийг хүлээн зогсоно.

Бүсгүй өөрийн үгээ давтан,

-Дээрдэхгүй болов уу гэж айх юм эмч ээ гээд үгээ амандаа бувгнаснаа найруулагчтай хэрхэн тоглохоо зөвлөх гэтэл...

Нэг хачин эмэгтэй гараас нь барин,

-Хатагтай Темпл! Хатагтай Темпл! Таны бие муу байна уу? гэлээ.

Жилл өнгөрсөн үеэс одоо үед эргэн ирсэн мэт санагдаж, нэг л өөр ертөнцөд байгаа мэт санагдлаа. Тархи толгойгоо үзүүлэн, Тоби хий үзэгдэл аятай үнэхээр энд тэндгүй яван түүнийг айлган алахыг оролдож байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй байлаа.

Тийм ээ түүнийг шалгах хэрэгтэй!

Жилл урт гудмаар Тобигийн унтлагын өрөө рүү явлаа. Хэсэг зуур зоригоо чангалан зогссоноо үүд нээн оров. Тоби урьдын адил орондоо хэвтэж, сувилагч түүнийг нойтон хөвөнгөөр арчиж суув. Бүсгүй Жиллийг харснаа,

-Өө, хатагтай Темпл үү, та юу? Манай өвчтөн ямар сайн байгааг хараач! гэлээ.

Жилл хөдөлгөөнгүй биеийг сонжин харлаа.

Тобигийн хөл гар нь үрчийж хатингаршиж, араг яснаас санжигнах нь хуурай мөчир мэт сэрдийж, хоёр гуян завсар нь хэрэгцээгүй болсон том эрхтэн нь үхсэн могой мэт гулдайн унжжээ. Арьсны шаранга нь арай гайгүй харагдавч нүүрэнд нь нөгөө зэвүү хүргэсэн инээд хэвээрээ байлаа. Бие нь үхэж, харин энэ нүд! Нүд нь амьд, ууртайгаар гялалзан үзэн ядан ярихад Жилл түүний үг бүхнийг ойлгож байв. Эмч Тобигийн ухаан гэмтээгүй гэсэн. Хөдөлж чадахгүй, эрэмдэг хүн бодож, мэдэрч үзэн ядаж, өшөө авалт сэдэж, Жиллийг хөнөөх арга

хайж чадна. Ер нь сүүлдээ Тоби түүнийг хөнөөхийг, бүсгүй нөхрийнхөө үхлийг хүсэх болжээ.

Бүсгүйн үзэн ядалт түүнд хүнд цохилт болж, жигшил дүүрэн харцнаас нь: "Чи харж байгаарай, би чамайг алах..." гэсэн үгийг олж сонслоо.

Жилл хобр цэнхэр нүдийг дахин нэг хараад хагарсан цэцгийн савыг эргэн санаж, түүний амссан аймшиг нь зүүд биш байсныг ойлгожээ.

Үхлийн тулаанд тэдний хэн нэг нь ялах болно.

Бүлэг 34.

Каплан эмч Тобиг үзэж дуусаад Жиллтэй уулзахаар очлоо.

-Усан санд иллэг хийх хэрэггүй гэж бодож байна. Цагаа дэмий үрэхийн нэмэр. Би Тобигийн булчин шөрмөс нь бага ч болов чангарна гэж бодсон юм, гэвч нэмэр алга. Би физик эмчилгээний эмчтэй уулзанаа.

-Хэрэггүй! гэж Жилл дуу алдан бархирлаа.

Каплан эмч гайхан толгой өндийлгөн хараад,

-Жилл ээ, та Тобигийн төлөө их юм хийснийг би мэднэ. Гэвч энэ удаад ямар ч найдвар байхгүй. Би...

-Бид бууж өгөхгүй! Бууж өгөхгүй... гэх Жиллийн дуунд цөхөрсөн өнгө илрэв.

Каплан эмч эргэлзэн мөрөө хавчаад,

-За яахав, энэ таны хувьд тийм чухал.. .

-Тун чухал.

Жилл үнэнээ хэлжээ. Түүний амьдралын тухай асуудал яригдаж байгаа болохоор үүнээс илүү чухал гэж юу байх вэ? Жилл юу хийх ёстойгоо ойлгожээ.

Маргааш нь Дэвид утасдан Мадрид руу ажлаар явах болсноо дуулгажээ.

-Хоёр гурав хоногтоо чамтай ярьж чадахгүй л болов уу?

-Би чамайг санана. Тун их санана гэж Жилл шивнэв.

-Би ч гэсэн. Чи өвдөө юу? Дуу чинь нэг л хачин байх чинь. Ядраа юу?

Жилл өөрийн эрхгүй анилдах нүдээ нээх, тэсвэрлэхийн аргагүй толгойн өвчнөө мартаж гэж бие ихэд хүчлэн байлаа. Хамгийн сүүлд хэзээ унтаж, хэдийд хооллосноо санасангүй, зогсох тэнхэлгүй болтлоо сульдаж чангахан ярьж чадахгүй байв.

-Би зүгээр ээ, Дэвид. Би чамд хайртай. Ямар нэг юм болбол, миний хайрын тухай санаж яваарай.

Жилл ойртон ирж яваа машины дууг сонсов. Физик эмчилгээний эмч ирж яваа бололтой. Жилл яаран салах ёс гүйцэтгэчихээд доош гүйвэл шанаан тус газар нь лугшин өвдөж хөл нь нугарчих шахлаа. Бүсгүй эмчийг хонх дарах тэр агшинд үүд нээлээ.

-Өглөөний мэнд, хатагтай Темпл хэмээн эмч эр мэндлээд дотогш орохоор зүтгэхэд нь Жилл замд нь хөндөлдөв.

Эмч түүнийг гайхан ширтэхэд,

-Каплан эмч хойшид усан дотор иллэг хийх хэрэггүй гэсэн хэмээн Жилл хэлэв.

Залуу эрийн царай барайлаа. Тэгэхээр наашаа дэмий ирсэн байх нь! Урьдчилаад сануулчихаж болохгүй байсан юм байх даа?! Тэрээр ийм үед эрээлэх юмгүй дургүйцлээ илэрхийлдэг ч гэсэн хатагтай Темпл ер бусын азгүй эмэгтэй тул,

-Зүгээр ээ, хатагтай Темпл, би ойлгож байна гээд толгой мэхэсхийн машин руугаа эргэн явлаа.

Жилл моторын дуу холдон явахыг хүлээж байгаад дээш гарлаа. Гэнэт толгой нь эргэн шатны хашлагаас зууран авч намдтал нь хэсэг зогслоо. Түүнд буцах нүүдэл байхгүй, хэрэв эргэж буцвал тэрээр өөрөө үхэх болно.

Жилл Тобигийн өрөөний үүдэнд очин бариулыг эргүүлэн хаалга нээн орвол Гэллахер сувилагч хатгамал хатган сууж байснаа хөмсгөө өргөн Жиллийг гайхан харлаа.

-Хөөе, хөө! Биднийг эргэхээр ирээ юу! Ямар аятайхан хэрэг вэ! Ноён Темпл их баярлана даа. Тийм үү, ноён Темпл ээ?

Дэр тойруулан түшүүлж оронд нь шомбойтол суулгасан Тоби Жиллийг гөлийн ширтэх нь,

"Би чамайг ална, заавал ална!" гэж сануулж байх шиг.

Жилл сувилагч руу явж очин,

-Би нөхөртөө дэндүү бага цаг зарж байна гэж бодлоо гэв.

-Би ч гэсэн тэгж бодож байна гэж сувилагч жонгиноод,

-Гэвч таны өвдсөнийг хараад, өөртөө. . .гэлээ.

-Одоо миний бие сайжирсан хэмээн үгийг нь таслаж,

-Би ноён Темплтэй ганцаар үлдэхийг хүсч байна гэлээ.

Сувилагч хатгамалаа хумин аваад бослоо.

-Тэгэлгүй яах вэ гээд тэрээр толгой дохиод,

-Энэ түүнд тун хэрэгтэй гэдэгт би итгэлтэй байна. Тийм үү, ноён Темпл ээ! Хатагтай Темпл би гал тогоо орж аяга цай ууя.

-Хэрэггүй. Би таныг өнөөдөр эртхэн явуулах гэсэн юм. Гордон сувилагчийг хүлээхийн хэрэггүй гээд Жилл сэтгэлийг нь засан инээмсэглээд,

-Санаа бүү зов, би түүнтэй хамт байна гэв.

-Гэвч... мэдээж... дэлгүүр хоршоогоор ороход муугүй...

-Зүйтэй, тун сайн байна. Цагаа сайхан өнгөрөөхийг хүсье.

Жилл гадаа хаалга дуугаран, машины дуу гартал хөдөлгөөнгүй зогслоо. Бүх юм нам гүм болмогц бүсгүй Тоби руу эргэн харав. Амьдын төдий нөхөр нь Жиллийг нүд цавчилгүй гярхай гэгч нь ширтэнэ. Тэрээр дөхөж очин хөнжлийг нь хуу татахад хагас амьтай, хавирга нь хэрзийсэн араг яс байхыг харлаа.

Тобиг суулгахаар буланд байх тэргэнцэрийг ор руу дөхүүлэн тавиад, нөхөр рүүгээ гар сунган сарвайснаа хүрч зүрхэлсэнгүй. Түүнээс хэсэгхэн зайтай мушийн инээх хатингар хүний баг мангуу хүний инээд тодруулан, хурц нүднээс нь өш хонзон хорсолтойгоор цацрана. Жилл бөхийн хамаг хүчээ шавхан байж Тобиг өргөв. Тэр дэрс мэт хөнгөн байсан ч гэлээ турж эцсэн Жиллийн хувьд хэрээс нь хэтэрсэн хүнд ачаа байжээ. Жилл Тобид хүрмэгц мөсөн агаар түүнийг бүрхэн авахыг мэдэрлээ.

Шанаа нь хүчтэй лугшин, нүдний нь өмнүүр өнгө өнгийн толбо бүжиглэн хөвөөд толгой нь эргэлээ. Бүсгүй ухаан алдаж байгаагаа мэдэрсэн ч гэлээ ингэж болохгүй, Жилл хамаг хүчээ шавхан байж тэргэнцэрт суулгаад бүсийг нь бүслээд цагаа харвал ердөө л хорин минут үлджээ.

Жилл тоормосыг нь мултлаад Тобиг гудмаар түрсээр цахилгаан шат руу явав. Бүсгүй Тобигийн нүдэнд харагдахгүйг хичээн ард талд нь зогссон ч гэлээ түүний хилэнт харцыг мэдэрсээр. Гэнэт хүйтэн өмхий агаар уушгийг нь дүүргээд, хоолой руу нь огшин амьсгаа давчдаад ирэхэд нь тэр өвдөг сөхрөн унаад амаараа агаар ховдоглон амьсгалаж, бачуу цахилгаан шатанд дотор нь муухайран огиудасаа арай ядан барилаа. Өрөвдөх сэтгэлгүй аймшигтай тэмтрүүл шиг юм тэмтрэхэд, цахилгаан шатны хаалга нээгдэв.

Бүсгүй гадагш гаран сөхөрч суугаад цэвэр агаар амьсгалан жаал хэвтвэл бие нь гайгүй боллоо. Дараа нь цахилгаан шат руу эргэн очвол Тоби таг дуугүй, түүнээс нүд салгалгүй ширтэн хөдөлгөөнгүй суух ажээ.

Жилл тэргэнцэрийг цахилгаан шатнаас гарган усан санг чиглэн явлаа. Үүлгүй цэв цэлмэг, дулаахан, цэцэгсийн үнэр ханхалсан сайхан өдөр байв.

Жилл тэргэнцэрийг усан сангийн хамгийн гүнзгий талд нь аваачин тоормосыг нь гишгээд нөхрийнхөө урд талд гарч зогслоо. Гүн хөх нүдэнд нь сэжиглэсэн, гайхан тээнэгэлэсэн харц холилдон гялалзана. Жилл бэхэлгээ бүсийг эцэст нь тултал чангаллаа. Дахиад дотор нь муухайран хоолой нь бачуураад ирлээ. Цаг нь болсон. Энэ бүхэн эцэс төгсгөл болох цаг нь болсон. Юу болохыг ойлгон өшөө хорсол нь тэчъяадсан сандралаар солигдоод ирэхийг Жилл түүний нүднээс нь харан ойлголоо.

Тэрээр тоормосыг мултлан тэргэнцэрийг ус руу түлхлээ.

Тоби эрэмдэг уруулаа хөдөлгөн хашгирахыг оролдсон боловч дуу гарсангүй. Айдаст автсан Жилл тэр даруй түүнийг харж зүрхэлсэнгүй. Тоби хамаг хүчээрээ тогтоон барьчихав уу гэлтэй тэргэнцэр хэсэг зуур чичирхийлэн усны мандал дээр тогтов. Нөхөр нь амьдралынхаа төлөө эцсийн хүчээ шавхан босохыг хэрхэн оролдож байгааг харав. Тэр гэнэт суларчихаад гарч ирэн ясан савраараа түүний багалзуурыг базах... Жиллийн чихэнд,

-Би хүсэхгүй, үхэхийг хүсэхгүй байна! гэж түүний бархирах дуу сонсогдов. Тэрээр энэ нь түүний хоосон санаанаас гарав уу эсвэл Тоби амь орчихов уу гэдгийг ойлгосонгүй, гэвч тэр ямартаа ч гэсэн сүүлийн хүчээ шавхан өөрийн мэдэлгүй тэргэнцэрээ налан гэдэсхийж байгаа харагдав. Тэргэнцэр агшин зуур их ус цалгиулсаар усны гүн рүү далд орлоо. Усны бяцхан эргүүлэг тэргэнцэрийг хаман авч явахад, Жилл сүүлийн удаа Тобигийн цэнхэр нүд нь түүнийг тамд унагахаа амлан зэвүүцсээр далд орохыг харлаа.

Бүсгүй дагжтал чичрэн, тэнхээ ортлоо хэсэг хөдөлгөөнгүй зогссоноо хөлөө зөөн гишгэхтэйгээ болмогц усан санд орон хувцсаа норгоод цагдаагийн хэлтэс рүү утасдахаар гэр рүүгээ явлаа.

Бүлэг 35.

Бүх сонингууд Тоби Темплийн үхлийн тухай шуугилдацгааж эхлэв. Тэр ардын баатар болон тодорч, харин Жилл эр зоригоо дөвийлгөн магтуулжээ. Магтаалын нийтлэл бүхэн дээр Жилл, Тоби хоёрын инээмсэглэсэн зураг. . . Тэдний хайр дурлалын түүхийг дахин сэргээн амь оруулж, агуу хошин жүжигчиний эмгэнэлт төгсгөл бүгдийн зүрхийг нь шимшрүүлэн, нулимс дуслуулна. Засгийн газрын гишүүн, гэрийн ажилтай эмэгтэй, улс төрч, саятан нарийн бичгийн дарга гээд улс орны өнцөг булан бүрээс харууслын захидал, цахилгаан ирсээр байв.

Дэлхий даяар хүн ардад баяр баясгалан бэлэглэгч агуу авьяастан Тобиг алдан хүнд хохирол амссан ч түүнийг үүрд дурсах болно. Ийм авьяастай жүжигчин дахин хэзээ ч төрөхгүй.

Тоби Темплийн үхлийн шалтгааныг мөрдөн байцаах шүүх хурал Гранд-авеню дахь Лос-Анжелесийн эрүүгийн хэргийн шүүхийн жижигхэн бачуу тасалгаанд пиг дүүрэн хүнтэй хийжээ. Жиллийг ирэхэд гэрэл зурагчид, гэрэл зургийн сурвалжлагчид, үймсэн олон отон хүлээж байв. Тэрээр даруухан хар костюм өмсөн, нүүрээ бага зэрэг гоодсон нь урьд өмнөхөөсөө илүү үзсгэлэнтэй харагдана. Тоби Темпоийн үхсэнээс

хойш хэд хоногийн дараа Жилл нойр нь хулжих зүдэргээ, аймшигаас ангижран гүн бат нойрсож ид шидийн гэлтэй хуучин хэвэндээ оржээ. Толгойн өвчин нь ул мөргүй алгаа болж, хоол унданд орсон байна. Түүний цусыг шимэн сорогч чөтгөр устан үгүй болжээ.

Жилл өдөр болгон Дэвидтэй ярин, мань эрийг очье гэхэд нь түүнийг хүлээхийг ятгаж чадлаа. Тэдний өмнө бүхэл бүтэн амьдрал үргэлжлэх их хугацаа бий.

Хуралд зургаан гэрч дуудагджээ. Ээлжийн сувилагч нар шүүгчид өвчтөний биеийн байдал, тэр ямар эмчилгээ хийлгэж байсан тухай тодорхой ярьцгаав.

Хатагтай Гэллахер гэрчийн байранд хүрэлцэн ирэв.

-Тэр өдөр таны ээлж байсан уу? гэж яллагч асуув.

-Арав цаг хүртэл.

-Тэгвэл та хэдийд явсан бэ?

Бага зэрэг тээнэгэлзэв.

-Ес хагаст.

-Та үргэлж дараагийн сувилагчийг ирэхээс өмнө явдаг байсан уу, хатагтай Гэллахер?

-Үгүй ээ, эрхэм ээ. Анх удаа эрт явсан юм.

-Яагаад энэ өдөр өвчтөнг ганцаар орхисноо тайлбарлаач?

-Хатагтай Темпл өөрөө хүссэн юм. Тэр нөхөртэйгээ ганцаар үлдэхийг хүссэн юм.

-Баярлалаа. Та явж болно.

Хатагтай Гэллахер гэрчийн суудлаас буулаа.

"Мэдээж, энэ золгүй тохиолдол гэж тэрээр батлаад, Жилл Темпл шиг сайхан бүсгүй ийм зовлон амсах ч гэж дээ!" хэмээн өрөвдөн бодлоо.

Сувилагч хатагтай Темплийн өрөө рүү харвал буйдан сандалд унтаж байхыг хараад хөөрхий эмэгтэйг сэрээхгүйг хичээн чимээгүйхэн явсаар гэрлийг нь унтраан хаалгыг нь хаан гарахдаа гудамжинд байсан үнэтэй цэцгийн савыг нь хагалчихжээ. Мэдээж тэрээр хатагтай Темплд үнэнээ хэлэхийг хүсч байсан ч, төлөхийг шаардвал яах билээ хэмээн айж, хатагтай Темпл савны тухай дуугарахгүй байхаар нь сувилагч чимээгүй өнгөрөхөөр шийджээ.

Физик эмчилгээний эмчийн мэдүүлэгт,

-Та ноён Темплийг өдөр бүр үздэг байсан уу?

-Тийм ээ, эрхэм ээ.

-Түүнд усан санд иллэх хийдэг байсан уу?

-Тийм ээ, эрхэм ээ. Бүлээн усаар, тэгээд. . .

-Тэр өдөр... эмчилгээ хийгдсэн үү?

-Үгүй, эрхэм ээ.

-Яагаад?

-Тэр намайг буцаачихсан юм.

-Та хатагтай Темплийг хэлээд байна уу?

-Яг үнэн.

-Хатагтай Темпл шалтгаанаа танд хэлсэн үү?

-Каплан эмч бүх эмчилгээг зогсоосон гэсэн.

-Та тэгээд ноён Темплийг харалгүй буцаж явсан уу?

-Тийм ээ, эрхэм ээ.

Каплан эмч дуудагдаж гарч ирэв.

-Хатагтай Темпл, золгүй явдлын тухай ярихаар тан руу утасдсан уу? Та талийгаачид үзлэг хийсэн үү?

-Цагдаагийнхан түүнийг усан сангаас татгаж гаргасан. Цогцос тэргэнцэрт хүлээтэй хэвээр байсан. Цагдаагийнхан шинжилгээ, харин би талийгаачийн биед үзлэг хийгээд аврах оролдлого хийхэд оройтсоныг хүлээн зөвшөөрсөн. Уушиг нь усаар дүүрчихсэн амьдын ямар ч шинж тэмдэг байхгүй байсан

-Та дараа нь яасан бэ, Каплан эмч ээ?

-Хатагтай Темплийг үзсэн. Тэрээр хийрхэн бие нь тун их муу байсан. Миний сэтгэл их зовсон.

-Каплан эмч ээ, та хатагтай Темплд физик эмчилгээ үр дүнгүй гэж хэлсэн үү?

-Тэгсэн. Би энэ нь цаг дэмий үрсэн ажил болохыг хэлсэн.

-Хатагтай Темпл хэрхэн хүлээж авсан бэ?

Каплан эмч Жилл рүү хяламхийн хараад,

-Тун таагүй хүлээж авсан. Тэрээр эмчилгээг үргэлжлүүлнэ хэмээн зүтгэсэн гээд хэсэг эргэлзсэнээ,

-Би хэдийгээр тангараг өргөсөн ч гэлээ, өмгөөлөгч нар үнэнийг мэдэхийг хүсч байгаа тул би үүргийнхээ дагуу тайлбар хийх ёстой гэж нэмж өгүүлэв.

Танхимд нам гүм болж, Жилл эмчийг анхааралтай ширтэв. Тэрээр өмгөөлөгчид хандан,

-Би өөрийнхөө үг бүрийн төлөө хариуцлага хүлээхэд бэлэн байна. Хатагтай Темпл хамгийн сайн, эрэлхэг бүсгүй. Түүний нөхөр эхний удаа харвалт өгөхөд бүгд эдгэрэх найдваргүй гэдгийг хүлээн зөвшөөрч байсан. Тэгээд яасан бэ? Бүсгүй ганцаар ямар ч туслалцаагүйгээр дэлхийн нэг ч эмч хийгээгүйг хийж түүнийг эдгээн эргэн амьдруулсан гээд Жиллийг дахин харлаа.

Бүсгүй босон гэрчийн суудалд очиж, тангараг өргөв.

-Энэ таны хувьд хүндхэн шалгуур болж байна гэдгийг би ойлгож байна гэж шүүгч хэлээд,

-Асуудлыг аль болох хурдан дуусгая гэлээ.

-Баярлалаа гэж Жилл намуухан дуугаар хариулав.

-Та яагаад Каплан эмчийн үгнээс зөрөн физик эмчилгээг үргэлжлүүлэх болов?

Тэрээр шүүгчийг элэг эмтрэм өрөвдөлтэйгээр хараад,

-Тобиг хөл дээр нь босгох бүхий л аргыг хэрэглэх гэсэн билээ. Тоби амьдрах дуртай, би түүнийг аврахыг оролдсон юм. Би. . . гэснээ хэсэг чимээгүй болсноо,

-Би түүнд туслах ёстой байсан. Өөрөө шүү.

-Таны нөхрийг нас барсан өдөр физик эмчилгээний эмч ирснийг та буцааж явуулсан уу?

-Тийм ээ.

-Гэхдээ та урьд нь эмчилгээг үргэлжлүүлэхийг хүсч байснаа мэдэгдсэн биз. Яагаад ийнхүү зөрүүдлэх болсноо тайлбарлах уу?

-Бүх юм тун амархан. Тобиг зөвхөн бидний хайр халамж эдгээнэ гэдгийг би мэдэрсэн. Би тэр үед түүнийг . . . гэж тэрээр үргэлжлүүлэх тэнхэлгүй болон чимээгүй болсноо,

-Би Тобид хайртайгаа түүнд туслахыг хүсч байгаагаа ойлгуулах ёстой байлаа гэлээ.

Тэнд байгаа хүмүүс үг бүрийг нь чих тавин сонсож танхим гүн чимээгүйд умбажээ. Жилл үг бүрээ цэгнэн удаан гэгч нь ярьж эхлэв.

-Би Тобигийн өрөөнд орсонд тэр намайг хараад тун баяртай байсан! Тэгээд би өөрөө усан санд авч оруулахыг хүссэн. Усанд иллэг хийхээр усны хувцсаа өмссөн, тэгээд түүнийг орноос нь босгон тэргэнцэрт суулгахдаа гэнэт бие эвгүйрхээд ирэхийг мэдэрсэн. Би түүнд туслаж чадахааргүй сульдсанаа ойлгох ёстой байжээ. Гэвч энэ миний нөхөр шүү гэж бодоод больж чадаагүй. Би Тобиг тэргэнцэрт суулгаад түүнтэй ярин, усан сан руу очсон. Түүнийг түрээд захаар нь явж...

Дахин чимээгүй болов.

-Би Тобигийн бүсийг нь тайлахаар завдтал гэнэт толгой эргэн, би унасан, тэгээд. . . тэгээд гэтэл тоормос санаандгүй мултарсан байсан. Тэргэнцэр өнхрөн усан санд живсэн. Би түүнийг тогтоохоор зүтгэсэн, гэвч. . . барьж авч чадаагүй, тэгээд Тоби.. . гээд Жиллийн дуу тасалдан,

-Би ус руу үсрэн орж түүнийг суллахаар оролдсон боловч бүс нь дэндүү чанга байсан. Би тэргэнцэрийг гаргахаар тагтал, тэргэнцэр... тэргэнцэр . . . дэндхүү хүнд. . .

Жилл шаналснаа нуух гэж хормын төдийд нүдээ аниад,

-Би Тобигоо аврах гэж оролдоод түүнийгээ алчихлаа гэж шивнэх шахуу үгээ дуусгав.

Барагцаагаар гурван минутын дараа өмгөөлөгч:

Тоби Темпл золгүй байдлаар нас нөгчсөн гэсэн тогтоол уншиж танилцуулжээ.

Танхимд Клифтон Лоренс сууж байсан юм. Тэрбээр Жилл Тобиг алсан гэдэгт бүрэн итгэж байлаа. Гэвч нотолгоо байхгүй нь тун гачлантай. Жилл ялаас мултарч чадлаа,

Ингээд хэрэг хаагдах нь тэр ээ.

Тобиг телевизийн шинэ шоуны зураг авалт эхлэх найман сарын нэгэн нарлаг өдөр оршуулжээ. Талийгаачтай салах ёс гүйцэтгэхээр ирсэн алдартнуудыг харахаар зуу зуун хүн хуран цугларсан байна.

Зураглаачид салах ёс гүйцэтгэх ажиллагааг, түүнд оролцогч кино од, продюссор, найруулагчдыг дэлгэц дүүрэн авч байв. АНУ-ын ерөнхийлөгч, мужийн захирагч, студийн захирал, томоохон корпорацийн ерөнхийлөгчид, ахмад дайчдын нийгэмлэгийн тэргүүн гэх мэтийн томоохон тушаалтнуудаас гадна шалихгүй жүжигчид, оролцон тоглогчид, хувцас зохион бүтээгчид үсчин гээд Америкийн өнцөг булан бүрээс Тоби Темплтэй хамтран ажиллаж байсан хүн бүхэн хайртай хүнтэйгээ салах ёс гүйцэтгэхээр иржээ.

Энд туранхай нэг хүү өрөөнд нь орж ирээд өөрт нь зохиол бичиж өгөхийг гуйн зогсож байсныг эргэн дурсах зохиоч О'Хэнлон, Рейнжер нар, костюмаа толийтол индүүдсэн хөөрхий агент эр Клифтон Тобигийн анх түүн рүү утасдаж байсныг нь дурсан зогсоно.

Сүүлчийн үүргээ биелүүлэхээр Эл Карузо хүртэл иржээ. Тэр бууралтаж, бөгтийн хэзээ ч хөгжилтэй байж харагддаггүй хүрэн нүдэнд нь дүүрэн нулимс мэлтэлзэнэ. Тэрээр Тоби сайн хүн, эелдэг нөхөр байсан юм гэж бодох ажээ.

Сэм Уинтерс авсны дэргэд Тоби хэдэн сая хүнд инээд баясал бэлэглэсэн бол хэмээн өөрөөсөө асуун зогсоно. Хэн нэгэн Сэмийн ханцуйнаас чангаахад нь тэрээр эргэн харвал царайлаг, хар үстэй, арван найм орчим насны нэгэн бүсгүйтэй золтой л улаан нүүрээрээ мергөлдчихсөнгүй.

-Та намайг мэдэхгүй, ноён Уинтерс гэснээ инээмсэглээд,

-Таныг Уильям Форсын шинэ кинонд жүжигчин хайж байгаа хэмээн би сонссон юм л даа. Би Огайогоос ирсэн, тэгээд. .

Дэвид Кеньоныг ирэхгүй байхыг Жилл хориглосон авч тэр түүнтэй хамт байх естой гэж ятгахад бүсгүй тэртэй тэргүй бүх юм дууссан тул ялгаа юу байхав гээд зөвшөөрчээ.

Нэгэн бүхэл бүтэн амьдралыг харуулсан жүжиг төгсөн хөшиг хаагдаж, үзэгчид ч тарцгаав. Жилл хунд хүчир сорилтыг даван туулж туйлдаа хүртэл ядарсан ч уй гашуу сэтгэл зүрхнээс нь арчигдан арилж, хамгаас аз жаргалтай байлаа.

Жилл Касл осолд амь үрэгдэн, Жозефина Цински гардь шувуу мэт өндөр аван дүүлэн нисэх болно. Тэрээр аз жаргал, амар амгалан дүүрэн бялхсан өөрийн ертөнцөд хөл тавин алхлаа. Энэ аз жаргалаа дэлхийн бүх хүн зонтой хуваалцахыг хүсчээ.

Оршуулах ажиллагаа дуусах дөхжээ. Хэн нэг нь Жиллийг хөтлөн машинд нь хүргэж өглөө. Дэвид машины дэргэд Жиллийг эрхэмлэн хайрлан харж зогсоно. Бүсгүйг инээмсэглэхэд Дэвид түүнийг хөтлөн нэгийг шивнэхэд, гэрэл зургийн сурвалжлагч зургийг нь авч амжжээ.

Жилл, Дэвид хоёр олны жишигээс гажаад яахав хэмээгээд таван сар хүлээсний эцэст гэрлэхээр шийдсэн байна. Дэвид удаан хугацаагаар хилийн чанадад ажилласан ч гэлээ өдөр бүр Жилтэй ярина.

Тобиг оршуулснаас хойш дөрвөн сарын дараа Дэвид,

-Надад нэг чухал санаа байна! Хойшид хүлээхийг хүсэхгүй! Ирэх долоо хоногт Европод хуралд явна. Алив хоёул Франц руу "Бретань" хөлгөөр аялая. Онгоцны ахмад бидний гэрлэх ёслолыг гүйцэтгэх болно. Бал сараа Францад өнгөрүүлээд, дараа нь хаа дуртай газар руугаа хэдий хугацаагаар ч хамаагүй явцгаая. За ямар вэ?

-Өө тэгэлгүй яах вэ, Дэвид!

Жилл сүүлийн удаа байр сууцаа тойрч энд болсон бүхнийг эргэн саналаа. Анх уригдан ирсэн оройн хоол, гайхалтай цэнгүүн, Тобигийн өвчин. . . түүнийг эдгээхээр оролдсон оролдлого. Харин дараа нь . . . дэндүү гунигтай явдал.

Жилл эндээс бүрмөсөн явж байгаадаа их баярлаж байлаа.

Жиллийг Парк-авеню дахь "Риженси" зочид буудалд аваачихаар хүлээж байсан лимузин нь ухасхийн давхилаа. Буудлын захирал нь өөрөө түүнийг пентхаусийн асар том люкс өрөөнд нь өөрөө оруулж өгөөд,

-Зочид буудлын ажилтнууд үргэлж таны мэдэлд байх болно, хатагтай Темпл. Ноён Кеньон таны хүссэн бүгдийг биелүүлэхийг тушаасан! гэж тэрээр мэдэгдэв.

Арван минутын дараа Дэвид утасдаж,

-Бүх юм ёсоороо юу? гэлээ.

-Энд таван унтлагын өрөө байна, Дэвид ээ. Ийм олон өрөөгөөр би юу хийх билээ? гээд инээв.

-Дэргэд чинь байгаагүй нь тун харамсалтай юм, би байсан бол үзүүлээд.. .

-Ганц ч болов амлалтыг чинь сонсох шив хэмээн бүсгүй хошигнон хэлээд,

-Би хэзээ чамтай уулзах болж байна? гэв.

- "Бретань" маргааш очино. Хөлөг дээр уулзацгаая. Би шинэ гэрлэгсэдийн өрөө захиалсан. Хонгор минь жаргалтай байна уу?

-Би хэзээ ч ийм жаргалтай байсангүй.

Энэ их аз жаргал нь мартагдсан зүүд мэт тэртээ алсад манантан бүүдгэрэх доромжлол, гай зовлонгийн өр төлөөс болон амтлагдах ажгуу.

-Машин өглөө очиж авна. Жолооч нь хөлөг онгоцны билет өгөх болно.

-Би бэлэн байж байна гэж Жилл хэллээ.

Бүх юм оршуулган дээр Жилл, Дэвид хоёрыг хамт байхад нь авсан тэр гайтай гэрэл зурагнаас ч болсон байж магадгүй. Эсвэл зочид буудлын ажилтанууд, эс бөгөөс "Бретань" хөлгийн

ажилтнуудын хэн нэг нь гэнэ алдан Жиллийн хаана байгааг нь хэлснээс ч болсон байж магад. Гэлээ гэхдээ Америк даяар алдартай эмэгтэйн гэрлэлт нь нууц хэвээр байж чадсангүй. Хуримын тухай мэдээлэл "Ассошшейтэд пресс" агентлагийн сэтгүүлд хэвлэгдэн үүний дараа америк, европын сонингийн эхний нүүрэнд, тэр ч бүү хэл "Голливуд репортер", "Дейли вэрайти" сонинд хүртэл гарчээ.

Лимузин яг 10 цагт зочид буудлын үүдэнд ирэхэд, гурван ачигч Жиллийн тээшийг ачив.

Ахмадын ахлах туслагч нь Жиллийг онгоцны зогсоол дээр угтан авлаа.

-Та "Бретань" хөлгөөр аялаж байгаа нь бидний хувьд ихээхэн аз завшаан тохиолоо, хатагтай. Бүх юм бэлэн. Би танд замчилья.

Тэрээр Жиллийг дагуулан зугаалах тавцангаар явсаар энд тэндгүй цэцэг тавьсан тусгай тагт бүхий том саруулхан өрөөнд оруулаад,

-Ахмад танд гүнээ хүндэтгэн мэндчилж байгаагаа дамжуулахыг хүссэн билээ. Та түүнтэй оройн зоогон дээр уулзах байх. Хуримын ажиллагааг тэсэн ядан хүлээж байна хэмээн дамжуулахыг хүссэн.

-Баярлалаа гэж Жилл толгой дохиод,

-Ноён Кеньон хөлөг дээр ирсэн эсэхийг мэдэв үү? гэсэнд,

-Тэрбээр дөнгөж сая утасдсан шүү. Нисэх онгоцны буудлаас ирж яваа байх. Ачаа тээшийг нь хэдийнэ авчирсан. Ямар нэг юм хэрэг болбол надад дуулгана биз ээ гэв.

-Баярлалаа, одоохондоо юу ч хэрэггүй гэж хариулсан нь хүссэн бүхнээ хүртсэн түүний хувьд туйлын үнэн үг байлаа. Түүн шиг аз жаргалтай хүн энэ хорвоо дээр даан ч алга аа.

Өрөөний хаалга тогшоор үйлчлэгч баглаа цэцэг барин орж ирлээ. Нэгдсэн улсын Ерөнхийлөгч илгээжээ. Эргэн дурсахуй...

Тэр усан онгоцны хашлаганы дэргэд тавцан дээр зогсоод цовоо сэргэлэн, хөгжилтэй, хүсэн хүлээсэн амралтаа эдлэхээр яарсан, эсвэл амраг хайрттайгаа учрахаар гэгэлзэн яваа зорчигч бүрийг нүдээрээ нэгжин шатнаас нүд үл салгах ажээ.

Тэнгист гарахаас хориод минутын өмнө 11. 40-д усан онгоцны зогсоол дээр лимузин хүрч ирлээ. Дэвид Кеньон машинаас үсрэн буугаад цагаа хяламхийн харснаа жолоочдоо,

-Отто, та машин сайн барих юмаа гэв.

-Баярлалаа, эрхэм ээ. Танд болон хатагтай Темплд хуримын аялалаа сайхан өнгөрүүлэхийг хүсэж болохсон болов уу?

-Баярлалаа, Отто.

Дэвид Кеньон тасалбар шалгагчийн зогсож буй хаалга руу яаравчлав. Жиллийг угтан авсан ахмадын туслах түүнд,

-Хатагтай Темпл таны өрөөнд байгаа, эрхэм Кеньон гэв.

-Баярлалаа гээд Дэвид шинэхэн гэрлэсэн хосын өрөөнд энхрий ялдам инээмсэглэн түүнийг хүлээн байгаа Жиллийг төсөөлөн бодоод. . . зүрх нь сүрхий цохилон булгилав. Тэрээр өрөө рүүгээ явахыг завдтал хэн нэгний,

-Ноён Кеньон оо... хэмээн дуудах сонсогдов.

Дэвидыг эргэн харвал хашлаганы дэргэдээс маасайн инээх нэгэн эр өөрийг нь чиглэн айсуй.

Дэвид энэ эрхэмийг урьд хожид огт зүс үзээгүй ч гэлээ үл таних эрийн хэт наалинхайтан эелдэглэхэд нь иймэрхүү улс үргэлжид нэгийг гуйж байдгийг саятнуудын нийтлэг зөнгөөрөө андахаа байжээ. Тэрээр хүйтэн царайлан нөгөө эрийг ширтэв.

Үл таних эрийг гар сунгахад Дэвид гарыг нь гайхан атгаад,

-Бид танил билүү? хэмээн асуусанд,

-Би Жиллийн хуучин танил нь гэж тэр хүн тайлбарлаад,

-Намайг Лоренс. Клифтон Лоренс гэдэг гэхэд нь Дэвидийн санаа амрав.

-Тун баяртай байна, ноён Лоренс хэмээн Дэвид эелдэгээр толгой дохив. Тэр явахыг яарсангүй.

-Жилл намайг таныг тосон уулзахыг хүссэн юм гэж Клифтон хэлээд,

-Түүнд танд үзүүлэх өчүүхэн сүприз байгаа гэлээ.

-Чухам ямар юм бол оо? гэж Дэвид гайхав.

-Би танд үзүүлье, явцгаая.

Дэвид бага зэрэг эргэлзлээ.

-За яахав. Нэг их цаг авахгүй болов уу?

-Яалаа гэж дээ, эрхэм Кеньон гэж Клифтон жуумалзав.

Тэд зорчигчдын дэргэдүүр өнгөрөн доод тавцан руу буун өндөр хаалганы дэргэд ирцгээв.

Клифтон хаалгыг нээгээд Дэвидийг орохыг урин дохив. Дэвид хоосон, том кино заалыг хараад гайхаж хоцров.

-Энд үү?

-Энд гээд Клифтон мушилзаад, бүхээг рүү эргэн харж кино механикчид толгой дохив.

Механикч эр Лоренстой удтал наймаалцсаны эцэст хоёр зуун доллароор, түүнд туслахаар зөвшөөрөхдөө, чангаар,

-Энэ тухай хэзээ нэгэн цагт мэдэх юм бол би ажлаа алдана хэмээн архирсан ажээ.

-Бүү санаа зов, энэ ердөө л даагаа нэхэж байгаа юм. Та ердөө л биднийг оруулаад хаалгаа хаан, аппаратаа залгана. Бид арван минутын дараа явцгаана.

Эцэст нь киномеханикч зөвшөөрсөн аж.

Дэвид Клифтоныг эргэлзэн ширтээд,

-Кино юм уу? гэвэл,

-Суугтун, эрхэм Кеньон гэлээ.

Дэвид урт хөлөө ачин суухад, Клифтон зэрэгцэн суугаад түүнийг сэм ажиглав.

Кино эхэллээ. Дэвид ой гутам, ёс бус жигшүүрт зүйл гарах дэлгэцнээс нүд салгаж чадахгүй, итгэж. ядна. Жилл, Жилл ганцхан шөнийг хамт өнгөрөөсөн шигээ чармай шалдан орон дээр хэвтэнэ. Яасан тод тодорхой, дүр зураг гээч вэ! Дэлгэц дээрх эр бүсгүйн нүүрэн дээр сандайлан суух нь холгүй ам руу нь хөвчрөн хатуурч боссон эрхгэнээ гудчин хийх аймшигт зургийг хараад хамаг бие нь хөших нь тэр. Бүсгүй түүнийг нь амь тавин аймшигтайгаар хөхөхөд бас нэгэн эмэгтэй гарч ирэн Жиллийн салтааг тэлэн хэлээрээ. . .

Дэвидийн дотор нь муухайран огиудас хүрчээ.

Бараан царайт мексик эр гэнэт оролцон бүсгүйг цааш түлхчихээд Жилл дээр мордоод авлаа. Дэвидийн нүдний өмнүүр улаан манан татаад ирэв.

Тэр. . . 15 настай болчихсон. . . Тэр Бетийн өрөө рүү харайн орлоо. . . Эгч нь мексик цэцэрлэгчийн өвөр дээр шалдан суучихсан дэмийрчихэв үү гэлтэй,

-Өө Тэнгэр минь, би чамд ямар их хайртай гээч, Хуан!

Дахиад, дахиад хүчтэй! Битгий зогсоорой! Хүчтэй! . . . хэмээн гийнан үглэнэ.

Түүний эгч нь, хайртай эгч нь шүү дээ!

Хүү өөрийгөө хянах чадалгүй болтлоо галзуутай уурлан цаас зүсдэг хутга шүүрэн авч Бетийг түлхэн зайлуулчихаад цэцэрлэгч мексик эрийн цээжинд нэг, дахин нэг, гурав дахь удаагаа, хана цусанд будагдтал дүржээ.

Бет аймшигтайгаар,

-Бурхан минь, үгүй ээ, үгүй! Дэвид ээ, болиоч! Би түүнд хайртай! Бид гэрлэнэ хэмээн бархирах сонсогдов.

Цусан далай болжээ.

Эх нь өрөөнд орж ирэн Дэвидийг хөөж гаргав. Ээж нь Кеньоны гэр бүлийн эртний найз тойргийн прокурортой ярилцаж байхыг сонсчээ. Тэд ямар нэг юмны тухай гудамд их л удаан ярилцаж байснаа, мексик эрийн шарилыг шорон руу авч явжээ. Маргааш өглөө нь түүнийг камертаа амиа хорлосон хэмээн зарлав. Харин Бет эгч нь гурав хоногийн дараа галзуугийн эмнэлэгт хүргэгдсэн аж.

Дэвид уур нь тэсэхийн аргагүй оволзон ухаан солиорч, зэрэгцэн суугаа эрийг гэнэт заамдан аваад суудлаас нь гуд татан босголоо. Зангидсан гарын хүчтэй том нударга Лоренсын гурвынх нь дунд буун хамрыг нь хавтгайлан цааш чихэж орхив. Юу хийж байгаагаа мэдэхээ больсон Дэвид,

-Бетийг, Жиллийг, өөрийг нь доромжилсных нь төлөө хэмээн хашгичив.

Клифтон Лоренс хамгаалахыг завдавч цохилт нь мөндөр мэт дараа дараагаар буух ажээ. Хамар дундуур нь нударга дахин буухад яс үс нь яйран шажигнахад, улайрсан бух шиг уурласан Дэвид эс анзааран дахин нударга далайн цохитол уруулыг нь хэгзлэн цус усан оргилуур адил годгодлоо. Айдаст автан хөдөлж ч чадахаа больсон Лоренс ердөө л дараагийн нударга буухыг нь хүлцэнгүйгээр хүлээж агийн хэвтэнэ. Бүх юм дуусан нам гүм болоход танхимд агент эрийн уухилан амьсгалах, дэлгэц дээр тачаадан гийнах дуу л сонсогдоно.

Клифтон алчуур гаргаад цусаа тогтоохыг оролдож нүүрээ дарсаар танхимаас гарч, Жиллийн өрөө рүү явлаа. Тэрээр гал зуух руу орон үймэн бужигналдах тогооч, үйлчлэгчдийн хажуугаар зөрөн явсаар хөргөгчийн дэргэд очиж, ам цаасанд атга мөс боож аваад хэгзэрсэн уруул, хавтгайлагдсан хамартаа жин тавив. Нүдэд нь залуу хосын дүрс бүхий хуримын асар том бялуу туслаа. Клифтон гярхай гэгч харснаа бүсгүйн дүрс рүү гараа явуулан, толгойг нь бяцлав.

Жиллтэй ярилцах цаг нь болжээ.

Хөлөг зогсоолоос хөдлөхөд, Жилл хөл дор нь үл мэдэг чичирхийлэн мэдэгдэхэд мэгдэн толгойгоо өргөөд Дэвидийн яагаад удаж байгааг үл ойлгон, хувцас хунараа өлгөж эхлэв. Хаалга тогших сонсогдоход,

-Дэвид! хэмээн Жилл уулга алдан баярлаад үүд рүү харайн очиж нээгээд хайртыгаа тэврэн

авахаар гар сунгалаа.

Гэтэл гудамд цус нөжиндөө хутгалдсан үзээрийн царайтай Клифтон Лоренс зогсож байжээ.

Жилл айн мэгдэн, түүнийг гайхан хараад,

-Чи энд юу хийж байгаа юм бэ? Чи. . . чи яагаав? гэсэнд,

-Мэндийг чинь мэдэх гэж ирсэн юм гэлээ.

Жилл эргэлзэн хөмсөг зангидан харлаа.

-Дэвидийн даалгаврыг биелүүлэх гэсэн юм.

-Дэвидийн гэнээ?

Клифтон өрөөнд түрэмгийлэн дайрч ороход Жилл юунаас ч юм сандчин айж чичирч гарлаа.

-Нэг кино байдгийг санаж байна уу? гэж Лоренс асуугаад,

-Цагаан бүрхтэй сайхан залуучууд, гэвч хорлонтой хар санаатай улс байдаг даа. Муу санаа биеэ отно гэдгийг чи мэдэх үү. Би ийм киноны дунд өссөн хүн дээ, Жилл. Цагаан бүрхтэй залуус үргэлж ялан дийлдэг сэн дээ гэлээ.

-Чиний юу яриад байгааг ойлгохгүй байна

-Хуучны кино биелэлээ олж байгааг ганц удаа ч болов харахад сайхан байна шүү гээд хавдан цус нөж болсон

уруулаараа инээхчээ аядаад,

-Дэвид явчихсан. Үүрд явчихсан гэлээ.

Жилл итгэж ядан толгой сэгсрэв. Яг энэ мөчид хөл дор нь мэдрэгдэж байсан чичиргээ намдав. Хөлөг зогсчээ. Клифтон тавцан руу гарснаа,

-Алийв, нааш ир гэхэд нь, Жилл хэсэг эргэлзсэнээ айдаст автсаар түүний араас очлоо. Дэнид тээр дор зүтгүүр онгоцонд сууж байв. Тэр явчихлаа. Жилл хашлаганаас зууран,

-Яагаад тэр вэ? Юу болоо вэ? гэж гайхан бувгнав.

Клифтон Лоренс түүн рүү эргэн,

-Би түүнд чиний тоглосон киног үзүүлсэн юм гээд хорлонтойгоор маасагнан инээв.

Жилл юу болсныг агшин зуур ойлгоод,

-Ээ Тэнгэр минь, үгүй ээ! Үүнийг л үгүй ээ шүү! Чи намайг алчихлаа гэж хашгирлаа.

-Тэгэхээр бид өр ширгүй болох шив.

-Зайл! Эндээс зайл! гэж Жилл бахирав.

Бүсгүй түүн рүү дайран урт хумсаа хацарт нь шигдэн цусан судалд мөр үлдээлээ. Клифтон Жиллийн нүүрэн дундуур нь хүчтэй нударгаа буулгав. Бүсгүй өвдөг сөхрөн унаад толгойгоо базлан, амьсгал нь давчдан атиралдан уналаа.

Лоренс Жиллийг харж удаан зогслоо. Тэрээр өөрийгөө хэн болохыг Жиллд ойлгуулах гэсэн нь энэ ээ.

-Баяртай, Жозефина Цински гэж хэлчихээд доод тавцан руу бууж, нүүрээ алчуураар даран явлаа. Санаагаа гүйцээсэн тэр алгуурхан явах зуур зорчигчдыг нэгд нэгэнгүй шинжин ер бусын дүр төрх, ааш аягийг эрэлхийлнэ. Шинэ авьяастныг хаанаас олж болохыг хэзээ ч мэдэхгүй. Тэрээр одоо санаа

амар ажил руугаа явах болно. Гэнэт аз нь шовойж хоёр дахь Тоби Темплийг ч олох юм билүү, хэн мэдлээ!

Лоренсыг явсны дараа Клод Дессар үүд тогшив. Өрөөнөөс нэг л хачин авиа гарахыг сонссон тэрээр хариу хүлээсэнгүй, чангаар,

- Хатагтай Темпл! Аж ахуйн эрхлэг Клод Дессар байна. Би танд тус болж чадах болов уу? гэлээ.

Таг чимээгүй. Зургаа дахь мэдрэхүй нь энэ эмэгтэйд нэг л аймшигтай юм учирсныг ойлголоо. Түүнийг айлгаа юу, эсвэл алж орхио юу. . . гэсэн аймшигт бодол толгойд нь эргэлдэж, үс нь өрвийлөө.

Дессар бариулыг эргүүлбэл хаалга түгжээгүй байв. Үүдийг алгуур нээвэл Жилл Темпл тасалгааны нөгөө буланд онгоцны гэгээвчээр цааш харан зогсож байлаа. Дессар нэг юм хэлэх гэснээ нэг л хачин хөшиж орхин матийсэн нурууг нь харан хэсэг зогссоноо чимээгүйхэн буцаад явах уу эсвэл өвдөж зовоо юу гэдгийг нь асуух уу хэмээн эргэлзэж байтал гэнэт үхлийн шарх аван тарчлах араатан аятай сэтгэл шимшрүүлж, яс янгинам дуугаар чарлалаа.

Дессар сандран үүдийг нь сэм хаагаад хэсэг чагнавал үг сүггүй цурхиран уйлахад сэтгэл нь зовон кино заал руу эргэлэв.

Энэ үдэш ахмадын ширээнд хоёр суудал эзгүйрчээ. Ахмад хооллож байснаа хажуугийн ширээнд сууж байсан Дессар руу доживол тэр уучлал эрснээ яаравчлан босоод хүрч ирлээ.

-Өө Дессар! гэж чин сэтгэлээсээ мэндлээд дуугаа намсган тэс өөр өнгөөр,

-Хатагтай Темпл, ноён Кеньон хоёр юу болоов? гэж сэмхэн асуув.

Дессар ийш тийш болгоомжтой харснаа,

-Ноён Кеньон хөлгийг орхин лоцманы хамт эрэг рүү явсан. Хатагтай Темпл өрөөндөө байгааг та юу гэж бодож байна гэлээ.

Ахмад амандаа хараал урсгав. Угийн ёсорхог ахмад тэсвэр алдан журмаа зөрчин,

-Новш гэж! Хуримын бэлтгэл үнсэн товрог болох шив.

-Мэдэж байнаа, ахмад аа! Дессар мөрөө хавчин, тэнгэр ширтээд,

-Америкчууд аа гэж! хэмээв.

Жилл харанхуй өрөөнд буйдан сандалд хөлөө нугалан эрүүндээ тулгаж агийгаад, гөлийн суужээ. Тэр Дэвид Кеньоныг, Тоби Темплийг, тэр ч бүү хэл өөрийгөө ч бодон энэлэн шаналсангүй. Гагцхүү Жозефина Цински нэртэй бяцхан охины төлөө ихийг бодож мөрөөдсөн боловч энэ бүхэн нь одоо салхинд хийсэн үгүй боллоо.

Жилл хөдөлгөөнгүй суусаар, хэдхэн цагийн өмнө бүх дэлхий түүний хөл дор сөхөрч байсан бол одоо. . . бүх юм хоосорч эл хуль болжээ. Шанаанд нь лугшин өвдөх нь мэдрэгдсээр. Жилл өвдгөө элгэндээ наагаад улам эвхрэн бүгдээс тусгаарлагдахыг хүслээ. Тэр ядарчээ, дэндүү их ядарч. . . Юу ч хүсэхгүй, юу ч бодохгүй, зөвхөн энэ чигтээ суухыг л хүсэж байв. Тэгвэл зовлон нь бага ч болов холдох байх.

Жилл эцсийн хүчээ шавхан ор руугаа мөлхөх шахуу явсаар орондоо орон нүдээ анив.

Тэгтэл нөгөөх мөсөн агаар түүн рүү дөхөн ирж, тойрон эргэлдэж, энхрийлэх түүний дуу гарч, өөрийг нь дуудав. "За одоохон, одоохон" гэж Жилл бодлоо. Ингээд өндийн босоод тархинд нь хангинан зогсоо зайгүй дуудах дуудлаганд үг дуугүй захирагдан өрөөнөөсөө гарлаа. Шөнийн хоёр цагт хөлгийн тавцан хов хоосон байх ажээ. Жилл тэнгис рүү харвал сарны гэрэлд тэнгисийн давалгаа хөлгийн бортыг намуухан цохилно.

Толгойн өвчин нь улам нэмэгдэж, төмөр бахиар хавчих мэт хүчтэй өвдөнө. Нөгөө дуу Жиллийг санаа зовох хэрэггүй, бүх юм сайн сайхан болно хэмээн итгүүлэхийг оролдоно. Гэнэт "Доошоо хар!" гэж дуу тушаав.

Жилл дуулгавартайгаар харвал харлан харагдах далайн усанд нэг хүний дүрс тодоров. Тоби түүн рүү инээмсэглэн, цэнхэр нүд нь сүүмийсэн харагдана.

Мөсөн агаар дахин үлээж Жиллийг хашлага тийш зөөлөн түлхэв. Усанд харагдах өнөөх дүрс баярлан дохилзож, цовчин Жиллийг ёроолгүй гүн хар ус руу урина.

Салхи бүр ч хүйтэрч хамаг биеийг нь нэвглэн үлээж дагжтал чичрүүллээ.

"Бүү ай. Ус хачин сайхан бүлээхэн байна. Чи энд надтай үүрд хамт байгаач. Явья, Жилл ээ" гэх дуу хоолой дахин сонсогдов.

Жилл хормын төдийд нүдээ аниад нээвэл, нөгөө инээмсэглэсэн царай урьдын адил хэвээр харагдав. Тоби хөлгийг орхихгүй нь бололтой, түүний үзэшгүй муухай гар хөл нь усан дотор

санжигнана.

"Алив, нааш ир" гэх дуу дахин гарлаа.

Жилл хашлага дээгүүр тэгнэн, Тобид амар тайван орхихыг хэлэх гэтэл салхи түүнийг өргөн хашлага давуулчих нь тэр. Бүсгүй шөнийн хилэн хар агаарт балетчин шиг хөвлөө.

Тобигийн нүүр улам ойртож, эрэмдэг гараа сунган Жиллийг хатингар биедээ наан тэвэрэн авлаа.

Тэд үүрд мөнхөд нийлэн...

Ингээд салхи, тэнгис хоёр энэ хорвоод гэмгүй царайлан үлдэж, харин энэ түүхийг бүтээсэн одод тэнгэрт гялалзан байлаа.

ТӨГСӨВ.